**Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр**
**Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар**
**2023 оны жилийн эцэс**

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Суурь түвшин | Шалгуур үзүүлэлт | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого | | | | | | | | | |
| 1 | 1.1.1. “Ковид-19” халдварт цар тахал, шинэ болон дахин сэргэж байгаа халдвараа урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн дэглэм, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг зохион байгуулах | 2021 - 2024 | 105/6752 | ААН, байгууллагын тоо, сургалтын тоо | - | 100/6500 | Аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийхэд хүний нөөцийн дутмаг байдлаас эмч, мэргэжилтнүүд 2-3 ажил давхар хариуцан, ажлын ачаалал ихтэй ажиллаж, аюулгүй ажиллагааны өдөр тутмын зааварчилгааг тогтмол өгдөггүй, ХАБЭА-н дотоод журамгүй, химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэлгүй гэх мэт нийтлэг зөрчлүүд илэрсэн. Илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар "MNS 4969:2000", "MNS 6231:2011", "MNS 6392:2013" стандартуудыг баримталж ажиллах, ажлын байрны орчин, аюулгүй байдлыг сайжруулах, ХАБЭА-тай холбоотой баримт бичгийг бүрдүүлэх зөвлөмж өгсөн. Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо,ХАБЭА-н зөвлөлтэй хамтран Эрүүл мэндийн байгууллагуудын ХАБЭА хариуцсан ажилтан, удирдлагуудад ХАБЭА-н мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулж, 25 хүн хамруулсан. Сайншанд сумын өрхийн эрүүл мэндийн төв, Мандах, Сайхандулаан сумдын эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд 65%-тай байсан. Эрүүл мэндийн байгууллагуудын үйлчлэгч, асрагч 28 ажилчдад ХАБЭА тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зөвлөмж мэдээллийг өгч арга зүйгээр хангасан. Орчны эрүүл мэнд арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн байгууллагууд 48 удаагийн сургалтад 1804 иргэн, 189 удаагийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сурталчилгаанд 6243 иргэнийг хамруулж, 134 төрлийн гарын авлагыг шинээр хэвлүүлэн 3820 хүнд тарааж, цахимаар 270 төрлийн зөвлөмж мэдээлэл түгээж, 10125 хандалт авсан. Нийт 964 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж, 206 байгууллага, аж ахуйн нэгжийн 13604 иргэнийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 23 удаагийн сургалт сурталчилгаа, 104 иргэнээр нэмэгдэж, 190 төрлийн 6063 зөвлөмж сэрэмжлүүлэг тараасан. Цахимд 367 төрлийн мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг, видео зөвлөмж байршуулж, 122201 хүний хандалт авсан нь өмнөх оны мөн үеэс 34 мэдээлэл, 8568 хандалтаар нэмэгдсэн. | |
| 2 | | 2. Шинэ болон дахин сэргэж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг иргэд, олон нийт болон мэргэжлийн байгууллагуудад зохион байгуулж, шаардлагатай дадлыг хэвшүүлж, чадавхжуулах | 2021 - 2024 | 514 | сургалт, сурталчилгааны тоо | - | 300 | Ковидын халдвар, томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, баяр амралтын өдрүүдэд халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн баримтлах талаар цахимд 367 төрлийн мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг, видео зөвлөмж байршуулан, 122201 хандалт авсан нь өмнөх оны мөн үеэс 34 мэдээлэл, 8568 хандалтаар нэмэгдсэн. Орон нутгийн "DTV" телевиз, "МОНЦАМЭ" агентлагийн орон нутгийн байгууллага, “Dornogovi post” цахим мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан эрүүл мэндийн мэдээллийг иргэдэд түргэн шуурхай хүргэж ажилласан. Хэвлэл мэдээллээр нийт 67 төрлийн мэдээ, мэдээлэл / “Эмчийн зөвлөгөө”-13, охид хөвгүүдийн цаг-5, цаг үеийн мэдээлэл, зар, видео бичлэг-25, зөвлөмж шторк-24 /-ийг тус тус хүргэж ажилласан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/373 дугаар тушаалын дагуу Коронавируст халдвар, томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус тус 1 удаа тодотгол хийж, 20 эрүүл мэндийн байгууллагыг цаг үеийн мэдээллээр хангаж, арга зүйн заавар чиглэл өгч ажилласан. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | “Ковид-19” халдвараас сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл, сэрэмжлүүлгийг олон талт арга хэмжээгээр иргэдэд тасралтгүй хүргэж, давхардсан тоогоор 964 удаагийн сургалт, сурталчилгаа,аян, нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, 196 байгууллага, аж ахуйн нэгжийн 15602 иргэнийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 23 удаагийн сургалт сурталчилгаа, 104 иргэнээр нэмэгдэж, 190 төрлийн 6063 зөвлөмж сэрэмжлүүлэг тарааж, иргэдийг мэдээллээр хангасан. | |
| 3 | | 3. Сургалтын байгууллагын багш нарын цахим хичээл боловсруулах арга зүйн сургалт зохион байгуулж, үр нөлөөг дээшлүүлэх. | 2021 - 2024 | 2 | - | | 2 | "Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг дэмжих арга зүй", "Боловсролын сэргэлт-Сургуулийн өмнөх боловсрол", "Боловсролын сэргэлт-Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт" сургалтад 14 арга зүйч, 22 захирал, 33 цэцэрлэгийн эрхлэгч, СӨБ-ын бүлгийн багш нарт "Kilmory-X", "CUBASE" зэрэг цахим программ дээр ажиллах арга зүйн сургалтыг зохион байгуулж 90 гаруй багш хамруулсан. Үүний үр дүнд БЕГ-с зохион байгуулсан “Монгол бахархал” аянд “Тэмүжиний бага нас” зохиомжит контентоор оролцож Сайншанд сумын 11-р цэцэрлэгийн багш нар 2-р байранд шалгарсан амжилт үзүүлсэн. Багш нарын хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, өнгө, дүрс,1080 нягтаршилтай, сонирхолтой агуулгатай сургалтын цахим хэрэглэгдэхүүн болон цахим хичээл боловсруулж 350 хичээлтэй цахим сан бүрдүүлэн сургалтад ашигласан. Контент үйлдвэрлэгч "ARGUN GROUP"-н "IPAD", "IPTV" зэргийг хичээл сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлж, сургалтын шинэлэг арга барилаар хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжсэн 12 шинэ сургалтын технологи, арга зүй боловсруулж түгээн дэлгэрүүлсэн. "Medlee.mn" цахим платформд контент бэлтгэн байршуулах арга зүйн сургалтыг 12 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сургуулийн 200 гаруй багш хамруулан зохион байгуулсан. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны цахим хичээл боловсруулах арга зүйг нэмэгдүүлэх чиглэлээр арга зүйн 18 сургалт зохион байгуулж, 1356 багш, нийгмийн ажилтан, удирдах ажилтан, албан хаагч хамруулж, чадавхжуулсан. | |
| 4 | | 4. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын чиглэлээр хяналт шинжилгээ, тандалт судалгаа, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | 2021 - 2024 | 96 | - | | 200 | Коронавируст халдварын илрүүлэг, тандалт шинжилгээг 2 нэгдсэн эмнэлэг, 14 сумын эрүүл мэндийн төв, Ханги боомт, 4 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 20 цэгээс өдөр бүр мэдээг авч, тайлант хугацаанд нийт 4446 шинжилгээ /түргэвчилсэн оношлуураар - 3735, Бх-ПГУ-711/ хийгдсэн байна. ПГУ шинжилгээний сорьцыг цуглуулж, 2 нэгдсэн эмнэлгийн молекул биологийн лабораторид 691 шинжилгээ хийж, халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр 5 сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийж, эрсдэлийг үнэлэн, зөрчил дутагдал илрүүлж, зөвлөмж өгч, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх талаар сургалт болон зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Энэ онд коронавируст халдвар (covid-19)-ын 249 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 33.8 болж өмнөх оны мөн үеэс 1146,6 тохиолдлоор буурсан. Халдварт өртсөн 249 тохиолдол болон тэдний хавьтал 729 хүнд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлснээр хүндрэл, эндэгдэл бүртгэгдээгүй байна. | 100% |
| 5 | | 5. Зорилтод бүлгийн хүүхдүүдийг томуугийн вакцинд хамруулах | 2021 - 2024 | 650 | - | | 700 | Томуу, томуу төст өвчний халдварын дэгдэлт, бага насны хүүхдийн томуугийн халдвар, уушгины хатгалгаанаас сэргийлэх зорилгоор жил бүр 0-12 насны хүүхдүүдийн дунд томуугийн эсрэг дархлаажуулалтыг уламжлал болгон хийж, санхүүжилтийг орон нутгийн Засаг | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлж хэвшсэнээр томуугийн шалтгаанаар эндэх хүүхдийн тоо буурсан. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/358 дугаар тушаалаар 5660 хүүхдийг дархлаажуулах Солонгос улсын "Грийн" кросс үйлдвэрийн томуугийн эсрэг 4 цент вакциныг татан авч, дархлаажуулалтын 19 нэгжээр дархлаажуулалтыг зохион байгуулж, хамрагдвал зохих 2-5 насны 4595 хүүхдийн 2740 буюу 59.6%-ийг үнэ төлбөргүй дархлаажуулалтад хамруулсан. | |
| 6 | | 6. Цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн аюулгүй бүсийг бий болгож, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авах, хөрсний хяналт шинжилгээ хийх | 2021 - 2024 | 100 | - | | 40 | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН3388/3713 төсөл”-ийн хүрээнд хоногт 3000м3 бохир ус хүлээн авах хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлыг улсын төсвийн 6350.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр “Компорт импекс” ХХК гүйцэтгэж, 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдөр барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан. Тус цэвэрлэх байгууламж нь механик, биологи, гүйцэд цэвэрлэгээний технологитой ба цэвэрлэгдсэн усыг цэцэрлэг, зүлэгжүүлэлт, зам талбай, хөрсний усалгаанд ашиглахад зориулагдсан цооногтой. Мөн цэвэрлэгээний явцад гарсан лагийг боловсруулан бордоо, түлш гаргах тоног төхөөрөмжтэй жишиг байгууламж болсон. Цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдээд гарч буй хаягдал ус нь MNS 4943:2015 стандартын шаардлага буюу ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтээс хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэхгүй байгааг лабораторийн шинжилгээгээр тогтоосон. Орон нутгаас | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн бүсийг тогтоон мөрдүүлэх, ойр орчмын газрын хөрснөөс дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэхээр бэлтгэл хангаж байна. Дорноговь аймаг, Япон улсын Шизоүка муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд саарал усыг дахин ашиглах боломж, инженер техникийн ажилчдыг бэлтгэх, сургаж дадлагажуулах, туршлага судлуулах арга хэмжээг цахим болон танхимаар 6 удаа зохион байгуулж байгууллаа. | |
| 7 | | 7. Ундны усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаалах | 2021 - 2024 | 40 | бохирдлоос хамгаалсан удны усны эх үүсвэрийн тоо | | 40 | Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг 10 худагт шинээр тогтоож хашаажуулж, тэмдэгжүүлэх ажил хийгдэж тус ажлыг 100,0 хувь гүйцэтгэсэн. Хүн амын ундны усны эх үүсвэрийг шинжилгээнд хамруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, усны аюулгүй байдлыг хангах зорилгоор 14 сумын унд ахуйн хэрэглээний давхардсан тоогоор 95 цэгээс дээж авч, Мэргэжлийн лабораторид 82, Улаанбаатар хотын Геологийн төв лабораторид 6 дээж, "Ханлаб" лабораторид 7 дээжийг шинжлүүлсэн. Сайншанд, Замын-Үүд, Айраг сумдын ЕБ-ын 9 сургууль, 20 цэцэрлэгийн унд ахуйн хэрэглээний уснаас 54 сорьц авч, Мэргэжлийн хяналтын газрын сорилт шинжилгээний лаборатортид шинжлүүлж, шаардлага хангаагүй 2 ундны усыг илрүүлж, 11 дүгнэлт, 8 зөвлөмж хүргүүлсэн. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр аймгийн "Ус, ариун цэврийн аюулгүй байдлыг ханган ажиллах нэгдсэн төлөвлөгөө" боловсруулж, жишиг загвар боловсруулахаар зөвлөх, мэргэшсэн инженер, эрүүл ахуйч зэрэг 8 хүний бүрэлдэхүүнтэй баг байгуулан ажиллаж байна. Өргөн, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан сумдын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | худгийн хамгаалалтын бүстэй 131 газар давхцалтай байгаа тул давхцалыг арилгуулах ажлыг сумдын Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлэн ажиллалаа. Сумдад усны сан бүхий газар ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, түүний ойр орчмын газрын хог хаягдлыг цэвэрлэх ажилд 200 ААНБ, 3500 иргэн, ажилтан, албан хаагчид оролцон 2500,0 га талбайн ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 29 автомашин техник хэрэгслээр 470,0 тн хог хаягдлыг цэвэрлэж эх үүсвэрийг бохирдохоос сэргийлсэн. | |
| 8 | | 8. Сургуулийн багш, сурагч, ажилтнуудыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулах | 2021 - 2024 | 0.8 | - | | 0.85 | Аймгийн нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын эмнэлгээр дамжуулан ЕБС-ийн 627 багш, ажилтан, цэцэрлэгийн 511 багш, ажилтан нийт 1138 хүнийг сургууль, цэцэрлэгийн багш, ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулсан. Үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 554 багш, ажилчид, хеликобактерийн шинжилгээнд 682 хүн хамруулж 93 буюу 13.6% нь эерэг, бамбайн даврын шинжилгээнд 119 хүн хамруулж 6.7% нь өөрчлөлттэй, дууны хөвчийн дурангийн үзлэгт 47 хүн хамрагдсанаас 100% өөрчлөлтгүй зэрэг тус тус дүн гарсан. Үзлэгт хамрагдсан болон өөрчлөлт илэрсэн багш, ажилчдад эрүүл ахуйн болон эмчилгээний талаар зөвлөгөө өгч, нарийн мэргэжлийн эмчид дахин үзүүлж эрүүлжих арга хэмжээ авахыг зөвлөсөн. Цэцэрлэгийн хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулж төрийн болон төрийн бус өмчийн нийт 42 цэцэрлэгийн 5197 хүүхэд үзлэгт хамрагдахаас 4058 буюу 78.1 хувьтай хамрагдсан. Нийт хүүхдийн 2668 хүүхэд буюу 65.7% нь эрүүл, 1398 хүүхэд буюу 34.4 хувь нь өвчлөлтэй илэрсэн ба дараагийн шатлалын эмчийн үзлэгт 42 хүүхдийг илгээсэн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байна. | |
| 9 | 1.1.2. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ ний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана. | 9. Эрүүл мэндийн байгууллагуудын хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх | 2021 - 2024 | 0.05 | | | 0.15 | Эрүүл мэндийн байгууллагууд Коронавируст халдварын үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийн мэдээллийг "burtgel.mohs.mn", "Google drive" зэрэг программд 7 хоног бүр тогтмол оруулж, эрүүл мэндийн газар болон эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нөөцийн бэлэн байдалд хяналт тавьж, нөөц багассан эм, эмнэлгийн хэрэгслийн хугацааг алдалгүй бүрдүүлж, улсын хэмжээнд тасалдал үүсээд байсан "Окситоцин" эмийг 3 удаагийн татан авалтаар 1570 ширхгийг авч эмнэлгийн тусламж үйлчилгээнд тасалдал үүсгэлгүй ажилласан. Мөн ЭМС-ын тушаал, ЭМГ-ын гамшгийн нөөц хөрөнгөөс 18 эрүүл мэндийн байгууллагуудад "Ковид 19" илрүүлэх түргэвчилсэн оношлуур, хросол, амьсгалын багтаамж хэмжих тоног төхөөрөмж нийт 165 сая төгрөгийн эм, багаж, тоног төхөөрөмжийг хуваарилж нөөцийг нэмэгдүүлэн, ЭМБ-ууд Коронавируст халдварын үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн 2 сарын нөөцтэй байна. | 100% |
| 10 | | 10. Сайншанд суманд зоонозын өвчин судлалын тандалтын нэгж байгуулах | 2021 - 2024 | 0 | нэгжийн тоо | | 2 | Монгол улсын Засгийн газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Зоонозын төвгүй аймгуудыг төвтэй болгох зорилгоор МУ-ын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/18 дугаар тушаалаар 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад 26,0 сая төгрөг тусгаж, Хүн амын суурьшил ихтэй Сайншанд сумын төвдөө “Зоонозын төв”-ийг байгуулах чиглэл ирсэн. Үүний дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын 2-р багт "Зоонозын төв" байгуулах чиглэл ирж, Зоонозын төв байгуулах барилгын газрыг орон нутгийн “Газар зохион | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгууллалтын 2023 оны төлөвлөгөө”-нд тусгуулж, Эрүүл мэндийн яамруу “Батлагдсан нэг маягийн зураг”-т холболтыг зургийн даалгавар хүргүүлснээр барилгын зураг төслийг 2023 онд багтаан хийж, 2024 онд барилгын үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж байна. Сайншанд суманд – “Зоонозын төв”-ийг байгуулснаар Замын үүд, Ханги хилийн боомтуудад “Зоонозын тандалтын нэгж”-үүдийг салбарлан байгуулахаар төлөвлөж, ЭМГ-т Зооноз хариуцсан нарийн мэргэжлийн эмчийг сургаж, хүний нөөцийг бэлтгэж байна. Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн Эмгэг судлалын лабораторид тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл худалдан авч, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 182.0 сая төгрөгийг тусгуулсан | |
| 11 | | 11. Сайншанд сум болон Ханги хилийн боомтыг РТ-ПСР оношлуулаар хангах | 2021 - 2024 | 0 | оношлуурын тоо | | 300 | Халдварт өвчин судлалын үндэсний төвийн нэгдсэн лабораторийн баг аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийж, 12 эмч мэргэжилтнүүдийг ажлын байрны сургалтад хамруулж, арга зүйгээр ханган ажилласнаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн молекул биологийн лаборатори нь "Бүсийн лавлагаа лаборатори" болж, олон төрлийн томуугийн вирус илрүүлэх шинжилгээг орон нутагтаа хийх боломжтой болсон. Аймгийн болон Замын Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт нийт 107,8 сая төгрөгийн лабораторийн оношлуурыг худалдан авч, 10111 ширхэг оношлуурын нөөцтэй байна. Орон нутгийн төсвийн 121,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ханги хилийн боомтод “Молекул биологийн лаборатори”-ийг байгуулахаар дагалдах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тендер шалгаруулалтад “Медбуян ХХК” шалгарч 23 нэр төрлийн 70 ширхэг тоног | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төхөөрөмжийг нийлүүлж, тоног, төхөөрөмжийг ажиллуулах сургалтыг зохион байгуулан хүлээлгэн өгсөн. Одоогоор Ханги боомтод ПСР-ийн шинжилгээ хийгдээгүй бөгөөд тандалтын зорилгоор Хатанбулаг сумын Ханги, Замын-үүд сумын хилийн боомтын ажилчид, оршин суугч, хилээр нэвтрэх явган зорчигч, автобусны жолооч нараас 14 хоногт 1 удаа түүврийн аргаар 141 хамар залгиурын сорьцыг авч ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид хувилбарын тандалтад илгээж, лабораторид суурилсан тандалтыг тасралтгүй үргэлжлүүлж халдвар зөөвөрлөгдөхөөс сэргийлж ажилласнаар Ковидын халдварын тархалт, хүндрэл бүртгэгдээгүй байна. | |
| 12 | | 12. Шуурхай арга хэмжээний хамтарсан багийг чадавхжуулан, ажиллах нөхцөл, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах | 2021 - 2024 | 1/34 | - | | 2/68 | Аймгийн түвшинд “Томуугийн цар тахлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний чиглэл”-ээр хэлэлцүүлэг, ширээний дасгал сургуулилтыг зохион байгуулан, томуугийн цар тахлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, жишиг төлөвлөгөө гаргах зорилгоор ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт судалгааны баг сургалт зохион байгуулсан. Тус сургалтад ЭМГ, АНЭ, ЗҮНЭ, ӨСЭМТ, БШУГ, ОБГ, МЭГ зэрэг байгууллагуудын нийт 17 мэргэжилтнүүдийг хамруулж, салбар хоорондын төлөвлөгөөг гаргаж, ажлын уялдаа холбоог сайжруулж ажилласан. Шуурхай удирдлагын нэгжид Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/60 дугаар тушаалын дагуу Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгээр 39.5 сая төгрөгний 6 төрлийн тоног төхөөрөмж хуваарилсныг татан авч, бэлэн байдлыг хангасан. | 90% |
| 13 | 1.1.3. “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай | 13. Орон нутгийн төсвийн нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 0.25 | төсөв нэмэгдүүлэлтийн хувь | | 0.2 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т заасны дагуу Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн төсөвт 50.0 сая | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ | | | | | | | төгрөг, аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулахаар орон нутгийн төсөвт өмнөх жилээс 2 дахин их буюу 1,2 тэрбум төгрөг тусган 655,8 сая төгрөг буюу 54 хувийг зориулалтын дагуу зарцуулсан. Аймгийн Засаг даргын 2023 оны А/146 дугаар захирамжаар гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулахад 15.9 сая төгрөгийг орон нутгийн төсвийн нөөц хөрөнгөөс зарцуулсан. Онцгой байдлын ерөнхий газар, БНСУ-ын Сөүл хотын Гал, гамшгийн удирдах газрын хамтын ажиллагааны хүрээнд тус улсын “Good Neighbors International” олон улсын ТББ-аас буцалтгүй тусламжаар Онцгой байдлын газарт хуваарилсан түргэн тусламжийн "Старекс" маркийн автомашины гаалийн нэмэгдсэн өртгийн албан татвар, бусад холбогдох төлбөр хураамжийн зардал болох 938.2 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын 2023 оны А/236 дугаар захирамжаар шийдвэрлүүлсэн. | |
| 14 | | 14. Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлыг төсөвт тусгах | 2021 - 2024 | 150 сая төгрөг | хөрөнгийн хэмжээ | | 350 сая | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т заасны дагуу Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн төсөвт 50.0 сая төгрөг, орон нутгийн төсөвт гамшгаас хамгаалах зардал 1.2 тэрбум төгрөгийг тусган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Иххэт, Даланжаргалан, Айраг сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулийг 2023 оны 04, 09 дүгээр сард, Алтанширээ суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 04 дүгээр сард, Улаанбадрах суманд Команд штабын сургуулийг 04 дүгээр сард тус тус зохион байгуулсан. Гамшгаас хамгаалах дадлага, сургуульд дээрх 5 сумын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн 329 томилгоот бүрэлдэхүүн, 594 иргэн, 71 техник хэрэгсэлтэйгээр ажиллан ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, аж ахуй нэгж, байгууллагын удирдлагын зүгээс сургуулийн бэлтгэл ажлыг сайн хангасан, нөөц бүрдүүлэлт, гамшгаас хамгаалах бүтээлч ажил, санал санаачлагыг харгалзан үзэж шалгасан.  Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхыг дээшлүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/146 дугаар захирамжаар “Гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах”-д 15,9 сая төгрөгийг шийдвэрлэж зарцуулсан. | |
| 15 | | 15. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинэчлэн барьж, ашиглалтад оруулах | 2021 - 2024 | 0 | агуулахын тоо | | - | Ковид-19 халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд Сайншанд сумын 3 дугаар багт "Тотал дистрибюшин" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар хүнсний агуулахын барилгыг ашиглалтад хүлээн авсан.  “Тотал дистрибюшн” ХХК-ны 750мкв талбайтай, 60 гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан нөхцөлд нөөцлөн Дорноговь аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг тасралтгүй хангаж байна. | 100% |
| 16 | | 16. Замын-Үүд, Ханги авто замын шалган нэвтрүүлэх боомтод ариутгал, халдваргүйтгэлийн байгууламжийг байгуулах | 2021 - 2024 | 0 | ариутгал, халдваргүйтгэлийн байгууламжийн тоо | | - | Монгол Улсын Засгийн газрын 350,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ариутгалын байгууламжийг худалдан авч 2021 онд Замын-Үүд боомтын экспорт, импортын зам дээр 2 байгууламжийг, орон нутгийн хөгжлийн сангийн 240.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ханги боомтын автозамын шалган нэвтрүүлэх хэсгийн экспорт, импортын 2 зурваст халдваргүйтгэлийн байгууламжийг тус тус суурилуулсан. | 100% |
| 2. Хүний хөгжлийн бодлого | | | | | | | | | |
| 17 | 2.1.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс | 17. "Халдварт бус өвчинтэй тэмцэх” | 2021 - 2024 | ЭМСС-д хамрагдсан хүний тоо 54236, | ЭМСС-д хамрагдсан хүний тоо, үзлэгт | | 55000/4800 | Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, ард иргэдийг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх, иргэн бүр эрт илрүүлгийн үзлэг, оношил гоонд тогтмол хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн боловсрол-ыг дээшлүүлж, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүү-лэх арга хэмжээг хэрэгжүүлнэ | аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд “Эрүүл, идэвхтэй амьдрал” зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл мэндийн зөв мэдлэг дадлыг төлөвшүүлэн халдварт бус өвчнийг илрүүлэх явуулын үзлэг зохион байгуулах | | үзлэгт хамрагдсан хүний тоо 4197 | хамрагдсан хүний тоо | | | хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зэрэг чиглэлийн хүрээнд “Эрүүл хоол–Хөдөлгөөн эрүүл мэнд”, “Ажлын байрны Түмэн дасгал”, “Энэ жилдээ-Эрүүл жиндээ”, “Гэр дүүрэн инээмсэглэл”, “Сэтгэцийн эрүүл мэнд”, “Ахмадын эрүүл мэнд”, “Гүзээгүй монгол”, “Хамтдаа сэргийлье” зэрэг 23 удаагийн аян, арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 23601 хүнийг хамруулснаар өмнөх оны мөн үеийнхээс 9656 хүнээр нэмэгдсэн. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээ оношилгоонд 28174 иргэн хамруулж, хамрагдвал зохих хүн амын 40.1%-ийг эзэлж байгаа нь улсын дунджаас 3.0%-иар, аймгуудын дунджаас 5.5%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Үзлэгийн 64.8% (17421)-ийг 0-17 насны хүүхэд, 35.2% (9463)-ийг 18-аас дээш насны хүн ам эзэлж байна. Үзлэгээр шинэ өвчлөлийн 6080 тохиолдол бүртгэгдсэнээс 16 хавдар батлагдан эмчилгээнд хамруулсан. Уг арга хэмжээний хүрээнд 5 зорилт, 30 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан батлуулж төлөвлөгөөний хэрэгжилт 95.6 хувьтай байгаа нь өмнөх оны хэрэгжилтээс 4.4%-иар өссөн байна. Тайлант онд 4569 удаагийн өдөрлөг, сургалт, сурталчилгааг зохион байгуулж, давхардсан тоогоор 207 байгууллагын 67664 хүн хамруулж, 238 төрлийн 18895 зөвлөмж тараан, цахимд 4508 төрлийн мэдээлэл байршуулж, 105236 хандалт авсан нь өмнөх оны мөн үеэс 113 удаагийн сургалт арга хэмжээ, 5233 хүнээр нэмэгдсэн. | |
| 18 | | 18. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлж, идэвхтэй тандалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулах | 2021 - 2024 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 85,1 Идэвхитэй тандалтанд хамрагдсан хүний тоо 26043 | өлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Идэвхитэй тандалтанд хамрагдсан хүний тоо | | 89%/26600 | Дархлаажуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх “Улаанбурханы халдвараас сэргийлье” 2 сарын аянг зохион байгуулж, дархлаажуулалтаас хоцорсон 346 хүүхдийг нөхөн дархлаажуулж, 118 аж ахуйн нэгж байгууллагын 2076 ажилтан албан хаагчид, 1718 эцэг эхэд сурталчилгаа | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хийж 1362 ширхэг гарын авлага тараасан. Мөн 260 удаа цахимаар мэдээлэл хүргэн 2344 хандалт авч, эдгээр үйл ажиллагааны үр дүнд заавал хийх дархлаажуулалтын хамралт 90%-д хүрсэн. Хоолны хордлого, гэдэсний халдвар, усны аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, стандарт жорлон барьж ашиглах зорилгоор "Аюулгүй хүнс-Эрүүл бие", "Дэлхийн усны өдөр" сарын аян зохион байгуулж 71 удаагийн сургалт сурталчилгаанд 991 айл өрх, 4237 хүн хамрагдаж, 82 төрлийн 4495 ширхэг гарын авлага тарааж, цахимаар 220 төрлийн мэдээлэл зөвлөмжийг түгээж 70889 хүн хандалт авсан. Сүрьеэгийн идэвхтэй тандалтыг эрчимжүүлснээр 6545 хүн хамруулж 54 шинэ сүрьеэг илрүүлсэн. БЗДХ-ын идэвхтэй тандалтад нийт 5461 иргэнийг хамруулж, шинээр 265 БЗДХ-ыг илрүүлж, 10000 хүн амд ногдох БЗДХ 37,0 болж өмнөх оны мөн үеэс 1,8 хувиар буурсан. Эрт илрүүлгийн үзлэгээр ДОХ/тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээнд нийт 1562 иргэн хамруулж 94 хүнд зөвлөгөө өгсөн. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд халдварт өвчин 10000 хүн амд 194,7 промиль болж өмнөх оны мөн үеэс 1043,3-аар буурсан. "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ"-ний төлөвлөгөөг 39 заалттай боловсруулан баталж 2023 онд 91,6%-тэй хэрэгжүүлсэн. | |
| 19 | | 19. "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" зорилтод хөтөлбөрийн хүрээнд эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг хөгжүүлэх, эмгэг нярайн тасгийг байгуулж, зайн оношилгоо, зөвлөгөөг | 2021 - 2024 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 95, Нярайн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь 54 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, Нярайн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь | | 97%/67% | "Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг 92.6 хувьтай биелүүлсэн. Аймгийн хэмжээнд жирэмсний хяналтад 1157 эмэгтэйчүүд орж, эрт үеийн хяналт 90.5%-д хүрсэн. "Жирэмсний хяналтыг сайжруулж, дутуу төрөлт, ургийн өсөлтийн саатлыг бууруулах"- 2 сарын аянг хэрэгжүүлснээр бага жинтэй нярай 3, дутуу төрөлт 5 тохиолдлоор | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | өргөжүүлж, эх нярайн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | | тус тус буурсан.  Гепатит В вирустай 6 тохиолдол илрүүлж,10 нярайд иммуноглобулин эмчилгээг хийсэн. БЗДХ-тай 12 эхийг илрүүлэн эрүүлжүүлж, төрөлхийн тэмбүү 1 бүртгэгдсэн нь 10000 хүн амд 0.1 байна. Жирэмсэн эхчүүдэд зориулсан сургалтыг 101 удаа зохион байгуулж, нийт 2960 хүнийг хамруулж, 39 төрлийн 1405 сурталчилгааны материал тараасан. Эх барих эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмч нарын 183 зөвлөгөө, мэдээллийг “Бүүвэй ертөнц”, "Дорноговь жирэмсэн эхчүүд" эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан түгээж давхардсан тоогоор 5307 хүний хандалтыг авч иргэдийн мэдлэгийг дээшлүүлсэн.  ЭМЯ, ДЭМБ-тэй хамтран ОХУ-ын санхүүжилтээр “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулснаар эх нярай, хүүхдийн эндэгдлийг бууруулах” төслийг Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгт 3 дахь жилдээ хэрэгжүүлж ОХУ-д эх барих эмэгтэйчүүд, нярайн эмч нарыг 2, ЭХЭМҮТ-т ажлын байрны 14 хоногийн сургалтад 9 эмч мэргэжилтнийг, 12 удаагийн богино хугацааны сургалтад 212 эмч мэргэжилтнийг, шинээр төгссөн 38 залуу эмч, мэргэжилтнүүдийг төрөх хүүхдийн тасагт ажлын байрны дадлагажих сургалтад тус тус хамруулсан.  АНЭ-ийн нярайн тасагт 2 нярайн эмч ажиллаж, нярайн эрт илрүүлэг оношилгоонд түнхний ЭХО, дутуу нярайд ретинопатия илрүүлэх оношилгоог, дутуу нярайд сурфактант эмчилгээг амжилттай хийж байна. Дээрх үр дүнд 1000 амьд төрөлтөд ногдох перинаталь эндэгдэл 10.0 промильд хүрч, улс, аймгуудын дунджаас 0.3 промилоор доогуур үзүүлэлттэй гарсан. Нярайн нэн шаардлага тоног төхөөрөмжийн хангалт 95%-тай байна. “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хэмжээ төлөвлөгөөний хэрэгжилт 97.1%-тай хэрэгжсэн. | |
| 20 | | 20. “Хавдрын эсрэг" арга хэмжээг хэрэгжүүлж хавдрын эрт илрүүлэг, үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан хүний тоо-35852 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан хүний тоо, | | 82.5%/36000 | Хавдрын 3 төрлийн эрт илрүүлэг үзлэгт 7258 хүн хамрагдаж, дундаж хамралт 17.4%-д хүрч, шинээр умайн хүзүүний хорт хавдар 1 тохиолдлыг эрт үед нь илрүүлсэн. “Хавдрын эсрэг дэлхийн өдөр”-ийн хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөгийн зохион байгуулж нийт 166 иргэнд үйлчилгээ үзүүлж 12 төрлийн 150 ширхэг гарын авлага тараасан. Эмнэлгийн байгууллагууд 65 удаагийн сургалт сурталчилгаанд 2850 хүнийг хамруулан, 32 төрлийн 1954 зөвлөмж сэрэмжлүүлэг, цахимаар 32 төрлийн мэдээлэл түгээж 7800 хандалт авсан нь өмнөх оноос 160 хандалтаар өсөж иргэдийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлсэн. МЭХ-той хамтран "Хавдаргүй Монгол эмэгтэй" төслийн хүрээнд 14 сумын хөх, умайн хүзүүний хавдар илрүүлэх үзлэгийг 3344 эмэгтэйд хийж, хорт хавдартай 5, хавдрын сэжигтэй 64 эмэгтэйг илрүүлэн лавлагаа шатлал руу илгээсэн. Нийт 106 хавдар, 64 нас баралт бүртгэгдсэн 2020 оны мөн үетэй харьцуулахад эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг нэмэгдсэнтэй холбоотойгоор өвчлөл 10 тохиолдол, нас баралт 15 тохиолдлоор буурсан. Шинээр илэрсэн өвчлөлийн 36.6% нь эрт үедээ оношлогдож, хавдрын эмчийн хяналтад 467 хүн байгаагийн 37.9% нь 5-аас дээш жил амьдарч байгаа нь хавдар эрт шатандаа оношлогдсоноор амьдрах чадвар тодорхой хэмжээгээр уртасч байгаа үр дүн харагдаж эхэлсэн нь 2020 оны мөн үетэй харьцуулахад хяналтын хүн 37 хүнээр, эрт үедээ илэрсэн нь 2.1%-иар, 5-аас дээш жил амьдарч байгаа хүн 0.9%-иар тус тус өссөн үзүүлэлтэй байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Хавдрын тасаг 2 их эмчтэй, 10 ортой ажиллаж, полихими эмчилгээг нэвтрүүлж, уг эмчилгээнд 270, хими эмчилгээнд 81 | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүнийг хамруулсан. “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөөг 86.1%-тай хэрэгжүүлэн ажиллалаа. | |
| 21 | | 21. “Элэг бүтэн Монгол” зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлж, оношилгоо, эмчилгээний хамралтыг сайжруулах | 2021 - 2024 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 70 Оношилгооны хамрагдалтын хувь 35 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Оношилгооны хамрагдалтын хувь | | 83% 51,8% | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний 2023-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 85%-тай байна. 2020 онд В, С илрүүлэг шинжилгээнд 397 хүн хамруулж, хамралтын хувь 1.9% байна, 2023 онд В, С вирусийн илрүүлэг шинжилгээнд 10776 хүнийг хамруулж, хамрагдвал зохих хүн амын 22%-ийг эзэлж, 2020 оноос 20.1%-иар нэмэгдсэн байна. Шинжилгээнд хамрагдсан иргэдээс В вирусийн халдвартай 241 хүнийг, С вирусийн халдвартай 194 хүнийг тус тус илрүүлсэн. Тухайн арга хэмжээний хүрээнд 17 удаагийн сургалт, сурталчилгаанд 896 хүнийг хамруулж, 32 төрлийн цахим мэдээллийг түгээж 642 хүний хандалт авч, 11 төрлийн гарын авлагыг хэвлүүлж 505 хүнд тараасан. Тархвар судлалын заалтаар элэгний В вирустэй эхээс төрсөн 18 нярайд В гепатитын иммуноглобулин эмчилгээг хийж, хяналтандаа авснаар хүүхдүүдэд халдвар илрээгүй байна. В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтэд сурталчилснаар дархлаажуулалтад шинээр 30 хүн, давтан тунд 87 хүн тус тус хамрагдсан. Эхээс төрсөн нярайг В гепатитын иммуноглобулинаар тарих үйл ажиллагааг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад тасралтгүй зохион байгуулж, бэлэн байдлыг хангах зорилгоор 30 тун вакциныг татан авч нөөц үүсгэсэн. Цочмог гепатитын 2 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 0.3 ногдож, 2020 оны мөн үеэс 0.1-ээр буурчээ. | 90% |
| 22 | | 22. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлж, | 2021 - 2024 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, Урьдчилан | өлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, Урьдчилан сэргийлэх | | 70% 75/750 | “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих сарын аян”-ны хүрээнд ’Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд’’ нээлттэй | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх | | сэргийлэх үзлэгт эрэгтэй ажилчдаа хамруулсан байгууллага/ хүний тоо 57/520 | үзлэгт эрэгтэй ажилчдаа хамруулсан байгууллага/ хүний тоо | | | хаалганы өдөрлөгийг зохион байгуулж УНТЭ-ийн Андрологи-урологийн нарийн мэргэжлийн эмч нарын багийг урьж ажиллуулан нийт 150 иргэнд үзлэг, шинжилгээ хийж, 50 гаруй өвчлөл илрүүлэн 2 иргэнд мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлсэн. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнддээ тавих анхаарал хандлага өөрчлөгдөж, халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт 27207 хүн хамрагдсанаас 44,6%-ийг эрэгтэйчүүд эзэлж, үүнээс цэргийн насны 987 эрэгтэйг үзлэгт хамруулсан. Явуулын амбулаторийн үзлэгт 6 сумын давхардсан тоогоор 6100 хүн хамрагдсанаас 39,1% нь эрэгтэйчүүд эзэлсэн нь “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” сургалтыг эрэгтэйчүүд олноор ажиллаж буй байгууллагын албан хаагчдад 8 удаа цахим болон танхимаар зохион байгуулж, 5889 эрэгтэйг хамруулж, 310 төрлийн мэдээллийг цахим хаягуудад байршуулан 10425 хандалт авч, шинээр 135 төрлийн гарын авлагыг хэвлэн 3357 хүнд тараасан. Хилийн цэргийн 0168 дугаар анги, анхан шатны амилуулах суурь тусламж үзүүлэх сургалт, дадлагыг зохион байгуулж цэргийн ангийн 30 албан хаагчийг хамруулж чадавхжуулж, тус ангид шүдний эмчийн явуулын үзлэг зохион байгуулж, 144 хүн хамруулан, өвчтэй 139 хүнийг илрүүлж, 57%-г эрүүлжүүлсэн. Хилийн цэргийн 0168 дугаар анги, ЗХ-ний 253-р анги, Замын-Үүд сумын Цэрэгжүүлсэн хамгаалалтын анги зэрэг 3 байгууллагын 98 албан хаагчдад ‘’Дархлаажуулалт’’, ‘’Давсаа хасъя”, ‘’Нөхөн үржихүйн эрүүл мэнд’’ сэдвээр сургалт хийж, мэдээлэл өгсөн. ЗХ-ний 253-р ангийн 14 албан хаагчдыг ДОХ/Тэмбүү, элэгний B,C вирусийг илрүүлэх урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулж, элэгний B вирусын 1 тохиолдол шинээр | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | илрүүлж, хяналтад авсан. цэргийн анги,ЗХ-ний 336 дугаар ангийн давхардсан тоогоор 601 албан хаагчдыг явуулын амбулаторийн үзлэгт хамруулсны 71.3%-ыг эрэгтэйчүүд эзэлж байгаа нь 2020 оны мөн үетэй харьцуулахад цэргийн насны залуучуудын үзлэгт хамрагдалт 63 хүнээр буюу 7.5 хувиар өссөн. "Эрүүл чийрэг эр хүн'' төлөвлөгөөг 95%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. | |
| 23 | | 23. “Эрүүл шүд” зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлж, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэлтийг нэмэгдүүлэх, амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг дадлыг олгох сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, Хамрагдсан хүний тоо 10765 Эрүүлжүүлэлтийн хувь 84 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, Хамрагдсан хүний тоо Эрүүлжүүлэлтийн хувь | | 95% 11500 87% | Иргэдэд “Амны хөндийн эрүүл ахуйн зөв мэдлэг дадал төлөвшүүлэх” 285 удаагийн сургалт, сурталчилгаанд 11259 хүүхэд, эцэг эхчүүдийг хамруулж, цахим орчинд 106 төрлийн мэдээлэл байршуулж, 3261 хүний хандалт авч, 38 төрлийн 2893 ширхэг зөвлөмж, санамж, гарын авлага тарааж, иргэдэд мэдлэг олгосон. “Шүд угаалтын аварга шалгаруулах” тэмцээнийг анх удаа орон нутагт зохион байгуулж, 72 сурагч хамруулсан. Хувийн хэвшлийн 7 шүдний эмчийг нийгмийн хариуцлагын дагуу 2 суманд ажиллуулж, 471 хүнийг үзлэгт хамруулж, өвчлөлтэй 399 хүний 675 шүдэнд эмчилгээ хийж 76% эрүүлжүүлсэн. Аймгийн Засаг даргын 2023 оны А/228 дугаар захирамжийн дагуу нөөц хөрөнгөөс 29.7 сая төгрөг шийдвэрлүүлж, 13 суманд шүдний эмчийн явуулын үзлэг хийхээр төлөвлөж, одоогоор 11 суманд зохион байгуулж, 2710 хүнийг хамруулснаас 2161 нь хүүхэд байсан. Үүнээс 5170 шүдэнд эмчилгээ хийж, 1931 хүнийг /71.9/ эрүүлжүүлсэн үр дүнтэй ажилласан. Эрүүл мэндийг дэмжих бүлгэмийн дэмжлэгтэйгээр ХХ-ийн 2 эмнэлэгтэй хамтран 7 цэцэрлэгийн 299 хүнд “Амны хөндийн эрүүл мэнд” сэдвээр сургалт зохион байгуулж мэдлэгийг дээшлүүлсэн. Орон нутагт Шүдний 2 хувийн эмнэлэг шинээр нэмэгдэж, хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүд орон нутагт хийгддэггүй гажиг засал, мэс заслын чиглэлээр | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | эмчилгээг нэвтрүүлсэн. "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” дэд хөтөлбөрийн хүрээнд хувийн хэвшлийн 7 шүдний эмчийг нийгмийн хариуцлагын дагуу Айраг, Зүүнбаян сумдад 7,7 хоногоор ээлжлэн ажиллуулж, 1105 хүнд үзлэг хийж, шүдний өвчлөлтэй 954 хүний 1654 шүдэнд эмчилгээ хийж 92.4% эрүүлжүүлж, ЭМД сангаас 73.8 сая төгрөг зарцуулсан. Төр, хувийн хэвшлийн 12 шүдний эмнэлэг, кабинетаар 0-18 насны нийт 15098 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 9473 хүүхэд буюу 90.7%-ийг эрүүлжүүлж, ЕБС-ийн Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлж буй ангиудад “Ангидаа шүдээ угаах” уриалгыг гаргаж, хэвшүүлсэн. Хүүхдийн шүдний үзлэгийг 2020 онтой харьцуулахад 8880 хүүхдээр, эрүүлжүүлэлт 2.2%-иар тус тус нэмэгдэж, 4 зорилт, 28 үйл ажиллагааны хүрээнд хэрэгжилт 96,8%-тай байна. | |
| 24 | 2.1.2. Орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ-ний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэнхувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг бодлогоор дэмжиж орон нутагтаа оношлогдон, эмчлүүлэх боломжийг бий болгоно | 24. Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, автомашины парк шинэчлэлийг хийж тусламжийн чанар хүртээмжийг сайжруулах | 2021 - 2024 | Шинэчлэгдсэн авто машины тоо 7 | Шинэчлэгдсэн авто машины тоо | | 1 | Яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт шинээр 23.2 сая төгрөгийн 7 төрлийн тоног төхөөрөмж нэмэгдсэнээр анхан шатанд 91,6%, лавлагаа шатлалд 98%-д хүрч өмнөх оноос 3.4%-иар, 2020 оноос нэмэгдэж, анхан шатны ЭМБ-д 100% хүчилтөрөгч өтгөрүүлэгч, монитор, тарианы шахуурга, 58,8% нь дефибрилятортой болсноор амилуулах болон лавшруулсан тусламж үйлчилгээг үзүүлэх чадавх бэлэн байдал сайжирсан. Яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт 2020 оноос анхан шатанд 14.4%, лавлагаа шатлалд 7.6%-иар нэмэгдсэн байна. ДЭМБ, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар бүх ЭМБ-дад спиромертийн аппараттай болж, эмч нарыг сургалтад хамруулснаар эмнэлгүүдийн яаралтай тусламжийн хүний нөөцийн чадавх, тоног төхөөрөмжийн хангалт сайжирсан. Лавлагаа шатлалын 2 эмнэлэг болон автозам дагуу байрлах Айраг, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Даланжаргалан сумдын ЭМТ-д орон нутгийн болон хандив тусламжийн хөрөнгө оруулалтаар бүрэн тоноглогдсон эмнэлгийн яаралтай тусламжийн автомашинтай болсноор анхан шатны ЭМБ-ууд 1-3, Нэгдсэн эмнэлгүүд 8-13 автомашинтай, болж, автомашины хангалт 2020 онтой харьцуулахад лавлагаа шатлалд 90%, анхан шатлалд 88 хувьтай байна. Осол гэмтлийн шалтгаан нас баралт өмнөх оны мөн үеэс 8,7%-иар, 2020 онтой харьцуулахад 6,3%-иар буурсан үзүүлэлттэй байна. | |
| 25 | | 25. Босоо тэнхлэгийн автозам дагуух эрүүл мэндийн байгууллагуудын осол гэмтлийн үеийн яаралтай тусламж үзүүлэх чадавхийг сайжруулах | 2021 - 2024 | Яаралтай тусламжийн нэн шаардлагатай тоног төхөө рөмжийн хангалтын хувь 80,2 | Яаралтай тусламжийн нэн шаардлагатай тоног төхөө рөмжийн хангалтын хувь | | 83% | Осол гэмтэл ихээр гардаг замын хэсэг буюу “Хар цэг”-ийн судалгаанд Айраг сумын 64 дугааэр зөрлөг, Алтанширээ 35-34 дүгээр зөрлөг, Эрдэнэ сумын Хангинуурын даваа, Замын-Үүд сумын нартын хошуу гэсэн 4 хар цэг багтсан байдаг. Эдгээр хар цэгүүдийн ойролцоох эмнэлгийн ажилчдыг чадавхжуулахаар аймгийн нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламж, гэмтлийн эмч нартай хамтран “Осол гэмтлийн үеийн яаралтай тусламж үйлчилгээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж, нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг эмнэлгүүдэд олгосноор тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж, осол гэмтлийн шалтгаан нас баралт өмнөх оны мөн үеэс 8,7%-иар, 2020 онтой харьцуулахад 6,3%иар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант онд яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалтыг 23.2 сая төгрөгийн үнэ бүхий 7 төрлөөр нэмэгдүүлж дунджаар анхан шатанд 91,6%, лавлагаа шатлалд 98%-д хүрч өмнөх оноос 3.4%-иар нэмэгдэж, анхан шатны ЭМБ-д 100% хүчилтөрөгч өтгөрүүлэгч, монитор, тарианы шахуурга, 58,8% нь дефибрилятортой болсноор амилуулах болон лавшруулсан тусламж үйлчилгээ үзүүлэх чадавх бэлэн байдал сайжирсан | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | | 26. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтыг шат дараатай нэмэгдүүлж, сум орон нутагтаа оношлуулж эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх | 2021 - 2024 | Лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 52 | Лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | | 68% | Сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийг биохими, шээсний хагас анализатортай болгох, эмч нарыг дүгнэлт гаргах чадварыг дээшлүүлэх, лабораторийн шинжилгээний нэр төрөл, хүртээмжийг сайжруулах зорилгоор Эрдэнэ, Хөвсгөл, Даланжаргалан, Алтанширээ, Улаанбадрах, Иххэт сумдад 1-3 төрлийн 108,2 сая төгрөгийн аппараттай болсон. Сайхандулаан, Өргөн сумд лабораторийн тоног төхөөрөмжгүй байна. Лабораторийн эмч, мэргэжилтнүүдэд "ISO 15189:2015 стандарт, магадлан итгэмжлэл, лабораторийн өнөөгийн байдал" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 45 лаборант нарыг хамруулан, чадавхжуулсан. Сайншандын ӨЭМТ-үүд ОНХС-ийн 43,1 сая төгрөгийн Мобайл төхөөрөмж нийлүүлэгдсэнээр анхан шатны ЭМБ-ууд 100% Мобайл төхөөрөмжтэй болж, иргэд хаана байхаас үл хамааран анхан шатны эмнэлгүүд дээрээ "ЭХО", "Зүрхний цахилгаан бичлэг" зэрэг 8 төрлийн цусны шинжилгээ өгөх нөхцөл бүрэн бүрдсэн. Анхан шатанд лабораторийн тоног төхөөрөмжийн хангалт 2023 онд 15.7%-аар нэмэгдэж, 80.7%-д хүрсэн ба 2020 оноос 17.3%-иар буюу 176,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж нэмэгдсэн байна. | 100% |
| 27 | | 27. Лавлагаа шатлалд орчин үеийн болон нэн шаардлагатай оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, хангалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь 84,2 | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | | 87% | Аймгийн нэгдсэн эмнэлэг ходоодны дурангийн иж бүрдэл, мэс заслын өрөөний тоног төхөөрөмж, мэс заслын хагалгааны гэрэл, иж бүрэн зөөврийн рентген аппарат худалдан авах 4 удаагийн тендерийг амжилттай зохион байгуулж, салбарын хөрөнгө оруулалтаар мэс заслын "C-Arm" рентген аппараттай болж оношилгоо, эмчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн. Замын-Үүдийн нэгдсэн эмнэлэг шинээр компьютер томографын оношилгоог нэвтрүүлж, орчин үеийн дэвшилтэт тоног | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төхөөрөмж бүхий эрүүл мэндийг дэмжих төвийг ашиглалтад оруулж, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг улам өргөжүүлснээр нэгдсэн эмнэлгүүд хэвлийн диализ, полихими эмчилгээ, дурангийн хагалгаа, чих хамар хоолой, нүд, хөнгөвчлөх зэрэг 11 нэр төрлийн тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн. Нэгдсэн эмнэлгүүд мэргэшсэн тусламж үйлчилгээний багцын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутагтаа чанартай тусламж үйлчилгээ авах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, лавлагаа шатлалд нийтдээ 783.7 сая төгрөгийн 24 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж шинээр нийлүүлэгдсэнээр тоног төхөөрөмжийн хангалт 86.2% болж 2020 оноос  608 ширхэг 7,409,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж нэмэгдэж, 1.7%-иар өссөн байна. | |
| 28 | 2.1.3. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ | 28. Иргэдийн эрүүл мэндийн цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх шаардлагатай арга хэмжээ авах | 2021 - 2024 | Цахим санд байгаа мэдээллийн тоо 220000 | Цахим санд байгаа мэдээллийн тоо | | 260000 | "Health.gov.mn" вэб сайтад суурилсан программд 38009 иргэдийн эрүүл мэндийн мэдээллийг шинээр бүртгэснээр аймгийн хэмжээнд хүний эрүүл мэндийн мэдээллийн 4 санд нийт давхардсан тоогоор 639.385 мэдээлэлтэй боллоо. "Hi info" V3.0 программд халдварт бус өвчин /АМ-6/, эмнэлгээс гаргагч /СТ-4/ мэдээллүүдийг үүсгэж санг баяжуулсан.   Мэдээллийн сан бүрдүүлэхэд эрүүл мэндийн салбарт хэрэглэж байгаа программуудын хоорондын мэдээллийн хөрвүүлэлтийг сайжруулж боловсронгуй болох талаар ЭМЯ, ЭМТХ-үүдэд санал хүргүүлж байна.  Мэдээллийн санг статистик мэдээ мэдээлэл гаргах, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл хийх, иргэний хувийн мэдээллийг нууцалж, судалгаа шинжилгээний ажилд мэдээллийг ашиглаж ажилладаг. | 90% |
| 29 | | 29. Анхан шатлалд явуулын болон алсын | 2021 - 2024 | Мобайл технологи нэвтрүүлсэн | Мобайл технологи нэвтрүүлсэн | | 10 | ОНХС-ын 43,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар мобайл технологийг 3 | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зайн тусламж үйлчилгээний цахим технологийг нэвтрүүлж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх | | АШЭМБ-ын тоо 3 | АШЭМБ-ын тоо | | | эрүүл мэндийн төвд нийлүүлснээр аймгийн хэмжээнд анхан шатны ЭМБ-уудад 100 хувь Мобайл технологи нэвтэрсэн. Мөн ЭМЯ-ны 136,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар анхан шатны эмнэлгүүдэд 100 хувь уушгины багтаамжийг тодорхойлох спирометрийн багажаар хангасан. Мобайл үзлэгт 6123 хүнийг хамруулж, 5309 шинжилгээ хийж, 288 өвчлөл шинээр илрүүлж, дээд шатлалд 112 хүн илгээж, 176 хүний эмчилгээний асуудлыг шийдэж, 5 хавдар эрт шатанд нь илрүүлж, зүрх судасны эмгэгтэй 53 хүнийг зайн оношилгооны дамжуулалтаар оношилж, 34 хүнийг арьсны төвтэй холбогдож, эмчилгээг заалгаснаар хөдөөгийн малчид оношилгоо шинжилгээг орон нутагтаа хийлгэх боломж бүрдсэн. 2019-2020 онуудад Мобайл технологи 4 суманд хэрэгжиж байсан учраас 2023 онтой харьцуулахад зайн оношилгооны төрөл 2-оор нэмэгдэж, үзлэг 5812-оор нэмэгдсэнээр алсын дуудлага болон хөдөөгийн малчдыг дээд шатлалд илгээх хүний тоо тодорхой хувиар буурч, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын оношилгооны чадавх сайжирсан. | |
| 30 | 2.1.4. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт-ийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлнэ | 30. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой аргыг нэвтрүүлэх | 2021 - 2024 | 8960,0 | Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хэмжээ | | 100% | Эрүүл мэндийн салбарын 36656,5 сая төгрөгийн төсөвтэй ажиллахаар төлөвлөсөн ба төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлж, өр авлагыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан. Санхүүжилтийн гүйцэтгэл 62 хувьтай 2517,7 сая төгрөгийн өртэй, 320,0 сая төгрөгийн авлагатай байна. Нийт өрийн 36,7 хувь нь аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн өр эзэлж байна. Төсвийн орлого бүрдүүлэлтэд хяналт тавих, үр ашигтай зарцуулах, өр авлага барагдуулах зорилгоор сар бүр төсвийн зохицуулалт хийх саналыг авч, хянаж, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан ЭМЯ-д хүргүүлсэн. Сумын эрүүл мэндийн төвүүдийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төсвийн төлөвлөлтийг ЭМДС-аас авсан гүйцэтгэлийн санхүүжилттэй уядуулан 11,12 сарын төсөвт өр авлагагүй гаргахгүй тодотгол, тооцооллыг хийж ЭМЯ-д хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайдын А/345 тушаалаар хүн ам цөөтэй, эмч мэргэжилтэн дутуу , ЭМДС-ыг авахад хүндрэл тулгараад байгаа 4 СЭМТ-д тус бүр 10,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Төрийн өмчийн 20 ЭМБ 15,9 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 26,5%-иар нэмэгдэж, ЭМДҮЗ-ийн 06,07,08 дугаар тогтоолуудаар тариф нэмэгдэж анхан шатлалд 4 багцын үйлчилгээ 84%, ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолын санхүүжилт 12,0% иар, лавлагаа шатлалд 13,5% -иар тус тус нэмэгдэж, нийт орлогын гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс анхан шатанд 218,6 сая төгрөгөөр, лавлагаа шатлалд 1.668,7 сая төгрөгөөр өссөн. | |
| 31 | | 31. Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | ЭМД-аар санхүүжиж буй тусламж үйлчилгээний нэр төрлийн тоо 9, ЭМД-д хамрагдалтын хувь 67 | ЭМД-аар санхүүжиж буй тусламж үйлчилгээний нэр төрлийн тоо ЭМД-д хамрагдалтын хувь | | 16/79% | ЭМДЕГ-тай гэрээ байгуулан ЭМД-ын санхүүжилтийн тусламж үйлчилгээний нэр төрлөө нэмэгдүүлсэн. ЭМДЕГ-ын 2021 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан оношийн бүлгээр санхүүжиж, төр, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн тусламжийн тариф ижил болж, лавлагаа шатлалын бүх эмнэлгүүд амбулаторийн тусламж үйлчилгээ, өндөр өртөгтэй оношилгоо эмчилгээ, өдрийн эмчилгээ, диализ, хэвтүүлэн эмчлүүлэх тусламж, хөнгөвчлөх, хими эмчилгээ, яаралтай, түргэн тусламж, урьдчилан сэргийлэх, жирэмсний хяналт нийт 11 төрлөөр, анхан шатны эмнэлгүүд 4 багц үйлчилгээгээр үйлчилж байна. Нэгдсэн эмнэлгүүд үндсэн 11 төрлийн тусламж үйлчилгээгээр 13,5 тэрбум төгрөг, анхан шатны эрүүл мэндийн төвүүд 4 багц, 3 тусламж үйлчилгээгээр 1,8 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан. Хувийн хэвшлийн эмнэлгүүд, УАРСТ-д хэвтүүлэн эмчлэх | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 711,6 сая төгрөгийн санхүүжилт авч, дутагдаж буй зардлуудад зарцуулахын зэрэгцээ цалинг нэмэгдүүлж, илүү цагийн хөлс, үр дүнгийн урамшууллалд зарцуулсан. Эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр үнийн хөнгөлөлттэй зайлшгүй шаардлагатай эм 923.4 сая төгрөгийн эмийг 47 эмийн сангаар олгосноор ЭМД сангаас санхүүжих тусламж, үйлчилгээ нэмэгдсэн. | |
| 32 | 2.1.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ. | 32. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг хангуулна. | 2021 - 2024 | Хэрэгжилтийн хувь 81 | Хэрэгжилтийн хувь | | 85% | ЭМГ-ын даргын А/153, А/154 дүгээр тушаалуудаар үнэлгээний хороог байгуулан, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2,830 сая төгрөгийн 31 багц бүхий нээлттэй тендер, Сумын эрүүл мэндийн төвүүдийн 274 сая төгрөгийн 26 багц бүхий нээлттэй тендерүүдийг зохион байгуулсан. Хуулийн дагуу тендерүүдийг 4 удаа нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, нийт 47 багцад хамгийн сайн үнэлэгдсэн 26 байгууллагатай гэрээ байгуулж, татан авалтууд хуваарийн дагуу хийгдсэн. Эмийн үнийн өсөлттэй холбоотойгоор тендер амжилтгүй болсон 10 багцад тодотгол хийн харьцуулсан тендер дахин зарлагдаж байна. Эрүүл мэндийн байгууллагууд Төрийн худалдан авах ажиллагааны Цахим дэлгүүрт байршсан эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурыг Ерөнхий гэрээний худалдан авалтаар авч нийт 79 нэр төрлийн, 568 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурыг 17 ЭХНБ-аас худалдан авсан. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэгт хийн систем угсарч, суурилуулах ажлыг "Петро хими" ХХК 117.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Сумын эрүүл мэндийн төвүүдийн хэрэгцээт эм хэрэгслийн захиалгыг 4 удаа нэгтгэн зохион байгуулж, нийгмийн хариуцлагын хүрээнд "Дорнын гэгээ тун" ЭХНБ эм хэрэгслийг стандартын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дагуу хадгалж, сумын эрүүл мэндийн төвүүдэд түгээж, чанар стандартын хэрэгжилт 100 хувь хангагдсан. | |
| 33 | | 33. Шинэчлэгдсэн цахим жорын программыг өргөжүүлж, эрүүл мэндийн даатгалын сангийн үнийн хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Цахим жороор үнийн хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлсэн хүний тоо 42068 | Цахим жороор үнийн хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлсэн хүний тоо | | 45000 | Тархины саажилт, хүүхдийн уналт таталтын эсрэг эмийг хүүхдэд /0-19 нас/ ЭМД-ын сангаас 100% хөнгөлөлттэй олгож эхэлсэн. Хүн амын дунд зонхилон тохиолддог, нас баралтын хувь өндөртэй зүрх судас, чихрийн шижин, уушгины эмгэг болон хавдрын үеийн эмзүйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Новартис эмийн хүртээмжийг сайжруулах” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 11-р тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх 159 ерөнхий нэршлийн, 561 эмийн жагсаалтыг баталж, иргэд хурууны хээгээ уншуулан харьяалал харгалзахгүйгээр бүх шатлалын эмнэлгүүдээр хөнгөлөлттэй эм бичүүлэх боломжтой болсон бөгөөд ЭМДЕГ-аас 71-ээс дээш насны иргэд, бусдын асаргаанд байдаг, уналт таталт, саажилттай иргэд хурууны хээ уншуулахгүй хөнгөлөлттэй эм бичүүлэх боломжийг бүрдүүлж, эмийн хүртээмжийг нэмэгдүүлсэн. Мөн 15 ерөнхий нэршлийн 24 тун, хэмжээ бүхий эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувийн хөнгөлөлттэй олгож нийт 47 эмийн сан, 33369 хүнд, 923.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй эмээр үйлчилсэн ба урьд оны мөн үеэс 11,3-аар буурсан байна. ЭМДЕГ-ын 2023 оны 08 дугаар тогтоолоор иргэдээс төлөх өртөг нэмэгдсэн, ЭЭС ОНӨҮ ААТГ нь татан буугдсан зэргээс шалтгаалсан. | 90% |
| 34 | 2.1.6. Эрүүл мэндийн ажилтны хөгжил, нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилт-ийг сайжруулж, хүний нөөцийн хангалтыг | 34. Эмч, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодын ахисан түвшний сургалтад хамруулж, мэдлэг чадварыг | 2021 - 2024 | Сургалтад хамрагдсан хүний тоо 3432 | Сургалтад хамрагдсан хүний тоо | | 3580 | "Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулахад анхаарч, мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад 23, танхимын болон цахим сургалтад давхардсан тоогоор 1660, ЭМБ-ын дотоодын сургалтад | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлж, нөхцөл боломжоор хангана. | дээшл үүлэх | | | | | давхардсан тоогоор 2305 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулж, нийт 3980 хүний мэдлэг чадварыг дээшлүүлсэн. Лондонгийн "CIPD" их сургуульд 1 албан хаагч, Тайвань улсын их дээд сургуулийн үйл ажиллагаатай танилцах аялалд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга оролцож, БНСУ-д ажлын байрны дадлагажуулах 3 сарын сургалтад 1 эмч, ОХУ-ын Москва хот дахь Эх барих эмэгтэйчүүд, перинатологийн эрдэм шинжилгээний төвд ажлын байрны дадлагажих сургалтад ОХУ-ын Засгийн газрын санхүүжилтээр Замын-Үүд нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүд, нярайн эмчийг, ЭМЯ-ны дэмжлэгээр БНСУ болон БНХАУ-д 2 эх баригч, 5 сувилагчийг тус тус хамруулж, мэдлэг чадавхыг нэмэгдүүлсэн. АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуулийн Эм найруулагчийн ангид 2020-2023 онд суралцаж төгссөн 16 оюутан, тус онд шинээр элсэн орсон Эх баригчийн ангийн 11 оюутан, Их эмчийн ангийн 3, нийт 30 оюутантай орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээг байгуулж, сургалтын төлбөр болох 23,0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас 100% олгож, орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэжлээр хүний нөөц бэлтгэх ажлыг дэмжиж ажилласан. Мөн Сайхандулаан, Өргөн сумын Засаг дарга орон нутгийн санхүүжилтээр 4 оюутны сургалтын төлбөр болох 18,7 сая төгрөгийг төлж 5 жилийн хугацаатай ажиллахаар гэрээ байгуулан ажиллуулж байна. 2020-2023 онуудад давхардсан тоогоор 11670 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг дотоод, 12 эмч, мэргэжилтэнг 12 удаа гадаад сургалтад хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлсэн. | |
| 35 | | 35. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн | 2021 - 2024 | Хүний нөөцийн ханалтын хувь 93,9 | Хүний нөөцийн ханалтын хувь | | 96% 10 | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд “Нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийг | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамгааллыг сайжруулан тогтвор суурьшилтай ажиллуулах эдийн засгийн хөшүүргийг оновчтой, хүртээмжтэй болгох | | Дэмжлэг үзүүлсэн сумын тоо 4 | Дэмжлэг үзүүлсэн сумын тоо | | | хэрэгжүүлж, сум орон нутгийн удирдлагуудтай "Хамтран ажиллах гэрээ" байгуулж, эмч мэргэжилтнүүдийг орон сууцаар хангах, тогтвор суурьшилтай ажиллах хөшүүргийг бий болгож, дэмжих зорилгоор анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж байгаа 38 эмч мэргэжилтнийг төрийн албан хаагчийн орон сууцанд суулган, түрээсийн төлбөрөөс чөлөөлсөн. Гэр бүлээрээ хөдөө ажиллаж байгаа залуучуудад "эзэмшлийн газар", 8 албан хаагчдыг "малжуулах төсөл"-д хамруулж, 65 толгой бог мал, 1 ажилтанд "гэр" үнэгүй олгосон. Монгол Улсын Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"–ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Төрийн албан хаагчийг орон сууцжуулах" хөтөлбөрөөр аймгийн Нэгдсэн эмнэлэгт шилжин ирж ажиллах 6 эмч, ажилтныг байраар хангасан. Түрээслээд өмчлөх орон сууцанд орох боломжийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн 14 эмч, сувилагч, асрагчид олгож, Замын-үүд сумын Нэгдсэн эмнэлэг нь 18 айлын орон сууцыг ашиглалтад оруулж албан хаагчдыг дэмжин ажилласан. Мөн 3 сумын эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 4 эмчид 15,4 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлж, шинээр 105 эмч мэргэжилтнийг ажлын байраар хангаж, ЭМБ-уудын хүний нөөцийн хангалт анхан шатанд 89,5%, лавлагаа шатлалд 83,7%, салбарын хэмжээнд дунджаар 86,6%-тай байна. 2020-2023 онуудад 97 эмч мэргэжилтэнг төрийн албан хаагчийн байраар хангаж, 856 эмч мэргэжилтэнд 134,3 сая төгрөгний мөнгөн дэмжлэг үзүүлсэн нь 2020 онтой харьцуулахад байраар хангасан албан хаагч 38 хүнээр нэмэгдсэн. | |
| 36 | 2.1.7. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүд ийн барилга | 40. Уламжлалт анагаах ухаан, рашаан сувиллын үйл | 2022 - 2024 | 0 | Гүйцэтгэлийн хувь | | 70% | Аймгийн Засаг даргын 2022 оны А/76 дугаар захирамжаар "Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв"- | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | ажиллагааг өргөжүүлэн, орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай арга хэмжээ авах | | | | | | ийн бүтэц орон тоог шинэчлэн баталсан. Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв нь 2023 онд 28 орон тоо, 39 ор, сувиллын 60 ортой ажиллаж, эхний 10 сарын байдлаар 1086 хүнийг хэвтүүлж, амбулаторийн үзлэг 1559 хүнд үзүүлснээр өмнөх оноос хэвтүүлэн эмчлүүлсэн хүн 7.6%-иар, үзлэг 18.4-иар тус тус өсч, шинээр 2 төрлийн эмчилгээг нэвтрүүлж, 413 хүнд үйлчилсэн. Урьдчилан сэргийлэх үзлэгийг 3 сум, 5 албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд зохион байгуулж нийт 422 хүнд үзлэг, 500 гаруй хүнд хүчилтөрөгчийн коктейлоор үйлчилсэн нь өмнө оноос 26.4%-иар нэмэгдсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 137,9 сая төгрөгөөр Халзан-Уул" рашаан сувиллын “Нийтийн бие засах газрын шинэчлэл” ажлын тендерт “Эрхэм бадрах” ХХК шалгарч бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгснөөр амрагч, аялагчдын ая тухтай нөхцөлд үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж Уламжлалт анагаах ухаан, рашаан сувиллын үйл ажиллагааг дэмжсэн. Халзан уул рашаан сувиллын үйл ажиллагааг орон нутгийн B media сувгаар сурталчлан мэдээлэл өгч, 2023 онд 21 төрлийн эмчилгээ сувилгаа хийж, шинээр 2 төрлийн эмчилгээ нэвтрүүлэн ажиллаж 682 сувилуулагч хүлээн авсан нь 2020 оныхоос 31.4%-иар нэмэгдсэн байна. | |
| 37 | | 36. 2.1.7.3. Зарим сумдын эрүүл мэндийн төв, өрх, багийн эмнэлгийн барилгыг шинээр барих болон барилгын өргөтгөл, засвар үйлчилгээг хийнэ. | 2021 - 2024 | | Гүйцэт гэлийн хувь, 100% | | | Эрүүл мэндийн салбарт улс, орон нутгийн төсвийн 18,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 4 эрүүл мэндийн төвийг шинээр ашиглалтад оруулж, 9 эрүүл мэндийн төвд засвар хийж, 133 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангаж, 22 автомашиныг олгож эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад дэмжин ажилласан. Орон нутгийн төсвийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл хийх ажлыг "Энержи парагон" ХХК, гүйцэтгэж, улсын комисс ажиллуулах хүсэлтийг ирүүлээд байна. Ажлын гүйцэтгэлийн явц 97 хувьтай. Сайхандулаан суманд орон нутгийн хөгжлийн сангийн 66,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЭМТ-ийн барилгын ажлыг "Эргэл хийц" ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Даланжаргалан суманд ЭМТ-ийн барилга барих ажлыг "Элит конкрет" ХХК 1,6 тэрбум төгрөгөөр ажил гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна. | |
| 38 | | 37. Халдвартын эмнэлгийн барилга шинээр барих | 2022 - 2024 | 0 | Гүйцэтгэлийн хувь | | | Орон нутгийн хөгжлийн сангийн 2181.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 2 дугаар багт Халдвартын эмнэлгийн барилга угсралтын ажлыг "Төгс-Өнөд" ХХК гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 100% |
| 39 | | 38. Сумдын эрүүл мэндийн байгууллагуудыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | | | Улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар Алтанширээ, Хөвсгөл, Хатанбулаг, Даланжаргалан, Дэлгэрэх, Улаанбадрах, Эрдэнэ сумдад төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажлыг 2020-2022 онуудад ашиглалтад оруулсан бөгөөд тус сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Эрүүл мэндийн төвүүдийг төвлөрсөн шугам сүлжээнд бүрэн холбогдсон. | 100% |
| 40 | | 40. Аймгийн нэгдсэн эмнэлгийн ажиллах нөхцөл боломжийг сайжруулах болон хийн систем, хүчил төрөгчийн үйлдвэртэй болгох | 2021 - 2024 | | | | | Аймгийн нэгдсэн эмнэлэгт 732,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1 цагт / 20 нанометр куб/ 3 баллон дүүргэх хүчин чадалтай “Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр”-ийг барьж, хийн систем угсарч, суурилуулан эмнэлгийн дотор талын хийн хоолойн дамжуулах системийг бүрэн угсарч, холбогдох эмч мэргэжилтэн ажилтнуудыг ажлын байрны сургалтад хамруулан, тусламж үйлчилгээнд ашиглаж эхэлсэн. Шинэ халдвартын эмнэлэг болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн гадна автозогсоол байгуулах ажлыг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 291,4 сая төгрөгөөр “Дэлгэр баясах зам” ХХК хийж гүйцэтгэж, эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдийн аюулгүй зорчих боломжийг хангасан. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нийт 9 эмчийг гадаад улсад туршлага судлах сургалтад хамруулж, мэдлэг чадавхыг нэмэгдүүлсэнээс гадна шилжин ирж ажиллах 6 эмч, ажилтныг байраар хангасан төдийгүй түрээслээд өмчлөх орон сууцанд 14 эмч, сувилагч, асрагчид хамрагдсан. Нэгдсэн эмнэлгүүд мэргэшсэн тусламж үйлчилгээний багцын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутагтаа чанартай тусламж үйлчилгээ авах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, лавлагаа шатлалд нийтдээ 783.7 сая төгрөгийн 24 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж шинээр нийлүүлэгдсэнээр тоног төхөөрөмжийн хангалт 86.2% болж 2020 оноос 608 ширхэг 7,409,6 сая төгрөгийн ТТ нэмэгдэж, 1.7%-иар өссөн байна. Үүний үр дүнд нарийн мэргэжлийн 11 нэр төрлийн тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааг тогтмол дэмжиж, халдвартын эмнэлгийн угаалга, ариутгалын барилга–484,6 сая төгрөг, серверийн шинэчлэл 64,1 сая төгрөг, зөөврийн рентген, компьютерын 5 ширхэг иж бүрдэл 97,8 сая төгрөг зэрэг нийт 646,5 сая төгрөгийг санхүүжилтийг олгож ажилчдын ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн. | |
| 41 | 2.1.8. АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог сайжруулж, төгсөгчдийг орон нутагт мэргэжлээ-рээ ажиллах хөшүүргийг оновчтой хэрэгжүүлнэ. | 41. Мэргэжилтэн бэлтгэх ангийн тоог нэмэгдүүлэн, орон нутгийн оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэн, тогтвор суурьшилтай ажиллах үр дүнтэй хөшүүргийг бий болгох | 2021 - 2024 | Бэлтгэж буй мэргэжлийн тоо 5, Дэмжлэг үзүүлсэн оюутны тоо 24 | Бэлтгэж буй мэргэжлийн тоо, Дэмжлэг үзүүлсэн оюутны тоо | | 7 30 | Орон нутагт зайлшгүй хэрэгцээтэй, дутагдалтай байгаа мэргэжлээр оюутан элсүүлэх, суралцаж байгаа оюутнуудын сургалтын төлбөрийг орон нутгаас шийдвэрлэхээр АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуулийн эм найруулагчийн ангид 2020-2023 онд суралцаж төгссөн 16 оюутан, тус онд | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шинээр элсэн орсон эх баригчийн ангийн 11 оюутан, их эмчийн ангийн 3, нийт 30 оюутантай орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээг байгуулж, сургалтын төлбөрийг 100 хувь олгосон. Аймгийн Засаг даргын 2023 оны А/740 дугаар захирамжаар 5.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, оюутны дотуур байранд шаардлагатай зарим тоног, төхөөрөмжийг нийлүүлж оюутнуудын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэн оюутнуудын таатай амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн. Аймгийн Засаг даргын 2023 оны А/610 тоот захирамжаар АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн сургалтын чанар, орчин нөхцөлийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. АШУҮИС-ийн Дорноговь дахь салбар сургуулийн 43 багшийн 98% нь магистр, Политехникийн коллежийн 43 багшийн 46.5% буюу 20 багш магистр зэрэгтэй байгаа нь өмнөх оноос 2 хувиар өссөн. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн багшийг чадавхжуулах, сургалтын чанар, орчин нөхцөлийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны А/610 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан, “Анагаахын боловсрол олгох сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих аймгийн зорилтот хөтөлбөр”-ийг боловсруулан, аймгийн ИТХ-ын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 13/01 тогтоолоор батлуулсан. | |
| 42 | 2.2.1. “Хөдөлгөөн - эрүүл мэнд" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжгэй | 43. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн орчимд “Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн", хүүхдийн парк байгуулах | 2022 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | - | Төв цэнгэлдэх хүрээлэнгийн орчмыг “Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн” болгох ажлын хүрээнд “Хүүхдийн парк”-ыг 6.3 га газарт төлөвлөж “Архидеа” ХХК, “Говь парк” цэцэрлэгт хүрээлэнг 108 га газарт төлөвлөж “Онч тэнхлэг” ХХК-ууд ерөнхий | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан бодлогыг хэрэгжүүлнэ. | | | | | | | төлөвлөгөөний зураг төслийг боловсруулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн 707,4 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн Төв цэнгэлдэх хүрээлэнд шаардлагатай засвар, сүүдрэвч хийх ажлын тендерт “Энержипарагон" ХХК шалгарч, засварын ажлыг бүрэн дуусгаж 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдөр хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн 6.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 3-р багийн нутаг дэвсгэр төв цэнгэлдэх хүрээлэнгийн зүүн талд "Хүүхдийн парк" байгуулах ажлын тендерт "Дэлгэр баясах зам" ХХК, "Энержи парагон" ХХК, "Уртын уул" ХХК-иуд шалгаран ажлыг гүйцэтгэж 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж байнгын ашиглалтад оруулсан. Тайлант хугацаанд 7400 гаруй хүүхэд, багачууд хүүхдийн паркаар үйлчлүүлсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 80,0 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын 8 дугаар багт байрлах "Говь парк" цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсвийн ажлын тендерт "Онч тэнхлэг" ХХК гүйцэтгэгчээр шалгарч, ажлын явц 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгийн төсвийн 67.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр “Говь парк” цэцэрлэгт хүрээлэнд гүний худаг гаргах, нөөцийн сав байрлуулах ажлыг хийсэн ба тайлант онд 10379 ширхэг мод тарьж, ногоон байгууламжийн ажлыг эхлүүлсэн.Дээрх цэцэрлэгт хүрээлэн нь нийт 136 га талбайд ногоон байгууламж, явган хүний болон дугуйн зам, хөшөө дурсгал, сагсан бөмбөг, гар бөмбөг, агаарын теннис, skateboard гольфын талбай, ахмад, бага настны чийрэгжүүлэлтийн талбай зэргийг төлөвлөсөн.“Говь парк”, төв цэнгэлдэх хүрээлэн орчмын газраас цэцэрлэгийн ахлах бэлтгэл анги, сургуулийн бага ангийн 5000 гаруй | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүүхэд аялсан. | |
| 43 | | 44. Спортын төрлүүдийг хөгжүүлэхэд спортын холбоод, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах | 2021 - 2024 | 40 | Хамтран ажиллагч байгууллагын тоо | | 43 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний “Цаг гаргая” аяны хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг шугаман бүжиг, алхалт, гүйлт зэрэг төрлөөр 7 хоног бүрийн Баасан, Бямба, Ням гарагуудад хамруулж давхардсан тоогоор 11351 иргэн, хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийг биеийн тамирыг хөгжүүлэх хүрээнд нийт 37083 иргэнийг тус тус хамруулсан. Усан спорт сургалтын төвд давхардсан тоогоор 1680 хүүхэд хамрагдсан. Эрүүл мэндийн газартай хамтран “Ажлын байрны түмэн дасгал”, “Хийн дасгал”-ын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 23 багийн 230 тамирчин оролцсон. Спортын холбоодтой хамтран нийт 78 тэмцээнийг 11 төрлөөр зохион байгуулж 10736 тамирчин оролцуулсан. "Жюү жицү"-ийн холбоотой хамтран “Дорноговь опен” Дэлхийн чансааны 800 оноо олгох бүсийн зэрэглэлийн Олон улсын тэмцээн, спортын холбоодтой хамтран нийт 78 тэмцээнийг 19 төрлөөр зохион байгуулж 10736 тамирчин оролцуулсан нь өмнөх оноос 70%-иар өссөн байна. | 90% |
| 44 | | 46. “Унадаг дугуй” -г нийтийн хэрэглээ болгох | 2021 - 2024 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 70% Хичээллэгсдийн тоо 55, Сонирхогчдын тоо 200 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Хичээллэгсдийн тоо Сонирхогчдын тоо | | 90% 80 400 | Дугуйн спортын, аяллын "Хулан" клубээс санаачлан унадаг дугуйг нийтийн хэрэглээ болгохоор аймгийн хэмжээнд судалгаа хийж, судалгааны дүнд үндэслэн ойрын дугуйн аялал, зугаалгыг жил бүр явуулж хэвшсэн. Дугуйн спортоор хичээллэгч өсвөрийн болон ахмад тамирчдын аймгийн аварга шалгаруулах сорилт тэмцээнд 25, "Сайншандын цом"-ын аварга шалгаруулах тэмцээнд 209, “Khamar Monastery-2023” засмал замын ба уулын дугуйн уралдаанд Өмнөговь, Сэлэнгэ, Ховд, Улаанбаатар хотын 250 тамирчид тус тус оролцож, нийт 3 | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | удаагийн тэмцээнд 484 тамирчид хамруулсан бөгөөд орон нутгийн төсвөөс нийт 18,9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.  Мөн Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Хайрхан хөгжлийн төвийн стандарт тэмцээнд 1, Өмнөговь аймагт зохион байгуулагдсан Говийн бүсийн болон холын зайн тэмцээнд 1, "Дархан-88" тэмцээнд 15, Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын дугуйн төрөлд 7, нийт 4 удаагийн тэмцээнд 24 тамирчид амжилттай оролцсон. Аймгийн хэмжээнд нийт 420 хүн унадаг дугуйг хэрэглээний болон спортын зориулалтаар тогтмол хэрэглэж дугуйн спортоор хичээллэж эхэлснээр нийт хичээллэгсдийн тоо 2020-2023 онд 26 хувиар өссөн. | |
| 45 | 2.2.2. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, спортоор хичээллэх орчныг сайжруулна. | 48. Сайншанд суманд стандартад нийцсэн хөл бөмбөгийн болон граундгольфын талбай байгуулах. | 2022 - 2024 | - | Талбайн тоо | | 1 | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 80 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын 8 дугаар багт байрлах "Говь парк" цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсвийн ажлын тендерт "Онч тэнхлэг" ХХК гүйцэтгэгчээр шалгарч ажлын явц 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Дээрх цэцэрлэгт хүрээлэн нь нийт 136 га талбайд ногоон байгууламж, явган хүний болон дугуйн зам, хөшөө дурсгал, сагсан бөмбөг, гар бөмбөг, агаарын теннис, skateboard, гольфын талбай, ахмад настны болон хүүхэд багачуудын чийрэгжүүлэлтийн талбай зэргийг бий болгохоор төлөвлөсөн. | 50% |
| 46 | | 49.  Зарим сумдад спортын ордон байгуулна. | 2022 - 2024 | | | | | Алтанширээ суманд спорт зал шинээр барихаар зураг төслийг “Би Өү Экс Экс” ХХК боловсруулж, орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан. | 30% |
| 47 | 2.2.3. “Өсвөрийн шигшээ баг"- ийн үйлажиллагааг дэмжих арга хэмжээ (2021-2024)-ний хүрээнд их спортын төрөл, шигшээ багийг нэмэгдүүлж, гадаад, дотоодын тэмцээн уралдаанд | 52. Их спортын төрөл, шигшээ багийг нэмэгдүүлж, олон улс, улс, бүсийн тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна. | 2021 - 2024 | Спортын төрөл 8, Зохион байгуулсан тэмцээний тоо 1 | Спортын төрөл Зохион байгуулсан тэмцээний тоо | | 9/3 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл доор зохион байгуулагдаж буй 21 аймгийн футзалны цомын аварга шалгаруулах тэмцээн, U23 залуучуудын сагсан бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээн, “Дорноговь опен” Жюү жицүгийн дэлхийн чансааны 800 оноо олгох | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцох тамирчдыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ. | | | | | | | Олон улсын тэмцээн, “Нийтийн бүжгийн 7-р их наадам”-ын 15 багийн 350 бүжигчин, “Khamar monastery-2023" засмал зам ба уулын дугуйн улсын уралдаан, Авто кросс автомашины уралдаан зэрэг томоохон уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж 2000 гаруй тамирчдыг оролцуулж аймгийн орон нутгийн төсвөөс 74,5 сая төгрөгний зардал гаргасан. Ковид -19 цар тахлын нөхцөл байдлын улмаас олон улс, улс, бүсийн тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах боломж бага байсан тул 2020 онд гандболын залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 11 багийн 250 гаруй тамирчид оролцсон. 2020 онтой харьцуулбал тэмцээнд оролцогчдын тоо 1750-р нэмэгдсэн. 2020 онд өсвөрийн шигшээ багийн тоо 8 төрлөөр 370 гаруй тамирчид хичээллэж байсан. Өмнөх онд Сагсан бөмбөг, Жүдо бөх, Гандбол, Чөлөөт бөх, Хөл бөмбөг, Бокс, Хөнгөн атлетик, Волейбол, Ширээний теннис гэсэн спортын 10 төрлөөр үнэ төлбөргүй секц, сургалтад 400 хүүхдийг хамруулснаар 36.5 хувиар өссөн. Энэ онд 11 төрлийн секц ажиллаж байгаа нь 2020 оноос 3 төрлөөр нэмэгдсэн. | |
| 48 | | 53. Өсвөрийн шигшээ багийн төрлийн тоо, медалийн чанарыг нэмэгдүүлж, багш дасгалжуулагчдыг урьж хамтран ажиллах | 2021 - 2024 | Шигшээ багийн төрлийнтоо 8, Хичээллэгсдийн тоо 370, Хамтран ажилласан багшийн тоо | Шигшээ багийн төрлийнтоо Хичээллэгсдийн тоо Хамтран ажилласан багшийн тоо | | 10 420 2 | Спортын холбоодтой хамтран өсвөр үеийн шигшээ багийг спортын 11 төрлөөр хөгжүүлэн, үйл ажиллагааг дэмжин ажиллалаа. Өсвөр үеийн шигшээ багт 630 гаруй тамирчид хичээллэж улсын аварга шалгаруулах тэмцээнд алт 5, мөнгө 7, хүрэл 7 медаль, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд алт 17, мөнгө 13, хүрэл 14 медаль хүртсэн амжилт үзүүлсэн. Монгол Улсын спортын мастер боксын дасгалжуулагч Г.Баасанг 3 жилийн хугацаатай урьж, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж хүүхдүүдийн ур чадварыг нэмэгдүүлэн ажилласан. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Монголын Хүүхдийн спортын зуны VII наадмын шигшээ тэмцээнд өсвөрийн шигшээ багийн тамирчид спортын 8 төрлөөр 71 тамирчид оролцож, нийт алт 2, мөнгө 3, хүрэл 5 медаль хүртсэн амжилт үзүүлсэн. 2020 онд өсвөрийн шигшээ багийн тоо 8 төрлөөр 370 гаруй тамирчид хичээллэж байсан. Өмнөх онд Сагсан бөмбөг, Жүдо бөх, Гандбол, Чөлөөт бөх, Хөл бөмбөг, Бокс, Хөнгөн атлетик, Волейбол, Ширээний теннис гэсэн спортын 10 төрлөөр үнэ төлбөргүй секц, сургалтад 400 хүүхдийг хамруулсан ба 2020 оноос хойш өсвөрийн шигшээ багийн хүүхдийн тоо 36.5 хувиар, медалийн чанар 50 хувиар, спортын төрөл 3-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | |
| 49 | | 54. Тив, дэлхий, олимп, улс, бүсийн чанартай тэмцээнд оролцох тамирчид, дасгалжуулагчдад дэмжлэг, урамшуулал олгох | 2021 - 2024 | Урамшуулсан тамирчдын тоо 60 | Урамшуулсан тамирчдын тоо | | 75 | Өсвөр үе, залуучуудын шигшээ баг"-ийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн дэмжих захирамжийг гарган, тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн, медаль хүртсэн тамирчид, бэлтгэл сургуулилтыг ханган оролцуулсан дасгалжуулагчдыг урамшуулан, тэдний амжилтыг ахиулах зорилгоор амжилт гаргасан 90 тамирчин, 10 дасгалжуулагчийг аймгийн Засаг даргын 2023 оны А/191 дүгээр захирамжаар нийт 23,5 сая төгрөгөөр урамшуулсан. Тив, дэлхийн чанартай тэмцээнд оролцох тамирчдад 6 сая, улс, бүсийн тэмцээнд оролцох тамирчдад 30,8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Шатар, жүдо бөх, жюү жицү, чөлөөт бөх, пара жүдо зэрэг төрлөөр нийт 15 тамирчин оролцож алт 1, хүрэл 2, шагналт 5 дугаар байранд тус тус шалгарсан. 2020 онд тив, дэлхий, олимп, улс, бүсийн чанартай тэмцээнд амжилт гаргасан 48 тамирчин дасгалжуулагчийг урамшуулсан. Өмнөх онд тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | медаль хүртсэн тамирчид, бэлтгэл сургуулилтыг ханган оролцуулсан дасгалжуулагчдыг урамшуулан, тэдний амжилтыг ахиулах зорилгоор 2022 онд амжилт гаргасан 28, тамирчин, 4 дасгалжуулагчийг урамшуулснаар энэ онд дэмжлэг 68 хувиар, тамирчдын тоо 27.8 хувиар өссөн. | |
| 50 | 2.3.1. “Чадварлаг багш”зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн ур чадварыг тогтмол дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг ханган, Боловсролын байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлж, орчин нөхцөлийг сайжруулна. | 55. "Хүүхэд бүр цэцэрлэгт" сургалтын арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин 89.1%, Үүнээс 5 настай сурагчдын хамрагдалтын хувь 97 | СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин Үүнээс 5 настай сурагчдын хамрагдалтын хувь | | 94%/98.5% | Цэцэрлэгийн буюу 2-5 насны 6197 хүүхэд байгаагаас төрийн өмчийн цэцэрлэгт 5025, төрийн бус өмчийн 1 цэцэрлэгт 38, төмөр замын 6 цэцэрлэгт 712, нийт 5775 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, СӨБ-ын хамран сургалтын бохир жин 93,1 хувьтай байна. Нийт 5 настай 1565 хүүхэд байгаагаас төрийн өмчийн цэцэрлэгт 1298 хүүхэд, хувилбарт сургалтад 43 хүүхэд, төмөр замын цэцэрлэгт 167 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 96,3 хувь байгаа нь өмнөх оноос 2.1 хувиар нэмэгдсэн. НҮБ-ын хүүхдийг ивээх сан, "Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих төв" ТББ-тай хамтран “Бага насны хүүхдийн цогц хөгжилд эцэг эх асран хамгаалагчийн оролцоо” сэдэвт 5 цогц сургалтыг зохион байгуулж аймгийн хэмжээнд 20 сургагч багш бэлтгэж, бага насны хүүхэдтэй 1000 эцэг эхэд энэ чиглэлийн мэдээллийг түгээн дэлгэрүүлж, гарын авлагын хамт хүргэсэн. БЕГ-аас зохион байгуулсан бэлтгэл бүлгийн багш нарт зориулсан цахим сургалтад төрийн өмчийн болон төмөр замын 37 цэцэрлэгийн 50 багш хамрагдаж, ажлын байрандаа тасралтгүй хөгжиж, мэдлэг аргазүйгээ дээшлүүлэн ажилласан. 2023 онд хувилбарт сургалтад нийт 341 хүүхэд хамрагдсан ба өмнөх оноос 22 хүүхдээр нэмэгдсэн байна. Мөн 2020 онд хувилбарт сургалтад 379 хүүхэд хамрагдсан нь цэцэрлэгийн хүртээмж болон хөл хориотой холбоотой байна. СӨБ-ийн хамран сургалтын цэвэр жин 2023 оны байдлаар 93,2 хувь байгаа | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нь өмнөх оноос 6,2 хувиар өссөн байна. Мөн 2020 оноос 6,2 хувь өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс 5 настай хүүхдийн хамрагдалтын хувь 2023 онд 96,5 хувь байгаа нь өмнөх оноос 2,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн 2020 онтой харьцуулахад 9,5 хувь өссөн байна. | |
| 51 | | 56. "Анги хамт олны олимпиад", "Зорилгын хүч", "Дэвжээ" зэрэг олон талт арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 4, Чанарын үнэлгээний гүйцэтгэлийн хувь 34.6 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо Чанарын үнэлгээний гүйцэтгэлийн хувь | | 7/37.1% | Сурагчдын хоцрогдлыг арилгах, гүйцэтгэлийн үнэлгээнд ахиц гарган, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор 1-12-р ангид дизайн технологи, англи хэл, орос хэл, эрүүл мэнд, математик, физик, бага анги /монгол хэл, математик /, үндэсний бичиг судлагдахуунаар “Анги хамт олны олимпиад”-ыг 3 үе шаттайгаар зохион байгуулж, давхардсан тоогоор 1144 бүлгийн 31023 сурагч хамруулж, судлагдахуун бүрийн гүйцэтгэлийн хувь гүйцэтгэлийн үнэлгээний дундажтай харьцуулбал 2,4-4,1 хувиар ахисан. Мөн 12-р ангийн сурагчдыг ЭЕШ-д бэлтгэх бэлтгэл ажлыг эрчимжүүлэх, математик, физикийн хичээлээр ЭЕШ өгөх сурагчдын чансааг тодруулах зорилгоор аймгийн ЕБ-н 10 сургуулийн 12-р ангийн сурагчдын дунд “Математик-Дэвжээ-1”, “Математик-Дэвжээ-2”, “Физик-Дэвжээ-1” зэргийг зохион байгуулж 9 сургуулийн 20 бүлгийн 460 сурагч, 70 багш хамруулж, мэргэжлийн зэрэгтэй багш нар сургалт зохион байгуулан, 10 агуулгын хүрээнд сорилго болон өртөөчилсөн бодлогоор өрсөлдөж мэдлэг боловсролоо дээшлүүллээ. Элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан 1 сурагч, бэлтгэсэн 1 багшид, 700 ба түүнээс дээш оноо авсан 25 сурагч, 21 багшид нийт 19,0 сая төгрөгийн урамшуулал олгосон. “Зорилгын хүч” арга хэмжээний хүрээнд төвийн 4 сургуулийн 307 сурагчийг хамруулан 7 судлагдахууны хүрээнд 3 түвшнээр 2 долоо хоногийн эрчимжүүлсэн сургалтыг 58 багш 31 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүлгээр зохион байгуулсан. 12-р ангийн сурагчдаас 7 судлагдахуунаар нэгдсэн байдлаар 2 удаа сорил авахад “Сорил-1”-д 1365 сурагч хамруулж 36,7%-н гүйцэтгэлтэй, “Сорил-2”-д 1314 сурагч хамруулж 40,4%-н гүйцэтгэлтэй шалгагдаж өмнөх оны сорилоос 3,7%-иар ахисан. | |
| 52 | | 57. Багш нарын ур чадвар, сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдаан, хичээл төрлийн олимпиад зохион байгуулах | 2021 - 2024 | Зохион байгуул сан арга хэмжээний тоо 1 | Зохион байгуул сан арга хэмжээний тоо | | 3 | Багш нарын сурган хүмүүжүүлэх уншлагад бэлтгэх, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, туршлага түгээн дэлгэрүүлэх зорилгоор Боловсролын хүрээлэнтэй хамтран онлайн сургалт зохион байгуулж 182 багш, удирдах ажилтан оролцсон. Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд багш нарын дунд “Сурагч төвтэй идэвхтэй сургалтын арга” шилдэг арга зүйн талаар илтгэл, “Сайн хичээл, шилдэг арга зүй-2023” ур чадварын уралдааныг Говийн ноён хутагт Д. Равжаагийн мэндэлсний 220 жилийн ойг тохиолдуулан 3 үе шаттайг зохион байгуулсан. 1-р шатанд 698 багш, 2-р шатанд 22 багш, 3-р шатанд 8 багш шалгарч эхний 3 байрыг шалгаруулж урамшуулсан. СӨБ-ын хөгжмийн багш нарын дунд “Хүүхэд төвтэй идэвхтэй сургалтын арга зүй-2023” ур чадварын уралдааныг илтгэлийн уралдаантай хослуулан 2 үе шаттай зохион байгуулж, хөгжмийн багш нарын мэргэжлийн мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэн ажилласан. Говийн ноён хутагт Д.Равжаагийн мэндэлсний 220 жилийн ойг тохиолдуулан улсын төрөлжсөн олимпиадын 2-ын даваag 13 хичээл төрлөөр зохион байгуулж 22 сургуулийн 251 багш, 999 сурагч хамруулж, нэгдсэн дүнгээр 12 жилийн сургуулиудаас Замын-Үүд сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль 1-р байр, Сайншанд сумын лаборатори 2 дугаар сургууль 2-р байр, Сайншанд сумын ЕБ-ын 5 дугаар сургууль 3-р байр | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | эзэлсэн. Шалгарсан багш сурагчид Улсын олимпиадын 3-ын давааанд оролцож монгол хэлний багшийн төрөлд тусгай байр, биологи 9-р анги тусгай байр, технологийн 2 багш тусгай байр эзэлсэн. | |
| 53 | | 58. "Аптан зул" арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 1 | Боловсролын байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, мэргэжлийн өндөр ур чадвар, эвсэг, хөдөлмөрч чанар, хамтын ажиллагаагаараа бусдадаа үлгэр жишээ болж буй шилдэг баг хамт олныг шалгаруулах “АЛТАН ЗУЛ-2023” наадмыг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 24 сургууль, 33 цэцэрлэгийн 1300 гаруй багш ажилтан оролцож, 7 номинацийн хүрээнд шилдгүүдийг шалгаруулж урамшуулсан. "Алтан зул-2023" наадмын "Аж ахуйн шилдэг баг"-аар Замын-Үүд сумын хүүхдийн 5-р цэцэрлэгийн хамт олон, "Шилдэг зан баг"-аар Сайншанд сумын ЕБ-ын 3-р сургуулийн Бага ангийн заах аргын нэгдэл, "Судлагдахууны шилдэг баг"-аар Замын-Үүд сумын ЕБ-ын 1-р сургуулийн "Элсэлтийн ерөнхий шалгалтын баг", “Сургуулийн өмнөх боловсролын шилдэг байгууллага"-аар Сайншанд сумын 12-р цэцэрлэгийн хамт олон, "ЕБ-ын 9 жилийн шилдэг сургууль"-аар Улаанбадрах сумын ЕБ-ын сургуулийн хамт олон, "ЕБ-ын 12 жилийн шилдэг сургууль"-аар Замын-Үүд сумын ЕБ-ын 3-р сургуулийн хамт олон, "Шилдгийн шилдэг баг, хамт олон"-оор Замын-Үүд сумын хүүхдийн 4-р цэцэрлэгийн хамт олон тодорч алтан зул цомын эзэд болсон. Мөн тус арга хэмжээгээр боловсролын салбарт хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөр, шинэчлэлийг харуулсан биологийн бүс, химийн бүс, физикийн бүс, "STEAM", "Робот ба программчлалын бүс", "Гар урлалын бүс", "AR", "VR технологийн бүс", “Сэтгэлийн үг” уран зохиолын бүс зэрэг 9 судлагдахууны үйл ажиллагааг танилцуулах | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | туршилтын эвент арга хэмжээг зохион байгуулж, олон нийтэд сурталчлан танилцуулсан. | |
| 54 | | 59. "Багш спорт", "Багш авьяас" арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 1 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 1 | “Багш авьяас” арга хэмжээг 12 сард зохион байгуулахаар төлөвлөсөн. Аймгийн Засаг даргын 2023 оны А/761 дүгээр захирамжаар Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “Хөдөөгийн багш нарын спортын XX наадам”-д оролцоход зориулж 7,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн ба 42 хүний бүрэлдэхүүнтэй баг, тамирчид амжилттай оролцсон. Сагсан бөмбөг, волейбол, даам, шагайн харваа, теннис зэрэг спортын 5 төрлөөр баг, тамирчдыг бэлтгэн оролцуулж, харилцан туршлага солилцон, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлсэн. Мөн багш нарын ур чадвар, авьяасыг дэмжин олон улс, улс, бүсийн уралдаан, тэмцээнд амжилттай оролцсон багш нар болон шавь нараа бэлтгэн амжилттай оролцуулсан нийт 12 багшид 9,5 сая төгрөгийн дэмжлэг, урамшуулал олгосон. “Багш дор мөргөмүй” багшийг алдаршуулах арга хэмжээг зохион байгуулж, боловсролын байгууллагад гэр бүлээрээ хамтран зүтгэсэн 8 ахмад багшид хүндэтгэл үзүүлж, багшийн багшийн шавь 14 багшийг алдаршуулсан. | 30% |
| 55 | | 60. Орон нутагт нэн шаардлагатай багш нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | Дэмжпэг үзүүлсэн багшийн тоо 9 | Дэмжпэг үзүүлсэн багшийн тоо | | 25 | "Алсын хараа-2050” Монгол улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлогын “Хөдөөгийн сэргэлт” зорилтын хүрээнд боловсролын үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах, шилдэг мэргэжилтнүүдийг Дорнын говь нутагтаа урин ажиллуулах, мэдлэг, чадвар, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Ирээдүйн төлөө” хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын шаардлагыг хангаж шалгарсан тул 5 жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласнаар 2 өрөө шинэ байрыг өөрийн болгох болзолтойгоор багш | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нарыг сонгон шалгаруулж, шалгуурт нийцсэн англи хэлний 4 багшийг урин ажиллуулж байна. Дуу хөгжмийн багшаар сурч байгаа 9 оюутанд тус бүр 4.0 сая төгрөг, нийт 20.0 сая, 10 оюутанд нийт 25.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. Мөн цэцэрлэгийн хөгжмийн багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлгийг байгуулж, харилцан туршлага солилцон хамтран ажиллах, МУБИС-ийн хөгжмийн тэнхимийн багш нарын “Хөгжим заах аргазүй”-н нэг өдрийн сургалтыг орон нутагт зохион байгуулан ажилласан. ЕБС-ийн 144 багш, удирдах ажилтан магистр зэрэгтэй ба 2023 онд магистрын хөтөлбөрт 10 багшийг хамруулсан. Нийт багшлах боловсон хүчний хангалтын хувь 2023 онд 90,5 байгаа нь өмнөх оноос 1,8 хувиар өссөн байна. Мөн 2020 онд 94.2 хувьтай байсан нь сургуулийн тоо цөөн байснаас хамаарч багшийн дутагдал бага байсан. Боловсрол, шинжлэх ухааны яам, Сургуулийн судалгаа хөгжлийн “Шинэ Монгол төв”-өөс 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх “Төрийн өмчийн сургуулийн менежментийг сайжруулах төсөл”, “Шинэ Монгол” сургуулийн сургалтын хөтөлбөрийг Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2, 6 дугаар сургууль, Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд хэрэгжүүлж, нийт багш нарыг чадавхжуулах сургалтад төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хамруулж байна. “Шинэ Монгол” сургуулийн сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэхэд аймгийн Засаг даргын 2023 оны А/628 дугаар захирамжаар 12,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Төсөл 1,5 жилийн хугацаанд хэрэгжих ба 2023 оны хэрэгжилт 100% байна. | |
| 56 | | 61. Их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж магистр | 2021 - 2024 | Хамтран ажилласан сургуулийн тоо 0, Магистр зэрэгтэй | Хамтран ажилласан сургуулийн тоо Магистр зэрэгтэй | | 2/6 | АШУҮИС-ийн Дорноговь дахь салбар сургуулийн 43 багшийн 98% нь магистр, Политехникийн коллежийн 43 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх | | багшийн тоо 54 | багшийн тоо | | | багшийн 46.5% буюу 20 багш магистр зэрэгтэй байгаа нь өмнөх оноос 2 хувиар өссөн. Сургуулийн өмнөх боловсролын 60 багш, удирдах ажилтан магистр зэрэгтэй ажиллаж байгаа бөгөөд зөвхөн энэ жил 15 багш, удирдах ажилтан магистрын хөтөлбөрт, 1 эрхлэгч докторантад шинээр элсэн суралцаж байна. ЕБС-ийн 144 багш, удирдах ажилтан магистр зэрэгтэй ба энэ онд магистрын хөтөлбөрт 10 багш хамруулсан. Мөн аймгийн "Политехник коллеж" нь "ХААИС", "ҮТИС", "Техник технологийн дээд сургууль"-тай хамтран ажиллаж багш, оюутнуудаа суралцуулах гэрээ байгуулсан. Мөн Глобал удирдагч их сургууль, Улаанбаатар их сургууль, Отгонтэнгэр их сургуульд ЕБС болон СӨБ-ын 4 багш магистрт суралцаж, нийт шинээр 39 багш, удирдах ажилтан магистр зэрэгтэй болохоор ажиллаж байна. “Гүүр” төсөл, хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж эхлээд байна. Төсөл, хөтөлбөрийн хүрээнд сум, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор Иххэт суманд “Оролцоонд суурилсан орон нутгийн стратеги төлөвлөгөө” боловсруулах ажил, сургалтын байгууллагын орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургууль, Политехник коллежийн лаборатори, практик сургалтын танхимыг сайжруулах төсөл болон гадаадын их, дээд сургуулиудын тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу орон нутагт эрэлттэй мэргэжлээр гадаадын их, дээд сургуульд суралцах хүсэлтэй 132 суралцагчийн судалгааг гаргасан. Судалгаан дээр үндэслэн хөтөлбөрийн хүрээнд тэтгэлэгт хамруулах үйл ажиллагааг 2024 оноос зохион байгуулахаар төлөвлөсөн. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | “Гүүр” төсөл, хөтөлбөр нийт 2 жилийн хугацаанд хэрэгжих ба 2023 оны төлөвлөгөө 90%-тай байна. | |
| 57 | | 72. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын танхимыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | Тоног төхөөрөмжөөр хангагдсан сургуулийн тоо 3 | Тоног төхөөрөмжөөр хангагдсан сургуулийн тоо | | 2 | Сайншанд сумын 2 ЕБС-д "ТИКА" олон улсын байгууллагын дэмжлэгээр сургуулийн урлаг заалны их засвар хийгдсэн. Дагалдах тоног төхөөрөмж болох 10 өнгийн гэрэл, 2 чанга яригч, 1 чадал, 1 өсгөгч худалдан авсан. Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургууль 5 төрлийн 6,1 сая төгрөгийн техник хэрэгсэл, биеийн тамирын спорт зааланд 7 төрлийн 9 ширхэг 7.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн. Мандах сумын ерөнхий боловсролын сургуульд чөлөөт бөхийн дэвжээ, сагсны бөмбөг 20 ширхэг, гар бөмбөг 20 ширхэг, хөл бөмбөг 10 ширхэг, теннисийн ширээ 1, модон морь, волейболын сетка, бөмбөгний сав, дасгалын бөмбөг, ханын шат, олс зэрэг нийт 11,3 сая төгрөгийн хэрэгцээт зүйл худалдан авсан. Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгт орон нутгийн хөгжлийн сангийн 19,9 сая төгрөгөөр гадна тоглоом, биеийн тамирын талбайн тохижилт хийгдсэн ба ерөнхий боловсролын сургуульд чөлөөт бөхийн 2 өмсгөл, 2 зодог шуудаг, 5ш сагсан бөмбөг, 9ш гар бөмбөг, 1ш онооны электрон самбар зэргийг худалдан авсан. Замын-үүд сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгт засаг даргын нөөц хөрөнгөөс 3,5 сая төгрөгийн биеийн тамирын багц тоглоом нийлүүлсэн. Мөн Сайншанд сумын ерөнхий боловсролын 6 сургуульд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 29,4 сая төгрөгийн биеийн тамирын иж бүрэн сагсны шийд худалдан авсан. Нөхөн хангалтын зардалд 2022 онд ерөнхий боловсролын 21 сургуульд 812,0 сая төгрөг, 2023 онд 835,0 сая төгрөг тус тус тусгагдсан ба зардал 23,0 сая төгрөгөөр нэмэгдсэн. 2020 онд урлаг, биеийн тамирын танхимыг | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангалт 60 хувьтай байсан бол 2023 онд 90 хувь хангагдсан. | |
| 58 | | 73. Насан туршийн боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэх шинэлэг арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 2 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 2 | Үндэсний бичгийн "Босоо бичиг бидний бахархал" цахим хуудас 5000 дагагчтай болсон нь мэдээ мэдээлэл, хичээл сургалтууд тогтмол хийгдэж байгаатай холбоотой юм.  Иргэдэд НТБ-ыг тэгш хүртээмжтэй хүргэх зорилготой иргэдийг сонирхлоор нь нэгтгэсэн "Бид жирэмсэн" залуу гэр бүлд зориулсан клуб, ээжүүдэд зориулсан "суралцагч ээж", үндэсний бичгийн "босоо бичиг бидний бахархал" клуб, англи хэлний "Lets learning English", хувь хүний хөгжлийн "Нарнаас урьтаж мандъя" клубууд байгуулан ажиллуулж байна. "Суралцагч иргэн-Суралцагч байгууллага-Суралцагч аймаг" уриатай үйл ажиллагаагаа явуулсан. Боловсролын нэгдсэн систем болох "Esis.edu.mn"-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нэмж бүртгэн өмнөх оны мөн үеэс 5 сурагчаар нэмэгдсэн. 2023 онд насан туршийн боловсролын төвийн болон нэгжийн багш нар үндсэн чиглэл болох амьдрах ухаан, гэр бүл гоо зүйн боловсрол, ёс зүйн төлөвшил, иргэний боловсрол, санхүүгийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, мэдээллийн технологийн чадвар олгох сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, үндэсний бичиг, англи хэлний сургалт, дүйцсэн хөтөлбөр, боловсрол нөхөн олгох зэрэг 201 нэр төрлийн сургалт, нөлөөллийн ажлыг төрийн албан хаагч, иргэд, сурагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нийт 23373 иргэнд явуулж ажилласан.  Үүнээс 0-18 насны 4840 хүүхэд, 18-55 насны 16803 иргэн, ахмад насны буюу 55-аас дээш насны 1730 иргэн хамруулжээ. | 90% |
| 59 | | 74. Насан туршийн боловсролын төвийн ажиллах нөхцөлийг сайжруулж, хөгжлийн | 2021 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | - | Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуульд 2022 онд нийт 30,4 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хөгжлийн бэрхшээлтэй | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтын танхим байгуулах | | | | | | хүүхдэд зориулсан тусгай хэрэгцээт хөтөлбөрийн хичээлийн танхимыг байгуулж, 2023-2024 оны хичээлийн жилд системд бүртгэлтэй 25 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас танхимаар 12 хүүхэд суралцаж байна. Энэ нь өмнөх оноос бүртгэл 4 хүүхдээр, танхимаар суралцагч 3 хүүхдээр нэмэгдсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, тэдэнд сурах таатай орчин бүрдүүлсэн Сайншандын 1-р сургуулийн тусгай хэрэгцээт хүүхдийн кабинетын үйл ажиллагааг тогтмолжуулсан. Сургалтыг мэргэжлийн 2 багш хичээллүүлж, 10 сурагч тогтмол суралцаж байна. Мөн Насан туршийн боловсрол төвөөс “Эрүүлжин хөгжих төв”-ийн 9 сурагчид сургалт  зохион байгуулж, багш нартай хамтран туршлага солилцон ажилласан. Хүүхэд бүрт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг гарын доорх материалаар хийн, сургалтад ашиглаж, бие бялдрыг чийрэгжүүлэх өрөөг тохижуулсан. | |
| 60 | 2.3.2. Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монголын түүх, хэл, соёл, ёс заншлаа мэддэг, эх орноороо бахархдаг төлөвшсөн ухаалаг иргэдийг бэлтгэх арга хэмжээг цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ. | 75. "Хутагтын нутгаар", "Торгон хил" сэдэвт болон бусад арга хэмжээг зохион байгуулж, оролцоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Хамрагдсан сурагчдын тоо 400 | Хамрагдсан сурагчдын тоо | | 1000 | Сурагчдад эх оронч хүмүүжлийг олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилготой “Торгон хил- Миний нутаг” орон нутгийн онцлогтой хөтөлбөрийн хүрээнд 14 сургуулийн 56 багш удирдлага, 776 сурагч, 37 эцэг эх нийт 869 хүнийг хамруулан зохион байгууллаа.  Өмнөх онд 42 сурагчийг хамруулан торгон хилээр аялж байсан бол энэ жил сумд, сургуулиуд зохион байгуулж 776 сурагч хамруулснаар 734 сурагчаар нэмэгдсэн. | 100% |
| 61 | | 76. Байгаль орчин, шинжлэх ухаан, танин мэдэхүйн олон талт арга хэмжээнд хүүхдүүдийг өргөнөөр хамруулан, орон нутгийн түүх, соёлыг таниулах | 2021 - 2024 | Хамрагдсан сурагчдын тоо 780 | Хамрагдсан сурагчдын тоо | | 900 | Монгол улсад Азийн физикийн 23-р олимпиадыг зохион байгуулах ажлын хүрээнд БШУЯ, БЕГ, ЕБС-иуд зэрэг 12 байгууллага хамтран “Физик танин мэдэхүйн” өдөрлөгийг зохион байгуулсан.  Тус өдөрлөгөөр багш, сурагчдад 2 өдөр 8 сэдвээр МУИС-ийн 4 доктор сургалт зохион байгуулан 70 багш, сурагч хамруулж физикийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хичээлийн туршилтуудыг 7 өртөөгөөр үзүүлэн, 1000 гаруй сурагч туршилтыг үзэж сонирхон, өөрсдөө туршилт хийсэн. “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Бага боловсролын эх хэл, математик чадварыг ахиулахад дэмжлэг болох зорилготой “Унших ба тоо бодох” чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаанд нийт 20 сургууль, бага ангийн сурагчдын хоцрогдлыг нөхөх, сурах идэвхийг нэмэгдүүлэх зорилготой “Тоглонгоо суралцья” хөтөлбөрт 4 сургууль хамруулж, "Стем" хэрэглэгдэхүүнийг ЕБС-н бага ангийн сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах чадварыг дэмжих, багш нарын шилдэг арга зүй туршлагыг илрүүлэн түгээн дэлгэрүүлэх зорилгоор үндэсний хэмжээнд зохион байгуулсан. “Бүтээлч багачууд,шилдэг арга зүй" уралдаанд төрийн өмчийн 20 сургуулийн 200 гаруй бага ангийн багш, 5000 гаруй сурагчид амжилттай оролцсон. Аймгийн төв музей, Данзанравжаагийн музей, аймгийн сүм хийд, кино театр зэргээр зугаалга хийж, олж мэдсэн зүйл, хүүхэд өөрийн санаа бодлоо зургаар илэрхийлэн бусдадаа тайлбарлан ярих, үзэсгэлэн гаргах, илтгэл тавих зэрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон. “Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтот хөтөлбөрийн хүрээнд сургууль, цэцэрлэгүүд “Орон нутгийн онцлогт тохирсон хүүхэд хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан 73 үйл ажиллагаанд 8436 хүүхдийг хамруулсан. | |
| 62 | 2.3.3. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг дэмжихүндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж сургуулиудыг үе шаттай | 77. “Үдийн хоол” арга хэмжээг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Үдийн хоол хөтөлбөрт хамрагдсан сургуулийн тоо 21 | Үдийн хоол хөтөлбөрт хамрагдсан сургуулийн тоо | | 23 | Ерөнхий боловсролын 10 сургууль түрээсийн гал тогоогоор, 12 сургууль дотуур байрны гал тогоонд хоол үйлдвэрлэлээ явуулж сурагчдад үйлчилж байна. Бага насны хүүхдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор Сайншанд сумын 1, 2, 9, 12-р | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | “Үдийн хоол” үйлчилгээнд шилжүүлэн, шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана | | | | | | | цэцэрлэг, Замын-Үүдийн 2, 4, 5, 6-р цэцэрлэг “Өдөр бүр 100 гр сүү” аяныг эцэг эхчүүдийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж хэвшсэн. “Хүүхдийн хоол” сэдэвт хэлэлцүүлгийг БШУГ, ХХААГ, ЭМГ хамтран цахим болон танхимаар зохион байгуулж 22 сургууль, 36 цэцэрлэгийн нийт 150 гаруй эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулсан. БЕГ, ШУТИС болон Монголын ложистикийн холбооны "Хүнсний хангамж"-ийн 5 төрлийн судалгаанд ЕБ-ын 22 сургуулийн 733 багш, 8623 эцэг эх хамруулсан. "Алсын хараа-2050" МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан чанартай амьдралын баталгаа, эрүүл монгол хүний суурь үндэс болсон хүүхдийн хоол хүнсний чанар, хүртээмжийг сайжруулах, хоол шим тэжээлийн боловсрол олгох нийгмийн олон талт асуудлыг шийдвэрлэх боломжийн хүрээнд зохион байгуулсан “Хүүхдийн хоол-Хөгжил" сэдэвт үндэсний чуулганд сургууль цэцэрлэгийн 10 тогооч, ЗДТГ болон БШУГ, ХХААГ, ЭМГ-ын 5 мэргэжилтэн оролцсон. БЕГ-аас эцэг эх, асран хамгаалагч, суралцагчдад зориулан хүүхдийн хоолны шим тэжээлийн талаарх боловсрол олгох нөлөөллийн аяныг сургууль цэцэрлэгүүд зохион байгуулсан. Мөн тогоочийн ур чадварыг сайжруулах, ажил мэргэжлийн онцлогийг олон нийтэд сурталчлах зорилготой тогооч нарын ур чадварын улсын уралдаанд сургууль цэцэрлэгийн 2 тогооч оролцон, 1 тогооч тусгай байрт шалгарсан. Ерөнхий боловсролын 22 сургуулийн бага ангийн 7800 гаруй хүүхэд үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна. Үдийн хоолны зардал нэг өдрийн 1500 төгрөг, дотуур байранд 745 хүүхэд хамрагдаж хоолны зардалд 4300 төгрөг, цэцэрлэгийн хүүхэд өдөрт 2475 төгрөгийн зардлаар хоол | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үйлдвэрлэлийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж, сургууль цэцэрлэгтээ авбал зохих хоолны илчлэг нормоо авч байна. | |
| 63 | | 78. Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах | 2021 - 2024 | Гал тогооны тоног төхөөрмж сайжруулсан сургуулийн тоо 3 | Гал тогооны тоног төхөөрмж сайжруулсан сургуулийн тоо | | 3 | БШУЯ-ны санхүүжилтээр 2,9 сая төгрөгийн өртөг бүхий 4 ширэмтэй шарах шүүгээг Айраг сумын сургуульд, Боловсролын ерөнхий газрын санхүүжилтээр 15,3 сая төгрөгийн өртөг бүхий 7 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмжийг Зүүнбаянгийн ерөнхий боловсролын сургуульд тус тус нийлүүлсэн. Сайншанд сумын хүүхдийн 12 дугаар цэцэрлэг, Замын-Үүд сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгүүд нөхөн хангалтын зардлаас 3,7 сая төгрөгийн өртөг бүхий гал тогооны хэрэгсэл, Улаанбадрах, Замын-Үүд сум тус тус нэн шаардлагатай тоног төхөөрөмж, худалдан авсан. Улаанбадрах сумын хүүхдийн цэцэрлэгт 5,3 сая төгрөгийн 5 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмжийг "Бадрах энержи" компани тусламжаар олгосон. Сайншанд сумын ЕБ-ын 1, 2, 3, 5, 6-р сургууль, Замын-Үүд сумын ЕБ-ын 1, 2-р сургууль, Иххэт, Дэлгэрэх сумдын сургуулиудад гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх шаардлага үүссэн тул аймгийн 2024 оны аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд санал оруулсан ба Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтын газарт холбогдох саналыг хүргүүлж ажилласан. 2022 онд 41,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байсан бол 2023 онд 27,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, гүйцэтгэл 70%-тай байна. Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийн хангалт 2020 онд 50,0 хувьтай байсан ба 2023 онд 65,0 хувьтай байна. 2023 онд 5 сургууль, 3 цэцэрлэгт нийт 28,2 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн. | 100% |
| 64 | | 79. Ерөнхий боловсролын | 2021 - 2024 | Ундны усны шүүлтүүр | Ундны усны шүүлтүүр | | 4 | Ерөнхий боловсролын 22 сургууль, 33 цэцэрлэг буюу нийт 55 байгууллагууд | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургуулиудыг ундны усны шүүлтүүрээр хангах | | сайжруулсан тоо 4 | сайжруулсан тоо | | | 64 ширхэг ундны усны шүүлтүүртэй бөгөөд Зүүнбаян багийн Ерөнхий боловсролын сургуульд 2 ширхэг ус цэвэршүүлэгчийг Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтын газраас олгосон. Бүх сургууль, цэцэрлэгийн анги танхимууд цэвэр ус уух нөхцөлөөр бүрэн хангагдсан. | |
| 65 | | 2.3.3.1. Сургууль, цэцэрлэг бүрт орон нутгийнхаа онцлогт тохирсон хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | Боловс руулсан хөтөл бөрийн тоо | | | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтод хөтөлбөрийн хүрээнд 22 ЕБС, 33 цэцэрлэг "Орон нутгийн онцлогт тохирсон" хөтөлбөрүүдээр хүүхэд хөгжлийг дэмжин ажиллаж байна. СӨБ-ын байгууллагууд "Говийн хөрс”, “Бяцхан ногоон төгөл”, “Цэмцгэр ногоон төгөл” “Миний нутгийн бахархал” , “Хутагтын говийн хүүхдүүд”, "Эко цэцэрлэг" "Бүтээлч ногоон цэцэрлэг" " Хөдөлмөрөөр хүмүүжье”, “Мнийн нутгийн бахархал зэрэг онцлог хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж хичээлийн жилийн үндсэн хөтөлбөрийн агуулгын хүрээнд засан сайжруулж ажиллаж байна. Орон нутгийн түүх соёлыг таниулах зорилгоор аймгийн төв музей, Данзанравжаагийн музей, аймгийн сүм хийд, кино театр зэргийг экскурс зугаалга хийж, олж мэдсэн зүйл болон өөрийн санаа бодлоо зургаар илэрхийлэн бусдадаа тайлбарлан ярих, үзэсгэлэн гаргах, илтгэл тавих зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж тайланг эцэг эхэд танилцуулсан. ЕБС-иуд орон нутгийн онцлогт хөтөлбөрийн хүрээнд "Нутаг сэтгэл", "Бид хутагтын үр сад", “Миний нутаг бидний бахархал", "Шинэ зууны малчин", “Миний нутгийн бахархал","Босоо бичигтэн”, “Монгол гэр” хөтөлбөрүүдийн хүрээнд “Малчны хотонд” үйл ажиллагаа, Их нартын тусгай хамгаалалттай газартай танилцах аялал, Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газраар аялж, нутаг орноороо бахархах, амьтдыг | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хайрлах сэтгэлгээг багаас нь төлөвшүүлж, мөн Саранхөхөө театрын туурь, энергийн төвтэй танилцаж, түүх өв соёлоосоо суралцахаас гадна Хамарын хийд орчмын хогийг цэвэрлэж байгальд ээлтэй аялах дадалд суралцлаа. | |
| 66 | 2.3.4. Цахим засаг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн -Цахим сургалтыг хөгжүүлэхэд багш нарын оролцоог дэмжиж, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ. | 80. Цахим сургалтыг хөгжүүлэх бүх талын арга хэмжэзг авч багш, суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо-2 Нийлүүлсэн компьютерийн тоо 135 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо Нийлүүлсэн компьютерийн тоо | | 2/50 | Замын-Үүд сумын ЕБ-ын 3-р сургууль "Andriod8 ISO" ухаалаг үйлдлийн системтэй "TINK" аппликейшн бүтээж, 1281 сурагч, 2100 эцэг эх, 65 багш хичээл сургалтын үйл ажиллагаанд тогтмол ашиглаж байна. "Medle.mn" цахим сургуулийн 10-р ангид 12 судлагдахуунаар 9 сургуулийн 154 сурагч, 11-р ангид 13 судлагдахуунаар 7 сургуулийн 82 сурагч хамруулан суралцаж байна. Дизайн технологийн судлагдахууны багш нар мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллаж аймгийн хэмжээний дээд эрэмбийн сэтгэх чадварыг хөгжүүлэх цахим даалгаврын сантай болсон. Даалгаврын санд 6-12-р ангийн дизайн технологийн хичээлийн 1317 даалгавар, 6-8-р ангийн дүрслэх урлагийн хичээлийн 816 даалгаврын боловсруулан байршуулж, багш нар болон сурагчид тогтмол ашиглаж байна. Сургалтын цахим орчныг сайжруулах үүднээс нөхөн хангалтын зардлын 835,4 сая төгрөгийн өртгөөр 22 сургуульд 188 багшийн зөөврийн компьютер, 10 интернэтийн дэд бүтцийн тоног төхөөрөмж, 9 сургуулийн удирдлагын цахим системийг /LMC/ худалдан авсан. Орон нутгийн төсвийн 854,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 20 сургуулийн 254 багшийг шинээр зөөврийн компьютероор хангасан. Цахим сургалтыг хөгжүүлэх ажлын хүрээнд "Mobicom" Корпорацаас хэрэгжүүлж буй "Smart education 3" төсөлд Сайншанд сумын 1 дүгээр сургууль хамрагдан 121,0 сая төгрөгийн өртөг бүхий “Дижитал анги”-тай болсон. Дижитал ангитай | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | болсноор "PEARSON ENGLISH", "EDUTEN MATHEMATICS" платформуудаар дамжуулан англи хэл, математикийн хичээлүүдийг үзэх, 8-р ангийн физикийн хичээлийг "VR" төхөөрөмжөөр виртуал орчинд үзэх, "VR" контентуудыг хичээлтэйгээ уялдуулан үзэх, "medle.mn" платформыг хичээл дээрээ ашиглах, мэдээлэл технологийн хичээлийг 1-р ангиас заах, сургууль тус бүр дээр "IT" клуб байгуулах зэрэг олон талын үр дүнтэй ажлууд зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуульд нийт 3 төрлийн цахим системийг 200 орчим багш, 7200 гаруй суралцагч, 7000 гаруй эцэг эх ашиглаж байна. | |
| 67 | | 83. Зарим сургуулийг цахим сургууль болгох, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | Жишиг цахим сургуулийн тоо 2, Тоног төхөөрөм жийн хангалтын хувь 60 | Жишиг цахим сургуулийн тоо Тоног төхөөрөм жийн хангалтын хувь | | - | Орон нутгийн төсвийн 854.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 20 сургуулийн 254 багшийг шинээр зөөврийн компьютертэй болгосон. Цахим сургалтыг хөгжүүлэх ажлын хүрээнд "Mobicom" Корпорациас хэрэгжүүлж буй "Smart education 3" төсөлд Сайншанд сумын 1-р сургууль хамрагдан 121 сая төгрөгийн өртөг бүхий “Дижитал анги”-тай болсон. Дижитал ангитай болсноор "PEARSON ENGLISH", "EDUTEN MATHEMATICS" платформуудаар дамжуулан англи хэл, математикийн хичээлүүдийг үзэх, 8-р ангийн физикийн хичээлийг "VR" төхөөрөмжөөр виртуал орчинд үзэх, "VR" контентуудыг хичээлтэйгээ уялдуулан үзэх, "medle.mn" платформыг хичээл дээрээ ашиглах, мэдээлэл технологийн хичээлийг 1-р ангиас заах, сургууль тус бүр дээр "IT" клуб байгуулах зэрэг олон талын үр дүнтэй ажил зохион байгуулсан. Нөхөн хангалтын зардалд 2022 онд ерөнхий боловсролын 21 сургуульд 812 сая төгрөг, 2023 онд 835 сая төгрөг тус тус тусгагдсан бөгөөд 2020 онтой харьцуулахад тоног төхөөрөмжийн нөхөн хангалт 100%-ийн гүйцэтгэлтэй байна. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 68 | 2.3.5. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшин, хэрэглэж хэвшинэ. | 84. “Миний монгол хэл, бичиг- 2025” зорилтод төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 8 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 15 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/733 дугаар захирамжаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус орон нутгийн салбар зөвлөлийг мэргэжлийн байгууллагын 7 гишүүнтэй шинэчлэн байгуулсан. Төлөвлөгөөний дагуу аймгийн төрийн албан хаагчдаас монгол бичгийн түвшин тогтоох сорил авч, үндэсний бичгийн цахим бичвэр боловсруулах сургалтад 90 гаруй төрийн байгууллагын 380 албан хаагчийг танхимаар, 14 сумын төрийн байгууллагын 100 гаруй албан хаагчийг цахимаар тус тус хамруулсан. Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлөөс Сайншанд сумын төрийн 33 байгууллагын архив, бичиг хэргийн 34 ажилтанд монгол бичгийн цахим бичвэрийн давтан сургалт, “Хамтдаа судалъя, хөгжье” үйл ажиллагааг 22 сургууль, 33 цэцэрлэгийн 1500 гаруй багш, “Сүегэр” уран бичлэгийн уралдаанд 27 багш, 23 сурагчийн бүтээл, 6-12-р ангийн үндэсний бичгийн “Анги хамт олны олимпиад”-ыг 3 үе шаттайгаар зохион байгуулж 267 бүлгийн 7377 сурагч оролцсон. “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг угтан сургууль бүр өөрийн онцлогтоо тохируулан багш, сурагч, эцэг эх, иргэдийг хамарсан 20 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Төлөвлөгөөнд 4 чиглэлийн 10 үйл ажиллагаа тусгасан ба хэрэгжилт 90 хувийн гүйцэтгэлтэй байна. | 90% |
| 69 | | 85. Монгол хэл, бичгийн улсын олимпиадыг орон нутагт зохион байгуулах | 2022 - 2024 | - | Зохион байгуулсан олимпиадын тоо | | - | Д.Равжаагийн мэндэлсний 220 жилийн ойг угтсан ажлын хүрээнд Монгол хэл, бичгийн улсын олимпиадыг 2023 онд орон нутагт зохион байгуулах талаарх саналыг Боловсрол шинжлэх ухааны яам, Монгол Улсын боловсролын их сургуулийн Монгол хэлний олимпиадыг зохион байгуулах дэд хороотой зөвлөлдөж, саналыг хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын 2023 оны А/733 дугаар захирамжаар | 30% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус орон нутгийн салбар зөвлөл”-ийг мэргэжлийн байгууллагын 7 гишүүнтэй шинэчлэн байгуулсан. Зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байгаа ба 2024 онд “Монгол хэл, бичгийн улсын олимпиад”-ыг аймагтаа зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. | |
| 70 | | 86. Иргэдэд зориулсан үндэсний бичгийн танхимыг сургуульд түшиглэн байгуулах | 2021 - 2024 | Танхимын тоо 3 | Танхимын тоо | | 2 | Хэлний бодлогын үндэсний зөвлөл аймгийн нийт төрийн албан хаагчдаас монгол бичгийн түвшин тогтоох сорил авч, үндэсний бичгийн цахим бичвэр боловсруулах сургалтад 90 гаруй төрийн байгууллагын 380 албан хаагчийг танхимаар, 14 сумын төрийн байгууллагын 100 гаруй албан хаагчийг цахимаар, 33 байгууллагын архив, бичиг хэргийн 34 ажилтанд монгол бичгийн цахим бичвэрийн давтан сургалтыг тус тус зохион байгуулсан. Мөн иргэдийн монгол бичгийн мэдлэг чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 20 цуврал хичээл, нутгийн зохиолчдын бүтээл, онч мэргэн үгс, сургаалын зохиол, монголын сонгодог яруу найргийн 70 гаруй хөрвүүлэг бэлтгэж, "Босоо бичиг-Бидний бахархал" группэд байршуулан бүлгэмийн 4899 гишүүдэд түгээсэн. Насан туршийн боловсролын төв, сумдын насан туршийн боловсролын нэгжийн сургалтын танхимд үндэсний бичиг, үсгийн чиглэлээр иргэд болон төрийн албан хаагчдын дунд түргэн уншлага, хүмүүн бичиг сонины захиалга, уншлага, сургалт, тэмцээн, уралдаан, арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж, 34 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 8000 гаруй хүнийг хамруулсан. Хатанбулаг, Мандах суманд үндэсний бичгийн танхимыг орон нутгийн 30,0 сая төгрөгийн төсвөөр байгуулан, Сайншанд, Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын сургуульд | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | түшиглэн үндэсний бичгийн 8 танхим тогтмол сургалт үйл ажиллагаагаа явуулж байна.  Төлөвлөгөөнд 4 чиглэлийн 10 үйл ажиллагаа тусгасан ба хэрэгжилт 90 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 71 | | 70. Зарим сумдад сургуулийн барилгыг шинээр барьж, сургууль, цэцэрлэг, дотуур байрны засвар үйлчилгээг хийнэ. | 2021 - 2024 | | | | | Боловсролын салбарт улс, орон нутгийн төсвийн 20,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 2 сургуулийг шинээр ашиглалтад оруулан, 5 сургууль, 3 цэцэрлэг, 2 дотуур байранд засвар хийж, ерөнхий боловсролын 17 сургуульд 10 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр ханган ажиллалаа.  Улсын төсвийн 17,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 1 дүгээр багт 320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилгын ажлыг "Жинсийн орой" ХХК, Хатанбулаг суманд 320 хүүхдийн сургуулийн барилгыг “Ньюконстракшн” ХХК барьж гүйцэтгэн, ашиглалтад хүлээлгэн өгсөн. Орон нутгийн төсвийн 2,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын   ЕБ-ын 1 дүгээр сургуулийн гадна дулаан, цэвэр усны шугамын засвар, 3 дугаар сургуулийн спорт заалны гадна фасадны засвар,  Айраг сумын ЕБС-ийн 1-р байрны их засвар, ын Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр, спорт заалны сантехник, цахилгааны засвар, урлаг заалны засвар, Зүүнбаян багийн ЕБС-ийн дотор халаалтын системийн засварын ажлуудыг тус тус бүрэн гүйцэтгүүллээ. Орон нутгийн төсвийн 247.1 сая төгрөгийн төсөвт өртгөөр Дэлгэрэх сумын Хүүхдийн цэцэрлэгийн засвар, Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн гадна фасадны засвар, Хөвсгөл сумын цэцэрлэгийн дээврийн засварын ажлуудыг гүйцэтгүүллээ. Орон нутгийн төсвийн 387,1 сая төгрөгийн төсөвт өртгөөр Хөвсгөл сумын ЕБС-ын дотуур байрны засвар, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Өргөн сумын ЕБС-ийн дотуур байрны дээвэр, гадна фасадны засварын ажлыг тус тус гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авсан. | |
| 72 | 2.3.6. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд мэргэжпийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог өргөжүүлнэ. | 87. Политехникийн коллеж болгох асуудлыг судалж шийдвэрлэх | 2021 - 2024 | - | Коллежийн тоо | | - | ХНХЯ-ны сайдын 2021 оны 05-р сарын 13-ны өдрийн А/68 тоот "Ангилал шинэчлэн тогтоох тухай" тушаалаар Политехник коллеж болсон. Политехникийн коллежид 2023-2024 оны хичээлийн жилд 20 мэргэжлийн 560 суралцагчийн элсэлтийн квот батлуулснаас 17 мэргэжлийн 465 суралцагч элсүүлэн нийт 804 суралцагчтай үйл ажиллагаа явуулж байна.  Суралцагч оюутнууд үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагыг тогтмол хийж хэвшсэн ба төрийн 19 байгууллагад 28, 101 аж ахуй нэгжид 240, иргэний ажлын байранд 83 суралцагч дадлага хийсэн. Төгсөгчдөд хөдөлмөр халамж үйлчилгээний газрын ажлын зар болон үйлдвэрлэлийн дадлага хийсэн газарт ажил олгогчийн захиалгаар ажилд зуучилдаг ба энэ жилд 277 суралцагч төгссөнөөс 156 суралцагч буюу 57 хувь нь ажлын байртай төгссөн. | 100% |
| 73 | | 88. Багшлах хүний нөөцийг нэмэгдүүлж чадавхжуулах | 2021 - 2024 | Багшийн тоо 30 | Багшийн тоо | | 40 | Орон нутагт дутагдалтай байгаа дуу хөгжмийн багш мэргэжлээр сурч байгаа 5 оюутанд тус бүр 4.0 сая төгрөг нийт 20.0 сая, 10 оюутанд нийт 25.0 сая төгрөгийн буюу орон нутгаас нийт 45.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.  Орон нутагт чадварлаг боловсон хүчнийг татах, багшлах боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор Түрээсийн орон сууц хөтөлбөрийн 1 дүгээр ээлжинд сургуулийн 16, цэцэрлэгийн 15 багшийг хамруулж, Аймгийн Нутгийн зөвлөлтэй хамтран Улаанбаатар хотоос өндөр ур чадвартай 6 багшийг орон нутагт урин, 5 жил тогтвор суурьшилтай ажиллуулахаар гэрээ байгуулан, тус бүр 45-54 мкв орон сууцаар үнэ төлбөргүй хангасан.  "Боловсролын | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ерөнхий газар”-аас зохион байгуулсан мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад гадаад хэл, мэдээллийн технологи, түүх, нийгмийн ухаан, биологийн судлагдахууны 5 багш хамрагдаж, батламж авсан. 2022 онд 1 багш, 2023 онд 3 багш багшлах эрхийн сургалтад хамрагдаж, сургах зүйн чадамж эзэмшсэн. Политехникийн коллежид 2023 онд 43 үндсэн багш ажиллаж байгаа нь өмнөх оноос 10 багшаар нэмэгдсэн. Нийт багшлах боловсон хүчний хангалтын хувь 2023 онд 90,5 хувь байгаа нь өмнөх оноос 1,8 хувиар өссөн байна. Мөн 2020 онд 94.2 хувьтай байсан нь сургууль, цэцэрлэгийн тоо цөөн байснаас хамаарч багшийн дутагдал бага байсан. | |
| 74 | 2.3.7. Орон нутагт мэргэжил сургалт,үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд сургуулиудын үйл ажиллагааг дэмжиж, оюутны сургалтын төлбөрийн дэмжпэг үзүүлнэ. | 89. Орон нутагт сургалтын үйл ажиллагаа явуулдаг их дээд сургуулиудад шаардлагатай мэргэжлээр сурах оюутнуудад төлбөрийн дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | Тэтгэлэг олгосон оюутны тоо 24 | Тэтгэлэг олгосон оюутны тоо | | 30 | Даланжаргалан сумын ЗДТГ, Уул уурхайн компаниудтай хамтран орон нутгийн харьяалалтай 51 оюутны 200.0 гаруй сая сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэг олгосон. АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн эх баригчийн ангийн 11, их эмчийн ангийн 3, эм найруулагч 16 нийт 30 оюутныг төгсөөд орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээ байгуулан сургалтын төлбөр болох 23,0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас олгосон. Анагаах ухааны сургуульд 14 хүнийг “Эх барихуй” мэргэжлээр сургаж төлбөрийг бүрэн шийдвэрлэж ажилласан. "Дезерет солар пауэр ван" ХХК нь ШУТИС-ийн дулааны эрчим хүчний чиглэлээр суралцаж буй 1 оюутанд 3 жилийн 100 хувийн сургалтын төлбөр олгосон. "Дашвааанжил" ХХК-аас Энэтхэг улсад газрын тосны мэргэжлээр суралцах 5 оюутанд сургалтын төлбөрийг 100 хувь олгохоор болсон. Гадаад харилцааг өргөжүүлэх “Гүүр” төслийг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | аймгийн хэмжээнд хэрэгжүүлж эхлэн Политехник коллеж, АШУҮИС-иудад шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмжийн худалдан авахад аймгийн Засаг даргын захирамжаар 40,0 сая төгрөгийн санхүүжилтийгологн дэмжлэг үзүүлсэн.  Уг төслийн хүрээнд гадаадын их, дээд сургуульд эрэлттэй мэргэжлээр суралцах хүсэлтэй 132 суралцагчийн судалгааг гаргаж тэтгэлэгт хамруулах үйл ажиллагааг 2024 оноос зохион байгуулахаар төлөвлөсөн.  Орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэжлээр суралцаж буй 97 оюутанд нийт 176,6 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. | |
| 75 | | 90. Орон нутагт их, дээд сургуулийн салбар байгуулах үйл ажиллагааг дэмжинэ. | 2023 - 2024 | - | Сургуулийн тоо | | 1 | Аймгийн ЗДТГ-аас “Дабльфиш” ХХК-ийн дэргэдэх Төмөр замын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан нийт 6 мэргэжлээр 265 оюутан суралцуулж байна.  Үүнд: Вагон үзэгч засварчин 17, Зүтгүүрийн туслах машинч 53, Төмөр замын замчин 60, Өртөөний жижүүр 65, Ачаа вагон хүлээлцэгч 66, Дохиолол төвлөрүүлэлт холбооны монтёр 4 байна.  Отгонтэнгэр их сургууль, Засагт хан дээд сургууль, Глобал удирдагч зэрэг их дээд сургуулиудтай хамтран багшийг ажлын байрандаа хөгжих боломжийг олгож, төлбөрийн уян хатан нөхцөлтэйгөөр сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай мэргэжлүүдээр бакалавр, магистрын эчнээ ангийн хөтөлбөрт багш нар онлайнаар хамрагдаж байна. | 90% |
| 76 | 2.4.1. Шинжлэх ухаан технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүх төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг орон нутгийн нийгэм, эдийн засагт өгч байгаа үр | 91. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий бүх төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих | 2021 - 2024 | - | Эрдэм шинжилгээний ажлын тоо | | 3 | "Ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг угтан хутагтын дагнасан судалгаа эрхэлдэг эрдэм шинжилгээний ажилтнууд, судлаачдыг оролцуулсан “Ноён хутагтын өв: өнгөрсөн, одоо, ирээдүй” Олон улсын эрдэм шинжилгээний хурал”-ыг зохион байгуулж, 5 орны 35 эрдэмтэн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өгөөжийг шалгуур болгон дэмжинэ. | | | | | | | судлаач оролцсон. Мөн “Адистэд хурсан гайхамшиг” тусгай үзэсгэлэн гаргаж ноён хутагтын музейн 130-аад үзмэр, эд өлгийн зүйлс дэлгэн олны хүртээл болгосон. “Эгшиглэнт говь” багц арга хэмжээг зохион байгуулж соёлын бүтээлч үйлдвэрлэл, гар урлал, инновац шингэсэн бүтээлүүд шалгаруулах бие даасан 14 удаагийн үзэсгэлэнг зохион байгуулсан. Мөн “Ноён хутагт Данзанравжаагийн яруу найргийн цоморлиг” хэмээх хутагтын Монгол, Төвөд хэлээр зохиосон 220 гаруй дуу, шүлэг, сургаал, жижиг үзэгдлийн хэлбэртэй зохиолуудыг эмхэтгэсэн хоёр дэвтэр бүхий ном, “Хутагтын нутгийн өв” хэмээх хутагтын өлгий нутаг дахь түүх, соёлын онцлох өв, музейн шилдэг үзмэрийн дээжис, түүх археологи, угсаатны талаарх судалгааны баримтуудыг мэргэжлийн гэрэл зургаар харуулсан өргөн агуулгатай мэдээллүүдийг тусгасан нэвтэрхий толийг эмхлэн гаргасан. Шинжлэх ухаан, технологи, инновацын үндэсний хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг багаар ажиллуулах, өөрсдийн зохион бүтээсэн төхөөрөмжөөр даалгавар гүйцэтгүүлэх, шингэний даралт, хөшүүргийн хүчний тухай онолын ойлголтыг техникт хэрхэн ашигладаг болохыг туршин хэрэглэх, програмчлалын ач холбогдлыг ойлгуулах зэргээр сурагчдын инженер сэтгэлгээ, зохион бүтээх чадварыг хөгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны А/729 дүгээр захирамжаар “Дорноговь робот-2023” Улсын аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг 2023 онд Миниробот зохион бүтээх, Ардүюно робот зохион бүтээх гэсэн 2 төрлөөр зохион байгуулж, 7 аймаг, нийслэлийн 2 дүүргийн 19 багийн 218 хүүхэд, 31 багш оролцсон. Тэмцээнд 19,1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 77 | 2.5.1. Нийгмийн даатгалын шинэчлэлийг хэрэгжүүлж, хамрах хүрээг өргөтгөж, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлнэ. | 92. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагыг бодитой төлөвлөх | 2021 - 2024 | Төлөвлөгөөний биелэлт 100% | Төлөвлөгөөний биелэлт | | 100% | Нийгмийн даатгалын санд 50911.4 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 51878.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 101.9 хувиар биелүүлж ажилласан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийгмийн даатгалын сангийн орлого 30,53 хувиар өссөн. Нийгмийн даатгалын сангийн зардал 63498.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөгдсөнөөс 60237.2 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 5.1 хувийн хэмнэлт гаргаж, зардлын хэтрэлтгүй ажилласан. Нийгмийн даатгалын сангаас 17806 иргэнд 68084,4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгосон. Тэтгэврийн даатгалын сангаас 10095 иргэнд 60867,5 сая төгрөгийг, тэтгэмжийн даатгалын сангаас 6846 иргэнд 3922,3 сая төгрөгийг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 181 иргэнд 852,2 сая төгрөгийг, ажилгүйдлийн даатгалын сангаас 684 иргэнд 2442,4 сая төгрөгийг тус тус олгосон. | 100% |
| 78 | | 93. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч болон даатгуулагчийн тоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Ажил олгогч- 697 Даатгуулагчийн тоо- 19638 | Ажил олгогч Даатгуулагчийн тоо | | 896 21468 | Шимтгэл төлөгч, ажил олгогчийн тоо 817 байна. 2023 онд шинээр 60 ажил олгогчийг шимтгэл төлөгчөөр бүртгэхээр төлөвлөснөөс 101 ажил олгогч хамруулж, гүйцэтгэл 168 хувь байна. 2022 онд 19638 иргэн нийгмийн даатгалд хамрагдсан байсан бол энэ онд 23960 даатгуулагчийг хамруулсан. 2023 онд шинээр 1435 даатгуулагчийг хамруулснаас албан журмын даатгалд 1051 иргэн шинээр бүртгэж, сайн дурын даатгалд 384 иргэн шинээр гэрээ байгуулсан бол үүнээс 115 нь малчид байна. 2022 онд 736 ажил олгогч байсан бол энэ онд 817 болж 81 ажил олгогчоор, 22626 даатгуулагчтай харьцуулбал 23960 болж 1334-р тус тус нэмэгдсэн. 2020 оны ажил олгогчоос 149, даатгуулагчаас 1761-р нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 79 | | 94. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх бүх талын арга хэмжээ авах | 2021 - 2024 | Орлогын биелэлт 100% | Орлогын биелэлт | | 100% | Улсын байцаагчийн албан шаардлага 21 байгууллагад хүргүүлж 16 байгууллагаас 169.80 сая төгрөг, Графикийн дагуу төлөх гэрээг 5 байгууллагатай байгуулж, 2 байгууллагын данс зарлагын гүйлгээг түр зогсоож 2 байгууллагын 24.4 сая төгрөг, Сум дундын шүүхийн эвлэрүүлэн зуучлахад хандан 10 байгууллагын 38.5 сая төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд 6 байгууллагыг шилжүүлж, 11.0 сая төгрөгийн авлагыг тус тус барагдуулж ажилласан. Нийгмийн даатгалын санд 50911.4 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 51878.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 101.9 хувиар биелүүлж ажилласан. | 100% |
| 80 | 2.5.2. “Цахим нийгмийн даатгал” арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулж иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй болгоно. | 95. Нийгмийн даатгалын үйл ажиллагааг цахимжуулан, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод шуурхай хүртээмжтэй болгох | 2021 - 2024 | Цахимжуулсан үйлчилгээний тоо-5 | Цахимжуулсан үйлчилгээний тоо | | Цахимжуулсан үйлчилгээний тоо | Монгол улсын Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 194 дүгээр тогтоолоор “Нийгмийн халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам” батлагдсан. Нийгмийн халамжийн үйлчилгээ нь 2020 оны 08 дугаар сараас эхлэн үе шаттайгаар цахим системд шилжсэн бөгөөд 2020 онд 5 төрлийн үйлчилгээ, 2021 онд 21 нэр төрлийн үйлчилгээ, 2022 онд 38 нэр төрлийн үйлчилгээ, 2023 онд 2 нэр төрлийн үйлчилгээ нэмэгдэж нийт нийгмийн халамжийн 66 нэр төрлийн үйлчилгээний хүсэлтийг цахимаар хүлээн авч байна. Дээрх үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ 2021 онд 3162 иргэн, 2022 онд 13447 иргэн, 2023 онд 10925 иргэн гаргасныг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн. Үүнээс гадна “И-Монголия” системд 4 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг оруулсан. Тайлант хугацаанд нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, тусламж хөнгөлөлтийг 24502 иргэнд 10,321.0 сая төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 26651 хүүхдэд 26,161.5 сая төгрөг тус тус олгосон. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 81 | | 96. Нийгмийн даатгалын архивын баримтыг бүрэн цахимжуулах | 2021 - 2024 | 0 | Цахимжуулалтын хувь | | 75% | Нийгмийн даатгалын хэлтсийн архивт хадгалагдаж байгаа 318 нэгжийг хуудас бүрээр нь "SICOS.ndaatgal.mn" программд бүрэн оруулсан. Энэ нь цаасан баримт шүүхгүйгээр лавлагаа гаргаж байгаа нь ажлын цаг ашиглалтыг хэмнэж байна. Мөн дотоод цахим сүлжээ болон "Able" программаар бусад аймаг, дүүргүүдтэй харилцаж аймаг дүүргүүдийн иргэдийн лавлагааны хүсэлт, лавлагааны хүсэлтийн хариуг өгч, авч ажилласан. Иргэд лавлагаа авахдаа "Local.ndaatgal.mn" программаас нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолтыг QR кодтойгоор гаргаж, 621 лавлагаагаар иргэдэд үйлчилсэн. | 100% |
| 82 | 2.5.3. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан, цахим системд үе шаттай шилжүүлнэ. | 97. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахим системд шилжүүлэх | 2021 - 2024 | 0 | Цахимжуулалтын хувь | | 75% | Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 194 дүгээр тогтоолоор “Нийгмийн халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам ” батлагдсан. Журмын хэрэгжилтийг хангуулахаар 2020 оноос хойш үе шаттайгаар цахим системд нэвтрүүлж байна. 2023 оны 10 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн 66 нэр төрлийн үйлчилгээг цахимжуулсан бөгөөд үйлчилгээнд хамрагдахаар 10739 иргэн хүсэлт гаргасныг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн. 2022 оны жилийн эцэст 64 нэр төрлийн үйлчилгээний хүсэлтийг цахим системээр хүлээж авч байсан бол тайлант онд 2 үйлчилгээг цахимд нэмж шилжүүлсэн бөгөөд хүсэлт гаргасан иргэдийн тоо 20.4%-р буурсан. | 90% |
| 83 | | 98. Хөдөлмөр эрхлэгчдийн орон нутгийн цахим бүртгэлийн мэдээллийн санг байгуулах | 2022 - 2024 | 0 | Цахим бүртгэлийн мэдээллийн сангийн тоо | | - | Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 194 дүгээр тогтоолоор “Нийгмийн халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам” батлагдаж журмын хэрэгжилтийн хүрээнд нийгмийн халамжийн 72 нэр төрлийн үйлчилгээнээс 66 үйлчилгээ буюу | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 91,6%-ийг цахимжуулсан. Тус үйлчилгээний үр дүнд 10739 иргэн хүсэлт гаргасныг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн.EJOB хөдөлмөр эрхлэлтийн цахим системд 247 ажил олгогч, 1324 ажлын байрны захиалга, 1427 ажил хайгч иргэн, 1208 шинээр бий болсон ажлын байр бүртгэгдэж, 1169 иргэн ажилд зуучлагдсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн цахим бүртгэлийн систем "ejob" платформын бүртгэлээс орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд Gobi cinema, Ахмадын сувилалын газар, "Саран хөхөө" театрын барилга, "Мандах наран-5" хорооллын барилгын ажил зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлуудад "Элит конкрет" ХХК, "Энержи парагон" ХХК, "Болор аграмба" ХХК зэрэг байгууллагуудын байнгын ажлын байранд 159 иргэнийг зуучлан ажлын байраар хангасан. | |
| 84 | | 99. Өрхийн амжиргааны түвшин тогтоох судалгааны чанарыг сайжруулж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот эзэнд нь хүргэх | 2021 - 2024 | 23448 иргэнд, 7,4 тэрбум | Нийгмийн халамжийн үйлчилгээ зорилтот иргэнд хүрсэн | | Нийгмийн халамжийн үйлчилгээ зорилтот иргэнд хүрсэн | Аймгийн Засаг даргын 2023 оны А/362 дугаар захирамжаар судалгаа хийх ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 14 сумын 478 өрхийг бүрэн хамруулан судалгаа авсан. Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт, тусламжийг давхардсан тоогоор 24502 иргэнд 9,159.9 сая төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 26309 хүүхдэд 23,496.4 сая төгрөг тус тус олгосон. Өрхийн амьжиргааны түвшний судалгааны үр дүнгээр доод түвшний 1428 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийн, сумдын амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн 151 өрхийн 293 иргэн, 393 хүүхдэд хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд нийгмийн халамжийн сангаас 79,3 сая төгрөгийг зарцуулсан. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 293 хүнээс хөдөлмөр эрхэлж байгаа 51 иргэн, хөдөлмөр эрхлээгүй 242 үүнээс хөдөлмөрийн чадвартай ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа 56 иргэн, | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөгжлийн бэрхшээлтэй иргэн 78, оюутан 21, ахмад настан 40 иргэн, жирэмсэн буюу хүүхдээ асарч байгаа 35, байнгын асаргаа шаардлагатай иргэнийг асарч байгаа 12 иргэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан иргэдийн тоо өмнөх оноос 13 хувь, ХЭБҮ-нд хамрагдаж буй өрхийн тоо 2 хувиар тус тус буурсан байна. Гэнэтийн гамшигт байдлын аюулын улмаас болон бусад шалтгаанаар орон гэргүй болсон нийт 100 өрхөд 350.0 сая төгрөгийн гэр олгож, амьдрах нөхцөл, боломжоор хангаж ажилласан. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч буй өрхийн тоо өмнөх онтой харьцуулбал 7%-иар, иргэдийн тоо 5%-иар, олгосон мөнгөн дүн 42%-иар буурсан байна. | |
| 85 | | 100. Орлого багатай болон эмзэг бүлгийн өрхийн гишүүдийг чадавхжуулах замаар ажлын байранд зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Зуучлагдсан ажлын байрны тоо 1088, үүнээс зорилтот бүлгийн иргэдийн тоо-84 | Зуучлагдсан ажлын байрны тоо, үүнээс зорилтот бүлгийн иргэдийн тоо | | 1400 20 | Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө өгөх үйлчилгээ, мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх сургалтад өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 409-өөс доош оноотой нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай орлого багатай өрхийн 95 иргэнийг хамруулж, Модуль-1, 2 сургалтад 10 иргэнийг хамруулан чадавхжуулсан. Зөвлөгөө өгөх болон сургалтын үр дүнд 57 иргэнийг байнгын ажлын байранд, 9 иргэнийг түр ажлын байранд зуучилсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 14 иргэн, түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагааны нийтийг хамарсан ажил, мод тарих арга хэмжээнд 165 иргэн, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 12 иргэнийг хамруулан санхүүгийн дэмжлэг үзүүлж хөдөлмөр эрхлэлтийг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нэмэгдүүлсэн. Зорилтот бүлгийн 404 иргэнийг чадавхжуулж,444 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | |
| 86 | 2.5.4. Орон нутгийн бүтээн байгуулалтын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэ ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тогтмол нэмэгдүүлнэ | 101. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх | 2021 - 2024 | МСҮТ төгссөн сурагчдын тоо 261 | МСҮТ төгссөн сурагчдын тоо | | 300 /гүйцэтгэлээр/ | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа”-ны үйлдвэрлэл дээрх сургалтыг “Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компаны Дорноговь аймаг дахь салбарын мэргэжлийн ажиллах хүчний хомсдолыг багасгах, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж 10 иргэнийг хамруулсан. Сургалтын үр дүнд 3 иргэний ажлын байрыг хадгалж, 3 иргэнийг байнгын ажлын байраар хангасан. Политехникийн коллежид 2023-2024 оны хичээлийн жилд 20 мэргэжлийн 560 суралцагчийн элсэлтийн квот батлуулснаас 17 мэргэжлийн 465 суралцагч элсүүлэн нийт 804 суралцагчтай үйл ажиллагаа явуулж байна. Суралцагч оюутнууд үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагыг тогтмол хийж хэвшсэн ба төрийн 19 байгууллагад 28, 101 аж ахуй нэгжид 240, иргэний ажлын байранд 83 суралцагч дадлага хийсэн. Төгсөгчдөд хөдөлмөр халамж үйлчилгээний газрын ажлын зар болон үйлдвэрлэлийн дадлага хийсэн газарт ажил олгогчийн захиалгаар ажилд зуучилдаг ба энэ жилд 277 суралцагч төгссөнөөс 156 суралцагч буюу 57 хувь нь ажлын байртай төгссөн. Аймгийн ЗДТГ-аас “Дабльфиш” ХХК-ийн дэргэдэх Төмөр замын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан нийт 6 мэргэжлээр 265 оюутан суралцуулж байна. Вагон үзэгч засварчин 17, | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зүтгүүрийн туслах машинч 53, Төмөр замын замчин 60, Өртөөний жижүүр 65, Ачаа вагон хүлээлцэгч 66, Дохиолол төвлөрүүлэлт холбооны монтёр 4 байна. Танхимын сургалтыг Оёдолчин мэргэжлээр “Дарь овооны эзэд”, гагнуурчин мэргэжлээр “Чадамж боломж” ХХК-ны сургалтын төвтэй тус тус хамтран ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй 30, хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнийг хамруулж Сургалтын үр дүнд 3 иргэний ажлын байрыг хадгалж, 5 иргэнийг байнгын ажлын байраар хангасан. Мэргэжил олгох сургалтад нийт 66 иргэнийг хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал суралцагчдын тоо 7,2% буюу 5 иргэнээр нэмэгдсэн. | |
| 87 | | 102. Цагийн болон өдрөөр ажиллах хөдөлмөрийн уян хатан топголцоо, нөхцөлийг бүрдүүлэх | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо-1, Түр шинэ ажпын байранд орсон иргэдийн тоо-485 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо Түр шинэ ажпын байранд орсон иргэдийн тоо | | 3 530 | Ажил олгогч байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэдийн цагийн болон өдрийн ажлын байрны захиалгыг тухай бүрд авч 7 аж ахуй, нэгж байгууллага, 17 иргэнээс ирсэн ажлын байрны 79 захиалгын зар мэдээг байгууллагын пэйж хуудас, орон нутгийн DTV телевиз болон цахим сайт, цахим хуудсаар долоо хоногт 2 удаагийн давтамжтайгаар шинэчлэн хүргэж, цагийн болон өдрийн ажил хийх сонирхолтой ажил хайгч иргэдийн мэдээллийн сан бүрдүүлэн 72 иргэнийг ажлын байранд зуучилсан. Цагийн ажлаас гадна түр ажлын байранд 54 иргэнийг зуучлан хөдөлмөр эрхлэлтийн "ИЖоб" цахим системд бүртгэсэн. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 сарын 03-ний өдрийн 01 тогтоолоор батлагдсан “Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа”-ны мод тарих, нийтийг хамарсан ажил, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээнд нийт 443 иргэнийг хамруулан түр ажлын байраар хангаж, ажлын хөлс болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зардалд нийт 144.7 сая төгрөгийг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. Цагийн ажилд зуучлах ажлын ярилцлагыг 2 ажил олгогч байгууллага болон 75 ажил хайгч оюутан залуучуудыг оролцуулан зохион байгуулж, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ирсэн 6 аж ахуй нэгж байгууллагын 12 ажлын байрыг танилцуулж ажилласан. Ярилцлагын үр дүнд 5 залууг цагийн ажилд зуучилсан. Цагийн болон өдрийн ажилд 103, түр ажлын байранд 92 иргэнийг зуучилж, төсөл хөтөлбөрийн хүрээнд 445 иргэн, нийт 640 иргэнийг түр ажлын байраар хангасан нь өмнөх оны мөн үеэс 310 иргэнээр буюу 93.9%-аар өссөн. | |
| 88 | | 103. Орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр бий болсон үйлдвэр, үйлчилгээний салбарын шинэ ажлын байранд ажиллагсдыг зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Шинэ ажпын байрны тоо 1295, Зуучлагдсан ажлын байрны тоо 1338, | Шинэ ажпын байрны тоо Зуучлагдсан ажлын байрны тоо | | 1400, 1500, | Хөдөлмөр эрхлэлтийн цахим бүртгэлийн систем "ejob" платформд 2023 оны 11 дүгээр сарын байдлаар орон нутгийн хэмжээнд шинээр бий болсон 1018 шинэ ажлын байрыг бүртгэж, 1169 иргэн ажилд зуучлагдсан нь өмнөх оноос ажлын байрны бүртгэл 1013 байсан нь 0,4%-иар, зуучлагдсан иргэдийн тоо 3,3%-иар өссөн. Орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд Gobi cinema, Ахмадын сувиллын газар, "Саран хөхөө" театрын барилга, "Мандах наран-5" хорооллын барилгын ажил зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлуудад "Элит конкрет" ХХК, "Энержи парагон" ХХК, "Болор аграмба" ХХК зэрэг байгууллагуудын байнгын ажлын байранд 159 иргэнийг зуучлан ажлын байраар хангасан. Өмнөх онтой харьцуулахад шинээр бий болсон ажлыг байрны бүртгэл 41,9%-иар өссөн үзүүлэлттэй байна. Газрын тос боловсруулах үйлдвэрт 427, Ханги боомтод 299, Алтанширээт аж үйлдвэрийн цогцолборт 30, аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явулах тусгай зөвшөөрөлтэй уул уурхайн компаниуд 2000, нийт 2756 ажлын байрыг шинээр бий болгон орон нутгаас ажиллах хүч | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | татан ажиллуулсан байна. | |
| 89 | | 104. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлж, сумдын ХАБЭА-н зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | 2021 - 2024 | Төлөвлөгөөний хэрэгжилт 100% | Төлөвлөгөөний хэрэгжилт | | 100% | ХАБЭА-н зөвлөл нь 3 зорилт 25 арга хэмжээтэйгээр төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаж ажилласан. ХАБЭА-н салбар зөвлөлийн дарга, нарийн бичиг нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж 29 албан хаагч хамруулж “ХАБЭА-н тухай хууль, салбар зөвлөлийн чиг үүрэг, тулгарч буй асуудал", "ХАБЭА-н хүрээнд хэрэгжих төсөл хөтөлбөр”-ийн талаар мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн аж ахуй нэгж, байгууллагын ХАБЭА-н асуудал хариуцсан болон хавсран гүйцэтгэж байгаа ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг “Дарь-Овооны эзэд” ТББ-тай хамтран 62 байгууллагын 70 ажилтан албан хаагчийг хамруулж сертификат олгосон. ХАБЭА-н сарын аяныг зарлаж “Эрүүл аюулгүй ажлын байр-Бидний суурь эрх” илтгэлийн уралдаан, “Шинэ сэргэлтийн бодлого-Уул уурхайн тоо бүртгэл”-н ажлын хэсэг 14 суманд ажиллаж хяналт шалгалтыг хийж зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Төр, хувийн хэвшлийн байгууллагууд, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг шторк, гарын авлагаар хангаж, байгууллагуудын болон 14 сумын цахим хаягаар үйлдвэрлэлийн осол гэмтлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээллийг хүргэж 13100 иргэний хандалт авсан. ХАБЭА-н төлөвлөгөөг 90%-тай хэрэгжүүлж ажилласан. | 90% |
| 90 | | 105. Хувийн хөдөлмөрийн бирж байгуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих | 2021 - 2024 | - | Хувийн хөдөлмөрийн биржийн тоо-1 | | - | Ажил олгогч байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэдийн цагийн болон өдрийн ажлын байрны захиалгыг тухай бүрд авч 7 аж ахуй, нэгж байгууллага, 17 иргэнээс ирсэн ажлын байрны 79 захиалгын зар мэдээг орон нутгийн DTV телевиз болон цахим сайт, цахим хуудсаар долоо хоногт 2 удаагийн давтамжтайгаар шинэчлэн хүргэж, цагийн болон өдрийн ажилд 77, түр | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ажлын байранд 54 иргэнийг зуучлан ажилласан. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 01 тогтоолоор батлагдсан “Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа”-ны мод тарих, нийтийг хамарсан ажил, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээнд нийт 443 иргэнийг хамруулан түр ажлын байраар хангаж, ажлын хөлс болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зардалд нийт 144.7 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. Нийт цагийн болон өдрийн, түр ажлын байранд 574 иргэнийг зуучилж ажиллуулсан. Хувийн хөдөлмөрийн бирж байгуулахаар санал ирүүлсэн “Хутагт мөрөн” ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулсан. Тус компани нь хувийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаагаа 11-р сарын 25-нд эхлүүлсэн бөгөөд нээлтийг үйл ажиллагааг 12-р сард хийхээр төлөвлөсөн. | |
| 91 | 2.5.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана. | 106. Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын барилга барих | 2022 - 2023 | - | Гүйцэтгэлийн хувь | | Гүйцэтгэл 100% | Улсын төсвийн 2.5 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр "Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын барилга барих" ажлыг 2022 оноос “Тогоруутай нуур” ХХК гүйцэтгэж байна. Барилгын үндсэн хийц бүтээцийн угсралт болон гадна инженерийн шугам сүлжээ, гадна цахилгаан хангамжийн ажил бүрэн хийгдсэн. Дотор заслын ажил, дотор халаалт, бохир усны шугамын ажил, дотор цахилгаан, салхивчийн ажлууд хийгдэж байна. Ажлын явц 90 хувьтай. Барилга угсралтын ажлыг гэрээнд заасан хугацаанд буюу 12 дугаар сарын 20-ны дотор хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна. | 90% |
| 92 | | 107. Сайншанд суманд Ахмадын сувиллын барилга барих | 2021 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | - | Улсын төсвийн 5,1 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд суманд 60 ортой "Ахмадын сувиллын барилга барих" ажлыг "Элит Конкрет" ХХК гүйцэтгэж дуусган, 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр улсын комисс | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ажиллаж, 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр нээлтийг хийж ашиглалтад оруулаа. | |
| 93 | | 108. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Эрүүлжин хөгжих төв”-ийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах | 2021 - 2024 | 0 | Хамрагдсан иргэдийн тоо | | 50 | Аймгийн хэмжээнд 282 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас 209 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж, 73 хүүхэд нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдах насанд хүрээгүй болон суралцахад хүндрэлтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх “Эрүүлжин хөгжих төв” –өөр дамжуулан 9 хүүхдийг сэргээн засах, өдөр өнжүүлэх үйлчилгээнд хамруулж байна. Төвийн үйл ажиллагаа болон цалингийн зардалд орон нутгийн төсвөөс 74,3 сая төгрөг батлагдсанаас тайлант хугацаанд 40,8 сая төгрөгийг зарцуулсан. Хүүхдүүдэд өдөр тутам сэргээн засах, бариа заслын үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж байгаа бөгөөд үйлчилгээний үр дүнд нийт хамрагдсан хүүхдүүдийн 50 хувьд нь бие бялдар, үйл хөдлөл, сэтгэхүйн онцлогт бүрэн өөрчлөлт гарч байна. Мөн 5 асран хамгаалагч ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан бол 3 асран хамгаалагч байнгын ажилтай болсон. Насан туршийн боловсрол төвд байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй 31 хүүхэд хамрагдан боловсролын үйлчилгээ авч байна. "FXB" төсөлтэй хамтын ажиллагааны хүрээнд 4 өрхийн 2 бүлэг тус бүрд 2.0 сая нийт 4.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авах дэмжлэг мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 1 иргэнийг хамруулан 10.0 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон. Мөн FXB төсөлд сонгогдсон өрхийн 25 иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлсэн. ХХҮГ-т аймгийн хараны | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах "Мэлмий" холбоо нь байрлаж FM радиогийн үйл ажиллагаа явуулж байна. | |
| 94 | | 93. Ахмад настны хөгжил, хамгаалал, оролцоог дэмжих цогц бодлогыг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | | | Ахмад настны хөгжил, хамгааллын хүрээнд Говийн бүсийн төрөлжсөн асрамжийн газарт 2020 онд Дундговь аймгаас 1, 2021 онд Дорноговь аймгийн 1 ахмад, 2022 онд Өмнөговь, Дорноговь аймгаас тус бүр 1 ахмад, 2023 онд 3 ахмад нийт 15 ахмад настан асруулж байна. Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын шинэ барилгын ажлыг улсын төсвийн 2,5 тэрбум төгрөгийн өртгөөр “Уртын уул” ХХК  гүйцэтгэж барилгын ажлын явц 90 хувьтай байна. Асрамжийн газрын барилгад шаардагдах “багц 1”, “багц 2”-ын тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвийн 103,6 сая төгрөгөөр худалдан авсан. Энэхүү барилга ашиглалтад орсноор ахмадуудын бүх талын оролцоог нэмэгдүүлэн хөгжүүлэх, үйлчилгээ үзүүлэх, амьдрах таатай орчин бүрдэнэ. Түрээсийн орон сууц хөтөлбөрийн 1 дүгээр ээлжинд 105 айлын орон сууцнаас 11 ахмад настан байртай болсон. Мөн улсын төсвийн 5,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд суманд 60 ортой "Ахмадын сувиллын барилга барих" ажлыг "Элит Конкрет" ХХК гүйцэтгэж дуусган хүлээлгэн өгсөн. Ахмад настнуудад үзүүлэх тусламж үйлчилгээний хувьд өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй байнгын асаргаа шаардлагатай ахмад настнуудад орон нутгийн төсвөөс 21,5 сая төгрөгөөр санхүүжүүлэн, аймгийн Улаан загалмайн хороотой гэрээлэн 2020 онд 18 ахмад, 2021 онд 28 ахмад, 2022 онд 20 ахмад, 2023 онд 11 ахмадад гэрийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлсэн. Ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор 84 байгууллага ахмадын сан байгуулсан | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгаа нь 2020 оны мөн үетэй харьцуулахад 34-өөр нэмэгдсэн. Аймгийн хэмжээнд 6803 ахмад байгаа ба 2020 оны мөн үетэй харьцуулхад 653 ахмадаар нэмэгдсэн. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор аймгийн Ахмадын хорооны 2020-2023 оны үйл ажиллагаанд жил бүр 70,4 сая төгрөг, нийт 281,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 344 багц арга хэмээний хүрээнд давхардсан тоогоор 60000 гаруй ахмадын хөгжил, оролцоог дэмжиж ажилласан. | |
| 95 | 2.5.6. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ. | 109. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх | 2021 - 2024 | Төвөөр үйлчлүүлсэн залуучуудын тоо-448, сургалт, арга хэмжээний тоо-5 | Төвөөр үйлчлүүлсэн залуучуудын тоо сургалт, арга хэмжээний тоо | | 530/5 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвөөр дамжуулан 17 сургалт, арга хэмжээг танхим болон цахимаар зохион байгуулж, 806 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. 1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх 7 удаагийн үйлчилгээгээр Ерөнхий боловсролын сургуулийн 9, 11, 12 дугаар ангийн 414 сурагч, 2. Ажил хайгч болон хувиараа бизнес эрхлэх хүсэлтэй 18-34 насны залуучуудад зориулсан "Модуль-1, 2" нэг удаагийн сургалтаар 17 иргэн, 3. Ажлын ярилцлагыг 2 удаа зохион байгуулж Монцемент ХХК-ний танхим, цахим хосолсон ярилцлагад 22 иргэн, МАК цемент ХХК-ний танхимын ярилцлагад 15 иргэн оролцсоноос 20 иргэн ажилд зуучлан орсон. 4. Залуусаа сонсох өдөр арга хэмжээний хүрээнд “Туршлагаасаа хуваалцъя” 2 удаагийн шууд лайв нэвтрүүлгээр 1394 иргэний хандалт авсан. 5. Цагийн ажлын зар авах, цагийн ажилд зуучлах тухай мэдээ мэдээллийг шууд лайв нэвтрүүлгээр хүргэж 4185 иргэний хандалт авсан. 6. Гадаадад ажиллах, сурах боломж цахим, танхим хосолсон 2 удаагийн уулзалтад 90 иргэн 7. Дорноговь аймгийн оёдолчин мэргэжилтэй болон оёдолчноор | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ажиллах хүсэлтэй 53 иргэнтэй уулзалт зохион байгуулж, оёдлын үйлдвэр, цех байгуулах, цаашлаад уул уурхайн компаны хөдөлмөрийн хувцас хэрэгслийг нийлүүлэх боломжийн талаар танилцуулж мэдээлэл хүргэсэн. 7. Ажилгүйдлийн тодорхойлолт 82 иргэнд, ажлын байрны мэдээллийг 113 иргэнд тус тус өгч ажилласан. Тайлант хугацаанд 17 сургалт, арга хэмжээг зохион байгуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10,6%, тус төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо 27,8%-иар тус тус өссөн. | |
| 96 | | 110. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжих | 2021 - 2024 | Төсөл, хөтөлбөр дэмжлэгт хамрагдсан бүлгийн тоо-24 | Төсөл, хөтөлбөр дэмжлэгт хамрагдсан бүлгийн тоо | | 24 /гүйцэтгэлээр/ | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвөөр дамжуулан 17 сургалт, арга хэмжээг танхим болон цахимаар зохион байгуулж, 806 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. 1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх 7 удаагийн үйлчилгээгээр Ерөнхий боловсролын сургуулийн 9, 11, 12 дугаар ангийн 414 сурагч, 2. Ажил хайгч болон хувиараа бизнес эрхлэх хүсэлтэй 18-34 насны залуучуудад зориулсан "Модуль-1, 2" нэг удаагийн сургалтаар 17 иргэн, 3. Ажлын ярилцлагыг 2 удаа зохион байгуулж Монцемент ХХК-ний танхим, цахим хосолсон ярилцлагад 22 иргэн, МАК цемент ХХК-ний танхимын ярилцлагад 15 иргэн оролцсоноос 20 иргэн ажилд зуучлан орсон. 4. Залуусаа сонсох өдөр арга хэмжээний хүрээнд “Туршлагаасаа хуваалцъя” 2 удаагийн шууд лайв нэвтрүүлгээр 1394 иргэний хандалт авсан. 5. Цагийн ажлын зар авах, цагийн ажилд зуучлах тухай мэдээ мэдээллийг шууд лайв нэвтрүүлгээр хүргэж 4185 иргэний хандалт авсан. 6. Гадаадад ажиллах, сурах боломж цахим, танхим хосолсон 2 удаагийн уулзалтад 90 иргэн 7. Дорноговь аймгийн оёдолчин мэргэжилтэй болон оёдолчноор ажиллах хүсэлтэй 53 иргэнтэй уулзалт | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зохион байгуулж, оёдлын үйлдвэр, цех байгуулах, цаашлаад уул уурхайн компаны хөдөлмөрийн хувцас хэрэгслийг нийлүүлэх боломжийн талаар танилцуулж мэдээлэл хүргэсэн. 7. Ажилгүйдлийн тодорхойлолт 82 иргэнд, ажлын байрны мэдээллийг 113 иргэнд тус тус өгч ажилласан. Тайлант хугацаанд 17 сургалт, арга хэмжээг зохион байгуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10,6%, тус төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо 27,8%-иар тус тус өссөн. | |
| 97 | 2.5.7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн тогтолцоог бэхжүүлж, байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ | 111. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг бүх түвшинд сурталчлан, хамтын ажиллагааг дэмжиж, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Зохион байгуулсан багц арга хэмжээний тоо-3 | Зохион байгуулсан багц арга хэмжээний тоо | | 5 | "Жендерийн тэгш байдал"-ын сургалтыг 7 сум, 6 агентлаг, оюутан залуучууд нийт 312 иргэнд жендерийн хэвшмэл ойлголтын хор уршгийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээж ажилласан. Сургалтад хамрагдсан иргэдийн дунд асуултын цаг гаргахад 80 гаруй хувь нь жендерийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдсэн гэж хариулсан. Мөн аймгийн төвийн Политехникийн коллеж, Татварын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Ерөнхий боловсролын сургуулиуд зэрэг 6 байгууллагын албан хаагч, сурагч, оюутан, зорилтот бүлгийн иргэдэд, жендерийн талын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, мэдрэмжээ хуваалцаж сурахын ач холбогдлыг таниулж ажилласан. Монгол Улсын Засгийн газар Жендерийн үндэсний хорооноос Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн дэмжлэгтэйгээр “Харилцан хүндэтгэе” нэг сарын аяныг зохион байгуулж цэцэрлэгийн 100 гаруй залуу эмэгтэй багш, ажилчдад “Өөрийгөө хайрлая”, “Жендерт суурилсан хүчирхийлэл, түүний суурь шалтгаан” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. “Залуусын оролцоо-хотын хөгжил 2023” залуучуудын чуулганыг зохион байгуулж “Жендерийн хэвшмэл ойлголт” | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сэдвээр сургалт хийсэн. Нийт 4 удаагийн сургалтаар 500 гаруй иргэн, албан хаагчдад мэдээлэл, сургалт хийсэн. | |
| 98 | | 112. Төрийн үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд иргэдийг бүх талаар тэгш хамруулах бодлогыг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Төлөвлөгөөний хэрэгжилт 90% | Төлөвлөгөөний хэрэгжилт | | 98% | "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа", "Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа"-ны төсөл сонгон шалгаруулах болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгоход урьдчилсан байдлаар дүгнэлт гаргах ажлын хэсгүүдэд 40% буюу 12 нь төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан шийдвэр гаргах түвшинд оролцоог ханган ажилласан. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэгт 2021 онд 9, 2022 онд 13-н төрийн бус байгууллага болон иргэдийн төлөөллийг оролцуулан шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог ханган ажилласан. 2022 онд 4 төрийн бус байгууллагаар дамжуулан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 363 иргэнд үзүүлсэн. Төсөл хөтөлбөрүүдийн сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт 2021 онд 36 хувьд нь, 2022 онд 43.3 хувьд нь төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан оролцоог ханган ажилласан. | 90% |
| 99 | 2.5.8. Гэр бүлийн үнэ цэнэ, тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ. | 113. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах бүх талын бодлого, нөлөөллийн үйл ажиллагааг явуулах | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 21 Хамрагдсан иргэдийн тоо 37000 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо | | 27/39000 | "Олон улсын гэр бүлийн өдөр", "Олон улсын охидын өдөр", "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр", "Олон улсын аавуудын өдөр", "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр" зэрэг тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд "Нэгдүгээрт хүүхэд", "Гэр бүлийн дундах эерэг харилцааг нэмэгдүүлэх", "Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэхийн ач тус", "Өсвөр насны хүүхдийн төлөвшил" зэрэг 42 үйл ажиллагаа, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хосуудын харилцан ойлголцол, бат бэх байдлыг дэмжих, | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | амьдрах ухаан, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлүүдээр төрийн байгууллагын албан хаагч болон иргэд рүү чиглэсэн 78 удаагийн сургалт зохион байгуулсан. Нийт 120 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаа, сургалтыг зохион байгуулсан. Гэр бүлийн орчин нөхцөлийн үнэлгээг Сайншанд, Алтанширээ, Мандах, Замын-Үүд, Хөвсгөл зэрэг 5 сумын эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа, хагас, бүтэн өнчин хүүхэдтэй нийт 224 өрхөд нөхцөл байдлын үнэлгээг хийсэн. Уг үнэлгээгээр цахилгааны аюулгүй байдал, хүнс тэжээлийн нөөц, галын аюулгүй байдал бохирын нүх зэрэг үнэлгээгээр дүгнэн эрсдэлтэй гарсан нийт 74 өрхөд 217 хүүхдэд 11,8 сая төгрөгийн хувцас, түлээ нүүрс, амин дэм, хүнсний дэмжлэг үзүүлсэн. Мөн 46 удаагийн цуврал хүүхэд хүмүүжлийн эерэг аргын зөвлөмж постер, 6 төрлийн подкаст, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай болон гэр бүлийн тогтвортой байдлын үндэс, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зэрэг 15 төрлийн танилцуулгыг бэлтгэн байршуулж, 19650 иргэд олон нийтэд тогтмол хүргэсэн. Үр дүнд нь гэр бүл салалт 72 байгаа нь урьд оноос 49 тохиолдлоор буурсан үр дүнтэй байна. | |
| 100 | | 114. Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах | 2022 - 2024 | 0 | Байгуулагдсан төвийн тоо Тоног төхөөрөмжийн хангалт | | - | Сэтгэл зүйн боловсролд анхаарах зорилгоор Гэр бүл хүүхэд залуучуудын газрын сэтгэл зүйч Сайншанд сумын түр хамгаалах байранд байрласан нийт 10 хүүхэд, 1 насанд хүрсэн иргэн, сэтгэл зүйн зөвлөгөө авахаар хандсан 14 иргэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 12 хүүхдэд тест, асуулга, проектив тест, ярилцлага хийх, темперамент тодорхойлох, зан үйлийн тодролыг тодорхойлох зэрэг хэлбэрээр үр дүнд нь өөрийн ямар хэв шинжийн темпераменттай, зан үйлийн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ямар тодрол байгаа, тэдгээрийн давуу болоод сул талуудаа мэдэж авч давуу талаа боломж болгох, сул талаа анхаарч, хяналттай байхад суралцах, зураг, үлгэрээр дамжуулан сэтгэл зүйн хүндрэл үүсгэлгүйгээр ойртох, хүчирхийллээс холдуулж аюулгүй байлгах, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, мөн сэтгэлгээний хөгжилд тодорхой нөлөө үзүүлэх зэрэг арга хэмжээг авсан. Сайншанд сумын 39 иргэдэд “Өсвөр насны хүүхдийн онцлог, тэдэнтэй харилцах харилцаа” сэдвээр, Онцгой байдлын газрын 17 алба хаагчид “Өөрийн сэтгэл зүйгээ танин ойлгоё” сэдвээр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 4 албан хаагчийн темпераментыг тодорхойлж, хэв шинж тус бүрийн онцлогийг тайлбарлан, сургууль цэцэрлэгийн эмч 29 албан хаагч, Сайншанд сумын 3 багийн нийгмийн ажилтантай хамтран 109 охидод Политехник коллежийн нэг, хоёрдугаар курсийн /16 анги/ 230 оюутанд сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөө хийж, тус зөвлөгөөгөөр өсвөр насныхны онцлог, ухамсрын тухай ойлголт, сэтгэл хөдлөл, уур сэдвээр ярилцан, сэтгэл заслын үйлчилгээнд хамруулах зэргээр нийт 411 иргэнд сэтгэл зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн. Аймгийн хэмжээнд 6 мэргэжлийн сэтгэл зүйч ажиллаж ганцаарчилсан 373, бүлгийн 803 нийт 1176 сурагчдад сэтгэл зүйчийн зөвлөгөөг өгөхөөс гадна аймгийн Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн эмч өсвөр насны 6 хүүхдийг 7-14 хоногийн давтамжтай үйлчилгээнд хамруулан ганцаарчилсан зөвлөгөөг өгч ажилласан. | |
| 101 | | 115. Иргэдийг гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ойлголт, хандлагыг сайжруулж, | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 15 Хамрагдсан иргэдийн тоо 15000 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо | | 21/18000 | Эцэг эх асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, зэрэг хандлага бий болгох зорилгоор 150 удаагийн сургалтаар 7500 иргэнийг хамруулсан. Тус нөлөөллийн арга | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | гэр бүлийн харилцаа болон хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх | | | | | | хэмжээний хүрээнд 28,0 сая төгрөгийг зарцуулж бүх шатны байгууллага, иргэн, аж ахуй нэгж байгууллагыг үүрэгжүүлэн ажилласан. Сайншанд сумын 8 багийн эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа болон хагас, бүтэн өнчин хүүхэдтэй нийт 150 өрхөд нөхцөл байдлын үнэлгээг хийж цахилгааны аюулгүй байдал, хүнс тэжээлийн нөөц, галын аюулгүй байдал бохирын нүх зэрэг үнэлгээгээр эрсдэлтэй гарсан нийт 33 өрхөд хүнсний дэмжлэг үзүүлэн нийт 3 сая төгрөгийн хариу үйлчилгээнд хамруулсан. “Намайг хамгаал” арга хэмжээг холбогдох байгууллагууд, бүх сум, орон нутгийн телевизүүдтэй хамтран зохион байгуулсан. 1. Нөлөөллийн аяны хүрээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор видео бэлтгэн цахим орчинд түгээсэн. 2. Олон нийтийн газар болон бүх сумдад “Намайг хамгаал, үргэлж анхаар, хамтдаа хамгаалъя” баннерыг байршуулсан. 3. Хүүхдийн эрхийн сайн дурын ажилтан, идэвхтэн багштай хамтран 14 сумдад 113 удаагийн сургалтаар 11,734 сурагч, эцэг, эхийг хамруулж, сургагч багш бэлтгэх ажлыг зохион байгуулсан. 4. “Монголын аюулгүй байдлын академи НҮТББ”-тай хамтран Сайншанд сумын 5 сургуулийн эцэг, эх багш, сурагч нийт 1,500 хүнд мэдээлэл хүргэсэн. Мөн “Сурагчийн аюулгүй байдал” 1,500 ш цахим номыг тараасан. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт 24 арга хэмжээтэйгээр төлөвлөн хэрэгжүүлэн ажилласан. Энэ хүрээнд "Гэр бүлдээ хүндэтгэлтэй хандъя", "Хүүхдэдээ хүндэтгэлтэй хандъя", "Хамтдаа хамгаалъя", "Үргэлж анхаар", Зөв хандлагыг түгээе” зэрэг 28 төрлийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нөлөөллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 120,000 хүн хамруулсан. Дээрх ажил, арга хэмжээг чанартай зохион байгуулснаар аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл өмнөх онтой харьцуулахад 10 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна. | |
| 102 | 2.5.9. Хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ. | 116. “Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | Төлөвлгөөний хэрэгжилт 100% | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж 20 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг хангасан. Үе тэнгийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх “Найз байя” аян, “Ээж охидын өдөрлөг”, “Нэгдүгээрт хүүхэд”, Зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжидийн нэрэмжит "Өсвөрийн бүжигчдийн улсын XVI наадам“, “Уран жиргээ” уран уншлагын улсын уралдаан, монгол бичгийн “Сайхан бичигтэн”, “Миний эх орон” гар зураг, “Рубик шоо” зэрэг 11 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулан нийт 1486 хүүхдүүдийг хамруулж, 0,3 сая төгрөгийн зардлыг зарцуулсан. "Монголын скаутын холбооны 2023 цугларалт", “Охидын өдөр”, "Жаргалан зуслангийн үйл ажиллагаа", "Зорилтот бүлгийн хүүхдийн зуслангийн 4 өдрийн хөгжлийн хөтөлбөр", "Хүүхдийн оролцооны үндэсний чуулга” зэрэг нийтдээ 58 удаагийн сургалт, тэмцээн, үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 8260 гаруй хүүхэд хамруулсан. "Юнител" групп нийгмийн хариуцлагын хүрээнд НҮБ-ын Хүн амын сантай хамтран “Unitel Hub” электроникийн суурь ойлголтуудыг олгох сургалтын танхимыг 44,0 сая төгрөгөөр тохижуулсан. Аймгийн хэмжээнд ГБХЗХГ, Ерөнхий боловсролын 4 сургууль мэргэжлийн сэтгэл зүйчтэй, ганцаарчилсан 373, бүлгийн 803 нийт 1176 сурагчдад сэтгэл зүйчийн зөвлөгөөг өгсөн. Мөн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | аймгийн 22 сургуулиуд камержуулалтын системтэй ба аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 05 албан даалгавраар камерын системтэй болгох, камерын чанарыг сайжруулах чиглэлийг өгч Иххэт сумын ЕБС гадна талдаа 3 камер шинээр тавьж, дотор 3 камерийг засварласан, Алтанширээ сумын ЕБС, дотуур байр гадна дотор камерыг бүрэн шинэчилж, нийт 12 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэсэн. Иргэдийн оршин суух газар, зам талбайн 98 байршилд камержуулалт байснаас шинээр 110 байршилд хяналтын камержуулалтыг нэмэгдүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна. | |
| 103 | | 117. Хүүхдийн зуслан барьж ашиглалтад оруулах | 2021 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | - | Улсын төсвийн 1589.7 сая төгрөг, орон нутгийн төсвийн 698.8 сая төгрөг, нийт 2288.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд суманд Хүүхдийн зуслан байгуулах ажлыг "Энержи парагон " ХХК, "Дэлгэр баясах зам" ХХК-ууд гүйцэтгэн ашиглалтад оруулсан. | 100% |
| 104 | | 118. Хүүхдийн ордны дэргэд “Хүүхдийн урлан бүтээх төв” байгуулах | 2022 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | - | Аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжаар батлагдсан “Хүүхэд хөгжил-2022” зорилтот жилийн хүрээнд хүүхдийн ордныг “Хүүхэд хөгжлийн төв” болгосон ба Хүүхэд хөгжлийн төвд уран нугаралт, шатар, хөгжим, охидын клуб, илтгэх урлаг, уран зургийн дугуйлан сарын 70,0 мянган төгрөгийн төлбөртэйгээр, монгол бичиг, матемиатик, рубик шоо, техник технологи /Unitel hub/-ийн дугуйлан төлбөргүйгээр тус тус хичээллэн, нийт 715 хүүхэд багачуудыг хамруулсан. Зорилтот бүлгийн 30 хүүхдийг энэ онд сонирхлын дагуу нь холбогдох дугуйланд хамруулж, төлбөрийн хөнгөлтийг үзүүлсэн. Өмнөх онтой харьцуулахад дугуйлангийн төрлийн тоо 2-оор, хүүхдийн тоо 248-аар өссөн. Хүүхдийн ордны Залуучуудын хөгжлийн төвд уран бичлэг, рубик шоо, фотошоп, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | математик, миний робот зэрэг 8 төрлийн үнэ төлбөргүй дугуйлан хичээллэж 300 хүүхдийг хамруулан ажилласан."Nextgen" залуучуудын санал санаачилгыг дэмжсэн нийгмийн төслийн уралдаанд Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих бүлгээс "DINO" багийн "Ардүюно Робот" төсөл шалгарч, улсын төсвөөс 20 сая төгрөгийн санхүүжилт авсан. Энэхүү төсөл нь Залуучуудын хөгжлийн төв дээр хэрэгжиж хүүхэд, өсвөр үеийнхний техник сэтгэлгээ, урлан бүтээх санал санаачилгыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байгаагаар давуу тал болсон. "Боломжийг хүүхэд бүрт" уриатайгаар 46 сая төгрөгийн санхүүжилтээр "unitel hub"-ыг залуучуудын хөгжлийн төвд тохижуулж тоног төхөөрөмжийг бүрэн угсарсан. Уг ажлын хүрээнд танхимыг засварын ажилд ГБХЗХГ-аас 3 сая төгрөгийг зарцуулж, засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Тайлант онд хүүхэд хөгжлийн төвийн засварыг орон нутгийн төсвийн 198,0 сая төгрөгийн санхүүжилтээр "Илч дулаан өсөх" ХХК гүйцэтгэж ашиглалтад орууллаа. | |
| 105 | | 119. Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн тоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх | 2021 - 2024 | Эцэг эхийн зөвлөлтэй байгууллагын тоо 35, Зохион байгуулсан арга хэмжээний тоо 35 | Эцэг эхийн зөвлөлтэй байгууллагын тоо, Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 90/90 /өссөн дүнгээр/ | Аймгийн хэмжээнд 91 эцэг эхийн зөвлөл үйл ажиллагаа явуулж, хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагаанд төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. "Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан "Гэр бүлдээ бичих захидал" арга хэмжээ, "Гэр бүлдээ зарцуулах цаг хугацаа үнэ цэнэ", "Хүүхдийн эрх үүрэг", "Давсаа хасъя" зэрэг сургалт нөлөөллийн арга хэмжээнд 807 иргэнийг хамруулсан. Сайншанд сумын 32 төрийн байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн 66 гишүүдийг оролцуулан Өсвөр насны охид, хөвгүүдэд тулгарч буй асуудал, цахим орчны зөв зохистой хэрэглээ, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үүргийн талаарх мэдээллээр хангах, нийгмийн оролцоог нь нэмэгдүүлэх зорилгоор уулзалт арга хэмжээ зохион байгуулсан. Энэхүү ажлын үр дүнд өсвөр насны хүүхдийн онцлог, тулгамдаж буй асуудлын талаар байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл нэгдсэн ойлголттой болсон. Сумд, агентлагууд хүүхдийнх нь төрсөн өдрөөр нэг өдрийн цалинтай чөлөө олгож хэвшсэн ба 0-3 насны хүүхэдтэй ажилтан, албан хаагчдыг богиносгосон цагаар ажиллуулсан. Тайлант онд 4 эцэг эхийн зөвлөл бүрэлдэхүүнээ шинэчлэн байгуулж, 2 эцэг эхийн зөвлөл шинээр байгуулагдсан. Нийт 91 эцэг, эхийн зөвлөл үйл ажиллагаагаа эрхлэн явуулж, 28 төрлийн арга хэмжээ зохион байгуулсан. 2020 оноос хойш эцэг, эхийн зөвлөлийн тоо 26.4 хувиар өссөн. | |
| 106 | 2.5.10. Залуучуудын хөгжил, оролцооны талаарх төрийн бодлого шийдвэр, дүрэм журмын хэрэгжүүлж залуучуудын санал санаачилгыг дэмжинэ. | 120. Залуучуудын хөгжил, оролцоог сайжруулж, санал санаачлагыг дэмжих | 2021 - 2024 | Дэмжсэн санал санаачилгын тоо-4 | Дэмжсэн санал санаачилгын тоо | | 7 | “Нээлттэй Дорноговь” зорилтод жилийн хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх, нийгэмд эерэг хандлага, өөрчлөлтийг бий болгох нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор “Хамтын ажиллагаа ба эерэг өөрчлөлт” төслийн уралдааныг зарлаж “Өгөх урлаг” НҮТББ “Говь гоё уу?”, “Нийгмийн дархлаа холбоо” ТББ-ын “Хүүхдээ хүндэтгэе”, “Хүчтэй залуусын давлагаа” ТББ-ын “Соёлоор өөрчилье”, “Өнгө Нэмье-дундын оффис” ТББ-ын “Өнгө Нэмье” төслүүдийг шалгаруулан нийт 20,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Төсөлд шалгарсан ТББ-уудтай хамтран хөдөөг харах өнцгийг өөрчлөх, хүүхэд, залуучууд, иргэдийн харилцаа хандлагад эерэг нөлөө үзүүлэх, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, соёлоор дамжуулан боловсрол олгоход чиглэсэн 38 төрлийн арга хэмжээний хүрээд давхардсан тоогоор 98000 гаруй иргэдийг хамруулж | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хандлагад эерэг өөрчлөлтийг бий болгосон. Залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гарааны бизнесийн хөгжүүлэх зорилгоор "Старт апп" төслийн уралдааныг зохион байгуулж нийт 38 төсөл ирснээс "Gennusis game" кафе, "Baby care" өрхөд хүрч үйлчлэх эрүүл мэндийн үйлчилгээ, Комик номоор дамжуулж өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөр, нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох гэсэн 4 төслийг шалгаруулан тус бүр 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Уралдаанд шалгарсан төслүүдийн хэрэгжилтийн үр дүнд 10 ажлын байр шинээр бий болж 16,0 сая төгрөгийн орлого олсон. Мөн “Нээлттэй аймаг” зорилтод жилийн хүрээнд бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт, сургалтыг зохион байгуулж “Бизнес ба хүний эрхийн зарчим”, “Татвар ба боломж”, “Үйлчилгээнд анхаарах асуудал”, “Бизнесээ амжилттай өргөжүүлэх, хөгжүүлэх” зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулж “Үйлчилгээний соёлыг бид түгээнэ” уриалгад 60 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллага нэгдлээ. | |
| 107 | | 122. Залуу гэр бүлийг орон сууцтай болгох төсөл, хөтөлбөрийг дэмжих | 2023 - 2024 | Орон сууцанд хамрагдсан өрхийн хувь 25 | Орон сууцанд хамрагдсан өрхийн хувь | | 25% | 2020 онд “Хямд өртөгтэй орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Сайншанд, Замын-Үүд сумдад “Мандах наран-1000 айлын орон сууц”-ны хороолол баригдаж орон сууцны 20%-ийг залуу гэр бүлийг орон сууцанд хамруулсан байна. Дорноговь аймгийн ИТХ-ын 2021 оны 04/04 дугаар тогтоолоор"Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам", 2023 оны 07-р сарын 04-ны өдрийн 12/02 дугаартай тогтоолоор "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах журам" -ыг тус тус батлан, журмын хүрээнд хөтөлбөрт хамрагдах | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүсэлтэй Сайншанд сумын 35 хүртэлх насны 25 залуу гэр бүлийн материалыг ажлын хэсэг хүлээн авч, шалгаруулалтыг зохион байгуулснаар 8 багийн 10 залуу гэр бүлийг түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөрт хамруулсан. Мөн Даланжаргалан сумын нутагт "МАК ЦЕМЕНТ" ХХК-ний 100 хувийн хөрөнгө оруулалтаар Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц ашиглалтад орж тус сумын 3 залуу гэр бүл, Сайхандулаан суманд 6 айлын орон сууцанд 3 байгууллагаас 6 залуу гэр бүл, Эрдэнэ суманд 27 айлын орон сууц ашиглалтад орж 10 орон сууцыг төрийн албан хаагчийн орон сууцын зориулалтаар худалдан авч, төсвийн 5 байгууллагын 10 албан хаагч залуу гэр бүлүүдийг дэмжиж орон сууцаар ханган 27 айлын орон сууцанд 17 залуу гэр бүл хамруулсан. Нийт 4 сумаас 36 залуу гэр бүлийг орон сууцанд хамруулсан. | |
| 108 | | 125. Залуучуудын хөгжил, оролцоо, эрх хамгааллын талаарх төрийн бодлого шийдвэр, дүрэм журмын хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | | | | | Залуучуудын хөгжлийн төвөөс мэргэжил сонголтын чиглэлээр “Ирээдүйн ээзд-2023” аян, “Мэргэжил сонголтоо хийсэн үү? сэдэвт сургалт, “Хичээлийн жилийн анхны уулзалт" зэрэг 5 удаагийн арга хэмжээ, сургалт зохион байгуулж Сайншанд сумын ЕБС-ийн 10-12 дугаар ангийн нийт 1180 сурагчдыг хамруулж энэ талын мэдээлэл, зөвлөгөө өгч, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгууллаа. Сайн дурын сарыг дэмжих ажлын хүрээнд “Нэг хамт олон-Нэг сайн дурын ажил” 3 төрөлт уралдаант аяныг зарлаж "Сайн дурын ажил гэж юу вэ? эшлэлийн уралдаанд 150 хүүхэд, сайн дурын ажлын action зургийн уралдаан, Reel уралдаанд нийт 43 байгууллага хамт олон оролцож 884 идэвхтэн хамрагдаж 3419 хүнд хүрсэн. Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр “Залуучуудын бодлогын хэлэлцүүлэг”, “Оролцоно төлөөлнө”, | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | “Эмэгтэйчүүдийн манлайлал” зэрэг 5 сургалт, "Залуусаа сонсох өдөр", Z generation interview, Иргэний мэдэх эрхийн сургалт, "Залуусын дуу хоолой" хэлэлцүүлэг зэрэг 6 төрлийн арга хэмжээг зохион байгуулж нийт 709 залуучуудыг хамруулж тэдний дуу хоолой, үзэл бодлыг сонсон орон нутгийн удирдлагуудад хүргэлээ. Нийт 32 сургалт, 30 арга хэмжээнд 8512 өсвөр үе, залуучуудыг хамрууллаа. | |
| 109 | 2.6.1. “Алсын хараа -2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, стандарт шаардлагад нийцсэн соёл урлагийн байгууллагын барилга байгууламжийн тоог нэмэгдүүлнэ | 123. Хамарын хийдэд ноён хутагт Д.Данзанравжаагийн нэрэмжит соёл аялал жуулчлалын цогцолбор байгуулах төслийг эхлүүлэх | 2022 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | 70% | Говийн ноён хутагт Д.Данзанравжаагийн нэрэмжит "Хутагтын өргөө, гэр театрын барилга" барих зураг төсвийн ажлыг "Сант номун"ХХК-иар хийлгэж 358,1 сая төгрөгийн өртөг бүхий үзэгчдийн танхим, тайз, тайзны арын өрөө, хурлын өрөө гэх мэт 232.58 м2 талбай бүхий барилга байгууламж, 0,3 га ногоон байгууламжийн төлөвлөлтийг гаргуулсан. Ханбаянзүрх хайрханы гэрэлтүүлэг зам талбайг өргөтгөж, засварлах, Шамбалын орон, Ханбаянзүрх хайрхан орчимд нийтийн бие засах газрууд, Хамарын хийдийн Шамбалын орныг 108 агуйтай холбосон автозам, зогсоол хийх ажил, Хунгийн хөшөө шинээр барих, Сайншанд-Хамарын хийд чиглэлийн автозамын засвар шинэчлэлийн ажлуудыг хийж аялагчдын ая тухтай аялах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд анхаарч орон нутгийн төсвөөс 2.0 тэрбум орчим төгрөгийг зарцуулсан. | 90% |
| 110 | | 124. Сайншандад 700 хүний суудалтай "Саран Хөхөө" шинэ театрын барилга барих | 2021 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | - | Улсын төсвийн 18.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд суманд 700 хүний суудалтай "Саран Хөхөө" театрын барилга шинээр барих ажлыг "Болор-Аграмба " ХХК 2021 оны 05 сарын 17-ны өдрөөс эхлэн гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын зоорийн давхрын гадна, дотор ханын өрөг угсралтын ажил, шавардлагын ажил, 1, 2 дугаар давхрын гадна ханын өрөг угсралтын ажил бүрэн дуусаж оффисын хэсэг буюу У19-У23 тэнхлэг дагуух 10.55 түвшин дэх | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хучилтын хийцийн ажил 95%-тай хийгдсэн.  У14-У18, Х1-Х7, Х22-Х28 тэнхлэгт харьяалагдах Р-15, ХР-16, ХР-17, ХР-19, Р-13, Р-18 рамуудын 12.65 түвшин дэх угсралтын ажил 70%-тай хийгдэж байна. Шилэн фасадын рам болон шил, барилгын 24м-ын алслалд хийгдэх трапец хэлбэрийн ган татангыг үйлдвэрлүүлэхээр БНХАУ-ын улсын үйлдвэрт захиалга өгөөд байна. Барилгын карказ угсралтын ажил- 85%, гадна ханын өргийн ажил-80%, дотор ханын өргийн ажил-50%, барилгын нийт явц 65%-тай байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн тайланг үндэслэн өссөн дүнгээр нийт 8.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосноос 2023 онд 5,5 тэрбум төгрөгийг олгож тайлант онд төлөвлөсөн барилга угсралтын ажлын гүйцэтгэл бүрэн хийгдсэн. | |
| 111 | | 125. Замын-Үүд суманд 500 хүний суудалтай соёлын ордон барих | 2021 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | - | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Замын-Үүд суманд 500 хүний суудалтай Соёл урлагийн ордны барилга барих" ажлыг гүйцэтгэгчээр “РСТ” ХХК шалгарч гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж байгаа ба барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн тайланг үндэслэн өссөн дүнгээр нийт 6,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосноос 2023 онд 3,8 тэрбум төгрөгийг олгож тайлант онд төлөвлөсөн барилга угсралтын ажлын гүйцэтгэл бүрэн хийсэн.  Барилга угсралтын нийт ажлыг гүйцэтгэл 80%-тай байна. | 90% |
| 112 | 2.6.2. Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангаж, “Цахим соёл”  арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 127. Номын санд “Үүлэн сервэр” электрон каталогийг нэвтрүүлж, номын фондыг нэмэгдүүлж, интернэтэд суурилсан үйлчилгээг хүргэх | 2021 - 2024 | Электрон каталогт оруулсан номын тоо, Үйлчлүүлсэн иргэдийн тоо | Электрон каталогт оруулсан номын тоо, Үйлчлүүлсэн иргэдийн тоо | | Үйлчилгээг идэвхжүүлж ном олголтын электрон хувилбарыг 50%-д хүргэх | Номын сангийн дотоод үйлчилгээгээр 8501 ширхэг ном олгож, 4920 иргэн үйлчлүүлсэн. Электрон катологийг ашиглан номын тооллогыг цахим болон нэг бүрчилсэн бүртгэлтэй тулган хийж гүйцэтгэсэн. Бүх төрлийн нийт 29651 ширхэг ном тооллогоор оруулсан.  Үүлэн серверийн "Dornogovi.Lib4u.net" электрон катологиор 1654 уншигч үйлчлүүлж, шинээр 320 ширхэг номыг цахим санд | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүртгэж электрон каталогид оруулсан. Номын баяжилт 2020 онд 300 ширхэг ном, 2022 онд 300 ширхэг ном, 2023 онд одоогийн байдлаар 329 ширхэг номыг хандив болон худалдан авсан байна. Номын сангийн цахим бүртгэлд бүртгэж авсан. 2020 онд зөвхөн номын сан дотроо электрон каталогийн хайлтыг хийж 220 уншигч ном хайж, 2022 онд үүлэн сервэртэй болж иргэд байгаа орчноосоо хайлтыг чөлөөтэй хийж 509 уншигч ном хайсан байна. 2023 онд 1904 иргэн номын сангаар үйлчлүүлж сүүлийн жилүүдэд цахим ном хайж үйлчлүүлж буй иргэдийн тоо өсөж байна. | |
| 113 | | 128. Соёлын байгууллагуудын үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэх | 2021 - 2024 | Цахим технологи нэвтрүүлсэн байгуулпагын тоо 1 | Цахим технологи нэвтрүүлсэн байгуулпагын тоо | | 3 | Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг тохиолдуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр үндэсний бахархал, өв соёлыг сурталчилсан, үндэсний онцлогийг агуулсан "Адистэд хурсан гайхамшиг" тусгай үзэсгэлэнг Чингис хаан музейд зохион байгуулж, 130 гаруй төрлийн эд өлгийн зүйлсийг дэлгэн "AR" технологиор дамжуулан гар утсаараа үзмэрийн мэдээллийг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн шинэлэг ажлыг зохион байгуулсан. Мөн "AR Mongolia" компаниар гар утасны "Danzanravjaa museum" аппликейшныг хийлгэж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Төхөөрөмж хөгжүүлэлтэд нийт 60,0 сая төгрөгийн үнэлгээтэй хийгдсэн. Үүлэн серверийн "Dornogovi.Lib4u.net" электрон катологиор 1654 уншигч үйлчлүүлж, шинээр 320 ширхэг номыг цахим санд бүртгэж электрон катологид оруулсан. 2022 оноос аймгийн номын сан “Үүлэн сервер” электрон катологиор цахим үйлчилгээг үзүүлж эхэлсэн бөгөөд 2023 онд цахим үйлчилгээний тоо нэгээр нэмэгдэж Говийн ноён хутагтын музейд AR технологийг нэвтрүүлж аппликейшинд 7 ширхэг соёлын хосгүй үнэт үзмэр болон ноён | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хутагтын 3D дүрийг шинээр нэвтрүүлсэн VR аппликейшинд 60 ширхэг үзмэрийг оруулж 1109 иргэн үзэж сонирхсон байна. 2020-2023 оны хооронд соёлын салбарт цахим үйлчилгээг хоёроор нэмэгдүүлсэн. | |
| 114 | | 129. Соёл урлагийн байгууллага, сургууль цэцэрлэгийн дуу хөгжмийн багш, мэргэжлийн уран бүтээлчдийг сургаж бэлтгэх | 2021 - 2024 | Бэлтгэгдсэн багш, уран бүтээлчийн тоо 9 | Бэлтгэгдсэн багш, уран бүтээлчийн тоо3 | | 5 | СУИС-д дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж байгаа 9 оюутны сургалтын төлбөрийг төлж суралцах боломжоор ханган орон нутагт дутагдалтай байгаа боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Дээрх оюутнуудаас 1 суралцагч төгсөн ирж Сайншандын ЕБС-д дуу хөгжмийн багшаар ажиллаж байна. Мөн Аймгийн Засаг даргын 2022 оны 04-р сарын 28-ний өдрийн А/280 захирамжаар Гоцлол бүжигчин С.Мягмарсүрэн нь Улаанбаатар хотын “Сити” их сургуулийн эчнээ ангид, бүжгийн найруулга, бүжгийн багш мэргэжлээр 2,5 жилийн хугацаатайгаар 2021 оноос эхлэн суралцаж 2023 оны 06 дугаар сарын 05-нд амжилттай төгссөн. Мөн А.Энхнаран нь СУИС-ийн хөгжмийн зохиолчийн эчнээ ангид 4 жилээр суралцаж байна. Улсын Драмын Эрдмийн театр болон "Саран Хөхөө" театр нь хамтын ажиллагааны хүрээнд 2023 оны 02 дугаар сарын 12-нд Улсын Драмын Эрдмийн театрын тайзнаа тоглогдсон Бертольт Брехтийн зохиол, Э. Ёндоншаравын найруулга " Сычуаны сайн хүн" уянгын жүжгийг үзэж өөрийн уран бүтээлд анализ хийх,ажлын байрандаа туршлага солилцох сургалтад тус театрын драм ангийн 6 уран бүтээлчдийг хамруулсан. Мөн Монголд хэрэгжүүлэх соёл урлагийн ODA төсөл хөтөлбөрийн "Орчин үеийн хүүхэлдэйн жүжгийн чиг хандлага" Моно жүжиг буюу нэг хүний хэрэглэгдэхүүн, жүжгийн тоглолт түүний өөрчлөлтийн талаар 2023 оны 10-р сарын 9-нөөс 13-ний хооронд тус театрын жүжигчин Д.Дариймаа нь уг | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сургалтаар өөрийн өдөр тутмын бэлтгэл сургуулилт, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн хамрагдсан. | |
| 115 | | 130. Соёлын байгууллагуудын үйлчилгээнд шинэлэг арга барилыг нэвтрүүлж хүртээмжийг сайжруулах. | 2021 - 2024 | Арга хэмжээний тоо 2, Үйлчилгээ авсан иргэдийн тоо. | Арга хэмжээний тоо 2, Үйлчилгээ авсан иргэдийн тоо | | 2/7000 | Үндэсний бахархал, өв соёлыг сурталчилсан, үндэсний онцлогийг агуулсан "Адистэд хурсан гайхамшиг" тусгай үзэсгэлэнг Чингис хаан музейд зохион байгуулж, 130 гаруй төрлийн эд өлгийн зүйлсийг дэлгэн AR технологиор дамжуулан гар утсаараа мэдээллээ авах боломжийг олгосон. Тухайн зохион байгуулагдаж буй үйл ажиллагааны цагийн төлөвлөлт, арга хэмжээний хөтөлбөрийн талаарх мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлэн, сонирхсон иргэдэд үйлчилсэн. Мөн "AR Mongolia" компаниар гар утасны "Danzanravjaa museum" аппликейшныг хийлгэж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Энэхүү апплейкишнээр иргэд музейн бүх төрлийн мэдээллийг авах боломжтой. Номын сангийн Үүлэн серверийн "Dornogovi.Lib4u.net" электрон катологид 29631 ширхэг ном байршуулж 1654 уншигчид үйлчлүүлсэн. Ном унших сонирхолтой иргэд энэхүү цахим платформыг ашиглан ном унших боломжоор хангагдсан. СГЗ Ш.Гүрбазарын зохиол, Э.Идэрболдын найруулга “Гэтэлгэх мөр” хөгжимт драмын жүжигт 45 уран бүтээлчид оролцож тайзнаа 10 удаагийн тоглолтоор нийт 2100 гаруй үзэгчдэд толилуулсан. | 70% |
| 116 | 2.6.3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, орон нутгийн онцлог шингэсэн соёлын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ | 131. Төрийн шагналт, “Болор цом”-ын эзэн яруу найрагчдын “Эх орон-Өв уламжлал” яруу найргийн чуулган зохион байгуулах | 2021 - 2024 | 0 | Зохион байгуул сан арга хэмжээний тоо, Оролц сон яруу найрагч ийн тоо | | - | “Эх орон-Өв уламжлал” яруу найргийн чуулганы 2021 онд зохион байгуулж Төрийн шагналт -1, Соёлын гавьяат зүтгэлтэн -2, Нацагдоржийн шагналт -3, Болор цомын эзэн -8, МЗЭ-ийн шагналт 16 нийт 25 зохиолч, яруу найрагчид оролцож, уран бүтээлийн дээжээсээ үзэгч олон нийтэд хүргэсэн. Уг арга хэмжээг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 14.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн, иргэдийн оюуны соёл сэтгэлгээнд хөрөнгө оруулалт хийж, яруу найрагчдын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүтээлийг сурталчлан таниулсан. | |
| 117 | | 132. Баяр наадам, тэмдэглэлт ой, томоохон арга хэмжээнд зориулсан уран бүтээлийг дэмжиж ажиллах | 2021 - 2024 | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо 2 | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо | | 3 | "Саран Хөхөө" театр Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойд зориулан “Гэтэлгэх мөр” хөгжимт драмын шинэ жүжиг туурвиж, 10 удаагийн тоглолтоор нийт 2100 гаруй үзэгчдэд хүргэсэн. Мөн ойн арга хэмжээг угтан Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Тэмээчдийн холбоотой хамтран “ИХ ГОВИЙН ТЭМЭЭ-2023” тэмээний наадамд Саран хөхөө театрын 34 уран бүтээлч бүрэн хэмжээний урлагийн тоглолтыг 1000 гаруй иргэдийн хүртээл болгосон. Аймгийн Засаг даргын 2023 оны А/331-р захирамжийн дагуу "Эгшиглэнт говь" сум сурталчлах өдөрлөгийг 14 сумын дунд зохион байгуулж, шилдэг үзүүлбэрүүдийн гала тоглолтыг "Соёлын сэргэлт - 2023" арга хэмжээний нээлтийг тохиолдуулан зохион байгуулсан. Соёл урлагийн газар Олон улсын яруу найргийн өдрийг тохиолдуулан Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төвөөс зохион байгуулсан “Алтан бийр-2023” яруу найргийн уншлага, Үндсэн хуулийн өдөрт зориулсан “Тусгаар тогтнолын дуулал” яруу найргийн наадам, Сар шинийн баярыг тохиолдуулан “Амар мэндийн ерөөл” "Мэндийн цэнхэр хадаг" телевизийн 2 контент, "Шашин урлагийн цэнгүүн", Хосуудын баярт зориулсан дагшаа хөгжмийн тоглолт, Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төвөөс хайрын шүлгийн ”Оюу-Ай” яруу найргийн наадмыг зохион байгуулж, 11,102 иргэн үзсэн. Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойн баяр наадмын нээлт "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжиг, "Эгшиглэнт говь" өвлөн уламжлагчдын тоглолт, “Дорнын үдэш” цэнгүүнийг зохион байгуулж, эдгээрт 500 гаруй уран бүтээлч, хүүхэд багачууд, ардын авьяастнууд оролцож орон нутгийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | DSB, DTV-телевиз, УБ хотоос C1, "Eagle" телевизүүдтэй хамтран орон даяар шууд дамжуулан давхардсан тоогоор 200 мянган үзэгчдийн хүртээл болгосон. "Саран Хөхөө" театрын 2 уран бүтээлчийн "Дөрвөн зүгийн эх орон", "Ээжийн цацал" бие даасан тоглолтод дэмжлэг үзүүлж ажилласан ба аймгийн Засаг даргын захирамжаар Баяр наадам, тэмдэглэлт ой, томоохон арга хэмжээнд зориулсан уран бүтээлийг дэмжиж нийт 83,8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | |
| 118 | | 133. Хүүхдэд зориулсан шинэ уран бүтээл тогтмол туурвих. | 2021 - 2024 | Уран бүтээлийн тоо 1 | Уран бүтээлийн тоо | | 1 | "Замын-Үүд сумын Соёл, спортын ордноос “Зөв ирээдүйн төлөө хамтдаа” зорилтот хөтөлбөрийн хүрээнд "Дүрсгүй отголдой" мини театрын хэрэгжүүлсэн “Нэг ангийнхан” сургамжит хүүхдийн драмын жүжгийг Замын-Үүд, Хөвсгөл, Улаанбадрах,Өргөн, Эрдэнэ сумдаар ЕБС-ийн 6-12-р ангийн 1200 хүүхдэд хүргэлээ. Улсын хүүхэлдэйн театртай хамтран Сайншанд, Замын-Үүд сумдад СӨБ-ын болон 1-5-р ангийн 2300 хүүхдийг хамруулан хүүхдийн жүжиг зохион байгууллаа. 2023 оны 02 сард оны шилдэг уран бүтээл шалгаруулах "Мөнгөн Мод", шилдэг хөгжмийн зохиол шилдэг дууны уран бүтээл шалгаруулах "Морин хуур-35" наадмуудад хүүхдэд зориулсан шинэ уран бүтээл "Хүүхдийн дууны цоморлог" бүтээлээр оролцож, дууны төрөлд тэргүүн байр эзэлсэн. "Нэгдүгээрт хүүхэд" уриан дор Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр "Саран хөхөө" театрын "Шидэт бэлгийн эрэлд" зохиомжит үлгэрийн баатруудын тоглолтыг 300 гаруй хүүхэд багачуудад үзүүллээ. Дэлгэрэх суманд зохион байгуулагдсан нэрт морин хуурч Чойн Банзрагчийн нэрэмжит өсвөрийн морин хуурч, уртын дуучдын бүсийн уралдаанд аймгийн Засаг даргын шийдвэрээр 5,0 сая төгрөг шийдвэрлэсэн. Дундговь | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | аймагт Говийн бүсийн аймгуудын дунд зохион байгуулсан “Хүүхдийн соёлын их наадам”-ын хүрээнд “Говийн хүүхдүүд” урлагийн наадамд ЕБС-ийн 2,5,6-р сургуулийн 20 сурагч Данзанравжаагийн бүтээлээр найруулсан шинэ амжилттай оролцон 150 гаруй үзэгчдэд хүргэсэн. 2020-2023 оны үзүүлэлтээр хүүхэд багачуудад зориулсан 7 уран бүтээлийг хийж гүйцэтгэж, 4428 хүүхэд хамруулан соён гэгээрүүлж ажилласан. | |
| 119 | | 134. Нутгийн яруу найрагч, хөгжмийн зохиолчдын дууг нутагшуулах, ардын авьяастнуудын дунд уралдаан зохион байгуулах, тоглолт хийх, шилдэг уран бүтээл, уран бүтээлчдийг сурталчлах | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 2 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 2 | Соёлын төвийн ажилтнууд болон ардын авьяастнуудын хамтарсан "Амьдаа заяа" уран бүтээлийн тоглолтыг Айраг, Даланжаргалан, Алтанширээ, Иххэт сумдад зохион байгуулж 420 гаруй хүнд хүргэсэн. Яруу найрагч Гүрсоронзонгийн "Нөгөө ертөнцийн хүн", Эрдэнэзулайн "Авгалдайн суурин",А.Эрдэнэ-Очир агсны "Хос ном" зэрэг бүтээлд дэмжлэг үзүүллээ. Ая зохиогч М.Тогтохбаяр “Миний дуунууд -2023” уралдаан, МУСТА Д.Туулхишиг “Жарган дуулъя”, Дэлгэрэх сумын ардын авьяастан Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төвийн гишүүн Г.Дарьсүрэн “Чи надаас гэрэлтэнэ" уран бүтээлийн цэнгүүнийг дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа. Дэлгэрэх сумын харьяат МУСТА нэрт морин хуурч Чойн Банзрагчийн нэрэмжит өсвөрийн уртын дуучид, морин хуурчдын говийн бүсийн уралдаанд Аймгийн Засаг даргын А/291 захирамжаар 5,0 сая төгрөг шийдүүлснээс гадна Төрийн соёрхолт Ардын уран зохиолч Б.Догмидын “Санаж сарвайх нутаг, ус мину” уншигч, зохиолчийн уулзалт цэнгүүн зохион байгууллаа. "Эгшиглэнт говь" сумдын соёлын өдрүүдээр 50 гаруй нутгийн яруу найрагч, хөгжмийн зохиолчдын бүтээлийг сэргээх, шинэ уран бүтээлүүдийг танхимаар 4200, цахимаар 2100 гаруй үзэгчдэд | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүргэлээ. Ноён хутагт Д.Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойн баяр наадмаар СГЗ Л.Эрдэнэбатын цомнол "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжиг, Говийн бүсийн "Говийн хүүхдүүд" урлагийн наадамд Хутагтын 8 бүтээлээр, Монголд зочлох жилийн хүрээнд "Нүүдэлчин Дэлхийн соёлын фестиваль"-д нутгийн хөгжмийн зохиолч, яруу найрагчийн 12 бүтээлээр оролцлоо."Намсрайн Батнасан сан"-гийн нэрэмжит "Шинэ зууны наран" найрал дууны анхдугаар уралдаан,Монгол Улсын Төрийн өргөмжлөлт ерөөлч, магтаалч, туульч З.Чулуунбаатарын нэрэмжит анхдугаар наадмыг дэмжиж ажилласан. Улаанбадрах, Алтанширээ, Айраг сумдад ардын авьяастнуудын дунд аймгийн чанартай уралдаан зохион байгуулахад хамтран дэмжлэг үзүүлсэн. | |
| 120 | 2.6.4. Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, судлан сэргээх, өвлөн уламжлуулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна. | 135. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын видео бичлэг, дуу дүрсийг хадгалж, цахим сан үүсгэн, өвлүүлэн үлдээхэд урамшуулах | 2021 - 2024 | Цахим санд хадгалагдсан бүтээлийн тоо 0 Урамшуулсан хүний тоо 2 | Цахим санд хадгалагдсан бүтээлийн тоо Урамшуулсан хүний тоо | | 3/25 | Аймгийн Засаг даргын санаачилгаар зохион байгуулагдсан "Эгшиглэнт говь" сумдын соёлын өдрүүдийн хүрээнд өвлөн уламжлагчдын цахим санг баяжуулан бүртгэлийг шинэчилсэн. Мандах сумын соёлын өдрүүдээр сумын түүхэн он цагийн 10 гаруй баримтат өвийг шинэчлэн гэрэл зургаар баталгаажуулан удаан жил ашиглахаар сайн чанарын материалд буулган хадгаллаа. Шавь сургалтыг хөхиүлэн дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны А/149 дугаар захирамжаар Монгол ардын уртын дууг лимбэ хөгжмөөр битүү амьсгаагаар хөгжимдөх төслийг хэрэгжүүлэгч сургагч багш Б.Отгондүүг шавь сургалт зохион байгуулах боломж нөхцөлөөр хангаж 4ш лимбэ хийхэд зориулж 1,8 тэрбум төгрөгийг шийдүүлэн ажиллалаа. "Соёлын сэргэлт-2023" арга хэмжээний нээлтэд оролцсон зураач гар урчууд, өвлөн уламжлагчдын бүтээлийг Ш.Энхбаяр, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Ю.Эрдэнэбулган нар гэрэл зургаар баримтжуулан авч үлдсэнээс гадна урлагийн тоглолт арга хэмжээг дүрст бичлэгээр баримтжууллаа. Энэхүү арга хэмжээнд зориулан аймгийн Засаг даргын захирамжаар 15,0 сая төгрөгийг шийдвэрлэлээ. Ноён хутагт Данзанравжаагийн мэндэлсний 220 жилийн ойн баяр наадмын хөтөлбөрт “Эгшиглэнт говь”-ийн шилдэг өвлөн уламжлагчдын тоглолт зохион байгуулж тус тоглолтод 40 өвлөн уламжлагчийг хамруулан 4.0 сая төгрөгийн урамшуулал олгохоос гадна “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд орон нутгаа төлөөлөн оролцсон 40 өвлөн уламжлагчид аймгийн Засаг даргын захирамжаар 8.0 сая төгрөгөөр урамшууллаа. Монгол Улсын Төрийн өргөмжлөлт ерөөлч магтаалч З.Чулуунбаатар агсны нэрэмжит улсын наадмын өвлөн уламжлагчдыг урамшуулах энгэрийн тэмдгийн төсөвт аймгийн Засаг дарга 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Нүүдэлчин фестиваль, З.Чулуунбаатар агсны нэрэмжит наадмын язгуур урлагийн тоглолт, эргэн тойрны үйл явцыг DSB телевизээр шууд дамжуулж,бичлэг болгон хадгалсан. | |
| 121 | | 136. Соёлын биет бус өвийг өвлөн уламжпагчдыг алдаршуулах, тоглолт арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 1 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 1 | Аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл урлагийн газраас хамтран “Амар мэндийн ерөөл” сар шинийн нэвтрүүлгийг DTV телевизээр, Сайншанд сумын ИТХ, ЗДТГ “Мэндийн цэнхэр хадаг” сар шинийн нэвтрүүлгийг 23 ардын авьяастнуудыг оролцуулан тоглолт зохион байгууллаа. "Эгшиглэнт говь" сумдын соёлын өдрүүдэд 140 гаруй өвлөн уламжлагч ардын язгуур урлагийн төрлөөр оролцсон. "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд сум тус бүр ардын авьяастнуудын тоглолт, аймгийн хэмжээний уралдаан, өв соёлын наадам, "Малчид дуулж байна", "Уяачид дуулж байна", "Багш нар | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | дуулж байна" зэрэг салбар мэргэжлийн чиглэлээр шинэ авьяастнуудыг олноор нээн илрүүллээ. Мөн Иххэт суманд лимбэ хөгжмийн шавь сургалтыг хичээллүүлж, 3 иргэнийг хамруулсан. Сайншанд хотноо залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх соёлын шинэ орон зайг бий болгон "Open mic" арга хэмжээ, МСҮТ, АШУҮИС-ийн оюутан сурагчдын урлагийн үзлэг наадам зэрэгт СУГ хамтран ажиллалаа. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд орон нутгаа төлөөлүүлэн СББӨ-ийн 7 ай савын хүрээнд 31 өвлөн уламжлагчийг хамруулсан. СББӨ-ийг түгээн дэлгэрүүлж, алдаршуулан сурталчлах зорилгоор Монгол Улсын Төрийн өргөмжлөлт З.Чулуунбаатар агсны нэрэмжит ерөөлч, магтаалчдын наадмыг Мандах суманд, Дэлгэрэх суманд хойд бүсийн өсвөрийн уртын дууч, морин хуурчдын “Өв алтан эрдэнэ” уралдааныг зохион байгууллаа. Тус уралдаан нь соёлын биет бус өвийг хойч үедээ өвлүүлэн уламжлуулахад чухал ач холбогдолтой наадам болсон. Мандах, Улаанбадрах суманд "Адууны өв соёл" арга хэмжээ, Замын-үүд суманд соёлын биет бус өвийн бэсрэг наадмыг хамтран зохион байгуулж амжилттай хэрэгжүүлсэн. “Соёлын сэргэлт-2023” улсын хэмжээний аяныг угтан Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейтэй хамтран 14 сумын 12100 хүнд соёлын үйлчилгээг үзүүллээ. “Соёлын сэргэлт-2023” арга хэмжээнд язгуур урлагийн тоглолт, боловсролын хөтөлбөр, WR, ЖДҮ-ийн үзэсгэлэн худалдаа зэрэг соёлын үйлчилгээг 14 сумын иргэдэд толилуулсан. | |
| 122 | | 137. Музейн сан хөмрөгийг баяжуулж, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг | 2021 - 2024 | Сан хөмрөгийн баяжилт 2, Бүртгэлжүүлсэн үл хөдлөх дурсгалт | Сан хөмрөгийн баяжилт Бүртгэлжүүлсэн үл хөдлөх дурсгалт | | 2/10 | Дорноговь аймгийн Мандах сумын Дэнгийн овоо орчмын “Дорны говь-2022” археологийн малтлага, судалгааны ажлын явцад илэрсэн | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүртгэлжүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах | | газрын тоо 198 | газрын тоо | | | олдворуудаас 4 ширхэг эд өлгийн зүйлийг музейн үндсэн сан хөмрөгт бүртгэж авсан. Ноён хутагт Данзанравжаагийн мэндэлсний 220 жилийн ойн баяр наадмын хүрээнд зохион байгуулсан "Ноён хутагт Данзанравжаа" уран бүтээлийн уралдаанд оролцсон 4 уран бүтээлч өөрсдийн бүтээлээ МССТ-д дурсгаснаар хөмрөгийг баяжууллаа. МССТ-өөс "Соёлын өвийн цогц үйлчилгээ-суманд" арга хэмжээг Айраг, Улаанбадрах суманд амжилттай зохион байгуулж Айраг сумын соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, 2022 оны "Язгуур алтан өв" СББӨ-ийн анхдугаар наадмын шилдэг өвлөн уламжлагч Б.Баасандоржоос өөрийн үе дамжин хэрэглэж, хадгалж ирсэн хэлхээ тоонотой таван ханатай гэрийн мод, ширэн айрагны хөхүүрийг музейн сан хөмрөгт бэлэглэснийг музейн сан хөмрөгөө үнэт үзмэрээр баяжууллаа. Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогоос хойш бүртгэгдсэн болон хамгаалалтад авах шаардлагатай 19 дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар сумдад чиглэл өгч ажилласнаар Хатанбулаг, Эрдэнэ, Даланжаргалан сумын соёлын төвөөс 12 үл хөдлөх дурсгалуудыг пайз, тэмдэг тэмдэглэгээтэй болгосон. 2020 онд музейн сан хөмрөгт 16 дэсийн 65 ширхэг, 2021 онд 2 дэсийн 2 ширхэг, 2022 онд 2 дэсийн 15 ширхэг, 2023 онд 16 дэсийн 16 ширхэг буюу нийт 36 дэсийн 98 ширхэг үзмэрээр сан хөмрөгийн баяжуулалт хийсэн. | |
| 123 | | 138. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгийг хөтлөх үндэсний уламжпалыг хэвшүүлэх зан үйлийг сургах, сургалт нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэх | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 2, Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо | | 20/1400 | Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолоор баталсан "Угийн бичгийг хөтлөх журам", УИХ-ын "Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай" 2022 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах арга | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хэмжээний хүрээнд Соёлын байгууллагууд нь "Удам судраа мэдэж угийн бичгээ хөтөлцгөөе", "Угийн бичгээ хамтдаа бичиж удмын түүхээ хамтдаа бүтээцгээе" аяныг өрнүүлэн 60 өрхийн угийн бичгийг шинээр эхлүүлэн соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг хийсэн. “Нэг ахмад- Нэг бүтээл” арга хэмжээнд 50 ахмад оролцож, насан туршийн боловсролын төвийн багш Ц. Мөнхсаруул угийн бичиг хөтлөх арга зүй сургалтыг зохион байгуулж хөдөөгийн багийн 87 айл өрхөд “Овог удам” нэртэй гарын авлага тараасан. Төрийн албан хаагчдыг хамруулан угийн бичиг хөтлөх арга зүйн сургалт мэдээллийг хүргэж ажилласан. Замын-үүд сумын Соёл, спортын ордноос 20 гаруй удаагийн сургалтыг Ерөнхий боловсролын сургууль болон албан байгууллагуудад зохион байгуулж, 422 иргэн, 457 сурагчийг хамруулж ажилласан. Ингэснээр 222 айл өрх угийн бичиг хөтөлж эхлэн, 240 хүүхэд угийн бичгээ тодорхой хэмжээнд хөтөлж сурсан. Нийтдээ 25 удаагийн сургалт, мэдээлэл хийж, 1215 гаруй иргэдийг хамруулж, угийн бичиг хөтлөх өрхийн тоо энэ онд өмнөх оноос 25 айл өрхөөр нэмэгдсэн. | |
| 3. Эдийн засгийн бодлого | | | | | | | | | |
| 124 | 3.1.1. Банк санхүүгийн зах зээлийн эрсдэл даах, найдвартай байдлыг сайжруулна. | 139. Банкны үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх замаар аж ахуйн нэгж, иргэдийн хуримтлал үүсгэхэд анхаарч бэлэн бус төлбөр тооцоог дэмжих | 2021 - 2024 | Хадгаламжийн үлдэгдэл 162 тэрбум төгрөг | Хадгаламжийн үлдэгдэл | | 175 тэрбум төгрөг | Аймгийн хэмжээнд нийт хадгаламжийн үлдэгдэл 202.1 тэрбум төгрөг болж 2022 онтой харьцуулахад 41.0 тэрбум төгрөгөөр, харилцах дансны үлдэгдэл 108.7 тэрбум болж 32.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн. Хадгаламж эзэмшигчийн тоо 73.7 мянга болж өмнөх оноос 2.8 мянгаар, харилцах данс эзэмшигч 177.6 мянга болж 12.9 мянгаар нэмэгдсэн байна. “Нээлттэй Дорноговь”зорилтот жилийн хүрээнд иргэд, олон нийтэд банкны бүтээгдэхүүн үйлчилгээ болон иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр мэдээ, мэдээллийг түгээж ажилласан. Орон | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нутгийн DTV телевиз, "Өнөөдрийн Дорноговь" сонинтой хамтран арилжааны 6 банк болон Насан туршийн боловсролын төвөөс “Дэлхийн мөнгөний 7 хоног” аяныг зохион байгуулж 866 хүүхэд, 50 иргэнд хуримтлалын ач холбогдлын талаарх мэдээллийг хүргэсэн.  Мөн банкны ажилчдын дунд "ТИК ТОК" уралдаан зарлаж цахимаар 20174 иргэнд мэдээлэл хүргэсэн. | |
| 125 | | 140. Иргэдийн санхүүгийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэн санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлэх | 2021 - 2024 | Сургалтад хамрагдсан хүний тоо 620 | Сургалтад хамрагдсан хүний тоо | | 1000 | Орон нутгийн DTV телевиз, "Өнөөдрийн Дорноговь" сонинтой хамтран арилжааны 6 банк болон Насан туршийн боловсролын төвөөс “Дэлхийн мөнгөний 7 хоног” аяныг зохион байгуулж 866 хүүхэд, 50 иргэнд хуримтлалын ач холбогдлын талаарх мэдээллийг хүргэсэн.  Мөн банкны ажилчдын дунд "ТИК ТОК" уралдаан зарлаж цахимаар 20174 иргэнд мэдээлэл хүргэсэн. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Цагдаагийн газар болон арилжааны банкнуудтай хамтран иргэдийн цахим залилангаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг масс мессежийг 4 үүрэн телефоны нийт 24916 хэрэглэгчдэд хүргэсэн. | 90% |
| 126 | | 141. Иргэдийн санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхэд анхаарч хугацаа хэтэрсэн зээлийг бууруулж зээлжих чадварыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Чанаргүй зээл 5.5 хувь | Чанаргүй зээл | | 5,0% | Банкнуудын зээлийн багц 306.8 тэрбум төгрөг, чанаргүй зээл 18.1 тэрбум буюу нийт багцын 5.9 хувийг эзэлж байсан бол энэ онд зээлийн багц 397.7 тэрбумд хүрч 90.9 тэрбум төгрөгөөр өссөн, хугацаа хэтэрсэн зээл 4.4 тэрбум буюу зээлийн багцын 1.1 хувь болж өөрчлөгдсөн нь өмнөх оноос 1.2 функтээр буурсан байна. Замын-Үүд сум дахь хилийн боомтын үйл ажиллагаа сэргэж байгаа нь банкны хугацаа хэтрэлт 3.6-1.9 тэрбум төгрөг болж багцад эзлэх хугацаа хэтрэлт 3.6-2.1% хүрч буурсан эерэг нөлөө үзүүлсэн. | 100% |
| 127 | 3.1.2. Төсвийн хөрөнгийг орон нутгийн хөгжилд чиглүүлэн үр ашигтай, хариуцлагатай зарцуулах | 142. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, татвар | 2021 - 2024 | Цахимжуулалтын хувь 81,2 Татвар төлөгчдийн тоо 18984 | Цахимжуулалтын хувь  Татвар төлөгчдийн тоо | | 90% 21975 | Сүүлийн 3 жилийн хугацаанд татвар төлөгчдөд чиглэсэн бүх төрлийн татварын үйлчилгээг  100 хувь цахимжуулсан бөгөөд НӨАТ-ын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлого баримтална. | төлөгчдийг татварт хамруулах хүрээг нэмэгдүүлэх | | | | | | хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор "Баримтаа аваарай" сошиал аяныг аймгийн хэмжээнд жил бүр зохион байгуулж, "Нэхэмжлэлд суурилсан" татвар ногдуулалт, төлөлтийн системээр цахим банкаар татвараа төлөх,тайлагнах боломжийг бүрдүүлсэн. 2021-2023 онд давхардсан тоогоор ААНОАТ-ын тайланг 2749, НӨАТ-ын тайланг 6557, суутган тайланг 9323, бусад төрлөөр 5852 татвар төлөгч цахимаар тайлангаа илгээсэн нь тайлангийн хамрагдалтын хувь жилд 3,3-5,2 хувиар өссөн. Замын-Үүд, Сайншанд, Даланжаргалан, Алтанширээ, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг сумдад татвар төлөгчдийн ажлын байранд явуулын пос машинаар татвар хураах үйлчилгээг үзүүлснээр давхардсан тоогоор 5822 татвар төлөгчийн 1357,4 сая төгрөгийн татварыг хураан улс, орон нутгийн төсөвт оруулсан. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, иргэдэд шуурхай үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлж Татварын хэлтсийн байранд банкны үйлчилгээг арилжааны банктай хамтран байршуулж, бэлэн болон бэлэн бусаар татвар хураах ажлыг зохион байгуулан ажилласан. | |
| 128 | | 144. Төсвийг зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн сахилга батыг сайжруулах | 2021 - 2024 | Зардлын хэмнэлтийн хувь 2,4 | Зардлын хэмнэлтийн хувь | | 3,3 | Тайлант 2023 онд орон нутгийн төсөвт 93,8 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 81,2 хувьтай байна. Орон нутгийн төсвийн орлогын биелэлттэй уялдуулан зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэн төрийн албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой зардал, төсвийн байгууллагуудын халаалтын зардлыг эхний ээлжид санхүүжүүлэх эрэмбэ тогтоож 133,0 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсэн нь | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төлөвлөгөөтэй харьцуулахад 78,4 хувь буюу 49,3 тэрбум төгрөгийн хэмнэлттэй байна. Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу 26 байгууллагад төлөвлөгөөт, удирдах дээд шатны байгууллагын шийдвэрээр 2, байгууллагын хүсэлтээр 1, иргэний өргөдлөөр төлөвлөгөөт бус 1 нийт 30 байгууллагад санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 425,4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 11 албан шаардлага, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 90 төлбөрийн акт тогтоон, 283,3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулж ажилласан. | |
| 129 | | 145. Төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийх хяналт шалгалтын үр өгөөжийг дээшлүүлэх | 2021 - 2024 | Шилэн дансны мэдээллийн хувь 99,3 | Шилэн дансны мэдээллийн хувь | | 99,7 | Аймгийн Засаг даргын баталсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөө болон төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтыг 2023 онд нийт 30 байгууллагад хийж, 425,4 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлэн 283,3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулсан нь 2020 онтой харьцуулахад илрүүлсэн зөрчил 44,3 сая төгрөгөөр, төлбөр барагдуулалт 106,3 сая төгрөгөөр өссөн байна. Монгол Улсын “Шилэн дансны тухай хууль”-д заасны дагуу 14 сумын 45 төсвийн байгууллага, аймгийн төвийн 10 байгууллага, нийт 55 байгууллагын цахим хуудсанд төсөв санхүүгийн мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн эсэхэд хяналт шалгалтыг жил бүр зохион байгуулсан. Цахим хуудсанд 2022 онд 7486 мэдээллийг хугацаанд нь, 522 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь байршуулбал зохих мэдээллийн 93,5 хувь байгаа нь өмнөх онтой харьцуулахад 4,6 функтээр буурсан үзүүлэлттэй байна. Дорноговь аймаг сүүлийн 3 жилд шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулбал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зохих мэдээллийг 93,5-98,6 хувиар байршуулж улсын хэмжээнд эхний 3 байранд эрэмбэлэгдсэн. | |
| 130 | | 146. Улсын секторын нягтлан бодох бүртгэлийг онлайн системд бүрэн шилжүүлэх | 2021 - 2024 | Цахимд шилжүүлэх хувь 90 | Цахимд шилжүүлэх хувь | | 100% | Төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг төсвийн байгууллагад мөрдүүлэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн багцад хамаардаг 117 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн “CT system” программд бүрэн шилжүүлсэн. | 100% |
| 131 | | 147. Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт”-ын бодлого хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Цахимд шилжүүлэх хувь 85 | Цахимд шилжүүлэх хувь | | 100% | Аймгийн худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 73 төсөл арга хэмжээг 100 хувь, 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан 84 төсөл арга хэмжээг 100 хувь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтын дэлгэрэнгүй төлөвлөгөө цэсэд байршуулан Сангийн яамаар батлуулсан. Тендер шалгаруулах урилгыг tender.gov.mn болон “Зууны мэдээ” өдөр тутмын сонинд байршуулж олон нийтэд нээлттэй зарласан. | 100% |
| 132 | 3.1.3. Төрийн худалдан авах ажиллагааг хариуцлагажуулан орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудыг бодлогоор дэмжинэ. | 148. Тендер шалгаруулалтад хуулийн дагуу давуу эрх нь тооцогдох боломж бүхий аж ахуйн нэгжүүдийн чадавхыг нэмэгдүүлж, орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтлах | 2021 - 2024 | Давуу эрхийн 10 хувь | Давуу эрхийн хувь | | Давуу эрхийн 70 хувь | Аймагт зарлагдсан төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгохоор тусгагдсаны дагуу 2022 онд 9 аж ахуйн нэгж, 2023 онд 1 аж ахуйн нэгжээс орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах, дотоодод үйлдвэрлэсэн бараа материал худалдан авах хүсэлт ирж, нотлох баримтуудыг үндэслэн дотоодын давуу эрхийн зөрүүг 2022-2023 онд нийт 1410.6 сая төгрөгөөр хийсвэрлэн тооцсон.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн дагуу тендерт оролцогч давуу эрх тооцуулах нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.<br>Давуу эрх олгох бол санал болгож буй үнийг хууль болон холбогдох | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцох тухай тендер шалгаруулалтын заавачилгаанд тусгасан. Худалдан авах ажиллагааны төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгохоор тусгагдсаны дагуу 2023 онд нийт тендерт шалгарсан ХХК-ын 44% нь орон нутгийг ХХК байна.Энэ нь 2020 онтой харьцуулахад 10%-иар өссөн үзүүлэлттэй байна. | |
| 133 | 3.1.4. Даатгалын хариуцлагын тогтолцоог сайжруулан, хамрах хүрээг нэмэгдүүлнэ | 149. Албан журмын даатгалын холбоо, даатгал, хөрөнгийн үнэлгээний компаниудын хохирол барагдуулах ажиллагааны уялдаа холбоог сайжруулах | 2021 - 2024 | Арга хэмжээний тоо 1 | Арга хэмжээний тоо | | 3 | Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийн хэрэгжилт, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, даатгалын хохирол, нөхөн төлбөрийг барагдуулах, иргэд жолооч нарын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, хөрөнгийн үнэлгээг бодитой хийх талаар аймагт үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа тусгай зөвшөөрөл бүхий 8 даатгалын компани, хөрөнгө үнэлгээний 2 компани болон Цагдаагийн газрын замын цагдаагийн тасаг, АЖДХолбооны салбарын уялдаа холбоог ханган 2023 онд 2 удаа уулзалт арга хэмжээг зохион байгуулсан.  Автотээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношлогоог зохион байгуулахад 04-р сард даатгалын компани, автотээврийн төвтэй хамтран сумдад ажиллаж, жолоочийн даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөрийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан. | 100% |
| 134 | | 150. Даатгалын байгууллагын нөхөн төлбөр олголтыг сайжруулах | 2021 - 2024 | Нөхөн төлбөр олголтын хувь 80 | Нөхөн төлбөр олголтын хувь | | 95,0 | Аймаг дахь даатгалын компаниуд 300.0-500.0 мянган төгрөгийн жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөрийг орон нутагтаа шийдвэрлэн шуурхай олгож байгаа бөгөөд дээрх мөнгөн дүнгээс давсан хохирлыг Цагдаагийн газрын зам тээврийн осол аваар гаргасан тухай тодорхойлолтын хамт төв салбаруудад илгээн 24 цагийн дотор шийдвэрлэж байна. 2023 онд 67 даатгалын тохиолдолд 52,118.5 мянган төгрөгийн нөхөн төлбөр | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | олгосон нь олговол зохих даатгалын нөхөн төлбөрийг 94 хувь байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 4,0 функтээр өссөн үзүүлэлт юм. | |
| 135 | | 151. Иргэдийг даатгалд хамруулах нөлөөллийн ажлыг дэмжих | 2021 - 2024 | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо 1 Иргэдийн даатгалд хамрагдсан тоо 600 | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо Иргэдийн даатгалд хамрагдсан тоо | | 1 1600 | Аймагт үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа даатгалын компаниуд нь тайлант хугацаанд нийт 7146 иргэн аж ахуйн нэгжтэй даатгалын гэрээ байгуулсан нь 2020 онтой харьцуулахад 2552 иргэн аж ахуйн нэгжээр өссөн үзүүлэлттэй байна. 2023 онд даатгалын хугацаа дуусаагүй 15100 гэрээ байна. Жолоочийн хариуцлагын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Өнөөгийн Ялалт" сонинд 4 удаа, аймаг дахь ДТВ, DSB телевизүүдэд 3 удаа нийтлэл, мэдээлэл нэвтрүүлэн, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. | 100% |
| 136 | 3.1.5. Хөрөнгийн зах зээлийг иргэндээ ээлтэй, эдийн засагт өгөөжтэй байдлаар хөгжүүлнэ. | 152. Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны компаниудыг орон нутагт үйл ажиллагаа явуулахад бодлогоор дэмжиж ажиллах | 2021 - 2024 | Үнэт цаасны компанийн тоо 1 | Үнэт цаасны компанийн тоо | | 2 | Хөрөнгийн биржид болон аймагт бүртгэлтэй үнэт цаасны "Бидисек", "Санар", "Гүүдсек" 3 компаниас "Гүүдсек ҮЦК" ХХК тогтмол үйл ажиллагаа явуулж байна. "Гүүдсек ҮЦК" ХХК-тай хамтран 810 иргэн, аж ахуйн нэгжид хувьцаа, үнэт цаасны талаар холбогдох мэдээ мэдээллийг тогтмол өгч 2023 онд 5980 хувьцааны дансыг нээж ажилласан. | 70% |
| 137 | | 153. Үнэт цаас, хувьцааны талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 2 Сургалтад хамрагдах хүний 364 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо Сургалтад хамрагдах хүний | | 2 580 | Тайлант онд арилжааны 5 банкны гаргасан IPO танилцуулгыг "Гүүдсек" компанийн цахим хуудсаар болон салбар нэгжүүд дээрээ сурталчлан, тус компанийн брокерууд цаг тухай бүрд нь иргэдэд данс нээн хувьцаатай холбоотой мэдээллээр хангаж, давхардсан тоогоор 810 бизнес эрхлэгч, иргэдэд үнэт цаас, хувьцааны талаарх мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. | 90% |
| 138 | 3.1.6. Нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлоход шаардлагатай мэдээллийн эх үүсвэртэй болно. | 154. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг төрийн бусад мэдээллийн сантай уялдуулан сайжруулж, хүн ам | 2021 - 2024 | Мэдээллийн сангийн тоо 3 Мэдээлэл ашиглах хувь 100 | Мэдээллийн сангийн тоо Мэдээлэл ашиглах хувь | | 5 100% | "Засаг захиргаа, анхан шатны нэгжид хөтлөгдөж буй хүн ам, өрхийн мэдээллийн сангийн шинэчилсэн мэдээллийг үнэн зөв, бодитой хөтлөх, баяжилтыг цаг хугацаанд нь хийх зорилгоор сар бүр алдааны | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зүйн нарийвчилсан мэдээллийг гаргахад ашиглах | | | | | | протоколыг татан авч, сумдад хүргүүлэн холбогдох заавар, зөвлөмжийг өгч 3086 орчим алдааг засварласан. ХАӨМС-нд ургийн овог, овог нэр, регистрийн дугаар зөрүүтэй 35 иргэний мэдээллийг, иргэдийн албан ёсны баримт бичгийг үндэслэн ҮСХ-нд хүргүүлж засварлуулсан. ХАӨМС-ийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, мэдээллийн сангийн нууцлалыг ханган ажилласан бөгөөд шинээр томилогдсон 5 багийн Засаг даргын хэрэглэгчийн мэдээллийг өөрчилж ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлсэн. "Хүн ам өрхийн мэдээллийн сан"-ийн чанарыг сайжруулах, сарын аяны үйл ажиллагааг эрчимтэй зохион байгуулснаар өрх, хүн амын тоо, тэдгээрийн шилжилт хөдөлгөөн, амьдарч буй орчин, орон сууцны нөхцөл зэрэг судалгаа, мэдээллийн чанар сайжирсан. Хүүхдийн мөнгийг 2023 онд хүн ам, өрхийн мэдээллийн сангийн дата мэдээлэлд үндэслэн олгох шийдвэр болон түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд тус сангийн хүн ам, өрхийн нарийвчилсан үзүүлэлтүүдийг ашиглав. Сум, орон нутгийн хэмжээнд нийгмийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхдээ өрх, хүн амын нийгмийн байдлын талаарх судалгааны албан ёсны эх үүсвэр болгож тус санг тогтмол ашиглаж хэвшсэн. | |
| 139 | | 155. Мал, тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулж, хөдөө аж ахуйн салбарын түүвэр судалгаанд хамрагдах өрхийн жагсаалт болон сэдэвчилсэн судалгааг гаргахад ашиглах | 2021 - 2024 | Мэдээлэл ашиглах хувь 100 | Мэдээлэл ашиглах хувь | | 100% | "Мал, тэжээвэр амьтдын 2018-2022 оны тооллогын үр дүнгээр “Хөдөө аж ахуйн салбарын 2022 оны танилцуулга”-ыг боловсруулан, бэлтгэн гаргалаа. Судалгаанд аймгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, малын тоо, насаар, төллөх малын тооны өөрчлөлт, төлийн тооны өөрчлөлт, худаг ус, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хашаа, малчдын тоо, тэдний соёл, ахуйн нөхцлийн талаарх мэдээлэл бүхий 17 зураг, 31 хүснэгт, 6 бүлгийн 49 хуудас судалгааг боловсруулж, 630 цахим хэрэглэгчдэд тархааж ажилласнаар цахим хэрэглэгчдийн тоог өмнөх оноос 30-аар нэмэгдсэн. | |
| 140 | | 156. Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тайланг боловсруулах, тархаах, шуурхай, хүртээмжтэй байдлыг сайжруулах, тооллого судалгааны мэдээллийн үр өгөөжийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Мэдээлэл ашиглах хувь 100 | Мэдээлэл ашиглах хувь | | 100% | “Мэдээ, тайлангийн графикийг шинэчлэн батлах тухай” ҮСХ-ны даргын 2022 оны А/229 тоот тушаалаар батлагдсан “ҮСХ-нд нийслэл, аймгийн статистикийн хэлтсээс 2023 онд ирүүлэх албан ёсны статистик мэдээ, тайлангийн график”-ийг үндэс болгон албан ёсны статистикийн 43 нэр төрлийн мэдээ, тайлан, 1 төрлийн тооллого, 5 төрлийн түүвэр судалгаанд хамрагдвал зохих сум, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг бүрэн хамруулан долоо хоног, сар, улирал, жилийн давтамжтайгаар мэдээллийг цуглуулан авч 8,588 нэгж мэдээг графикт хугацаанд нь ҮСХ-нд дамжууллаа. 2023 оны 10 сард үнийн мэдээг 42 удаа, жилийн эцсийн танилцуулгыг 1 удаа, сарын нийгэм, эдийн засгийн танилцуулгыг 10 удаа, улирлын болон салбарын инфографикийг 5 удаа, тэмдэглэлт баярын өдрүүдтэй холбоотой инфографикийг 3 удаа, сар бүрийн нийгэм эдийн засгийн байдлын тухай танилцуулгын мэдээллийг 10 удаа, статистик динамикийг 23 удаа, "Хөдөө аж ахуйн салбарын судалгаа-2022", "Хүн ам өрхийн үндсэн үзүүлэлт-2022", "Амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлтийн судалгаа-2022", "Худалдаа үйлчилгээний салбарын танилцуулга-2022", "Аж үйлдвэр, барилгын салбарын 2022"" танилцуулгыг тус бүр 1 удаа цахим хуудсанд байршуулж, иргэд, байгууллагуудыг татан авч үйл ажиллагаандаа ашиглах нөхцөлийг хангасан. Тайлант хугацаанд статистик мэдээллийн албан ёсны вэб | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хуудаст 12520 хэрэглэгч хандаж, статистикийн тооллого, судалгаа, мэдээллийн үр дүнтэй танилцан, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаандаа ашиглажээ. | |
| 141 | 3.2.1. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ | 157. Цагаан суваргын зэс молибдений үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэхэд орон нутгаас ус ашиглуулах гэрээ байгуулах, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох, замын трасс батлах зэрэг дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах, | 2021 - 2024 | Хамтран ажилласан арга хэмжээний тоо 0 | Хамтран ажилласан арга хэмжээний тоо | | 1 | Мандах сумын нутаг дахь Цагаан суваргын зэс молибдений үйлдвэрийг 2025 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн бүтээн байгуулалтын ажлыг 4 сараас эхлүүлж хөвүүлэн баяжуулах үйлдвэр, бутлуурын хэсэг, тээрмийн барилгын краказ угсралтын ажлууд хийгдэж байна. Барилгын ажлыг БНХАУ-ын "Жиансүяанг Жөүхэнг юүэн" ХХК гүйцэтгэж 185 гадаад ажилтан ажиллаж байна. Үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар ирүүлсэн хүсэлтийг аймгийн Газрын харилцаа, Барилга хот, байгуулалтын газраас хянан үзэж, холбогдох зөвлөмж чиглэлийг өгсөн. Галба-өөш, Долоодын говийн сав газрын захиргааны 2023 оны 06 дугаар ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ус ашиглуулах гэрээг байгуулж, усны төлбөрийн орлогод 1,2 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Мандах сумын Засаг даргын Тамгын газраас хог хаягдлын тухай хуулийн дагуу "Хог хаягдлын гэрээ"-г байгуулж төрийн байгууллагаас шаардлагатай үйлчилгээг шуурхай шийдвэрлэн дэмжлэг үзүүлж ажилласан. | 100% |
| 142 | | 158. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайн дэд бүтцийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас ус ашиглуулах гэрээ байгуулах, газар ашиглах эрх олгох, замын трасс батлах зэрэг дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах | 2021 - 2024 | Хамтран ажилласан арга хэмжээний тоо 0 | Хамтран ажилласан арга хэмжээний тоо | | 2 | Иххэт сумын нутагт "Зүүн цагаан дэл" хайлуур жоншны далд уурхайн дэд бүтцийн ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан ашиглаж буй талбайн зориулалтыг хэсэгчилж өөрчлүүлэх хүсэлтийг "Монголросцветмет" ТӨҮГ-ын Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэрээс ирүүлснийг хянаж Иххэт сумын Засаг даргын 2023 оны А/83 дугаар захирамжаар шийдвэрлэн гэрээ байгуулж, гэрчилгээ олгосон. Умард говийн гүвээт-Халхын дундад | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | талын сав газрын захиргаанаас ус ашиглах гэрээг байгуулсан. “Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, тэсэлгээний ажил явуулах” 595 дугаар тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад орон нутгаас дэмжсэн саналыг Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яаманд тус тус хүргүүлж үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. | |
| 143 | | 159. Уул уурхайн баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлэх. | 2021 - 2024 | Боловсруулах үйлдвэр-7 Баяжуулах үйлдвэр-8 нүүрс угаах үйлдвэр-4 Дэмжлэгийн тоо-10 Боловсруулах үйлдвэр-10 Баяжуулах үйлдвэр-11 Нүүрс угаах үйлдвэр-6 | Хамтран ажилласан арга хэмжээний тоо | | Хамтран ажилласан арга хэмжээний тоо 5 | Эдийн засгийн өсөлтийг хангахуйц нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт "Олон ихт баян" ХХК-ийн төмрийн хүдэр боловсруулах үйлдвэр, Сайншанд суманд “Рричвилл гринлинг медиа” ХХК-ийн ган бөмбөлгийн үйлдвэр ашиглалтад орж, захиалгын дагуу бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхэлсэн. Өргөн суманд “Таймон флоуртек” ХХК-ийн жонш баяжуулах үйлдвэр, Иххэт суманд “Төвшин” ХХК-ийн жонш баяжуулах үйлдвэрүүдийн барилгын ажил дууссан Улсын комисс хүлээж аваагүй үйлдвэрийн ажил эхлээгүй хүлээгдэж байна. Алтанширээ сумын нутаг дэвсгэрт баригдаж буй Газрын тос боловсруулах үйлдвэрийн иргэний барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажил 97 хувийн гүйцэтгэлтэй, "Монголиан транс ложистик" ХХК-ийн "Алтанширээт" үйлдвэр технологийн паркийн барилгын ажил 45 хувийн гүйцэтгэлтэй, Айраг сумын нутаг дэвсгэрт "Алтраг ахас" ХХК-ийн манган боловсруулах үйлдвэрийн барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй, Цагаан суваргын зэс молбидены үйлдвэрийн хөвүүлэн баяжуулах үйлдвэр, бутлуурын хэсэг, тээрмийн барилгын суурийн цутгалт, краказ угсралтын ажлууд 60 хувийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гүйцэтгэлтэй, Хөвсгөл сумын нутагт баригдаж буй "Гэрэлт говь" аж үйлдвэрийн угаах үйлдвэрийн барилга, коксийн үйлдвэрийн барилгын ажил 100 хувьтай, төмөр замын далан, гүүрэн байгууламжийн ажил 80 хувийн гүйцэтгэлтэйгээр ажлаа үргэлжлүүлж байгаа бөгөөд барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг гэрээгээр ашиглуулах, ус ашиглуулах, хог хаягдлын гэрээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт гэх мэт нийт 10 удаагийн дэмжлэгийг төрийн байгууллагуудын зүгээс үзүүлсэн. "Алтанширээт" үйлдвэрлэл, технологийн парк байгуулахад шаардагдах 674.44 га талбайг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11/12 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авч үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлсэн. | |
| 144 | 3.2.2. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна. | 160. Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлэх. | 2021 - 2024 | Үйлдвэрийн дэд бүтцийн ажлууд болох авто зам-100%, төмөр зам-100% ЦДАШ-100%, Үйлдвэрийн талбай тэгшлэлт-95%, Хашаа угсралтын ажил-30% | Хамтран ажилласан арга хэмжээний тоо Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл | | 2/80% | Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны бүсэд 640 хүүхдийн сургуулийг барьж ашиглалтад оруулахын зэрэгцээ Шинэ зууны гудамжны автозамд нийт 1860 м2 талбайд нөхөөс хийж, 2,2 км явган хүний зам, дугуйн зам шинээр барьж ашиглалтад оруулснаар иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцөл боломж бүрдүүлэхэд дэмжлэг үзүүллээ. Сайншанд сумын 7 дугаар багт байрлах "Тэс петролиум" ХХК-ийн ШТС-ын тойргоос 1, 6 дугаар багийн офицерын төв зам хүртэлх 3.6 км хатуу хучилттай авто замыг орон нутгийн төсвийн 4,9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр "Дэлгэр баясах зам" ХХК гүйцэтгэж, ажлын явц 50 гаруй хувьтай байна. Дээрх ажлуудын үр дүнд Газрын тос боловсруулах үйлдвэр чиглэл дэх төв замын зорчих хэсгийн ачааллыг бууруулах юм. Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад ажиллаж байгаа 200 гаруй Энэтхэг улсын иргэн, 20 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гаруй Хятад улсын иргэдийг Гадаадын иргэн харьяат газарт тодорхойлолт хүргүүлж ажиллах зөвшөөрлийг гаргуулсан. Сумын малчин иргэд мах, сүү, сүүн бүтээгдэхүүнээ тус үйлдвэрийн шугам хоолойн туслан гүйцэтгэгч "Мега Инженеринг" ХХК-д нийлүүлж, түүхий эдээр ханган ажилласан. Үйлдвэрийн гүн боловсруулалтын технологийн байгууламжуудын барилга угсралтын ажил болох EPC 01 багцын ажил 97 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 145 | | 161. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих, бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлэх. | 2021 - 2024 | ТЭЗҮ боловсруулах ажпын хэсэг байгуулагдсан. | - | | Бүтээн байгуулалтын ажил-80% Дэмжлэгийн тоо-2 | Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн сумдын нутаг дэвсгэрт нийт 1334.66 га газрыг Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газрын зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09/08 тоот тогтоолоор батлуулсан. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах дамжуулах хоолой барих төслийн ерөнхий гүйцэтгэгч “Норинко интернэшнл” ХХК ажиллаж, төсөлд нийт 300 гаруй ажилтан ажиллаж байгаагаас БНХАУ-ын нарийн мэргэжлийн 170 гаруй ажилтан, орон нутгийн 100 гаруй иргэнийг ажиллуулж, ахуйн болон хүнсний бүтээгдэхүүнийг орон нутгийн 30 гаруй аж ахуйн нэгж байгууллагаас татан нийлүүлж байна. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг “Natural Sustainable” ХХК гүйцэтгэж шаардагдах судалгаа мэдээллийг төрийн 3 байгууллагаас гарган өгч дэмжлэг үзүүлсэн. Төслийн ажилд зориулан Алтанширээ, Дэлгэрэх сумдын нутагт 2 худаг гаргах зөвшөөрлийн усны сав газраас олгож, 7000м3 ус ашиглах дүгнэлт, түүхий тос хүлээн авах станцын барилга, байгууламжийг барих, Дэлгэрэх сумын нутагт баригдах дундын халаах, өргөх | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 4-р станцын барилга, байгууламж барих ажлуудын газрын олголтын асуудлыг шийдвэрлэж., барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл, зэргийг холбогдох байгууллагууд гарган өгч үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг бүрдүүлж ажилласан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Газрын тос дамжуулах хоолойн 133,5 км газрын хамгаалалтын зурвасыг 100 метрээр тогтоохоор төлөвлөн 1334,6 га газарт хамгаалалтын зурвас байгуулах саналыг хэлэлцүүлэн холбогдох газарт нь хүргүүлж шийдвэрлэсэн. Бүтээн байгуулалтын ажил 25 хувийн гүйцэтгэлтэйгээр үргэлжилж байна. | |
| 146 | 3.2.3. Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг дэмжинэ. | 162. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа уул уурхайн компанийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах хүртэл арга хэмжээг хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | БОМТ тайлан биелэлтийн хувь 90% Хамтран ажиллах гэрээний тоо-0 Зохион байгуулсан арга хэмжээний тоо-0 | БОМТ тайлан биелэлтийн хувь Хамтран ажиллах гэрээний биелэлт Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 90%/80%/3 | “Нээлттэй Дорноговь” чуулганы хүрээнд уул уурхайн зөвлөгөөнийг уул уурхайн ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 110 аж ахуйн нэгж, байгууллагын 211 төлөөллийг оролцуулан зохион байгууллаа. Зөвлөгөөний үеэр уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэн хамтран ажиллах “Хамтран ажиллах гэрээ”-г "Монцемент билдинг материалс" ХХК, "Говийн шандаст хүлэг" ХХК, "Фриендшип ресурс" ХХК, "Билэгт баялаг" ХХК, "Талст дөл" ХХК, "Олон ихт баян" ХХК, "Си Өү Эй Эл" ХХК, "Монголросцветмет" ТӨҮГ, "Доншен газрын тос /Монгол/" ХХК, "Түмэн айл инвест" ХХК зэрэг 10 компанитай байгуулсан, гэрээний хэрэгжилтийг 2024 оны 2 сард дүгнэнэ. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2022 оны гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөхөд 25 аж ахуйн нэгж байгууллагын дундаж 86.2 хувийн хэрэгжилттэй гарлаа. Тайлант онд уул уурхайн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | олборлох, баяжуулах чиглэлийн 31 компани, дэд бүтцийн 6 компанийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө баталнаас одоогоор 24 компани тайлангаа eic.mn цахим мэдээллийн санд оруулсан. Аймгийн 13 сумын нутагт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай эзэмшигч 43 компани байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг харьяалах сумын Засаг даргаар батлуулж бүртгэлжүүлсэн. Тайлант хугацаанд Улаанбадрах, Сайншанд сумын нутагт тусгай зөвшөөрөлтэй “Монгол Ураниум” ХХК-ийн хайгуулын 2 талбай, Айраг, Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Таванбаатар” ХХК, “Кингдаймонд” ХХК-ийн 2 талбай тус тус цуцлагдсан. Байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй 6 аж ахуйн нэгжийг тус бүр 500.000, нийт 3 сая төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан. Байгалийн нөөцийг зөвшөөрөлгүй ашигласан 9 аж ахуйн нэгжийг тус бүр 5 сая, нийт 45 сая төгрөгөөр торгож, 737,9 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж барагдуулсан. | |
| 147 | | 163. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллах. | 2021 - 2024 | Сайжруулсан зам-213км, Таван-толгой- Зүүн-баян чиглэлийн төмөр зам, Сайн- шанд-Баруун- Урт-Хөөт чиглэлийн төмөр замын ажил эхэлсэн | Хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | | 4 | Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Айраг, Даланжаргалан, Хатанбулаг, Мандах сумдад үйл ажиллагаа явуулж буй 9 аж ахуйн нэгжийн 1131,5 км орон нутгийн чанартай авто замын трассыг аймгийн Засаг даргын захирамжаар батлан, хатуу хучилттай, сайжруулсан авто зам барьж тээвэрлэлт хийх үүрэг чиглэлийг өгсөн. “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн 414,6 км төмөр зам 2021 онд, “Зүүнбаян-Ханги” чиглэлийн 226,9 км төмөр зам 2022 онд, Даланжаргалан–Бор-Өндөр чиглэлийн 50км хатуу хучилттай авто зам 2022 онд тус тус ашиглалтад орж уул уурхайн бүтээгдэхүүнийг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тээвэрлэж байна. Мандах сумын нутагт байрлах "Түмэн айл инвест" ХХК-ийн "Довцог худаг" нэртэй нүүрсний уурхайгаас Хатанбулаг сумын нутгаар дайран өнгөрч буй Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замын уулзвар хүртэлх 173.2 км нүүрс тээвэрлэлтийн зам, “Монголросцвемет” ТӨҮГ-ийн Дундговь аймгийн Баянжаргалан сумаас “Бор өндөр” уулын баяжуулах үйлдвэр хүртэлх Даланжаргалан сумын нутгаар дамжин өнгөрөх 75 км зам, Айраг сумын нутагт байрлах “Мин Ли Да” ХХК-ийн “Хонгор овоо” нэртэй жоншны уурхайгаас “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Айраг өртөөний 7 дугаар зам хүртэлх 28 км жонш тээвэрлэлтийн зам, Хатанбулаг сумын Сүж уулаас Таван толгой-Манлай-Ханги чиглэлийн замын уулзвар хүртэлх 28 км жонш тээврийн автозамын түр чиглэлүүдийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэж, зориулалтын дагуу тээвэр хийх байдалд Автотээврийн төвөөс тогтмол хяналт тавьж ажиллалаа. Ханги хилийн боомтоор уул уурхайн экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг 36 компанийн 975 тээврийн хэрэгсэл гүйцэтгэж байна. Мандах суманд үйл ажиллагаа явуулж буй “Их говь энержи” ХХК нь аймгийн Засаг даргын 2012 оны А/534 дугаар захирамжаар батлагдсан орон нутгийн чанартай авто замын трассын дагуу сайжруулсан болон хатуу хучилттай авто зам бариагүй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн тул дээрх замын трассыг аймгийн Засаг даргын 2022 оны А/537 дугаар захирамжаар хүчингүй болгосон. | |
| 148 | 3.3.1. Атрын IV аяныг хэрэгжүүлжорон нутгийн онцлогт тохирсон газар тариалан гийн үйлдвэрлэл ийг нэмэгдүүлэх замаар хүн | 164. Газар тариалан эрхлэгчдийг сургаж дадлагажуулах мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бэхжүүлэх арга | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 3, Оролцогчдын тоо 150, Бэлтгэгдсэн хүний нөөц 13 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо Оролцогчдын тоо Бэлтгэгдсэн хүний нөөц | | 6 200 15 | Газар тариалан эрхлэгчдийг чадавхжуулах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлын хүрээнд "Хөгжлийн шийдэл" ТББ-ын “Best” хөтөлбөр, "Дэлхийн зөн Монгол" ОУБ-ын “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | амын төмс, хүнсний ногооны хангамжийг тогтвортой өсгөнө. | хэмжээг зохион байгуулах; | | | | | | орон нутаг" төсөл, Монголын Хүлэмжийн аж ахуйн холбоо, "Булган голын алим" ХХК, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран нийт 11 удаагийн танхимын сургалт, 1 удаагийн талбайн сургалт, 3 удаагийн цахим сургалтыг зохион байгуулан давхардсан тоогоор нийт 735 тариаланчийг хамруулснаар сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо 2020 онтой харьцуулахад 215 хүн буюу 41,3 хувиар өссөн. "Политехникийн коллеж"-ийн хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ, фермерийн аж ахуйн мэргэжилтэй ажилтан бэлтгэх ангийг 2020 оноос эхлэн нээж 2023 оны байдлаар 49 суралцагч амжилттай төгсөж аж ахуй эрхэлж байгаа ба энэ онд 38 оюутан шинээр элсүүлсэн нь 2020 онтой харьцуулахад 25 суралцагчаар нэмэгдсэн байна. | |
| 149 | | 165. Тариалангийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимийг сайжруулан, бордоо, ургамал хамгааллын зохистой байдалд хяналт тавих; | 2021 - 2024 | Шинжилгээнд хамруулсан талбайн хэмжээ - 70/га/, Хяналт шалгалтын тоо-2 | Шинжилгээнд хамруулсан талбайн хэмжээ Хяналт шалгалтын тоо | | 0/га/ 2 | Тариалангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-д "Агрохими, агрофизикийн шинжилгээг таван жил тутамд тариалангийн газрын эзэмшигч, ашиглагч өөрийн хөрөнгөөр хийлгэнэ" гэж заасны дагуу "Дорнын говийн тариаланчид" төрийн бус байгууллага, Дархан-Уул аймгийн ургамал газар тариалан сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хөрс судлалын лабораторитой хамтран аймгийн тариалангийн 97,6 га талбайд хөрсний чанар, төлөв байдалд агрохимийн шинжилгээ хийж, сорилын дүн, зөвлөмжийг тариаланчдад хүргүүлсэн. Тариалангийн зориулалтаар ашиглагдаж буй 14 сумын 232 тариаланчийн 223 га талбайн хөрсний төлөв байдалд 14 удаа заавар зөвлөмж өгсөн. Баталгаатай эрүүл аюулгүй хүнс үйлдвэрлэлийг бий болгох ажлын хүрээнд "Эс эф си эс" баталгаажуулалтын байгууллагатай хамтран ажиллаж Даланжаргалан, Сайншанд сумын 12 тариаланч жимс, | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж гэрчилгээгээ гардан авсан. | |
| 150 | | 166. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох шинэ сортын үрийг үржүүлэн хангамжийг нэмэгдүүлэх; | 2021 - 2024 | Сортын тоо-2, Үрийн хангамжийн өсөлтийн хувь-13 | Сортын тоо Үрийн хангамжийн өсөлтийн хувь | | 1 5 | Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2020-2023 он хүртэл тариалалтад 80 хувийн хөнгөлөлттэй олгосон 43 төрлийн хүнсний ногооны үр /давхардсан тоогоор/, төмсний 4 тн, тарвасны 3 кг, амтатгуаны 2кг, 2 тн сонгино, 500 кг сармисны үрийг татан авч 14 сумын газар тариалан эрхлэгчдэд хуваарилан олгож үрийн хангамжийг 2020 онтой харьцуулахад 30,2%-иар нэмэгдүүлсэн. Мөн хөдөө аж ахуйг дэмжих сангаас нийлүүлсэн Солонгосын бууцай, байцай, салат навчны 3-н төрлийн сортыг тариалан туршсан. Сорт сорилтын ажлын хүрээнд "Мөнх ашиг хоршоо" эртийн байцааны 1, сонгино 1, тарвасны 1, сармис 1, бууцай 1, гүзээлзгэнэ 1, чавганы 40 ширхэг суулгац, нийт 7 төрлийн сортыг үр шинэчлэлд, амтат гуаны 2 сортыг ирээдүйтэй сортоор батлуулахаар туршилтын ажлыг 2 дахь жилдээ үргэлжлүүлэн ажиллаж байна. | 100% |
| 151 | | 167. Өрхийн тариалангийн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх замаар техник технологийг шинэчлэн, хамгаалагдсан хөрсний тариалалт, зоорийн хангамжийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Техник шинэчлэлтийн хувь-20, Нэмэгдсэн талбайн хэмжээ-9909 /м2/, Шинээр баригдсан зоорийн тоо-1, | Техник шинэчлэлтийн хувь Нэмэгдсэн талбайн хэмжээ Шинээр баригдсан зоорийн тоо | | 10% 300 /м2/ 1 | “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэх, хүнсний ногооны хангалтыг нэмэгдүүлэх, өрхийн тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор улсын төсвийн 2,0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Шинэ хөдөө” төслийг хэрэгжүүлж төслийн хүрээнд 952,5 сая төгрөгийн үнэ бүхий 4 төрлийн хэмжээст хүлэмж 350 ш, 899,2 сая төгрөгийн үнэ бүхий 40 морины хүчтэй дугуйт трактор 20 ширхэг, анжис 20 ширхэг, роторт сийрүүлүүр 20 ширхэг, сийрүүлэгч манагч 20 ширхэг, төмс суулгагч 20 ширхэг, хүнсний ногооны үрлүүр 20 ширхэг, 38,0 сая.төгрөгийн үнэ бүхий 1,5 тн-ы багтаамжтай 40 ш усны нөөцийн савыг шинээр нэмэгдүүлэн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 14 сумын газар тариалан эрхлэгчдэд олгосон. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2023 оны тариалалтад 80 хувийн хөнгөлөлттэй олгосон 11 төрлийн хүнсний ногооны үрийг 14 сумын газар тариалан эрхлэгчдэд олгон дэмжлэг үзүүлсэн. Тариалалтаар 338 өрх, 30 аж ахуйн нэгж, байгууллага төмс 21.8 га-д, хүнсний ногоо 81.9 га-д, жимс, жимсгэнэ 9,6 га-д, малын тэжээлийн ургамал 56,1 га-д нийт 169,4 га талбайд тариалалт хийж өмнөх оны мөн үеэс талбайн хэмжээ 35,4 га талбайгаар нэмэгдэж, 900 м2 өвлийн хүлэмж, 29520 м2 зуны хүлэмжинд тариалалт хийж урьд оноос хамгаалагдсан хөрсний тариалалтыг 19200 м2-аар нэмэгдүүлсэн. | |
| 152 | | 168. Газар тариалан эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамруулан үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Тариалангийн чиглэлээр олгосон газрын хэмжээ-16/га/ Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэдийн тоо-7 Санхүүжилт -55.0 /сая төг/, Хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийн өсөлтийн хувь-10.7 | Тариалангийн чиглэлээр олгосон газрын хэмжээ Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэдийн тоо Санхүүжилт Хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийн өсөлтийн хувь | | 4 /га/, 5 30.0 /саятөг/ 3% | Алтанширээ, Сайншанд, Иххэт, Хатанбулаг, Хөвсгөл, Дэлгэрэх, Замын-Үүд сумдад 2020 онд "Сум хөгжүүлэх сан"-гаас газар тариалан эрхлэх 9 иргэнд 97,1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож дэмжлэг үзүүлж байсан бол 2023 оны байдлаар хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5-6 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нийт 18 иргэн, аж ахуйн нэгжид 420,0 сая төгрөг, мөн Замын-Үүд, Сайншанд, Айраг, Мандах, Сайхандулаан, Хатанбулаг сум "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас 8 иргэнд 157,0 сая төгрөг, 3 ААН, 2 хоршоонд 226,0 сая төгрөг, хүлэмж, мод үржүүлгийн чиглэлээр Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 1 аж ахуйн нэгжид 90,0 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1 иргэнд 5,0 сая,төгрөг нийт 38 иргэн, ААН, хоршоонд 967,6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож дэмжлэг үзүүлсэн. Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжин Айраг, Хатанбулаг, Сайхандулаан, Даланжаргалан, Сайншанд сумд 15 иргэн, 5 аж ахуйн нэгж, 1 хоршоонд | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нийт 169,5 га газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлсэн. Газар тариалан эрхлэгчдийг дэмжиж ажилласнаар өмнөх онтой харьцуулахад тариалан эрхлэгчийн тоо 128-аар, тариалсан талбайн хэмжээ 35,4 га-аар 2020 онтой харьцуулахад тариалан эрхлэгчийн тоо 229-аар, тариалсан талбайн хэмжээ 95 га-аар буюу 135,7 хувиар, ургацын хэмжээ 132,7 хувиар тус тус нэмэгдсэн. Ургац хураалтын эцсийн дүнгээр 117,2 тн төмс, 469.3 тн хүнсний ногоо, 2.0042 тн жимс, жимсгэнэ, 82.347 тн малын ногоон тэжээлийн ургамал нийт 670,8 тн ургац хураан авсан нь өмнөх оноос хураан авсан ургацын хэмжээ 29 хувиар, хүн амын төмс, хүнсний ногооны хангамж 11,1 хувиар тус тус өссөн. | |
| 153 | 3.3.2. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих замаар малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ | 169. Гол нэрийн зарим хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, цехийн тоо -6, Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, цехийн тоо-4 Гурилан бүтээгдэхүүний үйлдвэр, цехийн тоо-36 Төслийн тоо-10, Санхүүжилт - 253.0 /сая.төг/ Мах, сүү, гурилан бүтээг-дэхүүний хангалтын өсөлтийн хувь-60.3 | Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, цехийн тоо Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, цехийн тоо Гурилан бүтээгдэхүүний үйлдвэр, цехийн тоо Төслийн тоо Санхүүжилт Мах, сүү, гурилан бүтээг-дэхүүний хангалтын өсөлтийн хувь | | 9 8 41 4 150.0 /сая.төг/ 1.2% | Хүнсний үйлдвэрлэлийн нэмэгдүүлэх, худалдаа, үйлчилгээний салбарт дэмжэг үзүүлэх хүрээнд 2021-2023 онд Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Сайхандулаан, Хатанбулаг, Эрдэнэ, Өргөн, Сайншанд, Замын-Үүд сумдын “Хоршоо хөгжүүлэх сан”-аас сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэх 8 иргэнд 130,5 сая, хагас боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх 3 аж ахуйн нэгж, 6 иргэнд 500,0 сая, талх, нарийн боов, хэрчсэн гурилын үйлдвэрлэл эрхлэх 7 иргэнд 111,3 сая, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бусад чиглэлээр 6 иргэнд 191,1 сая, хүнсний ногоо тариалах 1 аж ахуйн нэгж, 5 иргэнд 142,0 сая, нийт 10 сумын 4 аж ахуйн нэгж, 32 иргэнд 1074,9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Тайлант хугацаанд Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолд тусгасан “Хүнсний болон Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” жилийн 5-6 хувийн хүүтэй зээлийг газар тариалан, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 18 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | иргэн, аж ахуйн нэгжид 739,0 сая төгрөгийг олгосноор 2021-2023 онд нийт 1813,9 сая төгрөгийг хүнсний үйлдвэрлэлийг дэмжихэд зарцуулсан. Гурилан бүтээгдэхүүний цех 37, мах, махан бүтээгдэхүүний 3 үйлдвэр цех, сүү, сүүн бүтээгдэхүүний 2 цех савласан усны 10 цех, өндөгний 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж хүн амын махны хэрэгцээг 100%, сүүний хэрэгцээний 76,3%, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээний 5,4%, төмс, хүнсний ногооны 23,3 %, өндөгний 73,6%-ийг орон нутгаас хангаж байна. Гол нэрийн хүнсний хүнсний бүтээгдэхүүний хангалтын хувь 2020 оноос  мах 20,8%-иар, сүүн сүүн бүтээгдэхүүн 7,9%-иар, гурил гурилан бүтээгдэхүүн 5.4% -иар тус тус өссөн. | |
| 154 | | 170. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагааг өргөжүүлж, тавих хяналтыг сайжруулах; | 2021 - 2024 | Гэрээ байгуулсан ААН-ийн тоо-17 Хяналт шалгалтад хамрагд сан ААН 50 /давхардсан тоогоор/ Иргэдийн тоо -51 /давхард сан тоогоор/ | Гэрээ байгуулсан ААН-ийн тоо Хяналт шалгалтад хамрагдсан ААН Иргэдийн тоо | | 3 65 79 | Хүн амын стратегийн хүнс-мах, сүү, гурилаар орон нутгийг тогтвортой хангах, улирлын нөөц бүрдүүлэх гэрээг 14 сумын 2 хоршоо, 4 иргэн, 49 аж ахуйн нэгжтэй байгуулан ажиллалаа. Дээрх аж ахуйн нэгжүүдийн нөөц бүрдүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн явцад хүнсний худалдаа, хоол, үйлдвэр үйлчилгээний чиглэлээр 10 удирдамжийн хүрээнд нийт 349 обьект /156 ААНБ, 193 иргэн/- ийг хамруулан хтөлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 1240 зөрчил дутагдлыг илрүүлж 540 буюу 43,5%-ыг арилгуулан, зөрчил ихээр илэрсэн 16 аж ахуй нэгж байгууллага, 15 иргэнд илэрсэн зөрчил арилгуулахаар 365 заалт бүхий улсын байцаагчийн 31 албан шаардлага хүргүүлснээс 40,3% биелэлттэй, 1 аж ахуй нэгж, 1 иргэнд 15 заалт бүхий улсын байцаагчийн 2 зөвлөмж хүргүүлсэн. Хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан орон нутгийн төсвийн хөрөнгөөр махны нөөц бэлтгэх тендерт “Үзүүрт зараа” ХХК шалгарч дотоодын хэрэгцээнд | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үхэр, хонь, ямааны нийт 49.5тн махны нөөцийг бүрдүүлэн 5 дугаар сараас 7 дугаар сарыг хүртэл Сайншанд сумын 5 цэгт зах зээлийн үнээс кг тутмыг 2000-3000 төгрөгийн хямд үнээр нийлүүлж ажилласан ба тус аж ахуйн нэгжийн хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. | |
| 155 | | 171. Сумдад мал нядлах эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн цэг байгуулах, малын гаралтай экологийн цэвэр бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх | 2022 - 2024 | Шинээр байгуулсан цэгийн тоо-7 Шинжилгээнд хамрагдсан махны хэмжээ /тн/-31.5 | Шинээр байгуулсан цэгийн тоо Шинжилгээнд хамрагдсан махны хэмжээ | | 2 31.5/тн/ | Мах хадгалах стандартын шаардлага хангасан 340 тонны багтаамж бүхий зориулалтын зоорьтой “Хайрхан” малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зах, “Суман зурхай” ХХК, мөн мал төхөөрөх 1, мах боловсруулах /хиам/ 2, мал нядалгааны 7 цэг үйл ажиллагаа явуулж байна. Мал нядалгааны цэгийг шинэчлэн болон сэргээн засварлах, мах боловсруулах чиглэлээр Алтанширээ, Сайншанд, Замын-Үүд, Хатанбулаг, Иххэт сум хоршоо хөгжүүлэх сангаас 2 ААН, 4 иргэнд нийт 380.0 сая төгрөг, “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл”-ийн хүрээнд махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэх 1 аж ахуйн нэгжид 270,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлснээр 40 тонны махны гүн хөлдөөх зоорийг Хатанбулаг суманд шинээр барьж, мах боловсруулах чиглэлээр зээл авсан иргэн, аж ахуйн нэгжүүд нь нийт 7 ажлын байрыг хадгалж, 15 ажлын байрыг шинээр бий болгосон. Мал, амьтны шилжилт хөдөлгөөн, мал малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлыг хангах, хяналт тавих, баталгаажуулалтын 9767 ширхэг гэрчилгээ бичигдэж, адууны мах 58.1 тн, үхрийн мах 227 тн, хонины мах 197.5 тн, ямааны мах 17.3 тн, тэмээний мах 53.3 тн, гахайны мах 0.1 тн, 43,1 тн ноос, 24.9 тн ноолуур, 1450000 ширхэг өндөг, 645 ширхэг арьс шир, 0,3 тн малын гаралтай дайвар бүтээгдэхүүн, 101718 толгой | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | амьд малыг үзлэг, тандалтад хамруулж, бүтээгдэхүүнд шинжилгээ хийсэнд мал эмнэлгийн улсын 5 байцаагч хяналт тавьж баталгаажуулсан. Аймгийн төв дээр "Суман зурхай" ХХК үхэр 9000, хонь 7500, адуу 6000 төгрөгөөр тус тус худалдан авч үхэр 27 тонн, хонь 30тонн, адуу 28 тонн нийт 85 тонн махны нөөцийг бүрдүүлсэн. Замын-Үүд сумын "Мал эрүүлжүүлэн тусгаарлах бүс"-д 120.0 мянган толгой малыг амьдаар нь зах зээлд бэлтгэн нийлүүлж, экспортлоход үзлэг шинжилгээнд хамруулж, эрүүлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулсан. | |
| 156 | | 172. Ноос, ноолуур, арьс шир боловсруулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжих; | 2021 - 2024 | Боловсруулах үйлдвэр, цехийн тоо-13, Төслийн тоо-2 Санхүүжилт-20.0 /сая.төг/ | | | 21 4 80.0 /сая.төг/ | Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 6 иргэн, 1 ААН, 4 хоршоо, арьс, ширний анхан шатны боловсруулалтын чиглэлээр 4 иргэн үйл ажиллагаа явуулж, иргэдийн захиалгын дагуу бэлэн хувцас, бэлэг дурсгалын зүйл, хонины элдсэн нэхий, үстэй дээл, монгол гэрийн эсгий дээвэр, гудас зэргийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байна. "Шинэ хөдөө" төслийн хүрээнд Айраг, Даланжаргалан, Иххэт, Алтаншираэ, Мандах, Сайхандулаан, Өргөн, Эрдэнэ сумдад олгосон "Нэхий элдэгч", "Арьстай мах хуулах" машиныг иргэдэд гэрээгээр ашиглуулан, үйл ажиллагааг жигдрүүлсэн. Алтанширээ сумын "Олон ширээ" хоршоо 107 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж, ХХС-аас 80,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг авч, ноос, ноолуурын холбооны гэрчилгээ аван хоршооны гишүүдийн бэлтгэсэн 40 тн ноолуурыг ангилан ялгаж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг "ГОЁЛ" үндэсний үйлдвэрт нийлүүлсэн. "Дэвжих эсгий" ХХК нь ХХС-аас 20.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч 2м*5м харьцаатай эсгий өдөрт 40-50 ширхэгийг үйлдвэрлэх хүчин чадалтай | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байнгын 3, түр ажлын байр 2-ыг бий болгосон. "Дорнын Үжин гоо" ХХК нь "Цагаан алт" ХХК-аас угааж, самнасан хонины ноосыг захиалгаар авч эцсийн бүтээгдэхүүн болгон МҮХАҮТ-тай гэрээ байгуулан 100% гар аргаар хийсэн 500 ширхэг чихмэл тэмээг, мөн Улаанбаатар хотын бэлэг дурсгалын дэлгүүрүүдэд 450 ширхэг чихмэл тэмээг захиалгаар тус тус нийлүүлсэн. Мөн Эрдэнэ, Өргөн, Мандах, Дэлгэрэх сумдын ХХС-аас 60,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 4 иргэнд арьс ширэн бүтээгдэхүүн, суран эдлэл үйлдвэрлэлийн чиглэлээр олгож 4 ажлын байрыг хадгалж, шинээр 1 ажлын байрыг нэмэгдүүлсэн. Сайншанд сумын 1 иргэн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 15,7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч арьс, шир боловсруулах цехийн үйл ажиллагааг шинээр эхлүүлж, мөн “Цагаан сүүний буян” ХХК, “Өлзийт баян мод” ХХК эрчимжсэн аж ахуй эрхлэх, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 360,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч үйлдвэрлэлийн байраа шинэчлэн, тоног төхөөрөмжөө нэмснээр борлуулалтын орлого 1.1%-р өссөн. | |
| 157 | | 173. Үндэсний үйлдвэрүүдэд чанар, стандартын шаардлага хангасан түүхий эд нийлүүлсэн малчдыг урамшуулалд хамруулах ажлыг зохион байгуулах; | 2021 - 2024 | Үндэсний үйлдвэрт тушаасан түүхий эд нийлүүлэлтийн хувь | Үндэсний үйлдвэрт тушаасан түүхий эд нийлүүлэлтийн хувь | | 5% | Монголын арьс, ширний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрхтэй 45 төлөөлөгч, мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэгч 19 хоршоо 14 суманд ажиллан, 2020-2021 онд үндэсний томоохон үйлдвэрүүдэд хонь, тэмээний ноос бэлтгэн нийлүүлсэн 14 сумын давхардсан тоогоор нийт 6085 малчин, мал бүхий өрхөд 2084,71 сая төгрөгийн урамшууллыг олгосон. Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Монгол | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээг татварын төлбөрийн баримтаар /и-баримтаар/ татварын нэгдсэн системд бүртгүүлсэн байхаар хуульчилсан тул төрийн байгууллагуудаар дамжуулан урамшуулал олгохоо больсон. Малчдын бэлтгэсэн түүхий эд, ноос ноолуур, арьс ширийг жил бүр “Өргөн шар худаг”, ”Говийн таван чандмань” хоршоонууд худалдан авч урамшууллын падаан бичиж олгон "Чойр Хайрхан" ХХК-д тушааж тухайн ААНБ-аас падааныг шивж татварын "Е баримт" үүсгэн малчид руу цахимаар илгээн баталгаажуулж байна. Энэ онд хонь, тэмээний ноос 66.4 тн, ноолуур-7.2тн-ыг малчид худалдан борлуулж урамшуулалд хамрагдсан байна. Малчдын бэлтгэсэн ноос, ноолуурын падааныг тухайн үйлдвэрүүд шууд шивж цахимаар малчид өөрсдөө баталгаажуулан урамшуулалд хамрагдаж байгаа нь шат дамжлага бага, үр дүнтэй байна. | |
| 158 | 3.3.3. Малын чанар, ашиг шимийг сайжруулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлнэ | 174. “Дэлгэрэхийн улаан" омгийн ямааны тархалтыг нийт хээлтүүлэгчийн 30 хувьд хүргэх, үрийг генийн санд хадгалуулах; | 2021 - 2024 | Шинээр тархаан сайжруулсан хээлтүүлэгчийн тоо-8900 Генийн санд хадгалуулсан үрийн тоо-0 | Шинээр тархаан сайжруулсан хээлтүүлэгчийн тоо Генийн санд хадгалуулсан үрийн тоо | | 250 0 | “Дэлгэрэхийн улаан” омгийн ямааны чанар, ашиг шимийн талаар болон тархалтыг нэмэгдүүлэх, ач холбогдол, хамтран ажиллах талаар зөвлөмжийг 14 сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, 11 сумын "Малчдын нэгдсэн сургалт, өдөрлөг"-ийн үеэр "Дэлгэрэхийн улаан" омгийн ямааны талаарх танилцуулга мэдээллийг давхардсан тоогоор нийт 1664 малчинд хүргэж ажилласнаар Улаанбадрах суманд 15, Мандах суманд 18, Алтанширээ суманд 25, Дэлгэрэх суманд 74, Иххэт суманд 23, Өргөн суманд 20, Эрдэнэ суманд 35 нийт 210 өсвөр хээлтүүлэгчийг бэлтгэж тус тус нийлүүлсэн. Өсвөр хээлтүүлэгч бэлтгэснээр сүрэг сэлбэх, нийлүүлгийн үед 10,500 толгой хээлтэгч хээлтүүлэх боломжийг бүрдүүлсэн. Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | "Дэлгэрэхийн улаан омог"-ийн ямааны 3000 үрийг генийн санд хадгалуулсан ба нийт 238 хээлтүүлэгч бэлтгэж уг омгийн хээлтүүлэгчийн тоо 1847 толгой буюу нийт хээлтүүлэгчийн 30%-ийг эзэлж байгаа нь өмнөх оноос 2.2 хувиар, 2020 оноос 57,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | |
| 159 | | 175. Мал сүрэгт эзлэх өндөр ашиг шимт малын тоог өсгөх замаар малын чанар, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх; | 2021 - 2024 | 70000 | Өндөр ашиг шимт малын тоон өсөлтийн хувь | | 0,5% | Өндөр ашиг шимт малын тоог орон нутагт нэмэгдүүлэх зорилгоор Алатау, Хар тарлан үүлдрийн 119 толгой үхэрт, 507 толгой "Дэлгэрэхийн улаан омог"-ийн ямаа, Нутгийн монгол хонь, ямаа нийт 626 толгой малд шингэлсэн үр болон гардан хээлтүүлэг хийсэн. Нутгийн малын чанар, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2022-2023 онд “Дэлгэрэхийн улаан омог"-ийн ишгэн ухна 238, барга, үзэмчин үүлдрийн 36 хурган хуц нийт 274 толгой өсвөр хээлтүүлэгчийг шинээр бэлтгэн бойжуулж тоо толгойг нэмэгдүүлсэн. Өндөр ашиг шимт малын тоо 2022 оны жилийн эцэст 79506 толгойд хүрч өссөн ба өмнөх онтой харьцуулахад 5 төрөл дээрээ 1.4 хувиар, 2020 онтой харьцуулахад 1,9 хувиар өсөж, нийт мал сүргийн 2,7 хувийг эзэлж байна. | 90% |
| 160 | | 176. Сумдад эрчимжсэн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжих; | 2021 - 2024 | Эрчимжсэн аж ахуйн тоо-61, Төслийн тоо-3, Санхүүжилт-200.0 /сая төг/ | Эрчимжсэн аж ахуйн тоо Төслийн тоо Санхүүжилт | | 68 4 100.0 /сая төг/ | “ИХ ГОВИЙН ТЭМЭЭ-2023” наадам зохион байгуулж уг наадамд 3 насны хурдан тэмээний уралдаан, тэмээн поло тэмцээн, сайхан тэмээтэй хос, шилмэл ингэ, буур зэрэг тэмцээн зохион байгуулж, сүү, цагаан идээ, ноос, арьсаар хийсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн болж 14 сумын 300 гаруй малчныг хамруулан тэмээн сүргийн гайхамшгийг олон нийтэд сурталчилсан. үүлэхээр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Төслийн хүрээнд Замын-Үүд суманд ингэний сүүгээр брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох зорилгоор үйлдвэрт шаардагдах ингэний сүүг хэрхэн цуглуулах, хамтран ажиллах талаар Мандах, Хатанбулаг, Хөвсгөл, Сайншанд, Улаанбадрах сумын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | малчидтай “Солид Партннерс Групп” ХХК-ны зүгээс харилцан санал солилцох ажлыг эхлүүлсэн. 2020 онд махны чиглэлийн фермер 8, сүүний чиглэлийн 30, мах, сүүний хосолсон 4 фермер, гахай 5, тахианы аж ахуй эрхлэгч 10 тус тус үйл ажиллагаа явуулж байснаас 2023 онд махны чиглэлийн фермер 10, сүүний чиглэлийн 72, гахай 7, тахианы аж ахуй эрхлэгч 12 иргэн, аж ахуйн нэгжтэй болсон. Мандах сум “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас сүүний үхрийн фермерийн үйл ажиллагааг өргөжүүлэх 1 иргэнд 7,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн. “Мөрөөдлийн говь” ХХК нь Сайншанд сумын 6-р багт хувийн 650,0 сая төгрөгийн хөрөнгөөр 60000 тахианы механикжсан ферм байгуулж, 30000 тахиатай үйл ажиллагаа явуулж байна. Мал аж ахуйн эргэлтийн хөрөнгийг дэмжих зээлд хамрагдахаар нэг иргэн 100,0 сая төгрөгийн зээлийн хүсэлт ирүүлснийг холбогдох газарт хүргүүлсэн. Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр 1 компани Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 100.0 сая төгрөгийн зээл хүсэж Жижиг дунд үйлдвэрийн газраас хийсэн урьдчилсан болон нарийвчилсан судалгаанд тэнцсэн. Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих чиглэлээр 2020 онд 6 иргэн, аж ахуйн нэгжид нийт 115.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож байсан бол 2023 онд 4 иргэн, аж ахуйн нэгжид нийт 545.0 сая буюу 430.0 сая төгрөгөөр илүү хөнгөлөлттэй зээлийг олгожээ. | |
| 161 | | 177. Малчид, иргэдийн захиалгын дагуу бод, бог малын зохиомол хээлтүүлэг хийх; | 2021 - 2024 | Зохиомол хээлтүүлэпт хамрагдсан малын тоо-448 Өсөлтийн хувь-3 | Зохиомол хээлтүүлэпт хамрагдсан малын тоо Өсөлтийн хувь | | 475 2% | Биотехнологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн 2020 онд “Алатау”, “Хар тарлан” үүлдрийн үхэрт шингэлсэн үрээр гардан хээлтүүлгийг нийт 116 толгой бод, "Дэлгэрэхийн улаан омог"-ийн 635 толгой ямаа, нийт 751 малд зохиомол хээлтүүлэг хийж 2020 оноос 23,4 хувиар | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нэмэгдүүлснээр төлийн чанар сайжрах, малын тавааралаг байдал нэмэгдэх боломжийг бүрдүүллээ. Малын зохиомол хээлтүүлгийн ажил үйлчилгээ 2023 оны байдлаар Өргөн, Сайншанд, Замын-Үүд, сумдын 232 үхэрт Алатау, Хар тарлан үүлдэр, Дэлгэрэхийн улаан омгийн ямаа, Нутгийн монгол хонь, ямаа 2848, нийт 3080 толгой малд шингэлсэн үр болон гардан хээлтүүлгийг 94%-тай хийсэн. | |
| 162 | 3.3.4. Бэлчээрийн төлөв байдал, даацад тулгуурлан нөхөн сэргээлт ийг хийж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна. | 178. Бэлчээр ашиглалтын нөлөөллийг фотомони-торингийн аргаар тодорхойлж, сум бүр орон нутгийн онцлогт тохирсон бэлчээр ашиглах журам, менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх; | 2021 - 2024 | Судалгаанд хамруул сан сумын тоо-14, Бэлчээр ашиглах журам, менежментийн төлөвлөгөө шинээр батлуулсан сумын тоо-5 | Судалгаанд хамруул сан сумын тоо Бэлчээр ашиглах журам, менежментийн төлөвлөгөө шинээр батлуулсан сумын тоо | | 14 2 | Бэлчээр ашиглалтын нөлөөлөлд фотомониторингийн аргаар хяналт хийх ажлыг Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөс 14 сумын 54 багийн хяналтын 72 цэгт  жил бүрийн 08 дугаар сарын 10-20-ны хооронд хийж өвөл, хаврын бэлчээрийн даацыг тооцож гаргадаг. Бэлчээрийн даацын мэдээнд үндэслэн өвөлжилт хаваржилт, отор нүүдлийн зураглалыг гарган холбогдох газруудыг мэдээллээр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд Айраг, Даланжаргалан, Иххэт, Сайхандулаан, Эрдэнэ, Сайншанд гэсэн 6 сум  бэлчээр ашиглах, отор нүүдэл зохицуулах журам, менежментийн төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулснаар нийт 10 бэлчээр ашиглах, отор нүүдэл зохион байгуулах журам, менежментийн төлөвлөгөөтэй боллоо. Алтанширээ, Хатанбулаг сумд бэлчээр ашиглах журам, менежментийн төлөвлөгөөг сумын ИТХ-аар 12 дугаар сард батлуулахаар иргэд, малчдадаа танилцуулж журмын төсөлд санал авах ажил хийгдэж байна. Тус аймагт хилийн зурваст 5 сумын 191 өрхийн 152.0 мянган  толгой мал, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 5 сумын 110 өрхийн 76.0  мянган толгой мал, өөр аймгийн нутагт 5 сумын 128 өрхийн 131.0 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 7 сумын 208 өрхийн 102.0 мянган толгой мал, сум дундын отрын бүс нутагт 1 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сумын 1 өрхийн 2.3 мянган толгой мал өвөлжиж байна. Эрдэнэ суманд Өвөрхангай аймгийн 3 өрхийн 1333 толгой мал, Хатанбулаг суманд Баянхонгор аймгийн 2 өрхийн 589 толгой мал, Хөвсгөл суманд Өмнөговь аймгийн 1 өрхийн 570 толгой мал өвөлжиж байна. | |
| 163 | | 179. Зарим сумдын бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготонотой тэмцэх, доройтлыг бууруулах, нөхөн сэргээх ажпыг зохион байгуулах; | 2022 - 2024 | Нөхөн сэргээсэн бэлчээрийн талбай - 60000/га/ | Нөхөн сэргээсэн бэлчээрийн талбай | | 30000/га/ | Ургамал хамгааллын хүрээлэнгээс 2022 онд Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдын бэлчээрийн талбайд мэрэгч амьтдын тархалт, олшролтын тодотгох судалгааг хийж 74,0 мянган га бэлчээрт мэрэгч амьтадтай тэмцэх ажил зохион байгуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан. МУ-ын Засгийн газрын 2019 оны 185 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/143 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/679 тоот захирамжийн дагуу бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой байгаль орчинд халгүй аргаар тэмцэх ажлын хүрээнд 2023 онд Улсын төсвийн 48,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдын нийт 30 мянган/га бэлчээрийн талбайд нутгийн 133 малчин, мал бүхий иргэдийг хамруулан энгийн механик, биологийн аргаар зохион байгуулсан. Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулснаар бэлчээрийн талхагдлыг багасган, бэлчээрийн ургамлын нөхөн ургах боломжийг бүрдүүлж хонин толгойд шилжүүлснээр 6,9 мянган толгой малыг бэлчээрлүүлэх боломж бүрдсэн. | 50% |
| 164 | | 180. Төр, хувийн хэвшлийн хөрөнгөөр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Шинээр гарсан худгийн тоо 23 Сэргээн засварласан худгийн тоо-31 | Шинээр гарсан худгийн тоо Сэргээн засварласан худгийн тоо | | 10 15 | Тайлант хугацаанд улсын төсвийн 157,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Айраг, Иххэт, Дэлгэрэх сумдад инженерийн хийцтэй 5 худгийг шинээр гаргаж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Мөн орон нутгийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төсвийн 342,0 сая төгрөгийн хөрөнгөөр Улаанбадрах Хатанбулаг сумдад инженерийн хийцтэй 7 худаг, Алтанширээ, Иххэт, Улаанбадрах, Хатанбулаг, Эрдэнэ сумдын ОНХС-ийн 286.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй 14 худаг, малчдын санаачилгаар 11 худгийг шинээр болон сэргээн засварлаж бэлчээрийн усан хангамжийг 37 худгаар нэмэгдүүлсэн. Инженерийн хийцтэй болон энгийн худгийг шинээр болон сэргээн засварласнаар 2021-2023 онд нийт 91 худаг уст цэгийг шинээр гаргаж 120.5 мянган га бэлчээрийг усжуулж 159.5 мянган толгой малыг услах боломж бүрдсэн. Аймгийн хэмжээнд 2020 онд бэлчээрийн 3174 худаг ашиглагдаж байсан бол өссөн дүнгээр 91 худгаар нэмэгдэж 2.9 хувиар өссөн. | |
| 165 | 3.3.5. Мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах нөхцлийг бүрдүүлнэ. | 181. Хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх "Масс мессеж" үйлчилгээг үргэлжпүүлэн хэрэгжүүлэх; | 2021 - 2024 | Илгээсэн мессеж тоо-98000 | Илгээсэн мессеж тоо | | 100000 | Мал аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээллийг малчдад шуурхай хүргэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны А/263 дугаар захирамжаар 6,1 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж "Мобиком" ХХК, "Скайтел" ХХК-тай тус тус гэрээ байгуулан “Масс мессеж” үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээлэл, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн богино, дунд хугацааны урьдчилсан мэдээ, өвөлжилтийн хувийн бэлтгэл эртнээс хангах талаар мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор 127270 иргэд, малчдад цаг алдалгүй хүргэн ажилласан. | 100% |
| 166 | | 182. Хадлан тэжээл бэлтгэх менежментийг сайжруулж, малын тэжээлийн ургамал тариалах ажилд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Хадлангийн салааны тоо-2 Малын тэжээл тариалсан хэмжээ /га/ -6.5 Өвс/тн/ -400, Тэжээл /тн/ -12 | Хадлангийн салааны тоо Малын тэжээл тариалсан хэмжээ /га/ Өвс/тн/ Тэжээл /тн/ | | 5 7.5 /га/ 60 /тн/ 16 /тн/ | Тайлант онд Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг, Эрдэнэ сумын нутагт нийт 56.1 га талбайд малын тэжээлийн ургамал тариалж 83 тонн ургац хураан авсан нь өмнөх оноос 65 тонноор нэмэгдсэн. Мөн "Дэлхийн Зөн Монгол” ОУБ-аас хэрэгжүүлж байгаа “Уур амьсгалын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд Иххэт суманд малын тэжээлийн ургамал тариалах сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтаар “Өнгөт” малчдын бүлгийг байгуулан малын тэжээлийн ургамлыг 5 га талбайд тариалахаар бэлтгэн 79,0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг нийлүүлэн тариалалтыг 2024 оноос эхлэхээр төлөвлөсөн. Мандах, Айраг, Сайхандулаан сумдад "Хоршоог хөгжүүлэх сан"-аас малын тэжээлийн ургамал тариалах төсөл өгсөн 2 хоршоо, 1 аж ахуйн нэгжид нийт 170,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Зээлд хамрагдсан ААНБ, иргэд нь 2024 оноос тариалалт хийж эхэлнэ. Бэлчээрийн даац, төлөв байдлаас шалтгаалан аймаг, сум, малчдын түвшинд бэлтгэвэл зохих нөөцийн хэмжээг Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоолоор тогтоосны дагуу аймгийн нөөцөд 600 тн өвс, 209 тн тэжээл, сумдын нөөцөд 648.9 тн өвс 268.9 тн тэжээл бэлтгэн, 97.8 хувьтай хангасан. "Дэлхийн зөн Монгол" олон улсын байгууллагын “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төсөлтэй хамтран аймгийн газар тариалан эрхлэгчдийн нэгдсэн сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж “Говийн бүсэд ногоон тэжээл тариалсан туршлага, ногоон тэжээл тариалах арга технологи” сэдвээр 97 тариаланчдад мэдээлэл хүргэсэн. "Нээлттэй Дорноговь" чуулганы үеэр хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааг сурталчлан оролцож малын тэжээлийн ургамал тариалах талаар сонирхсон иргэн, аж ахуйн нэгжид гарын авлага, номыг тарааж хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжийн талаар танилцуулсан. | |
| 167 | | 183. Малын тооноос хамааруулан өвс, тэжээлийн шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, стандартын | 2021 - 2024 | Аймаг, сумдын өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн хувь-53 | Аймаг, сумдын өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн хувь | | 70% | Өвс тэжээл хадгалах, аюулгүй нөөцийг бүрдүүлэх агуулахыг Дэлгэрэх, Иххэт, Эрдэнэ сумдууд сумын орон нутгийн хөгжлийн сангийн 313,7 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дагуу хадгалах | | | | | | байгуулснаар аймгийн нийт сумд мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангахад өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэн хадгалах агуулахтай болсон. Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоолоор тус аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 80 тн тэжээл, сумдын нөөцөд 560 тн өвс, 420 тн тэжээл нийт аймгийн хэмжээнд 660 тн өвс, 500 тн тэжээл бэлтгэх даалгавартайгаас одоогийн байдлаар аймгийн аюулгүйн нөөцөд 600 тн өвс, 209 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 648.9 тн өвс 268.9 тн тэжээл бэлтгэж аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт 97.8 хувьтай хангагдсан. | |
| 168 | | 184. Бэлчээрийн даацад тулгуурлан отор, нүүдлийг эртнээс төлөвлөн оновчтой зохион байгуулах; | 2021 - 2024 | Зохион байгуулсан ажлын тоо-1 | Зохион байгуулсан ажлын тоо | | 3 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/11 дүгээр тогтоолоор 6 сумын нийт 108,9 га бэлчээрийн газрыг "Сум дундын отрын нөөц нутаг"-аар тогтоож, 5 жилийн хугацаатайгаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. Дээрх отрын нөөц нутгуудад бэлчээрийн ургац 0.4-3.1 ц/га хэмжээтэй байх үед хонин толгойд шилжүүлснээр 64263 толгой мал өвөлжиж, хаваржих боломжтой. Аймгийн хэмжээнд гадны аймагт отроор өвөлжих 5 сумын 128 өрхийн 131,0 мян толгой мал байгаа бөгөөд бэлчээрийн даацын мэдээнд үндэслэн 2023-2024 оны өвөлжилт хаваржилт, отор нүүдлийн зураглалыг гарган холбогдох газруудыг мэдээллээр хангаж ажилласан. Отор нүүдлийг оновчтой зохион байгуулах ажлын хүрээнд хил хамгаалах ерөнхий газар, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр аймгийн удирдлагуудад отор нүүдэл хийх санал хүргүүлж, Мандах, Хатанбулаг, Хөвсгөл, Сайншанд сумд хил залгаа сумдтайгаа отор нүүдэл хийх гэрээ байгуулсан. Мөн Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын "Хэрлэнбаян-Улаан" отрын бүс | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нутгийн бэлчээр ашиглалтыг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн хуралд оролцож уг отрын бүс нутагт Дорноговь аймгаас 10 мянган толгой малыг отроор өвөлжүүлэхээр болсон. Тус аймагт хилийн зурваст 5 сумын 191 өрхийн 152.0 мянган толгой мал, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 5 сумын 110 өрхийн 76.0 мянган толгой мал, өөр аймгийн нутагт 5 сумын 128 өрхийн 131.0 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 7 сумын 208 өрхийн 102.0 мянган толгой мал, сум дундын отрын бүс нутагт 1 сумын 1 өрхийн 2.3 мянган толгой мал өвөлжиж байна. Эрдэнэ суманд Өвөрхангай аймгийн 3 өрхийн 1333 толгой мал, Хатанбулаг суманд Баянхонгор аймгийн 2 өрхийн 589 толгой мал, Хөвсгөл суманд Өмнөговь аймгийн 1 өрхийн 570 толгой мал өвөлжиж байна. | |
| 169 | | 185. Мал сүргээ тогтвортой өсгөн үржүүлж, нүүдлийн соёл, уламжлалыг хадгалан малчдын залуу халаал бэлтгэхэд хувь нэмрээ оруулж байгаа тэргүүний малчдыг урамшуулах, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 1 Малчдын тоо-55 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо Малчдын тоо | | 1 45 | Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулан мал сүргээ 5 төрөл дээр нь тогтвортой өсгөн үржүүлж, ашиг шимийг нь нэмэгдүүлэн, малч ухаан, ажиллах арга туршлагаараа манлайлан ажиллаж “Гавьяат малчин”-1, "Улсын хошой аварга малчин" 1, "Улсын аварга малчин" 16, "Алтан төлийн эзэн" 20, "Аймгийн хошой аварга малчин" 17, "Аймгийн аварга малчин" 91, "Аймгийн аварга тэмээчин" 11, "Аймгийн аварга саальчин" 2, "Аймгийн алдарт уяач" 25 нийт 184 малчин тодорсон. “Улсын шилмэл мал-2022" гойд, ашиг шимт малын цахим үзэсгэлэн худалдаанд Дэлгэрэх, Сайхандулаан сумдын 8 малчин өрхийг 12 толгой малтай оролцуулж, Дэлгэрэх сумын 3-р багийн аймгийн Аварга малчин Н.Санжидын "Дэлгэрэхийн улаан омог"-ийн эм ямаа "Гойд ашиг шимт мал"-аар шалгарсан. “Малчдын нэгдсэн зөвлөгөөн”, “Залуу малчдын | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, давхардсан тоогоор 4962 малчинд төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримталж буй бодлого шийдвэр, "Мал аж ахуйн үйлдвэрлэл, түүний эдийн засгийн тооцоолол", "Монгол тэмээ-Дорноговь" төслийн танилцуулга, "Малын эмийн зохистой хэрэглээ, анхаарах асуудал", "Малын тэжээлийн ургамал тариалсан туршлагаас" зэрэг сэдвүүдээр сургалт мэдээллийг танилцуулсан. "Мал аж ахуйн сэргэлт-Залуу малчдын үндэсний чуулган-2023" үндэсний хэмжээний чуулга уулзалтад 14 сумын 42 малчныг оролцуулж залуу малчдыг дэмжих, мал аж ахуйн эдийн засгийн ач холбогдлын талаарх мэдээ мэдээллээр хангасан. Сумдын хөдөө аж ахуйн салбарын ажлын үзүүлэлтээр Даланжаргалан, Эрдэнэ, Сайншанд сумд тус тус шалгарч "Аймгийн хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийн зөвлөгөөн"-ий үеэр тэргүүн туршлагыг танилцуулан, сум орон нутагтаа түгээн дэлгэрүүлэх зөвлөмж мэдээлэл өгч ажилласан. | |
| 170 | 3.3.6. Орон нутгийн худалдаа, үйлчилгээ, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин хөгжүүлж, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна. | 186. Сайншанд, Замын-Үүд сумдад ахуйн үйлчилгээ, худалдааны нэгдсэн төв байгуулах хувийн хэвшлийн санал, санаачлагыг дэмжих | 2021 - 2024 | Шинээр ашиглал-тад орсон ахуйн үйлчилгээ ний төвийн тоо-0 Шинээр ашиглал тад орсон худалдаа ны төвийн тоо-8 Төслийн тоо 1 Санхүүжилт-71.0 /сая.төг/ | Шинээр ашиглал-тад орсон ахуйн үйлчилгээ ний төвийн тоо Шинээр ашиглал тад орсон худалдаа ны төвийн тоо Төслийн тоо Санхүүжилт | | 1 2 2 200.0 /сая.төг/ | Хувийн хэвшлийн хөрөнгөөр тайлант онд Сайншанд суманд 6 худалдаа, үйлчилгээний зориулалт бүхий байгууламжийг ашиглалтад оруулж 100 гаруй ажлын байрыг бий болгосон ба 2020-2023 онд Сайншанд суманд 8, Замын-Үүд суманд 4 худалдаа, үйлчилгээний төв шинээр ашиглалтад орж, 180 гаруй ажлын байрыг бий болголоо. Сайншанд сумын 3 дугаар багт байрлах 7 давхар зочид буудал, худалдаа, үйлчилгээний зориулалт бүхий барилга байгууламжийг "Болор аграмба" ХХК хувийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулах шатандаа үргэлжилж байна. Мөн 7 дугаар багийн нутагт "Мандах наран -5" орон сууцны хорооллын 2 блок барилгын 1000 гаруй м.кв талбайг худалдаа, үйлчилгээний төвийн зориулалтаар төлөвлөн ашиглалтад оруулах | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шатандаа үргэлжилж байна. Замын-Үүд сумын "Төгрөг Уул" ХХК хувийн хөрөнгө оруулалтаар үйлчилгээний зориулалтаар 4 давхар худалдааны төв барьж, гүйцэтгэл 80 гаруй хувьтай үргэлжилж байна. Сайншанд суманд орон нутгийн худалдаа үйлчилгээ болон жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын А/47 дугаар захирамжаар 4 дүгээр багт "ONE MART" худалдаа үйлчилгээний төв байгуулахаар 15.5 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар олгосон. “Хоршоог хөгжүүлэх сан”-гаас худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн зориулалтаар 1 иргэн, 1 аж ахуйн нэгж байгууллагад 55 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих зорилгоор “Дорноговьд үйлдвэрлэв” бизнес эрхлэгчдийг дэмжих нэгдсэн төвийг Сайншанд сумын 2-р багийн нутагт төр- хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулахаар “Суман зурхай” ХХК-д 849 м2 газрыг аймгийн Засаг даргын 2023 оны А/589 дүгээр захирамжаар эзэмшүүлж, барилгын ажил 30 орчим хувьтай явагдаж байна. Орон нутагт бизнесийн таатай орчин бүрдүүлэх, хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжих хүрээнд газрын асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай техникийн нөхцөлийг олгох, мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллээр хангах чиглэлээр тухай бүрд хамтран ажиллаж байна. | |
| 171 | | 187. Орон нутгийн хүнс, газар тариалан, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэр-лэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах “Нутгийн брэнд” төвийг | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо-3 Хамрагд сан ААН, иргэдийн тоо-200 "Нутгийн бренд"төв байгуулах ажпын гүйцэтгэлийн хүвь-0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагд сан ААН, иргэдийн тоо "Нутгийн бренд"төв байгуулах ажпын гүйцэтгэлийн хүвь | | 2 200 30% | Орон нутгийн хүнс, газар тариалан, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах зорилгоор “Цагаан сар-2023”, “Намрын ногоон өдрүүд-2023” үзэсгэлэн худалдааг Сайншанд суманд зохион байгуулж 12 сумын давхардсан тоогоор 221 иргэн, аж | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжих | | | | | | ахуйн нэгж оролцож 220,0 сая.төгрөгийн борлуулалт хийсэн. Тайлант онд Сайншанд сумын 10 тариаланч MNS 6737:2018 Хөдөө аж ахуйн зохистой дадал /ХААЗД/ хэрэгжүүлэх удирдамж стандартын шаардлагыг хэрэгжүүлснээр газар тариалангийн үйлдвэрлэл хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэн гэрчилгээ, тэмдгээ гардан авсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийн шилдэг бүтээгдэхүүн, шинэ ургацын ногоог нэг дороос, үйлдвэрийн үнээр хэрэглэгчдэд хүргэх зорилгоор “Намрын ногоон өдрүүд-үндэсний үйлдвэрлэл 2023” нэгдсэн арга хэмжээнд аймгийн 3 үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн төлөөллийг оруулцуулсан. "Ай Ти Эм-mongoli" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгаа төлөөлөн "Хамарын хийдийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа" ОНӨААТҮГ, Сайншанд сумын ЗДТГ, гар урлалын 8 иргэн, 1 аж ахуйн нэгж байгууллага оролцоход аймгийн Засаг даргын 2023 оны А/687 дугаар захирамжаар 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Жижиг дунд үйлдвэрийн газраас эрхлэн гаргаж байгаа 21 аймгийн онцлог шинжийг харуулсан брэнд бүтээгдэхүүний катологид "Далт мөнгөн шанд" ХХК-ий "Загсгал цай", "Оюун шанд" ХХК-ий “Зээг чанамал", "Хашаатын говийн заг" ХХК-ий "Тансаг цагаан" ингэний хоормог, "Дорнын үжин гоо" ХХК-ны "Гоо брэнд" саван, Мөрөөдлийн говь ХХК-ны "Эрүүл эко Шанд эгг" өндгийг орон нутгийн брэнд бүтээгдэхүүнээр онцлон сурталчилсан. Аймгийн 34 зочид буудал, 16 гэр буудал, 9 хоолны газар, 2 сувиллын газрын мэдээллийг цахимд оруулснаас 6 буудал, 2 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сувилал мэдээллийг QR кодод оруулж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. | |
| 172 | | 188. Орон нутагт хэрэгжиж буй томоохон төсөл, хөтөлбөр, боловсруулах, баяжуулах үйлдвэрийн захиалгат ажлыг өрхийн болон жижиг, дунд бизнес эрхлэгчид гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх; | 2021 - 2024 | Гэрээ байгуулсан ААН-ийн тоо-0, Захиалгаар нийлүүлж буй иргэн,ААН-30, Захиалгаар хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч иргэн, ААН -25, Захиалгаар оёдлын үйлчилгээ эрхлэгч иргэн, ААН-5 | Гэрээ байгуулсан ААН-ийн тоо Захиалгаар нийлүүлж буй иргэн,ААН Захиалгаар хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч иргэн, ААН Захиалгаар оёдлын үйлчилгээ эрхлэгч иргэн, ААН | | 20 50 43 7 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн болон томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгидтэй жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийн холбох, борлуулалтыг нэмэгдүүлэх бодлого барин, “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн төсөл хэрэгжүүлэгч “JMC Projects Mongolia” ХХК-тай орон нутгийн худалдааны 3, цэвэр усны 1, мах, махан бүтээгдэхүүн 1 аж ахуйн нэгжийг холбож захиалгын дагуу нийлүүлэлт хийж байна. Тус үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцож буй туслан гүйцэтгэгч 8 компани нь цэвэр усны 4, махны 1, сүү, сүүн бүтээгдэхүүний 1, хүнсний ногооны 1 аж ахуйн нэгжтэй гэрээгээр, бусад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг Сайншанд сумын зах худалдааны төв, худалдаа, үйлчилгээний газруудаас сонгон авч байна. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 26 уурхай, боловсруулах болон баяжуулах 13 үйлдвэр, тээврийн 35 компани нь 14 сумын худалдааны 38, цэвэр усны 12, мах 1, махан бүтээгдэхүүний 1, сүү, сүүн бүтээгдэхүүний цех 1, фермер 6, өндөгний аж ахуй эрхлэгч 1, оёдлын үйлдвэр 1, цех 18, ногооны 4 аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээгээр, бусад өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, сэлбэг, шатах, тослох материалыг тухай бүрд орон нутгийн бизнес эрхлэгчдээс худалдан авсан. Тайлант хугацаанд Дорноговь аймагт амьдрах таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг өргөтгөх, хөрөнгө оруулалт татах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр “Урбан жинс” ХХК, “Солид партнерс” ХХК, “Олон ихт баян” ХХК, “Шунхлай” ХХК, “Дабл фиш” ХХК, “One mart” ХХК-иудтай санамж бичгийг байгуулж хамтын ажиллагааг эхлүүллээ. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 173 | | 189. Орон нутагт хэмжлийн нэгдмэл байдлыг хангаж, стандартыг сурталчлан цар хүрээг өрөгжүүлэх | 2021 - 2024 | Баталгаа жуулалтад хамруул сан хэмжих хэрэгслийн тоо-2500 Баталгаа жуулалтад хамрагдалтын өсөлтийн хувь-92 Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний тоо-1 | Баталгаа жуулалтад хамруул сан хэмжих хэрэгслийн тоо Баталгаа жуулалтад хамрагдалтын өсөлтийн хувь Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний тоо | | 3000 95% 1 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 79 дүгээр тогтоолын хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтад 25 обьектыг хамруулж, их эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй 5, бага эрсдэлтэй 19 үнэлэгдэж, 156 зөрчил, дутагдал илрүүлэн, зөрчлийг арилгуулахаар 92 заалт бүхий 15 албан шаардлага, 23 заалттай 14 зөвлөмж, дүгнэлт 1, хяналт шалгалтын танилцуулга 19 тус тус боловсруулан гаргасан. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хүрээнд эрүүл мэнд, байгаль орчин, төлбөр тооцооны зориулалтаар худалдаа, үйлчилгээний салбарт ашиглагдаж буй 417 жин хэмжүүр, хүнд даацын жин 63 авто пүү, 239 шатахуун түгээх станцын шингэн хэмжигч, айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжийн 843 усны тоолуур, 115 ширхэг автоцистерн баталгаажуулж, нийт 1677 ширхэг хэмжих хэрэгсэлд гэрчилгээ олгосон. Худалдаа, үйлчилгээний 780 газрыг тохирлын үнэлгээнд хамруулан заавар, зөвлөгөө өгч, 11 дотоодын бүтээгдэхүүн, 189 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон. Худалдаа, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох стандартын хэрэгжилт, бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн ашиглалтын талаарх нийт 10 удаагийн сургалт зохион байгуулж , 425 аж ахуй нэгжийн төлөөллийг хамруулан мэдлэг олгосон. Баталгаажуулалтын ажлын гүйцэтгэл 96 хувьтай явагдсан. | 100% |
| 174 | | 3.3.6.4. Худалдаа, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох стандартыг мөрдүүлэх, салбарын | 2021 - 2024 | | Тохирлын үнэлгээнд хамруулсан худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, бүтээгдэхүүний тоо-412 , Худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, | | | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 79 дүгээр тогтоолын хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтад 25 обьектыг хамруулж, их эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй 5, бага эрсдэлтэй 19 үнэлэгдэж, 156 зөрчил, | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүний нөөцийг чадавхжуулан мэргэжилтэй ажилтан бэлтгэх | | | бүтээгдэхүүнд олгосон тохирлын гэрчилгээ тоо-232, Стандартын шаардлага хангалтын хувь -60, Салбарын мэргэжилтэй ажилтны тоо -500, Сургалтад хамрагдсан иргэн, ААН-ийн тоо-150 | | | дутагдал илрүүлэн, зөрчлийг арилгуулахаар 92 заалт бүхий 15 албан шаардлага, 23 заалттай 14 зөвлөмж, дүгнэлт 1, хяналт шалгалтын танилцуулга 19 тус тус боловсруулан гаргасан. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хүрээнд эрүүл мэнд, байлгал орчин, төлбөр тооцооны зориулалтаар худалдаа, үйлчилгээний салбарт ашиглагдаж буй 417 жин хэмжүүр, хүнд даацын жин 63 авто пүү, 239 шатахуун түгээх станцын шингэн хэмжигч, айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжийн 843 усны тоолуур, 115 ширхэг автоцистерн баталгаажуулж, нийт 1677 ширхэг хэмжих хэрэгсэлд гэрчилгээ олгосон. Худалдаа, үйлчилгээний 780 газрыг тохирлын үнэлгээнд хамруулан заавар, зөвлөгөө өгч, 11 дотоодын бүтээгдэхүүн, 189 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон. Худалдаа, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох стандартын хэрэгжил, бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн ашиглалтын талаарх нийт 10 удаагийн сургалт зохион байгуулж , 425 аж ахуй нэгжийн төлөөллийг хамруулан мэдлэг олгосон. Баталгаажуулалтын ажлын гүйцэтгэл 96 хувьтай явагдсан. Хүнсний юулгүй байдлыг хангах хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 14 суманд зохион байгуулж, 165 ААНБ, 198 иргэн, нийт 363 обьектыг хамруулж, 1312 зөрчил дутагдлыг илрүүлж 565 буюу 43,06%-ыг арилгуулан, 19 аж ахуйн нэгж байгууллага, 17 иргэнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 36 албан шаардлагыг хүргүүлж, 4 аж ахуйн нэгжид 11,5 сая, 9 иргэнд 2,9 сая төгрөгийн торгууль шийтгэл ноогдуулж, чанар аюулгүй байдалд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хяналт тавьж ажилласан. | |
| 175 | 3.3.7. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулж, экспортыг нэмэгүүлнэ | 190. Малын эмч, мэргэжилтний хүний нөөцийг бүрдүүлэн, чадавхжуулах; | 2021 - 2024 | Мэргэжил дээшлүүл сэн болон давтан суралцсан эмч, мэргэжилтнүүдийн тоо-150 Хүний нөөцийн хангамжийн хувь- 53.5 | Мэргэжил дээшлүүл сэн болон давтан суралцсан эмч, мэргэжилтнүүдийн тоо Хүний нөөцийн хангамжийн хувь | | 200 5% | Мал эмнэлгийн салбарын албан хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор 1.5 кредит цагтай сургалтад 57 малын эмчийг, нарийн мэргэжлийн ажлын байрны сургалтад давхардсан тоогоор лабораторийн 6 шинжээч эмчийг тус тус хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлсэн. Тайлант хугацаанд нийт 18 удаагийн цахим, 24 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 602 эмч, мэргэжилтнийг хамруулснаар албан хаагчдын ажлын байран дээрх сургалтын тоо өмнөх оноос 8,5 хувиар өссөн. Малчдын нэгдсэн зөвлөгөөнд оролцсон 706 малчдад 3 төрлийн мэдээллийг хийж, 5 төрлийн 650 ш гарын авлага тарааж, мэдлэгийг дээшлүүлсэн нь өмнөх оноос сургалт, мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоо 6.5 хувиар өссөн. Байгууллагын 2 төрлийн цахим хаягт давхардсан тоогоор 26 постер, 5 төрлийн богино хэмжээний видео мэдээллийг байршуулж, үйл ажиллагааг сурталчлан 16000 иргэний хандалт авсан. Мал эмнэлгийн чиглэлээр 30 аж ахуй нэгжид 42 малын их эмч, 1 малын бага эмч, сумдын Мал эмнэлгийн 11 тасагт 8 байцаагч, 5 тархвар зүйч нийт 13 мэргэжилтэн, Мал эмнэлгийн газарт 6 малын эмч ажиллаж байгаа нь боловсон хүчний хангалт 48,7 хувийн хангалттайгаар анхан шатны мал эмнэлгийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Тайлант хугацаанд малын их эмчээр суралцаж байгаа оюутны судалгааг авч, Мал эмнэлгийн сургуулийн оюутануудтай уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулан давхардсан тоогоор 90 оюутныг хамруулснаар 11 ажлын байрыг нөхснөөр мал эмнэлгийн салбарын хүний нөөцийн хангалт өмнөх онтой харьцуулахад 10,3 хувиар өссөн. | 90% |
| 176 | | 191. Мал, малын | 2021 - | Хяналт шалгалтад | Хяналт шалгалтад | | иргэн-140, ААН- | Мал эмнэлгийн ажил үйлчилгээг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах; | 2024 | хамруул сан иргэн-109 ААН-55 | хамруул сан иргэн ААН | | 70 | сайжруулах зорилгоор 12 аж ахуй нэгж, 85 иргэнд хяналт шалгалтыг зохион байгуулсан. Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлыг хангах зорилгоор аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг махны 1 үйлдвэр, худалдан борлуулах төвлөрсөн 4 цэгт аймгийн "Цагдаагийн газар"-тай хамтран 2 удаа хяналт шалгалтыг хийж, 3 алдаа дутагдал нь байрны эрүүл ахуй, ажлын байрны хувцасгүй, ноцтой 1 зөрчилд мал эмнэлгийн гэрчилгээ аваагүй байсныг илрүүлэн холбогдох газрын эмч мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч, зөрчлийг 90 хувьтай арилгуулсан. Мал, амьтны шилжилт хөдөлгөөн, мал малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлыг хангах, хяналт тавих, баталгаажуулалтын 9767 ширхэг гэрчилгээ бичигдэж, адууны мах 58.1 тн, үхрийн мах 227 тн, хонины мах 197.5 тн, ямааны мах 17.3 тн, тэмээний мах 53.3 тн, гахайны мах 0.1 тн, 43,1 тн ноос, 24.9 тн ноолуур, 1450000 ширхэг өндөг, 645 ширхэг арьс шир, 0,3 тн малын гаралтай дайвар бүтээгдэхүүн, 101718 толгой амьд малыг үзлэг, тандалтад хамруулж, бүтээгдэхүүнд шинжилгээ хийсэнд мал эмнэлгийн улсын 5 байцаагч хяналт тавьж баталгаажуулсан. Мал эмнэлгийн 240 гэрчилгээ батлагдаагүй, 157 гэрчилгээг татгалзаж, саатуулсан 1 нийт 398 ш цахим гэрчилгээ буюу 0,4 хувь нь зөрчилтэй байгааг тухай бүр хяналтад авч, ашиглалтыг сайжруулсан. | |
| 177 | | 192. Малын гоц халдвар, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг зохион байгуулахад мал эмнэлгийн нэгж, | 2021 - 2024 | Өвчний төрөл-13 Арга хэмжээний тоо-16 Хамрагдалтын хувь-93 | Өвчний төрөл Арга хэмжээний тоо Хамрагдалтын хувь | | 13 16 95% | Мал амьтны гоц халдварт Шүлхий, Хонины цэцэг, Бог малын мялзан, Гахайн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 9311 өрхийн 908,9 мянган толгой малыг хамруулж нийт 304,6 сая төгрөгийг зарцуулсан. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | малчдын хамтын ажиллагаа, ур нөлөөг дээшлүүлэн малын өвчлөлийг бууруулах | | | | | | Малын халдварт Галзуу, Боом, Бруцеллёз зэрэг 9 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 9 удаа зохион байгуулж 815 өрхийн 970,8 мянган толгой мал, амьтныг хамруулан 206,0 сая төгрөгийг зарцуулсан. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх идэвхтэй үзлэг тандалтыг 15 удаа хийж 1279,3, идэвхгүй үзлэг тандалтыг 32 удаа хийж 1845.1 толгой мал нийт давхардсан тоогоор 3,1 сая толгой малыг хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад 67,7 хувиар өссөн. Мал, амьтны гоц халдварт өвчний 9 тохиолдол 4 суманд оношлогдож өвчилсөн мал өмнөх оноос 53,3 хувиар, өвчлөл оношлогдсон сум 57,1 хувиар тус тус буурсан. | |
| 178 | | 193. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлж, халдварт бус өвчний шалтгаан нөхцөлийг тодорхойлж эрүүлжүүлэн, малын зүй бус хорогдлыг бууруулах | 2021 - 2024 | Эмчлэн сэргийлэх арга хэмжээ тоо-3 Эмчлэн сэргийлэх арга хэмжээ хамрагдал тын хувь-31.5 Үзлэг, тандалтад хамруул сан малын тоо1.14 /сая. тол/ Шинжилсэн дээжийн тоо-44.6/мянга/ Зүй бус хорогдлын бууралтын хувь-2.5 | Эмчлэн сэргийлэх арга хэмжээ тоо Эмчлэн сэргийлэх арга хэмжээ хамрагдалтын хувь Үзлэг, тандалтад хамруул сан малын тоо Шинжилсэн дээжийн тоо Зүй бус хорогдлын бууралтын хувь | | 3 60% 1.4 /сая. тол/ 44.6 /мянга/ 2.5% | Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх 3 төрлийн арга хэмжээнд нийт 1245.8 мянган толгой мал, амьтныг хамруулсан нь мөн оны өмнөх үетэй харьцуулахад 145,8 мянган толгой малаар өссөн. Малын халдваргүй өвчний 136 дуудлага ирж, 129 толгой малд шаардлагатай эмчилгээ, үйлчилгээг хийж эдгэрүүлэн, 7 толгой мал хорогдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эмчилгээ үйлчилгээний чанар 58 хувиар өссөн. Малын халдварт бус байгаль орчноос шалтгаалах өвчнийг илрүүлэх зорилгоор 30 дээжийг шинжилгээнд хамруулан шалтгаан нөхцөлийг тодорхойлж, хариу арга хэмжээ авсан. Малын халдварт өвчин хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор малын хашаа хороо, худаг, уст цэг, бэлчээрийн 430,6 м2 талбайд халдваргүйтгэл хийж 106,1 мянган толгой мал, амьтны сэг зэмийг устгаж хөрсөөр дамжин халдварлах 3 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэн малын зүй бус хорогдлыг 2,5 хувиар бууруулсан. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сэргийлэх идэвхтэй үзлэг тандалтыг 15 удаа хийж 1279,3, идэвхгүй үзлэг тандалтыг 32 удаа хийж 1845.1 толгой мал нийт давхардсан тоогоор 3,1 сая толгой малыг хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад 67,7 хувиар өссөн.  Мал эмнэлгийн лабораторийн төлөвлөгөөт 5 төрлийн тандалт шинжилгээнд 25912 толгой мал, шинээр болон дахин сэргэж байгаа 4 төрлийн өвчний шинжилгээнд давхардсан тоогоор 108 малчин өрхийн 948 толгой малыг хамруулж, 9.6 сая төгрөг зарцуулсан. Адууны ям, үхрийн сүрьеэ, бусад төрлийн өвчнүүдийн шинжилгээг хийхэд сөрөг дүнтэй гарч, эрүүл тайван бүсийг баталгаажуулсан. | |
| 179 | | 194. Мал амьтны зооноз, шинээр болон дахин сэргэж байгаа өвчний тандалт, шинжилгээг тогтмолжуулж, зарим төрлийн өвчингүй тайван бүсийг баталгаажуулах; | 2021 - 2024 | Зооноз, шинээр болон дахин сэргэж байгаа өвчний тандалтад хамрагд сан малын тоо-16455 Шинжилсэн дээжийн тоо-44.6 Тайван бүсээр баталгаа жуулсан өвчний төрөл-0 | Зооноз, шинээр болон дахин сэргэж байгаа өвчний тандалтад хамрагд сан малын тоо Шинжилсэн дээжийн тоо Тайван бүсээр баталгаа жуулсан өвчний төрөл | | 10000 44.6 0 | Малаас хүнд халдварладаг зооноз халдварт бруцеллёз өвчний халдварыг тогтоох шинжилгээнд 1961 өрхийн 16602 толгой хээлтүүлэгч мал хамрагдаж, 10.3 сая төгрөг зарцуулсан. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 2453 өрхийн 598666 толгой охин төлийг 99.9 хувьтай хамруулсан.  Мал эмнэлгийн лабораторийн төлөвлөгөөт 5 төрлийн тандалт шинжилгээнд 25912 толгой мал, шинээр болон дахин сэргэж байгаа 4 төрлийн өвчний шинжилгээнд давхардсан тоогоор 108 малчин өрхийн 948 толгой малыг хамруулж, 9.6 сая төгрөг зарцуулсан. Адууны ям, үхрийн сүрьеэ, бусад төрлийн өвчнүүдийн шинжилгээг хийхэд сөрөг дүнтэй гарч, эрүүл тайван бүсийг баталгаажуулсан. Замын-Үүд сумын "Мал эрүүлжүүлэн тусгаарлах бүс"-д 120.0 мянган толгой малыг амьдаар нь зах зээлд бэлтгэн нийлүүлж, экспортлоход үзлэг шинжилгээнд хамруулж, эрүүлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулсан. Адууны нийлүүлгийн өвчний 32 дээжийг шинжилгээнд хамруулахад 3 дээжинд эерэг дүн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гарсан нь нийт дээжийн 9.3 хувьд халдвар илэрсэнд, хариу арга хэмжээг өвчний зааврын дагуу хэрэгжүүлсэн. | |
| 180 | 3.4.1. Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлнэ. | 195. Аймгийн аялал жуулчлалын төлөвлөгөөг хэрэгжүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлэх; | 2021 - 2024 | Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө батлагдсан. Жуулчдын тоо-60000 | Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөний хэрэгжилт Жуулчдын тоо | | 75%/65000 | Говийн догшин ноён Хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг угтан Ханбаянзүрх хайрханы гэрэлтүүлэг зам талбайг өргөтгөж, засварлах, Шамбалын орон, Ханбаянзүрх хайрхан орчимд нийтийн бие засах газрууд, Хамарын хийдийн Шамбалын орныг 108 агуйтай холбосон автозам, зогсоол хийх ажил, Сайншанд-Хамарын хийд чиглэлийн автозамын засвар шинэчлэл зэрэг ажлуудыг хийж орон нутгийн төсвөөс 2 тэрбум төгрөгийг зарцуулан жуулчдыг татах, аялал жуулчлалын бүсэд аялагчдын ая тухтай аялах нөхцөл боломжийг бүрдүүллээ. Аймгийн аялал жуулчлалын холбооны үйл ажиллагааг эрчимжүүлэх, шинэчлэн зохион байгуулалтад оруулах зорилгоор орон нутгийн аялал жуулчлалын бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, Хамарын хийдийн хамгаалалтын захиргаа ОНААТҮГ нийт 23 иргэний уулзалтыг зохион байгуулж аймгийн аялал жуулчлалын холбооны удирдах зөвлөлийн 9 гишүүнийг шинээр сонгосон. Соёл урлагийн газрын дэргэдэх Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлийн санаачилгаар аймгийн Говийн ноён хутагтын музейтэй хамтран Ноён хутагт Данзанравжаа, Өвөрбаясгалант хамарын хийд, Ханбаянзүрх хайрханы талаар “Хөтөч тайлбарлагч” бэлтгэх сургалтыг 03 дугаар сарын 16–ны өдөр зохион байгуулж 45 хөтөч тайлбарлагчдыг бэлтгэж, үнэмлэхжүүлсэн. Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх  ажлын хүрээнд “Зочлох, үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв” ТББ, “Монголын зочлох үйлчилгээний гэр холбоо” ТББ-ууд хамтран зочид буудал, зоогийн газар, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дэн буудал, жуулчны баазын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад зориулж “Ковидийн дараах борлуулалтын хэв маяг” сургалтыг 2021 онд, 2022-2023 онд аялал жуулчлалын бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад 2 удаагийн хэлэлцүүлэг, 3 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 120 гаруй хүн хамрагдаж, сургалтын үр дүнд үйлчилгээгээ сайжруулсан. Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэн тасалбарын мэдээгээр дотоодын 83554, гадаадын 2017 нийт 85571 аялагч аяласан нь 2020 онтой харьцуулахад 40,5 хувиар өссөн. | |
| 181 | | 196. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг шинэлэг байдлаар сурталчилах, | 2021 - 2024 | Аялал жуулчлалын цахим хуудастай | Цахим хандалтын хувь | | 30% | "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/417 дугаар захирамжийн дагуу DTV орон нутгийн телевизтэй аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах контент бэлтгэх ажлын гэрээг байгуулан Даланжаргалан сумын "Их нарт", Сайншанд сумын "Хамарын хийд", Эрдэнэ сумын "Бүрдэнэ булаг", аймгийн байгалийн болон түүхийн есөн гайхамшгийн танилцуулга боловсруулах ажлыг хийж байна. Мөн Сайншанд сумын 7, Замын-Үүд сумын 2 нийт 9 жуулчны бааз, Сайншанд 8, Замын-үүд 11, Айраг 3, Алтанширээ1, Дэлгэрэх 1, Даланжаргалан 5, Хөвсгөл 2, Улаанбадрах 2, Мандах 1 нийт 34 зочид буудал, 16 гэр буудал, 9 хоолны газар, 2 сувиллын газрын мэдээллийг цахимд оруулснаас 6 буудал, 2 сувилал мэдээллийг QR кодод оруулж, орон нутгийн аялал жуулчлалын 5 минутын видео танилцуулга бэлтгэж тус газрын https://do.mne.gov.mn/, https://www.dornogovi.gov.mn/intro/ сайтад байршуулж олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн http://www.touristinfocenter.mn, https://joinme.mn/ цахим сайтуудад | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | орон нутгийн аялал, жуулчлалын гол бүс нутгуудын танилцуулгыг оруулж 91479 гаруй хандалт авсан нь өмнөх оноос 8.2 хувиар өссөн. Мөн иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудыг төрийн мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлж "dornogovi.gov.mn" аймгийн цахим хуудасны гар утасны "Нээлттэй Дорноговь" аппликейшныг бүтээсэн. Тус аппликейшнаар дамжуулан аялал жуулчлалын чиглэлийн үйлчилгээнүүдийг нэг дороос авах боломжийг тус тус бүрдүүлж ажиллалаа. Соёл урлагийн газрын дэргэдэх Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлийн санаачилгаар аймгийн Говийн ноён хутагтын музейтэй хамтран Ноён хутагт Данзанравжаа, Өвөрбаясгалант хамарын хийд, Ханбаянзүрх хайрханы талаар “Хөтөч тайлбарлагч” бэлтгэх сургалтыг 03 дугаар сарын 16–нд зохион байгуулж 45 хөтөч тайлбарлагчдыг бэлтгэж, үнэмлэхжүүлсэн. | |
| 182 | | 197. Үндэсний зан заншил, уламжлал, түүх соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжиж, хөгжүүлэх | 2021 - 2024 | Цайны замын 5 цэгийг тогтоосон. Зохион байгуулсан эвент арга хэмжээний тоо 1 | охион байгуулсан эвент арга хэмжээний тоо | | 4 | Уламжлал мал аж ахуйн амьдрал, түүх соёл, унаган байгал, нүүдэлчин ахуйг танилцах зорилготойгоор “Их говийн тэмээ-2023” наадам, “Лусын тамга” арилгах арга хэмжээ, “НОЁН ХУТАГТЫН ӨВ: ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, "Адистэд хурсан гайхамшиг" тусгай үзэсгэлэнг тус зэрэг үйл ажиллагааг санаачлан зохион байгуулж нутаг орны онцлогийг сурталчлан танилцуулсан. Мөн "Талын салхи" мото фестиваль,“Сайншанд авто кросс-2023” уралдаан, "KHAMAR MONASTERY-2023" засмал замын болон уулын замын дугуйн уралдаануудыг амжилттай зохион байгуулж, нийт 10000 гаруй иргэд үзэж сонирхохоос гадна хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Үндэсний бахархал, өв соёлыг сурталчилсан, үндэсний онцлогийг агуулсан, 130 гаруй төрлийн эд өлгийн зүйлсийг дэлгэн AR технологиор дамжуулан гар утсаараа мэдээллээ авах боломжийг олгож "Danzanravjaa museum" аппликейшныг хийлгэж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Энэхүү апплейкишнээр иргэд музейн бүх төрлийн мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн. Соёлын өвийн өвлөн уламжлагчдаар дамжуулан аймгаа сурталчлах зорилготойгоор ”Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль, "Ай Ти эм-2023" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 7 ай савын 31 өвлөн уламжлагч, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 3 компани, 2 байгууллага оролцож өөрийн орон нутгийн соёлын биет бус өвийн онцлогыг гадаад дотоодын 3500 гаруй жуулчдад танилцуулсан  Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13/09 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-д тусгагдсан 15 чиглэл маршрутын дагуух түүх соёлын дурсгалт газруудын судалгааг нэгтгэж, зураглалд оруулсан.  "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/417 дугаар захирамжийн дагуу  аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах контент бэлтгэх ажлыг DTV телевизтэй хамтран "Их нарт", "Хамарын хийд",  "Бүрдэнэ булаг", аймгийн байгалийн болон түүхийн есөн гайхамшгийн танилцуулга боловсруулах ажлыг хийж байна. | |
| 183 | 3.5.1. Эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлнэ | 198. Сайншанд сумын дулааны станцын барилгын ажлыг эхлүүлэх | 2021 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | - | "Сайншанд сумын 7 дугаар багт Дулааны станц барих ажлыг орон нутгийн төсвийн 3,8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Чандмань-Илч” ХХК гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. Дулааны станц ашиглалтад орсноор 1000 айл өрхийг төвлөрсөн дулаан | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хангамжид холбох нөхцөл бүрдсэн. | |
| 184 | | 199. Чойр-Сайншандын 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барихад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах | 2021 - 2024 | Хамтран ажилласан арга хэмжээний тоо 0 | Хамтран ажилласан арга хэмжээний тоо | | 1 | Чойр-Сайншанд чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих зориулалтаар 2021 онд 7.8 га газрыг орон нутгаас шийдвэрлэж газрын гэрчилгээг олгосон ба 2022 онд ЦДАШ-ын холбогдох трассыг хянаж батлуулан орон нутгаас дэмжин хамтран ажиллалаа. | 100% |
| 185 | | 200. Сайншанд сумын дулаан хангамжийг хоёрдогч хэлхээнд шилжүүлэх. | 2022 - 2024 | Ус, дулаан дамжуулах төвийн тоо-4 | Ус, дулаан дамжуулах төвийн тоо | | - | Сайншанд сумын дулаан хангамжийг хоёрдогч хэлхээнд шилжүүлэх ажлын хүрээнд төв садны хашаанд 1, 4-р 58 байрны урд талд-1, 9 дүгээр цэцэрлэгийн баруун талд-1, 5-р 58 байрны хойно-1 ус дулаан дамжуулах төвийн нийт 4 барилгыг Эрчим хүчний яамны төслийн санхүүжилтээр "Одкон холдинг" ХХК, гадна шугам холболтыг Чандмань-Илч ОНӨХХК тус тус хийж гүйцэтгэн, 100% ашиглалтад оруулсан. | 100% |
| 186 | | 201. Зарим сумын цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх судалгааны ажлыг хийж, үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэх. | 2021 - 2024 | Судалгаанд хамрагдсан сумын тоо 1 | Гүйцэтгэлийн хувь 2 тарифт тоолуур суурилуулсан өрхийн тоо | | “Засаг Чандмань” уурхайгаас Дэлгэрэх сум хүртэл 16 км 10 кВ-ын ЦДАШ, дэд станц барих зураг төсвийн гүйцэтгэл 100% | Хатанбулаг сумын Ханги хилийн боомтын гадна цахилгаан хангамжийн 35/10кВ-ын 2500кВА хүчин чадалтай хүчний трансформатор бүхий 35кВ-ийн ил хуваарилах байгууламжтай иж бүрэн дэд станцын ТЭЗҮ хийх, зураг төсөл боловсруулах ажлыг 2022 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар төсвийг батлуулан худалдан авах ажиллагааны тендер зохион байгуулж “Перфект солюшн энд инженеринг” ХХК шалгарч, гэрээ байгуулан 45,125,300 төгрөгөөр хийж гүйцэтгэн, зураг, төсвийг хүлээлгэн өгсөн. Хатанбулаг сумын Ханги хилийн боомтыг байнгын цахилгаан эрчим хүчээр ажлын хүрээнд Дорноговь аймаг, БНХАУ-ын Дархан муу мянганы хошуу хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 10 кВт хүчин чадалтай цахилгаан дамжуулах агаарын шугамаар импортын эрчим хүчээр хангагддаг бөгөөд орон нутгийн удирдлагуудаас эрчим хүчний хүчин чадлыг 35 кВт цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10кВ- | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ын 10 мВт чадалтай дэд станцыг барихаар харилцан тохиролцож, зардлын асуудлыг БНХАУ-ын ӨМӨЗО-оос шийдвэрлүүлсэн. Хөвсгөл сумын төвлөрсөн шугам сүлжээний гадна цахилгаан хангамжийн ажил, Улаанбадрах сумын ЦДАШ солих, дэд станц барих ажлын судалгааны дагуу зураг төслийг “Электро” ХХК боловсруулж, орон нутгийн төсвийн 295.1 сая төгрөгийн төсөвт өртөгөөр "Смарт Крафт" компани гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Орон нутгийн төсвийн 344,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Иххэт сумын шинэ суурьшлын бүс “Барга” хороололд 04 кВт-ын цахилгаан дамжуулах гаарын шугамыг "Эрчим” ХХК гүйцэтгэж, ашиглалтад оруулан хамгаалалтын зурвасыг тогтоон, 254 өрхийг цахилгааны эх үүсвэрт холбон орон нутгийн иргэдийг тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүллээ. Сайншанд-Өргөн сум чиглэлийн 17 км 35 кВт хүчин чадал бүхий ЦДАШ-ын тулгуур солих ажлыг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн Дорноговь аймаг дахь салбар өөрийн 944,5 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэж, 80 хувьтай үргэлжилж байна. Тус аймгийн 14 сум нь төвийн цахилгаан эрчим хүчний нэгдсэн системд бүрэн холбогдсон ба 2020-2023 онд 60.52 км ЦДАШ, 37 дэд станц байгуулж, хүчин чадлыг 20 хувиар нэмэгдүүлж ажилласан. | |
| 187 | | 202. Мандах, Сайхандулаан сумдад халаалтын зуух, нэгдсэн инженерийн шугам барих судалгааны ажлыг хийх. | 2022 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | - | Орон нутгийн төсвийн 199,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандах, Сайхандулаан сумдын төвд төвлөрсөн халаалт, цэвэр, бохир усны шугам барих ажлын зураг төсвийг боловсруулах ажлыг "Хайдро дизайн прожект" ХХК гүйцэтгэж, гүйцэтгэл 60 гаруй хувьтай үргэлжилж байна. Уг ажлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан "Дорноговь аймгийг хөгжүүлэх 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө"-нд тусгасан ба | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шаардагдах санхүүжилтийг 2024 оны орон нутгийн төсөвт тусгуулахаар төлөвлөөд байна. | |
| 188 | 3.6.1. Зам, тээврийн сүлжээг байгуулж, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ | 204. Сайншанд-Баруун-Урт- Хөөт, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах. | 2021 - 2024 | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо 2 | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | | - | "Монгол Улсын Засгийн газраас ""Сайншанд-Баруун-Урт-Хөөт"" чиглэлийн төмөр замын төслийг одоогоор эхлүүлээгүй байна. Монгол Улсын Засгийн газраас уг бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээгүй байгаа тул орон нутгаас ямар нэгэн зөвшөөрөл авах, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах хэрэгцээ шаардлага үүсээгүй болно. | 100% |
| 189 | | 205. Сайншанд, Замын-Үүд сумдын авто замыг өргөтгөх судалгааны ажлыг хийж, авто зам, замын байгууламжид засвар шинэчлэлт хийх, шинээр барих. | 2021 - 2024 | Судалгааны ажлыг хийж дууссан | Төлөвлөгөөний хувь | | Төлөвлөгөөний хувь 100 | 2021 онд замын сангийн 692,1 сая төгрөг, ОНХС-ийн 648,0 сая төгрөг, ОНТ-ийн 2,210.0 сая төгрөг, СОНХС-ийн 116,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын хэмжээнд 88 авто машины хүчин чадал бүхий авто зогсоол, 0.26 км хатуу хучилттай авто зам, 0.4 км явган хүний замыг шинэчилсэн. 2022 онд орон нутгийн төсөв, замын сангийн 3717.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 7 байршилд шинээр автозам, автозогсоол барих ажлыг хийж гүйцэтгүүлсэн. 2023 онд орон нутгийн төсөв, замын сангийн 6,862,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 11 байршилд 270 машины автозогсоол, 4,3 км явган хүний болон дугуйн зам, 30,9 км авто замыг шинээр болон сэргээн засварлах , Замын-Үүд сумын 2 байршилд нийт 0,4 км хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулж авто замын сүлжээг өргөжүүлэн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулсан. | 90% |
| 190 | | 206. Сум, суурин газрыг хатуу хучилттай авто замаар холбох судалгааны ажлыг хийж, барилгын ажпыг эхлүүлэх арга хэмжээг авч ажиллах. | 2021 - 2024 | - | Гүйцэтгэлийн хувь | | Улаанбадрах, Хөвсгөл Хатанбулаг сумдыг аймгийн төвтэй хатуу хучилттай авто замаар холбох | Улсын төсвийн 3,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн улсын чанартай авто замаас Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барих ажлыг "Дорноговь | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ТЭЗҮ, зураг төсөв боловс руулах ажлын гүйцэтгэл 100% | АЗЗА" ТӨХК гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулснаар орон нутгийн авто замын сүлжээг нэмэгдүүлж, ард иргэдийг шуурхай, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн. Хамарын хийдийн 3 замын уулзвараас Зүүнбаян баг хүртэлх 20 км хатуу хучилттай авто зам барих ажлыг зураг төсвийг "HIB" ХХК-иар гүйцэтгүүлж 22,6 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгуулсан ба 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | |
| 191 | | 207. Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг технологи нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх. | 2023 - 2024 | Хот доторх ОР5 суурилуулсан Автобусны тоо-0 Хот хоорондын автобусанд Суурилуулсан төхөөрөмжийн тоо-3 | СР5 суурилуулсан автобус Нэмэгдсэн автобусны тоо | | СР5 суурилуулсан автобус-5 Нэмэгдсэн автобусны тоо-2 | Сайншанд хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээг батлагдсан 3 чиглэлийн дагуу 25 хүний суудалтай, 3 автобус өдөр бүр 07:00-18:30 цагийн хооронд өвөл, хавар, намрын улиралд том хүн, хүүхдэд үйлчилгээ үзүүлж хэвшсэн бөгөөд жилд давхардсан тоогоор 15,000 гаруй зорчигчийг аюулгүй тээвэрлэсэн байна. Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж буй 3 автобусанд GPS, түлш хэмжигч төхөөрөмж суурилуулах ажлыг "Гайхам" ХХК гүйцэтгэж, орон нутгийн төсвийн 3,2 сая төгрөгийг зарцуулсан. 2020 онд Замын-Үүд сумын ОНТ-ийн 68,0 сая төгрөгийн хөрөнгөөр 25 хүний суудалтай автобусыг худалдан авч ЕБ-ын 1, 2, 3, “Үлэмж тэнгэр” сургуулийн сурагчдыг ажлын таван өдөр, өглөө 07:00-08:30, орой 17:30-18:30 цагуудад үнэ төлбөргүй гэр, сургуульд хооронд тээвэрлэн үйлчилгээ үзүүлж, давхардсан тоогоор өдөрт 250 гаруй зорчигч үйлчилгээ авч байна. Орон нутгийн төсвийн 29,0 сая төгрөгийн хөрөнгөөр такси тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн тээврийн хэрэгсэлд суурилуулах 120 ширхэг хар хайрцаг худалдан авах тендер зарласан. UB cab такси дуудлагын үйлчилгээг орон нутагт нэвтрүүлж 75 жолоочийг бүртгэн үйлчилгээ үзүүлж эхэллээ. | 100% |
| 192 | | 208. Замын-Үүд суманд автотээврийн үйлчилгээний төв | 2023 - 2024 | Барилга угсралтын ажпын гүйцэтгэл 40% | Барилга угсралтын ажпын гүйцэтгэл | | - | Замын-Үүд суманд байрлах улс хоорондын зорчигч тээврийн төвийг барих барилгын ажлыг 2023 онд | 30% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | барих. | | | | | | суурийн блок болон ханын зутгуур, хучилтын хэсгийн битон болон армотурын ажлыг эхлүүлж, 2023 оны 10 сард тус шинжилгээний хариу нь гарсан. Шинжилгээний хариу дээрх ажлыг үргэлжлүүлэн барьж болох шийдвэрийг гаргасан тул барилгыг 2024 онд барьж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Зам тээврийн хөгжлийн яам, АТҮТ-өөс томилогдсон ажлын хэсэг ажиллаж байгаа болно. | |
| 193 | 3.7.1. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно. | 210. Хаягийн тэмдгийн суурилуулалтын ажлыг зохион байгуулж, хаягийн мэдээллийн нэгдсэн системд оруулан, олон нийтэд сурталчилах | 2022 - 2024 | Хаягжуулалт хийгдсэн сумын тоо-10 | Хаягжуулалт хийгдсэн сумын тоо | | 1 | Аймгийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн 208,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд, Улаанбадрах сумаас бусад сумдад 9021 хаягийн тэмдгийн суурилуулалтын ажил хийж, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд оруулсан. “Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай”, “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягжуулах журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2022 оны 180, 181 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталгаажуулаагүй гудамжийг баталгаажуулж, хаягийн мэдээллийн санд оруулах үүрэг, чиглэлийг өгснөөр гудамж зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмын дагуу шинээр 601 нэгж талбар, барилгыг дугаарлан хаягийн мэдээллийн системд бүртгэсэн. | 100% |
| 194 | | 212. Газарзүйн нэрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах | 2022 - 2024 | Тодруулалт хийгдсэн сумын тоо 0 Мэдээллийн сан 0 | Тодруулалт хийгдсэн сумын тоо Мэдээллийн сан | | Тодруулалт хийгдсэн сумын тоо- 14 | Газарзүйн нэрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 14 сумын газар зүйн нэрийн зөвлөлийг сумдын Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулж газар зүйн нэрийн тодруулалт хийх, мэдээллийн бүрдүүлэх ажлын даалгавар, төсөв, төслийг боловсруулж ГЗБГЗЗГ-т хүргүүлж батлуулсан. Сумдад газар зүйн нэрийн тодруулалт хийхээр орон нутгийн төсвийн 237.0 сая төгрөгөөр "Зарим сумдын газар зүйн нэрийн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тодруулалт хийх " ажлын тендерт “Тэгш хэм групп” ХХК шалгарч 219,1 сая төгрөгөөр гэрээ байгуулан хийж гүйцэтгэж байна. Суурин болон хээрийн судалгааны ажлыг 2023 оны 6-9-р саруудад хийж гүйцэтгэн одоогоор боловсруулалтын ажил хийгдэж 90 хувьтай байна. Гэрээт ажлын үр дүнг аймаг, сумдын Газар зүйн нэрийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн ба аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталгаажуулахаар бэлтгэл ажил хангалаа. Энэхүү ажлын хүрээнд газар зүйн нэрийн 1:100000, 1:25000 байр зүйн зурагт тодруулалт хийж, 11088 нэрийг газар зүйн нэрийн зурагт байршуулж, газар усны нэр бзрт хувийн хэрэг үүсгэн мэдээллийн сан үүсгэсэн. | |
| 195 | | 213. Устсан геодезийн цэг тэмдэгтийг сэргээн засварлах ажлыг зохион байгуулж, геодезийн хэмжилт, зураглалыг хийж гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэх | 2022 - 2024 | - | Сэргээн засварлагдсан цэг тэмдэгтийн тоо | | 213 | Аймгийн хэмжээнд геодезийн цэг тэмдэгтийн тооллогыг 2020 онд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас зохион байгуулж, Геодези, зураг зүйн тухай хуульд зааснаар цэг тэмдэгтийг орон нутгийн үндсэн хөрөнгөнд бүртгэсэн. Дээрх тооллогын үр дүнд аймгийн хэмжээнд Айраг 53, Алтаншираэ 5, Даланжаргалан 9, Дэлгэрэх 8, Замын-Үүд 9, Иххэт 13, Мандах 30, Өргөн 15, Сайхандулаан 20, Сайншанд 25, Улаанбадрах 18, Хатанбулаг 30, Эрдэнэ 11, Хөвсгөл 15 ширхэг нийт 261 ширхэг геодезийн цэг тэмдэгт устсан байна. Устсан цэг тэмдэгтийг сэргээн босгоход шаардагдах төсөв ажлын даалгаврыг боловсруулж, орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг жил бүр зохион байгуулан ажиллаж, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд Дэлгэрэх суманд 5, 2022 онд Сайншанд суманд 1, Замын-Үүд суманд 1, 2023 онд Дэлгэрэх суманд 5 цэг тэмдэгт, Сайхандулаан 10, Айраг суманд 3 цэг тэмдэгт, нийт геодезийн 25 цэг тэмдэгтийг 30,0 сая төгрөгөөр шинээр сэргээн засварласан. | 50% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 196 | 3.7.2. Иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн болон газрын кадастрын нэгдсэн ухаалаг системүүдийг орон нутагт нэвтрүүлнэ | 214. Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг газрын үнэлгээний системд оруулан, дүн шинжилгээ хийх | 2021 - 2024 | Үнийн мэдээний тоо 945 | Үнийн мэдээний тоо | | 1245 | Газрын биржийн цахим системд нийт 199 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг нэмж бүртгэсэн. Нэмж бүртгэсэн газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээнээс худалдагдсан 197, санал болгож буюу зарлан мэдээлсэн үнийн мэдээлэл 2 байна. Мөн нийт цуглуулсан үнийн мэдээг зориулалтаар ангилахад гэр бүлийн хэрэгцээний газар 188, худалдаа үйлчилгээний газар 6, үйлдвэрийн газар 3, хөдөө аж ахуйн 2 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ цуглуулсан болно. Мөн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай үл хөдлөх хөрөнгөгүй газрын зах зээлийн дундаж үнэ 6.358 мянга, үл хөдлөх хөрөнгөтэй газрын зах зээлийн дундаж үнэ 35.278 төгрөг байгаа бол худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх хөрөнгөгүй газрын зах зээлийн дундаж үнэ 10.0 мянга төгрөг байна. | 90% |
| 197 | | 215. Газрын бүртгэлийн нэгдсэн системд эзэмшил, ашиглалт, өмчлөлд олгогдсон газруудыг бүрэн хамруулж, нөхөн бүрдүүлэлт хийх | 2021 - 2024 | Бүртгэлд хамрагдалтын хувь 100 | Бүртгэгдсэн нэгж талбарын хувь | | 100% | Шинээр газар өмчлөх-315, эзэмших, ашиглах-529, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх-529, газар өмчлөх эрхээ гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх-25, худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах-342, эзэмшиж, ашиглаж байгаа газрын байршил хэмжээ өөрчилсөн-27, эрх сэргээх ба дуусгавар болгосон-200, барьцаанд бүртгүүлсэн-591, хугацаа сунгах-106, бусад-10 нийт 2674 нэгж талбарыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн газартай холбоотой өөрчлөлтийг хийж баталгаажуулсан. Харин 131 нэгж талбарыг нөхөн бүрдүүлэлтээр мэдээллийн санд бүртгэн оруулсан. | 100% |
| 198 | | 216. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг нэвтрүүлэх, | 2021 - 2024 | Хамтран ажилласан арга хэмжээний тоо 1 Систем нэвтрүүлэлтийн түвшин | Хамтран ажилласан арга хэмжээний тоо Систем нэвтрүүлэлтийн түвшин | | 2 100% | 2022 онд газрын үнэлгээний цахим системд инженерийн болон хүрээлэн буй орчны, нийгмийн дэд бүтцийн 462 мэдээллийг оруулж, 36163 нэгж талбарт үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн утга бодуулан дүн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсронгуй болгоход хамтран ажиллах | | | | | | шинжилгээ хийсэн. Газрын биржийн цахим системд 148 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг бүртгэсэн.  Үнийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, 1 м2 газрын зах зээлийн дундаж үнэлгээг гаргахад гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар 11076 төгрөг, худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэлийн зориулалттай газар 62298 төгрөг, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай газар 3000 төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын үнэ 54 хувиар өссөн, худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуйгаас бусад зориулалттай газар 6.6 хувиар буурсан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай газрын зах зээлийн үнэ өмнөх хэвээрээ байгаа судалгааны үр дүн гарсан. Газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулах үйл ажиллагааг газрын цахим биржээр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлсэн. 2023 онд аймгийн хэмжээнд нийт 13603 нэгж талбарт 4463.6 сая төгрөгийн газрын төлбөр, 11936 нэгж талбарт 20.08 сая төгрөгийн албан татварыг ногдуулан нэхэмжлэх үүсгэн Татварын удирдлагын системд илээсэн. Аймгийн татварын хэлтсээс сар бүр газрын төлбөр төлөлтийн мэдээг авч төлбөр татварын систем тулгалт хийдэг ба 2023 оны байдлаар нийт 6085 нэхэмжлэхийн төлөлтийн мэдээг хүлээн авч тулгалт хийснээс төлөв өөрчлөгдөөгүй 35 нэхэмжлэхийн төлөвийг шалган завсарласан. | |
| 199 | | 217. Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын кадастрын нэгдсэн ухаалаг системүүдийг бүрэн нэвтрүүлэх. | 2022 - 2024 | - | Системд хандсан иргэдийн тоо | | 5000 | Монгол Улсын Засгийн газраас 2021-2024 онд “Цахим үндэстэн” болох зорилт дэвшүүлсний хүрээнд ГЗБГЗЗГазраас газар зохион байгуулалтын болон газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн иргэд, олон нийтэд зориулсан цахим систем /www.egazar. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | gov.mn/-ийг 2021 оны 10 сараас албан ёсоор хэрэглээнд нэвтрүүлсэн ба www.egazar.gov.mn веб хандалтат цахим хуудаснаас иргэд, олон нийт цаг хугацаа, орон зайнаас үл хамааран 72 төрлийн үйлчилгээг цахимаар авах боломжтой болсон. 2023 онд тухайн шатны Засаг даргын шийдвэрээр шинээр газар өмчлөх-315, эзэмших, ашиглах-529, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх-529, газар өмчлөх эрхээ гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх-25, худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах-342, эзэмшиж, ашиглаж байгаа газрын байршил хэмжээ өөрчилсөн-27, эрх сэргээх ба дуусгавар болгосон-200, барьцаанд бүртгүүлсэн-591, хугацаа сунгах-106, бусад-10 нийт 2674 нэгж талбарыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн газартай холбоотой өөрчлөлтийг хийж баталгаажуулсан. Харин 131 нэгж талбарыг нөхөн бүрдүүлэлтээр мэдээллийн санд бүртгэн оруулсан. | |
| 200 | 3.7.3. Өрх гэр бүлийн худалдан авах чадварт нийцүүлэн орон сууцжуулах бодлого хэрэгжүүлнэ. | 218. "Мандах наран" орон сууцны хорооллын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | 2022 - 2024 | 1060 өрх | өрхийн тоо | | 1960 | Сайншанд сумын 7-р багт "Мандах наран-5" орон сууцны хорооллын 1152 айлын орон сууц барих төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн 13.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх" ажлын тендерт "Гантулга трейд" ХХК шалгарч төслийн эхний ээлжийн 384 айлын орон сууцнаас 72*4 блок 288 айлын орон сууцны барилгыг 10-р сард ашиглалтад оруулсан. 48 айлын 2 блок орон сууцны барилгын гүйцэтгэл 80%-тай үргэлжилж байна. Сайншанд сумын 7 дугаар багийн нутагт баригдсан “Мандах наран-5” орон сууцны хорооллын 502В, 502Д блок 144 айлын орон сууц нь “Түрээсийн орон сууц”-ны ангиллаар төлөвлөгдөж орон нутгийн хөгжлийн сангийн 13,5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр "Гантулга | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | трейд" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 12/02, 12/03 дугаар тогтоолоор "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах журам", "Түрээсийн орон сууцны сум, баг, байгууллагад олгох хувь хэмжээ"-г тогтоон, түрээсийн орон сууцанд хамрагдах иргэдийн хүмэлтийг хүлээн авч, зохион байгуулах, удирдлага зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллав. Түрээсийн орон сууц хөтөлбөрийн 1 дүгээр ээлжинд 105 айлын орон сууцыг зорилтот бүлгийн иргэдэд, журмын дагуу олгосноос хөгжлийн бэрхшээлтэй иргэн-7, ахмад настан-11, өрх толгойлсон эх, эцэг-2, олон хүүхэдтэй гэр бүл-6, залуу гэр бүл-10, эмч, сувилагч, асрагч-14, ерөнхий боловсролын сургуулийн багш-16, цэцэрлэгийн багш-15, малчин-17 байна. “Англи хэлтэй Дорноговь” зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд дадлага туршлага, ур чадвартай Англи хэлний 4 багштай орон сууцны бэлэглэлийн гэрээ байгуулан, тус бүр орон сууцны түлхүүрийг гардуулсан. Орон нутагт ажиллаж амьдрах иргэдийг дэмжих зорилгоор орон нутагт анх удаа түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллалаа. | |
| 201 | | 219. Инженерийн шугам сүлжээнд холбогдсон сумдад орон сууц барина. /Айраг, Даланжар галан, Алтанширээ, Иххэт, Өргөн, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, | 2021 - 2024 | Айраг 47, Өргөн 24, Даланжаргалан 40 Нийт 111 /айл/ | Өрхийн тоо | | 238 /айл/ | Аймгийн нутаг дэвсгэрт төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2021 онд Замын-Үүд суманд 25 айлын 1, Сайншанд суманд 50 айлын 2, Даланжаргалан суманд 8 айлын 1, нийт 83 айлын 4 орон сууц, 2022 онд Айраг суманд 37 айлын 1, Өргөн суманд 65 айлын 1, Даланжаргалан суманд 8 айлын 1, Улаанбадрах суманд 8 айлын 1, Сайншанд суманд 121 айлын 2, нийт 239 айлын 7 орон сууц барьж ашиглалтад оруулсан. 2023 онд 11 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дүгээр сарын байдлаар Сайхандулаан суманд 6 айлын 1, Замын-Үүд суманд 65 айлын 1, Сайншанд суманд 333 айлын 5, нийт 404 айлын 7 орон сууц ашиглалтад орсноор аймгийн хэмжээнд 2020 онтой харьцуулахад 726 айлын 18 орон сууцаар орон сууцны хүртээмж нэмэгдсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн 827,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хатанбулаг суманд 8 айлын орон сууц барих ажлыг "Аяа" ХХК тендерт шалгаран гүйцэтгэж байна. Газар шороо, суурийн ажил хийгдэж бусад бэлтгэл ажил хангагдсан. Ажлын явц 70 хувьтай үргэлжиж байна. | |
| 202 | | 220. Сайншанд суманд "Тохилог хотхон" орон сууц барих хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжих | 2021 - 2024 | - | Өрхийн тоо | | 20 /айл/ | Орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр 1, 2, 3, 4, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 332 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг “Инженер геодези” ХХК гүйцэтгэсэн. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын газрыг дахин зохион байгуулж, төвлөрсөн инженерийн хангамжид холбогдсон “Тохилог орон сууц” амины орон сууцны хорооллыг төлөвлөсөн. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд аймагт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийг дэмжих, Улаанбаатар хотоос шилжин суурьшигчид болон бизнесийн үйл ажиллагааг нутагшуулах зорилгоор зохион байгуулагдсан “Нээлттэй Дорноговь” арга хэмжээнд "Нээлттэй Дорноговь-Барилга, орон сууц" үзэсгэлэнгийн арга хэмжээг зохион байгуулсан ба энэхүү үзэсгэлэнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг олон нийтэд сурталчлах, төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргэх ажил зохион байгуулсан. Түүнчлэн "Амины орон сууцны инноваци хөгжлийн төв" ТББ-тай хамтран эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | амины орон сууцны төлөвлөлт, зураг төслийг танилцуулж, 5 иргэнд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зураг төслийг гардуулан ажилласан. Монгол Улсын Их сургуулийн эрдэмтэн багш нартай хамтран 2023 оны 3, 4 дүгээр сард дулааны алдагдал багатай “Пассив барилга” барих аргачлал, цахилгаан дулааны хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх боломжийн талаарх 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 100 гаруй иргэн хамруулан гарын авлага, мэдээллээр ханган ажилласан. | |
| 203 | | 221. Засгийн газраас хэрэгжүүлж буй түрээсийн орон сууц хөтөлбөрт орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах | 2022 - 2024 | 0 | Хамрагдсан өрхийн тоо | | Хамрагдсан өрхийн тоо 144 | Сайншанд сумын 7 дугаар багийн нутагт баригдсан “Мандах наран-5” орон сууцны хорооллын 502В, 502Д блок 144 айлын орон сууц нь “Түрээсийн орон сууц”-ны ангиллаар төлөвлөгдөж орон нутгийн хөгжлийн сангийн 13,5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр "Гантулга трейд" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Аймгийн ИТХ-ын 2023 оны 12/02, 12/03 дугаар тогтоолоор "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах журам", "Түрээсийн орон сууцны сум, баг, байгууллагад олгох хувь хэмжээ"-г тогтоон, түрээсийн орон сууцанд хамрагдах иргэдийн хүсэлтийг хүлээн авч, зохион байгуулах, удирдлага зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллав. Түрээсийн орон сууц хөтөлбөрийн 1 дүгээр ээлжинд 105 айлын орон сууцыг зорилтот бүлгийн иргэдэд, журмын дагуу олгосноос хөгжлийн бэрхшээлтэй иргэн-7, ахмад настан-11, өрх толгойлсон эх, эцэг-2, олон хүүхэдтэй гэр бүл-6, залуу гэр бүл-10, эмч, сувилагч, асрагч-14, ерөнхий боловсролын сургуулийн багш-16, цэцэрлэгийн багш-15, малчин-17 байна. Орон нутагт анх удаа түрээсийн орон сууц хөтөлбөрийг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | амжилттай хэрэгжүүлж ажилласан. | |
| 204 | | 222. Суурьшлын бүсэд дэд бүтэц бий болгох ажлыг судалгаанд тулгуурлан төлөвлөж үе шаттай хэрэгжүүлэх | 2021 - 2024 | - | Судалгааны ажлын үр дүн, барилгын гүйцэтгэл | | 100% | Орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус сумын 1, 2, 3, 4, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 332 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 11/13 дугаар тогтоолоор батлуулсан. Энэхүү хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Сайншанд сумын 6, 7 дугаар багуудыг холбосон 3.5 км авто зам, 7 дугаар багт 1.1 км автозамуудын барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Сайншанд сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт "Тэс петролиум" ХХК-ийн урд талд Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан 2 жил дараалан газрыг зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулаагүй үндэслэлээр 149 иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтын газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, 1100 айлын орон сууц, 960 суудалтай ерөнхий боловсролын сургууль, 150 хүүхдийн цэцэрлэг барих 16.7 га газрыг чөлөөлж, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. | 100% |
| 205 | 3.7.4. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттай гаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт технологи нэвтрүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. | 223. Хуучны орон сууцнуудын инженерийн шугам сүлжээг шинэчлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | Төлөвлөгөөний биелэлтийн хувь 0 | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | | Төлөв- лөгөөний биелэлтийн хувь 64,5% Сайншанд сумын 3-р баг 25, 26, 29, 65, 40, 30 айлын орон сууцны шугам сүлжээний шинэчлэлт 100% | Орон нутгийн төсвийн 130,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 102, 123 дугаар байрны пудволын дулаан, цэвэр усны шугам засварын ажлын гүйцэтгэгчээр "Хан баян буурал чандмань" ХХК шалгарч, ажлыг бүрэн дуусган хүлээлгэн өгсөн. Орон нутгийн төсвийн 17,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 108 дугаар /мэргэжилтний 12/ байрны бохир усны шугам шинэчлэх ажлыг “Хан Баян Буурал Чандмань” ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Уг ажлыг гүйцэтгэснээр оршин суугчдын тав тухтай амьдрах, орон сууцны нэгж | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | талбайн зах зээлийн үнэлгээ нэмэгдэх нөхцөл бүрдсэн. | |
| 206 | | 224. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг дахин ашиглах боломжийг судалж хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | 0 | ашиглалтад орсон цэвэрлэх байгууламжийн тоо | | Саарал усыг дахин ашиглах байгууламжийн барилга угсралт 100% | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН3388/3713 төсөл”-ийн хүрээнд хоногт 3000м3 бохир ус хүлээн авах хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлыг улсын төсвийн 6350.8 сая төгрөгийн төсөвт өртөгөөр “Компорт импекс” ХХК гүйцэтгэж, 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдөр барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан. Тус цэвэрлэх байгууламж нь механик, биологи, гүйцэд цэвэрлэгээний технологитой ба цэвэрлэгдсэн усыг цэцэрлэг, зүлэгжүүлэлт, зам талбай, хөрсний усалгаанд ашиглахад зориулагдсан цооногтой. Мөн цэвэрлэгээний явцад гарсан лагийг боловсруулан бордоо, түлш гаргах тоног төхөөрөмжтэй жишиг байгууламж болсон. Цэвэрлэх байгууламж ашиглалтад орсоноор Сайншанд хотын дэд бүтцийг хөгжүүлэх, оршин суугчдын тав тухтай амьдрах орчныг нэмэгдүүлэх, орон нутгийн байгаль орчныг сайжруулж, хөрсний бохирдлыг бууруулах, цэвэрлэгдсэн усыг дахин ашиглах боломж бүрдсэн. Дорноговь аймаг, Япон улсын Шизоүка муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд саарал усыг дахин ашиглах боломж, инженер техникийн ажилчдыг бэлтгэх, сургаж дадлагжуулах, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулж байна. | 90% |
| 207 | | 225. Зарим сумдын ус хангамжийн нөөцийн санг өргөтгөж, нөөцийг нэмэгдүүлэх. | 2021 - 2024 | Сайншанд сумын одоогийн ундны усны нөөцийн сангийн хэмжээ 2000 м3 | Гүйцэтгэлийн хувь, хэмжээ | | Барилгын ажил 100% | Сумдын ус хангамжийн нөөцийн санг өргөтгөж, нөөцийг нэмэгдүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлж Айраг, Мандах, Сайхандулаан сумдаас бусад 11 сумыг 100-3000 м3 хүчин чадал бүхий цэвэр усны нөөцийн сан байгуулсан. 2020-2023 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Хөвсгөл, Хатанбулаг, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх сумдад тус бүр 100 м3 хүчин чадалтай цэвэр усны нөөцийн сан шинээр байгуулсан. Улсын төсвийн 1983.5 сая төгрөгийн төсөвт төгрөгөөр Сайншанд суманд хоногт 3000 м3 ус нөөцлөх хүчин чадалтай цэвэр усны нөөцийн сан байгуулах ажлыг "Энержи парагон" ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Замын-Үүд сумын хүн амын ундны усны нөөцийн 3000 м3 хүчин чадалтай усан сан байгуулах ажлыг улсын төсвийн 2,0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэхээр батлагдсан. | |
| 208 | | 226. Зарим сумдын цэвэрлэх байгууламж барих ажпыг үе шаттайгаар хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | Даланжаргалан суманд шинээр барих цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын гүйцэтгэл 100% | Судалгаа, зураг төсөв хийгдсэн хувь | | Өргөн суманд шинээр барих цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын гүйцэтгэл 100% | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Сайншанд сумын Зүүнбаян баг, Өргөн, Айраг, Иххэт сумдад бага оврын цэвэрлэх байгууламж барих зураг төслийн ажлыг "Алтайн газрын хүч" ХХК гүйцэтгүүлэн 2021 онд хүлээн авсан. Даланжаргалан сумын ОНХС-гийн 294.0 сая төгрөгийн хөрөнгөөр цэвэрлэх байгууламж барих ажлыг "Аббадон констракшн" ХХК гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. Сайншанд сумын төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хэвийн явуулах, инженер техникийн ажилчдыг чадавхжуулах “Жайка” Олон Улсын байгууллагатай хамтарсан төслийн хүрээнд энэ онд онол, дадлага хэлбэрээр нийт 33 удаагийн танхим болон цахим хосолсон сургалтыг зохион байгуулж аймгийн ЗДТГ, Чандмань-Илч ОНӨХК, ГХБХБГ зэрэг нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын холбогдох 100 гаруй инженер, мэргэжилтнүүдийг хамруулж цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцаж, дадлагажуулах ажлыг зохион байгуулсан. Мөн энэ чиглэлээр аймгийн мэргэжилтэн, инженер | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | техникийн ажилчдаас бүрдсэн 6 хүнийг тус мужид богино хугацааны туршлага судлах сургалтад хамруулсан. | |
| 4. Засаглалын бодлого | | | | | | | | | |
| 209 | 4.1.1. Төрийн үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, төрийн цахим үйлчилгээг хөгжүүлнэ. | 227. Төрийн байгууллагуудад цахим хэрэглээг үе шаттай нэвтрүүлж, мэдээллийг шуурхай солилцох нөхцөлийг сайжруулна. | 2021 - 2024 | Цахим систем нэврүүлсэн сум, байгууллагын тоо: 5 сум | Цахим систем нэврүүлсэн сум, байгууллагын тоо | | 15 | Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит 150 байгууллагыг төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд бүртгэсэн нь 96 хувьд нэвтрүүлсэн байна. Системийн ашиглалтыг нэмэгдүүлэхээр төрийн болон төрийн өмчит байгууллагуудын бичиг хэргийн ажилтан, мэдээлэл технологийн ажилтан, хүний нөөцийн ажилтнуудад Цахим хөгжил харилцаа холбооны яам, "И-Монгол" академи УТҮГ-тай хамтран "ERP" системийн ашиглалтыг сайжруулах, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 7 удаагийн сургалтыг зохион байгуулан нийт 540 албан хаагчийг хамруулсан. 5 байгууллага албан бичгээ цахимаар бүрэн боловсруулан илгээж байгаа бөгөөд 150 албан хаагч тоон гарын үсгийг албан хэрэгцээндээ ашиглаж байна. Төрийн байгууллагын удирдлагын нэгдсэн системийг 2022 онд аймгийн төрийн болон төрийн өмчит 125 байгууллагад нэвтрүүлсэн бөгөөд 2023 онд 25 байгууллагаар нэмэгдүүлэн нийт 96 хувьтай байна. Систем ашиглалт нэвтрүүлсэн байдлыг 2020 онтой харьцуулахад 87 хувиар нэмэгдсэн. | 90% |
| 210 | | 228. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлж иргэд, байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулан хүртээмжийг нэмэгдүүлэх. | 2021 - 2024 | Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний тоо-52; Үйлчилгээ авсан иргэдийн тоо-1820; | Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээний тоод; Үйлчилгээ авсан иргэдийн тоо; | | 100, 1870, | Засгийн газрын 2022 оны 499 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж орон нутагт аймгийн төрийн үйлчилгээний нэгдсэн “ХурДан” төвийг байгуулж төрийн үйлчилгээг нэг дороос авах, цахимаар дамжуулан төрийн үйлчилгээг үзүүлэх, хүнд суртлыг арилгаж хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэн операторын горимд шилүүлэхээр орон нутгийн төсвийн 122,4 сая төгрөгийн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөрөнгө оруулалтаар шаардлагатай тоног төхөөрөмж, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус төвөөр дамжуулан нийт 1800 төрлийн үйлчилгээг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлж "Соёмбо цогцолбор", "Монгол шуудан" гэсэн 2 салбартайгаар үйл ажиллагааг явуулж байна. “ХурДан” төвд өөрөө өөртөө үйлчлэх боломжтой улсын бүртгэл, газрын албаны мэдээлэл авах "КИОСК" машинуудыг шинээр нэмэгдүүлэн байршуулсан. Тус төвөөр дамжуулан нийт 11822 иргэн, хуулийн этгээдэд Иргэний үнэмлэх, нийгмийн даатгал, жолооны үнэмлэх, үл хөдлөх хөрөнгийн лавлагаа болон согтууруулах ундааны зөвшөөрөл, галын аюулгүй байдлын дүгнэлт зэрэг 107 төрлийн үйлчилгээ үзүүлсэн. Төрийн үйлчилгээний лавлах 70521111 дугаарын “Call center” үйлчилгээгээр дамжуулан төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж нийт 1143 дуудлагад хариу өгч ажилласан. Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолын дагуу төрийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэхээр 53 төрлийн үйлчилгээг 2500 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан. 2022 онд 353 төрлийн үйлчилгээг цахим шилжүүлж 268007 иргэнд үзүүлсэн. 2023 онд 1800 төрлийн үйлчилгээг цахимд шилжүүлж 11822 иргэнд үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оноос 5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | |
| 211 | | 229. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг сайжруулж, иргэд, олон нийтийн оролцоог хангах. | 2021 - 2024 | Цахим хаягтай сум, байгууллагын тоо 6 сум, 10 агентлаг | Цахим хаягтай сум, байгууллага | | Цахим хаягтай сум, байгууллагын тоо 12 сум, 24 агентлаг | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж нээлттэй мэдээллүүдийг нэг дороос нөхцөлийг бүрдүүлж dornogovi.gov.mn аймгийн цахим хуудсанд нээлттэй байхаар заасан 5 төрлийн 98 заалтын мэдээллийг байршуулж ажилласан. Аймгийн талаарх мэдээ мэдээлэл, аймгийн онцлог, бүтээн байгуулалт, амьдрах таатай орчин, аялал | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | жуулчлал, бизнес эрхлэх боломж, газар зохион байгуулалт, ажлын байрны зар мэдээг авах боломжийг бүрдүүлсэн гар утасны "Нээлттэй Дорноговь" аппликейшныг бүтээж 2000 гаруй хүн татаж ашигласан байна. Цаашид хөгжүүлэлт хийж төлбөр тооцоо, аймгийн төрийн цахим үйлчилгээ авах, аялал жуулчлалын чиглэлийн мэдээллийг авах, санал хүсэлт, санал асуулга гэх мэт нэг дороос аймгийн талаарх үйлчилгээ, мэдээллийг авах боломжийг бүрдүүлэхээр "Цахим Дорноговь" хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн төрийн үйлчилгээний лавлах “Call center” үйлчилгээгээр дамжуулан төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж нийт 1143 дуудлагад хариу өгч ажилласан.  Төрийн өмчит 62 байгууллагыг албаны цахим хуудастай болгосон нь өмнөх оноос 4 байгууллаар нэмэгдсэн бөгөөд аймгийн хэмжээнд 72 хувьтай байна. Төрийн болон төрийн өмчит 46 байгууллага 2020 онд албан цахим хаяг ажиллуулж байсан нь аймгийн хэмжээнд 54 хувьтай байсан. 2023 онд 62 байгууллага албан цахим хаягтай болсон нь өмнөх оноос 4 байгууллага буюу 3 хувиар нэмэгдсэн байна. | |
| 212 | | 211. Төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, ажиллах таатай нөхцөл боломжийг бүрдүүлнэ. | 2021 - 2024 | | | | | Хатанбулаг 51.2 сая төгрөг, Эрдэнэ 57.7 сая төгрөг, Хөвсгөл 63.0 сая төгрөг, Улаанбадрах суманд 56.7 сая төгрөгөөр тус тус техник хэрэгсэл, лед дэлгэцийг худалдан авч, нийт 4 сумын Соёлын төвийн техник хэрэгслийг сайжруулахаар ОНТ-ийн 228.7 сая төгрөгөөр тохижуулсан.  Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж цахим шилжилтийг эрчимжүүлэхээр сумдын ЗДТГ болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарт хэрэгцээ шаардлагад нь нийцсэн хүчин чадал сайтай 326 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | компьютер, техник хэрэгслийг ОНТ-ийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан. Сайхандулаан суманд 6 айлын орон сууцанд 3 байгууллагаас 6 залуу гэр бүл, Эрдэнэ суманд 27 айлын орон сууцанд төсвийн 5 байгууллагын 10 албан хаагчийг дэмжиж орон сууцаар хангасан. Ханги боомтод Төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц барих ажлыг 850.0 сая төгрөг, Улаанбадрах суманд Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажлыг 480.0 сая төгрөг, Дэлгэрэх суманд Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажлыг 480.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр 2024 оны төсөвт тусгасан. Төрийн байгууллагын ажиллах нөхцөлийг сайжруулж Онцгой байдлын газрын автомашины граш, Дэлгэрэх сумын цаг уурын станцын барилга шинээр барьж, аймгийн Цагдаагийн газрын өргөтгөл, Айраг, Сайхандулаан, Мандах, Иххэт, Сайншанд сумдын Засаг даргын Тамгын газрын барилгад шаардлагатай засварыг хийж нийт 12 төрийн байгууллагын ажиллах нөхцөлийг сайжруулан 942,0 сая төгрөгийг зарцуулсан. Мөн 6 суманд нийт 659,8 сая төгрөгийн автомашин, 227,5 сая төгрөгийн мотоцикл авсан байна. Эмнэлгийн байгууллагад 22 автомашин олгож, автомашины хангалт 59,1 хувиар нэмэгдэж, соёлын салбарт нийт 1.7 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлж, 2020-2023 онд төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, бүх төрлийн тоног төхөөрөмж, техник, хэрэгслээр хангасан. | |
| 213 | 4.1.2. Төрийн бодлогын залгамж чанарыг хангаан, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг | 230. Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, ажил үүргийн давхцал, | 2021 - 2024 | Шинжилгээ хийсэн байгууллагын тоо-7; | Шинжилгээ хийсэн байгууллагын тоо | | 29 | Сайншанд, Замын-Үүд сумдын Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын байгууллагын үйл ажиллагаанд чиг үүргийн шинжилгээ хийх үүрэг хүргүүлж, чиг үүргийн шинжилгээг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дээшлүүлнэ. | хийдлийг арилгах бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх | | | | | | асуулга, ажлын байрны зураг авалтын аргаар хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан ирүүлснийг үндэслэн, сумын Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын байгууллагыг нэгтгэх замаар чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авч ажилласан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог чиг үүргийн оновчтой хуваарилж зарчмаар шинэчилж аймгийн Засаг даргын 2023 оны А/68 дугаар захирамж, 2023 оны А/305 дугаар захирамжаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтцийг тус тус шинэчлэн баталсан. 7 байгууллагын 32 албан тушаалын тодорхойлолтыг батлуулахаар албан тушаал тус бүрийн чиг үүрэгт дүн шинжилгээ, харьцуулалтыг хийж, Төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн МУ-ын ТАЗ-өөс зөвшөөрөл авахаар салбар зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 80 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| 214 | | 231. Орон нутагт дутагдалтай байгаа салбарын мэргэжлээр төрийн албанд шаардлагатай байгаа хүний нөөцийг бэлтгэх | 2021 - 2024 | Бэлтгэсэн хүний нөөц-40; | Бэлтгэсэн хүний нөөц | | 65 | Аймгийн хэмжээнд шаардлагатай байгаа мэргэжлээр оюутан элсүүлж, сургалтын төлбөр, хөнгөлөлтийн талаар их, дээд сургуулиудтай гэрээ байгуулан хамтран ажиллаа. СУИС-д дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж байгаа 9 оюутны сургалтын төлбөрийг төлж суралцах боломжоор ханган орон нутагт дутагдалтай байгаа боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Дээрх оюутнуудаас 1 суралцагч төгсөн ирж Сайншандын ЕБС-д дуу хөгжмийн багшаар ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2023 оны А/280 дугаар захирамжаар "Саран Хөхөө" театрын 1 хөгжимчин, 2 бүжигчнийг мэргэжил дээшлүүлэн суралцах боломжоор хангаж сургалтын төлбөрт 7,0 сая төгрөгийг зарцуулсан. АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сургуульд энэ хичээлийн жилд шинээр элсэн орсон эх баригчийн ангийн 11, их эмчийн ангийн 3, эм найруулагчийн 16 нийт 30 оюутныг төгсөөд орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээ байгуулан сургалтын төлбөр болох 23,0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас олгосноор эрүүл мэндийн салбарт орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэжлээр хүний нөөц бэлтгэхэд дэмжлэг үзүүллээ. Малын их эмчээр суралцаж байгаа оюутны судалгааг авч, Мал эмнэлгийн Их сургуулийн оюутнуудтай уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулан давхардсан тоогоор 90 оюутныг хамруулснаар 11 ажлын байрыг нөхсөн. Сумдын Засаг даргын Тамгын газраас шүдний эмч, мэдээллийн технологи, малын эмч, сувилагч зэрэг мэргэжлээр суралцаж байгаа орон нутгийн харьяалалтай 69 оюутны сургалтын төлбөрт орон нутгийн төсвийн болон хандив, тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлэн дэмжлэг үзүүлж орон нутагтаа ажиллуулах гэрээ байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 243 оюутныг төрийн байгууллагад дутагдалтай байгаа мэргэжлээр суралцах нөхцөл бололцоог хангаж, гэрээ байгуулан, төлбөрийг төлж, хөнгөлөлт үзүүлэн нийт 378.8 сая төгрөгийг зарцуулсан. | |
| 215 | | 232. Төрийн байгууллагын сургалтын орчныг сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах бодлого баримтлах | 2021 - 2024 | Албан хаагчийн хувь 80% | Албан хаагчийн хувь | | 95% 2 | "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийг боловсруулж нийт 150 гаруй сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 1500 гаруй албан хаагчдыг ажлын байранд нь сургасан. Төрийн албан хаагчдыг ажлын байранд нь сургах, мэргэшүүлэх чиглэлээр "Удирдлагын академи"-тай хамтран богино болон мэргэшүүлэх багц сургалтуудад албан хаагчдыг шат дараатай хамруулж, төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 6, Мэргэшүүлэх дунд хугацааны | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сургалтад 3, Ахлах түшмэлийн багц сургалтад улсын төсвийн зардлаар 5, байгууллагын зардлаар 2, хувийн зардлаар 2 албан хаагч нийт 18 албан хаагч тус тус хамруулсан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг "7:4:10" буюу төрийн алба хаагчдыг чадавхжуулах сургалтад Засаг даргын эрхлэх хүрээний агентлагууд, сумдын ЗДТГ-ын мэргэжилтнүүд, төсвийн байгууллагын мэргэжилтнүүд зэрэг давхардсан тоогоор 3700 алба хаагчдыг хамруулсан. Ажлын байранд болон танхимын сургалтаар аймгийн хэмжээнд Төрийн албан хаагчдын 35 хувийг хамруулсан. Цахимаар зохион байгуулж байгаа сургалтад төрийн албан хаагчдын 86 хувийг хамруулсан. | |
| 216 | | 233. Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, шинэ соёлыг төлөвшүүлэх | 2021 - 2024 | Болзолт уралдааны шалгуур хангасан байгууллага | Болзолт уралдааны шалгуур хангасан байгууллага | | 30 | Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 25 агентлагийн хяналт шинжилгээ үнэлгээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн, 14 сумын хуулийн асуудал эрхэлсэн албан тушаалтнууд, боловсролын салбарын 21 багш, тусгай чиг үүргийн 36 ахлах болон дунд шатны офицер, байцаагч нарт мэргэжлийн болон хувийн зан төлөв, зарчимч, тууштай, ёс зүйтэй, ажил хэрэгч чанараараа манлайлах, бусдыг дэмжих, чиглүүлэх хандлагыг төлөвшүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор “Ажлын байрны стрессийг зохицуулах арга зүй”, "Нийтийг хамарсан айдас, түгшүүр" "Ажлаас халшрах шинж", "Сэтгэцийн эрүүл мэндэд хэрхэн анхаарах вэ" сэдвийн хүрээнд 4 төрлийн мэргэжлийн сэтгэл зүйчийн сургалтад 14 албан хаагч хамруулсан. ЕБ-ын 22 сургуулийн нийгмийн ажилтан, бага ангийн багш нар нийт 254 алба хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" зэрэг | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сургалтыг зохион байгуулсан. Энэ оны 3 дугаар улиралд Айраг, Даланжаргалан, Улаанбадрах сум Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах талаар сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 405 алба хаагчийг хамруулсан. Мөн Айраг, Мандах сум төрийн албан хаагчийн дунд тэмцээн уралдаан, өдөрлөгийг зохион байгуулж, 200 гаруй албан хаагчийг хамруулсан. Даланжаргалан, Айраг, Улаанбадрах сум нийт төрийн албан хаагчийг багт хуваан, сарын турш цогцолбор тэмцээнүүд зохион байгуулж ажилласан нь төрийн албан хаагчийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, багаар ажиллах, удирдан зохион байгуулах чадамжийг дээшлүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн. | |
| 217 | | 234. Төрийн албанд жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Жендэрийн мэдрэмжтэй бодлого, шийдвэрийн хувь-60; | Жендэрийн мэдрэмжтэй бодлого, шийдвэрийн хувь | | 90% | “Жендерт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл “Дэвжээ” танин мэдэхүйн тэмцээн, "Хайраа хайрлая", "Хандлагаа өөрчилье", "Хамтдаа үлгэрлэе" зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа "Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан", "Өнгө нэмье-дундын оффис", "Нийгмийн дархлаа холбоо" нийт 3 төрийн бус байгууллагуудтай хамтран 6 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээгээр 4300 гаруй иргэд, албан хаагчдад жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчлан, хамтын ажиллагааг өргөжүүлсэн. Сайншанд, Замын-Үүд, Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл, Алтанширээ, Иххэт сум болон аймгийн Цагдаагийн газар, ШШГГ, АШУҮИС-ийн оюутан, төрийн албан хаагч нийт 312 иргэнд жендерийн хэвшмэл ойлголтын хор уршгийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээж ажилласан. “Жендерт суурилсан хүчирхийлэл, түүний суурь шалтгаан”, “Залуусын оролцоо-хотын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөгжил 2023” залуучуудын чуулганыг зохион байгуулж “Жендерийн хэвшмэл ойлголт” зэрэг сэдвээр сургалт хийж нийт 8 удаагийн сургалтаар 600 гаруй иргэн, албан хаагчдад мэдээлэл хийж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан. | |
| 218 | | 235. Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах | 2021 - 2024 | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо-89 | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо | | 143 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах 2019 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг мөрдөн ажиллаж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, ажлыг зохион байгуулж 6 орон нутгийн өмчит байгууллагын 11 ширхэг ашиглах боломжгүй болсон авто машиныг татан төвлөрүүлж 2022 оны 12 дугаар сарын 04-ны Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10/12 дугаар тогтоолоор худалдан борлуулах, балансаас балансад шилжүүлэх шийдвэр гарсан.  Тогтоолын дагуу нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулж, 8 ширхэг авто машины дуудлага худалдааг зохион байгуулж 1-р улирлын байдлаар дуудлага худалдааны орлого дансанд 25.7 төвлөрүүлээд байна. Замын-Үүд сумын "НААҮ" ОНӨ ХХК-ийн "Hyundai country" маркийн 2 авто машины дуудлага худалдааг олон нийтэд зарлан 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр дуудлага худалдаа явагдаж худалдан борлуулагдсан. Аймгийн Тамгын газрын албан хэрэгцээнд ашиглаж байсан "Лексус" 470, "Ланд круйзер" маркийн авто машины шийдвэр худалдан борлуулагдхаар шийдвэр гарсан боловч төрийн хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан дээрх 2 авто машиныг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | авто машины дутагдалтай байгаа сумдруу шилжүүлэхээр шийдвэрлэсэн. 2023 оны хагас жилийн байдлаар 12 сумд орон нутгийн өмчит байгууллагын 190 гэрээг хянан баталгаажуулсан. Үүнд үйлчилгээний зориулалттай 48 ширхэг, орон сууцны зориулалттай 138 байр, хөдлөх хөрөнгийг хянан баталгаажуулж 12,4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна. Орон нутгийн өмчит 151 хуулийн этгээдийн 2023 оны санхүүгийн тайланг хянан баталгаажуулж, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлсэн. | |
| 219 | | 4.1.2.5. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, чадварлаг төрийн албыг бэхжүүлж иргэн төвтэй төрийн үйлчилгээг төлөвшүүлэх | 2021 - 2024 | | | | | Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг байгууллага, сумдад чадахуйн зарчимд суурилсан төрийн албыг бэхжүүлж, иргэн төвтэй төрийн үйлчилгээг үзүүлж байна. Аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн "Хурдан" төвийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, цахим болон оператороор нийт 55 төрийн байгууллагын 1000 орчим үйлчилгээ үзүүлж байна. 2023 оны 11 сарын байдлаар 11,675 үйлчилгээ иргэд, аж ахуй нэгжид үзүүлсэн. Улаанбадрах суманд Төрийн албаны тухай хуулинд заасан Чадахуйн зарчимд суурилж ажлын үр дүнгээр сүүлийн жилүүдэд манлайлсан 2 албан хаагчийг "Мерит" зарчмын дагуу дэвшүүлэн шилжүүлэн ажиллуулж, Хатанбулаг, Мандах, Даланжаргалан сум болон Эрүүл мэндийн газар Удирдлагын Академийн дунд хугацааны сургалтад 2 албан хаагчийг хамруулсан. Мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 6 албан хаагч, ахлах түшмэлийн сургалтад 1 албан хаагчийг хамруулсан Замын-Үүд сум Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, ХХААГ-аас хэрэглэгчийн үнэлгээ авах судалгааг байгууллагын веб хуудсанд байршуулах холбоосыг үүсгэж, | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | судалгаанд нийт 2590 иргэн хамрагдсан бөгөөд иргэдийн төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар сэтгэгдэл эерэг хандлагатай байна. Дэлгэрэх суманд Төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх иргэн төвтэй төрийн үйлчилгээг байгуулах зорилгоор сумын ОНХС-н 135,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар нэг цэгийн үйлчилгээний төвийг байгуулсан. | |
| 220 | 4.2.1. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана. | 236. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн ангиудад орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хилийн торон саадыг шинэчлэх, хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | Хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 100% | Хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт | | 100% | Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 61 арга хэмжээтэйгээр батлан хэрэгжүүлж, 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Энэ хүрээнд 26,5 сая төгрөгийн санхүүжилтээр “Хил хамгаалалтад туслах хүчний нэгдсэн зөвлөгөөн”-ийг Замын-Үүд сум дахь хилийн цэргийн 0108 дугаар ангид зохион байгуулж, зөвлөлийн гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, цэргийн шинжлэх ухааны доктор, профессор дэслэгч генерал Ш.Арвайн хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлэх, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын “Туяат тоо” зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулсан. Хилийн ангиудад орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгоор хилийн 0108 дугаар ангид 28 айлын орон сууцны барилгын засварын ажилд 50 сая төгрөг, 0168 дугаар ангийн 0137 дугаар салбарын хариуцсан хэсгийг бүхэлд нь өндөр хүчин чадал бүхий камерын хамгаалалтад шилжүүлж “Цахим салбар” болгоход зориулж 50,0 сая төгрөг, 0129 дүгээр ангид орон сууцны гадна, дотор сантехникийн засварын ажилд зориулан 50,0 сая төгрөг, нийт 150,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлж хилчдийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Харин орчин үеийн техник | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | технологийн дэвшлийг нэвтрүүлэх хүрээнд хилийн цэргийн 0129 дүгээр ангид 12,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн хилийн ангиудын торон саадыг засварлах, сэргээх ажлын тооцоог гарган 2024 төсөвт оруулан дэмжлэг үзүүлэхээр төлөвлөсөн. | |
| 221 | 4.2.2. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. | 238. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож, нутаг дэвсгэрийн онцлог, хүн ам, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал болон судалгаанд суурилсан ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Төлөвлөсөн ажпын хэрэгжилт 90% | Төлөвлөсөн ажпын хэрэгжилт | | 100% | Эрүү, хэв журмын нөхцөлд дүн шинжилгээ хийж, түүнд үндэслэн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Та татгалз”, “Анзаар”, “Нэг зам нэг соёл”, “Соёлтой жолооч”, “Намайг хамгаал”, “Нэг цагдаа нэг айл өрх”, “Хүүхэд хөдөлгөөний аюулгүй байдал”, “Цахим залилан”, “Устгал” зэрэг 60 гаруй соён гэгээрүүлэх, анхааруулах ажлуудыг зохион байгуулсан. Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг 70 гаруй аж ахуйн нэгж, иргэнийг шалгаж 17 иргэн, 4 аж ахуй нэгжийг нийт 13,8 сая төгрөгөөр торгож, 67 литр архи, 43 литр пиво хурааж, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж ажилласан. Эдгээрийн үр дүнд согтуугаар үйлдэгддэг гэмт хэргийн тоо өмнөх оноос 13.6 хувиар, эрүүлжүүлэгдсэн иргэний тоо 78,6 хувиар тус тус буурсан. Шинээр гарсан болон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн талаар 72 төрийн байгууллагын 624 алба хаагч, төрийн бус 49 байгууллагын 519 ажилтан, малчин, иргэд 2941, ажилгүй 131 иргэн, оюутан 26, ерөнхий боловсролын ахлах бүлгийн 820 хүүхэд нийт 5061 иргэнд мэдээ мэдээллийг хүргэж, гэмт хэрэг үйлдсэнээр хуулийн ямар хариуцлага хүлээх талаар хууль зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулсан. Иргэдийн оршин суух газар, зам талбайн 98 байршилд камержуулалт байснаас шинээр 110 байршилд хяналтын камер, нийт 9 сумын аж ахуйн нэгж, байгууллагаас 260 гаруй хяналтын камерыг тус тус шинээр нэмэгдүүлсэн. Замын-Үүд суманд | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай зориулалтын 5 хяналтын камер болон тоног төхөөрөмж суурилуулж сум дундын цагдаагийн хэлтсийн хяналтын төвийг байгуулах ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 88,7 сая төгрөгийн төсөвт өртгөөр "Сонголт нар" ХХК хийж гүйцэтгэсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 92.6 хувьтай байна. | |
| 222 | | 239. Хяналтын камерийн нэгдсэн төвийг Сайншанд, Замын-Үүд сумдад байгуулах, бусад сумдад дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх. | 2021 - 2024 | Ажлын хэрэгжилт 50% | Ажлын хэрэгжилт | | 90% | Орон нутагт гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж одоогийн ашиглагдаж байгаа 32 ширхэг камер, шилэн кабелийг засварлах, шинэчлэх ажлыг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 19,8 сая, орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийн 19,0 сая, нийт 38,5 сая төгрөгийн хөрөнгөөр "Сонголт нар" ХХК гүйцэтгэсэн. Тайлант онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллага дэлгүүр, үйлчилгээний бусад газруудад стандартын шаардлага хангасан камер байрлуулах талаар  115 аж ахуйн нэгж байгууллагад чиглэл өгснөөр 15 аж ахуйн нэгж байгууллага 60 ширхэг чанарын шаардлага хангасан IP үйлдлийн камерыг байршуулсан.  Сайншанд сумын орон нутгийн хөгжлийн сангийн 135,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр хяналтын 69 камерыг засварлах, шинэчлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж "Сонголт нар" ХХК шалгаран 129,9 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.  Орон нутгийн төсвийн 1,587,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын төвийн 63 байршилд 163 ширхэг, 750,0 сая төгрөгийн хөрөнгөөр Замын-Үүд сумдын төвийн 38 байршилд 105 ширхэг нийт 2,337,5 сая төгрөгийн хөрөнгөөр 268 ширхэг камерийг | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | суурилуулж, хяналт, удирдлагын системийг байгуулах ажлын тендер зарлаад байна. Мөн хот доторх явуулын болон, хөдөлгөөнт эргүүл, хяналтыг ажлыг эрчимжүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн 16,0 сая төгрөгийн хөрөнгөөр олон нийтийн цагдаагийн энгэрийн камер 50 ширхэг, 29,0 сая төгрөгийн хөрөнгөөр такси тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн тээврийн хэрэгсэлд суурилуулах 120 ширхэг хар хайрцаг худалдан авах тендер зарласан. Сайншанд сумын зарим байршилд байгаа камерийн тоог нэмэгдүүлэх, гэрэлтүүлэг суурилуулах ажлыг орон нутгийн төсвийн 190,4 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгүүлэхээр тендер зарласан. Иргэдийн оршин суух газар, зам талбайн 98 байршилд камержуулалт байснаас шинээр 110 байршилд хяналтын камер, нийт 9 сумын аж ахуйн нэгж, байгууллагаас 260 гаруй хяналтын камерыг тус тус шинээр нэмэгдүүлсэн. | |
| 223 | | 240. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргаж, түр хамгаалах байрыг зарим суманд байгуулж, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлэх | 2021 - 2024 | Ажлын хэрэгжилт 50% | Ажлын хэрэгжилт | | 90% | Аймгийн хэмжээнд хүүхэд түр хамгаалах 2 байр байгаа ба Сайншанд сумын түр хамгаалах байранд бэлгийн хүчирхийллийн шинжтэй 11 насанд хүрээгүй хүүхэд, Замын-Үүд сумын “түр хамгаалах байр”-нд үл хайхрах болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрсэн 2, насанд хүрээгүй 6 нийт 8 хохирогчийг “Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу хүлээн авч, шаардагдах үйлчилгээнүүдийг үзүүлж ажилласан. Сайншанд сумын түр хамгаалах байрны үйл ажиллагаанд 53 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс, Замын-Үүд сумын түр хамгаалах байрны үйл ажиллагаанд 699,1 мянган төгрөгийг зарцуулсан. НҮБ-ын "Хүүхдийг ивээх сан"-аас Сайншанд сумын түр хамгаалах байрны үйлчилгээг дэмжин 2 удаагийн 2,6 сая төгрөгийн үнэ бүхий компьютер, ном, гарын авлагын | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дэмжлэг үзүүлж. хүүхдийн хүмүүжил төлөвшил, хөгжил хамгаалалд эцэг эхийн үүрэг оролцоо хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн лекторын 2 удаагийн сургалт, 51 төрлийн гэр бүлийн үнэ цэний талаарх зурагт зөвлөмжийг байгууллагын цахим хуудсаар дамжуулж 22,562 иргэнд мэдээлэл хүргэсэн. Мөн "Гэр бүлдээ зарцуулах цаг хугацаа үнэ цэнэ", “Хүүхдийн эрх үүрэг”, "Давсаа хасъя", “Хосын цаг агаар нэвтрүүлэг”, "Намайг хамгаал", "Чи ганцаараа биш", "Хамтдаа шалгая, хамгаалъя" зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сүм хийд, түүний дэргэдэх дотуур байрны үйл ажиллагаанд хяналт тавьж, хүүхдийн эрх, аюулгүй байдалд хяналт шалгалтыг тус тус зохион байгуулсан. “Хүүхдээ хүндэтгэе-Нийгмийн дархлаа” ТББ-тай хамтран аймгийн 6 сургуулийн 3,323 сурагч, 1004 эцэг эх, 14 сумын нийгмийн ажилтан багш, сэтгэл зүйчдэд хүүхэд хамгааллын үндсэн мэдлэг олгосон. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 4 зорилт 24 арга хэмжээтэйгээр төлөвлөгөө боловсруулан ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай биелсэн байна. | |
| 224 | | 241. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал,хариуцлагыг дээшлүүлж, зам тээврийн ослыг бууруулах | 2021 - 2024 | Төлөвлөгөөний хэрэгжилт 80% | Төлөвлөгөөний хэрэгжилт | | 95% | Аймгийн нутаг дэвсгэрт зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхээр “Соёлтой жолооч” арга хэмжээг зохион явуулж, гар утасны дугаар бичигч, постер зурагтай карт, соёлтой жолооч бичиглэл хэвлэж тээврийн хэрэгслүүдийн арын салхины шилэнд, 2 төрлийн постер хэвлэж, гудамж замд анносыг байршуулсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд санамж сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудас 1200 ширхэг хэвлэж, жолооч зорчигч | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нарт тараасан. Мөн “Нэг зам-Нэг соёл” ухуулга нөлөөллийн аяныг 2023.06.30-наас 08-р сарын 23-ны өдрийн хооронд зохион байгуулж, жолооч зорчигч нарт 6500 ширхэг санамж сэрэмжлүүлэг, зөвлөмж тараан өгсөн. Босоо тэнхлэгийн зам дагуу нутагладаг малчдад урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, Замын цагдаагийн болон сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нар 815 тооны бод малыг хүзүүвчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Замын-Үүд-Сайншанд чиглэлийн автозам дээр Эрдэнэ сумын 18-р худгийн орчим жолоочийн нойр сэргээгч дэржигнүүрийг 2 цэгт хийсэн. Хяналт шалгалтын чиглэлээр “Уусан бол бүү жолоод” нэгдсэн хяналт шалгалтыг 21 удаа зохион байгуулж ажилласан. Осол гэмтлийн шалтгаант нас баралт өмнөх оны мөн үеэс 8,7%-иар, 2020 онтой харьцуулахад 6,3%-иар буурсан үзүүлэлттэй байна | |
| 225 | | 242. Цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог нэмэгдүүлж, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлах, соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулах | 2021 - 2024 | Төлөвлөсөн ажлын хэрэгжилт 50% | Төлөвлөсөн ажлын хэрэгжилт 50% | | 90% | 14 сумын Засаг дарга нарт олон нийтийн цагдаагаар ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэж цагдаагийн газарт ирүүлэх талаар чиглэл хүргүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд одоогийн байдлаар 16 олон нийтийн цагдаа ажиллаж байна. Олон нийтийн цагдаа болон эргүүлийн цагдаад энгэрийн камер худалдан авах ажилд 16,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэхэд нь зориулж “Land cruiser-J200” маркийн автомашин-1, “BAIC BJ40” маркийн суудлын автомашин-1, “Everst” маркын мотоцикл 10 ширхгийг орон нутгийн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төсвийн хөрөнгөөр шийдвэрлэн гардуулан өгсөн. Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг дэмжих, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдэд эргүүлийн хуваарь гарган тодорхой маршрутын дагуу 20:00-00:00 цаг хүртэл цагийн хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэсэн. | |
| 226 | | 243. Соёл урлагаар дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэн, бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, зөв хэрэглээг төлөвшүүлэх сургалт сурталчилгааны ажлыг хийж, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх. | 2021 - 2024 | Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 100% | Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт | | 100% | "Хүүхдийн төлөвшил, хөгжил, хамгаалалтад эцэг, эхийн үүрэг, оролцоо, хариуцлага" сэдэвт сургалтыг аймгийн Соёл урлагийн газартай хамтран зохион байгуулсан. Прокурорын газар, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ерөнхий боловсролын сургуулийн багш, алба хаагчид, цагдаагийн газар, болон байгууллагуудын эцэг, эхийн зөвлөлд 2 удаагийн сургалтаар 960 гаруй хүнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Мөн олон нийтийг хамарсан соёл, спорт, урлагийн арга хэмжээний үеэр хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх талаар уриалгыг нийтэд түгээх, соён гэгээрүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлсэн. "Өв, соёл урлагийн наадам", "Үндэсний баяр наадам" зэрэг тэмдэглэлт өдрүүд болон Саран хөхөө театраас зохион байгуулсан "Гэтэлгэх мөр" туйлсын хөгжимт драмын жүжиг, соёл урлагийн тэмцээн уралдааны үеэр гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгч, видео бичлэгүүдийг хүргэж ажилласан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Анзаар” арга хэмжээг зохион байгуулж төр захиргааны байгууллага, аж ахуй нэгж, тагнуулын хэлтэс, эрүүл мэндийн газар, багийн өрхийн эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургууль, политехникийн коллежийн багш, нийгмийн ажилтан, эцэг, эх асран хамгаалагчдад мэдээлэл | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүргэсэн. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр  “Та татгалз” аяныг өрнүүлж, ерөнхий боловсролын сургууль болон оюутан залуусын дунд гар зураг болон видео бичлэгийн уралдааныг зохион байгуулсан. Нийтдээ бүх төрлийн донтолтын эсрэг 26 арга хэмжээ зохион байгуулж, 1256 хүүхдүүдэд мэдээлэл хүргэсэн. | |
| 227 | 4.2.3. Хууль сахиулах салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна. | 244. Барилга байгууламжийг шинээр барих, засвар шинэчлэлт хийх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | Ажпын гүйцэтгэл 100% | Ажпын гүйцэтгэл | | 100% | Хилийн ангиудад орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгоор хилийн 0108 дугаар ангид 28 айлын орон сууцны барилгын засварын ажилд 50 сая төгрөг, 0168 дугаар ангийн 0137 дугаар салбарын хариуцсан хэсгийг бүхэлд нь өндөр хүчин чадал бүхий камерын хамгаалалтад шилжүүлж “Цахим салбар” болгоход зориулж 50,0 сая төгрөг, 0129 дүгээр ангид орон сууцны гадна, дотор сантехникийн засварын ажилд зориулан 50,0 сая төгрөг, нийт 150,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлж хилчдийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн орчин үеийн техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх хүрээнд хилийн цэргийн 0129 дүгээр ангид 12,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2020 онд Цагдаагийн газарт 11 автомашин, 10 мотоцикль нийт 21 тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийсэн. Цагдаагийн газарт туулах чадвар сайтай жийп машин худалдан авах ажилд 235,0 сая төгрөг, аймгийн Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнд туулах чадвар сайтай мотоцикл 10 ширхгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс шийдвэрлэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх таслан зогсооход дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн Алтанширээ сум, Дэлгэрэх сум, Иххэт сум, Хөвсгөл сум, Эрдэнэ сум, Замын-Үүд сумын цагдаагийн газарт, туулах чадвар сайтай жийп машин худалдан авах ажилд 659 сая төгрөг, олон нийтийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | цагдаа болон эргүүлийн цагдаад энгэрийн камер худалдан авах ажилд 16,0 сая төгрөгийн дэмжлэг, камерын хяналт засвар үйлчилгээнд 19,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан. | |
| 228 | | 245. Төрийн архивыг үндэсний санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдлыг хангах | 2021 - 2024 | Ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 100% | Ажлын төлөвлөгөөний хэрэгжилт | | 100% | “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн барилга барихтай холбогдуулан Төрийн архивын байрыг хамт байлгахаар шийдвэрлэсний дагуу 2023 оны төсөвт барилгын зураг төсөл зохиох төсвийг тусгасан. Төрийн архивт хадгалагдаж буй 53000 гаруй цаасан суурьтай баримтыг 2 хадгаламжийн санд зориулалтын нягтруулсан шүүгээнд байрлуулан хадгалж,  Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/47 дугаар тушаалаар батлагдсан “Архивын зориулалтын барилга” MNS 6929:1:2021 стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг. Архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд мэдээлэл лавлагаанд өргөн ашигладаг баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажил үе шаттай хийгдэж байна. Төрийн архивын 2023 оны цахимжуулалтын ажлын төлөвлөгөөний дагуу 24 хөмрөгийн 44 дансны 504 хадгаламжийн нэгжийн 35258 хуудас баримтыг скайнердан, фотошоп программаар засварлаж хамгаалалтын хувь үйлдэв. Хамгаалалтын хувь үйлдсэн 24 хөмрөгийн 43 дансны 486 хадгаламжийн нэгжийн 33257 хуудас баримтыг программд тодорхойлон бичиж, цахим мэдээллийн сан үүсгэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 100% |
| 229 | 4.2.4. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, | 246. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, бэлэн байдлыг хангаж, | 2021 - 2024 | Гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээ хийлгэсэн сумын тоо 3 | Гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээ хийлгэсэн сумын тоо | | Гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээ | Иххэт, Даланжаргалан, Айраг сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулийг 2023 оны 04, 09 дүгээр сард, Алтанширээ суманд | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | гамшгийн эрсдэлийг бууруулах | | | | | хийлгэсэн сумын тоо 2 | гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 04 дүгээр сард, Улаанбадрах суманд Команд штабын сургуулийг 04 дүгээр сард тус тус зохион байгуулсан. Гамшгаас хамгаалах дадлага, сургуульд дээрх 5 сумын Онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн 329 томилгоот бүрэлдэхүүн, 594 иргэн, 71 техник хэрэгсэлтэйгээр ажилласан. Онцгой байдлын газраас томилогдсон ажлын хэсгийн зүгээс гамшгаас хамгаалах дадлага, сургуульд дээрх сумдын Онцгой комисс, Засаг даргын Тамгын газар, ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, аж ахуй нэгж, байгууллагын удирдлагын зүгээс сургуулийн бэлтгэл ажлыг сайн хангасан, нөөц бүрдүүлэлт, гамшгаас хамгаалах бүтээлч ажил, санал санаачлагыг харгалзан үзэж, Иххэт суманд 90.8 хувь буюу “А” дүүрэн хангалттай, Улаанбадрах суманд 90.4 хувь буюу “А”, Алтанширээ, Айраг, Даланжаргалан сумдад 90 хувь буюу “А” үнэлгээтэй дүгнэгдсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран “Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож “онц байдал” тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулийг 2023 оны 06 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулж, тус дадлага сургуульд аймгийн Засаг даргын 2023 оны "Ажиллагааны удирдлагын төв байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай" А/351 дүгээр захирамжаар байгуулагдсан, давхардсан тоогоор 103 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээр оролцож, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хурлын танхимд байрлан, өгөгдсөн цагийн байдалд хариу арга хэмжээ авч ажилласан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 230 | | 247. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн гамшгаас хамгаалах арга хэмжээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо 2 Хамрагдсан иргэд | Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажил Хамрагдсан иргэд | | 2 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран “Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож “онц байдал” тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулийг 2023 оны 06 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус дадлага сургуульд аймгийн Засаг даргын 2023 оны "Ажиллагааны удирдлагын төв байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай" А/351 дүгээр захирамжаар байгуулагдсан, давхардсан тоогоор 103 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээр оролцож, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хурлын танхимд байрлан, өгөгдсөн цагийн байдалд хариу арга хэмжээ авч ажилласан. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуй нэгжид 37 удаа, 74 цагийн багтаамжтай сургалтыг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор зохион байгуулахад 1228 ажилтан, алба хаагч, иргэд хамруулсан. Сайншанд, Хатанбулаг, Иххэт сумдын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд 3 удаа, аймгийн Төв номын сан, Музей, сургалт судалгааны төв, Иххэт сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт буюу аж ахуй нэгж, байгууллагын түвшинд 4 удаа нийт 7 удаа гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн. Онцгой байдлын ерөнхий газрын дэд даргын баталсан удирдамжийн дагуу 06 дугаар сарын 10-ны өдөр “Өсвөрийн аврагч-2023” тэмцээнийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахад 9 сургуулийн 63 сурагч оролцож, дээрх сурагчдад хүний амь нас, эрүүл мэндийг авран хамгаалах, анхан шатны тусламж үзүүлэх, гал | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | унтраах, химийн хордолтын бүсэд ажиллах талаар мэдлэг мэдээлэл олгосон. | |
| 231 | | 248. Цаг агаарын аюулт үзэгдэл, гамшгийн үеийн мэдээллийг амжиж анхааруулах системээр дамжуулан малчид, иргэдэд шуурхай хүргэх ажиллагааг сайжруулах | 2021 - 2024 | Хүргэсэн мэдээний тоо-35000 | Хүргэсэн мэдээний тоо | | 50000 | Онцгой байдлын ерөнхий газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөс ирүүлсэн анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээг хүлээн авч, малчид, иргэдэд шуурхай хүргэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, аймгийн Засаг даргын А/33, А/241, А/263 дугаар захирамжаар нийт 16,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн, Мобиком, Скайтел компаниудтай тус тус гэрээ байгуулан “Масс мессеж” үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, цаг агаарын болон цаг үеийн мэдээллийг давхардсан тоогоор нийт 412946 иргэн, малчинд хүргэсэн. Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилсан сэргийлэх шуурхай мэдээний эхийг 4 удаа бэлтгэж, сумдын Засаг дарга нар болон холбогдох албан тушаалтанд цахимаар хүргүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах талаар заавар, зөвлөмж өгч ажилласан. Онцгой байдлын ерөнхий газар болон Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн Онцгой байдлын газарт цаг агаарын анхааруулах болон сэрэмжлүүлэх мэдээний дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан тухай илтгэх хуудсыг /4/ удаа заасан хугацаанд хүргүүлэн ажилласан. Цаг агаарын аюултай үзэгдлээс анхааруулах мэдээг 18 удаа, сэрэмжлүүлэх мэдээг 17 удаа боловсруулан малчид ард иргэдэд "www.dornogovi.tsag-agaar.gov.mn" цахим хуудсуудаар болон Дорноговь цаг агаар, орчны мэдээ мэдээллийн фэйсбүүк хуудсаар дамжуулан хүргэж ажилласан. 2021 онд анхааруулах мэдээг 46 удаа, сэрэмжлүүлэх мэдээг 23 удаа, урьдчилан сэргийлэх мэдээг 4 удаа, 2022 онд анхааруулах мэдээг 37 удаа, сэрэмжлүүлэх мэдээг 18 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | удаа, урьдчилан сэргийлэх мэдээг 3 удаа, 2023 оны 10 сарын байдлаар анхааруулах мэдээг 17 удаа, сэрэмжлүүлэх мэдээг 21 удаа боловсруулан иргэдэд хүргэсэн. | |
| 232 | 4.3.1. Хөрш болон өндөр хөгжилтэй орнууд, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, гадаад харилцааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 250. Хөрш болон өндөр хөгжилтэй орнуудтай уламжлалт харилцаагаа үргэлжлүүлж, шинээр бусад улсуудын муж, хотуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх. | 2021 - 2024 | Гэрээ, санамж бичгийн тоо 8 | Гэрээ, санамж бичгийн тоо | | 14 | Бүгд Найрамдах Турк Улсын Сакарья хотын захирагч Дорноговь аймагт айлчилж аймаг, хотын хооронд боловсрол, эрүүл мэнд, спорт, аялал жуулчлал, түүх, соёл урлагийн салбарт хамтран ажиллах, мэргэжилтэн солилцоо, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ах дүү хотын харилцаа тогтоох, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай, Оросын Холбооны Улсын Эрхүү мужтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эхлүүлж, эрүүл мэнд, боловсрол, соёл урлагийн салбарт төдийгүй жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зэрэг асуудлаар хамтран ажиллах тухай Санамж бичгүүдийг ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газраас зөвшөөрөл авсны дагуу байгуулсан. Зарим сумдыг гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор БНХАУ-ын Сычуань мужийн Пенжоу хот, БНСолонгос улсын Кимхэ хотыг тус тус Сайншанд хоттой, Замын-Үүд сумыг Хөбэй мужийн Жанжякоу хоттой, Эрдэнэ сумыг ӨМӨЗО-ны Шилийнгол аймгийн Зүүн Сөнөд хошуутай тус тус эгч дүү хот болгож, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, худалдаа, эдийн засаг, боловсрол, соёлын салбарт хамтын ажиллагаагаа эхлүүлэх, хамтран хэрэгжүүлэгч талын ноу-хау, мэдлэг чадварыг нутагшуулахаар зорин ажиллаж байна. БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 2021,2022,2023 онуудад тус консулын газрын 100 хувийн санхүүжилтээр Дорноговь аймаг дахь | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | АШУИС-ын салбар сургуулийн эх баригчийн ангид суралцаж буй 30 оюутны сургалтын төлбөрийг чөлөөлсөн бөгөөд цаашид ч тэтгэлгийг жил бүр орон нутагт шаардлагатай мэргэжлээр сурч буй оюутнуудад олгох боломжийг бүрдүүлсэн. Мөн аймгийн иргэдийн оршин суух нөхцөлийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор эдгээр онуудад зорилгоор тус консулын газраас 90,000 юаний буцалтгүй тусламжийг олгосон. | |
| 233 | | 251. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг гадаад орнуудын ижил төстэй байгууллагуудтай холбож, үр ашигтай хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжих | 2021 - 2024 | Хамтын ажиллагаатай байгууллагын тоо 13 | Хамтын ажиллагаатай байгууллагын тоо | | 18 | Дорноговь аймаг, Япон Улсын Шизуока мужийн хооронд найрамдалт харилцааны нэг салбар болгож эхлүүлсэн ахлах ангийн сурагч харилцан солилцох үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилгоор Санамж бичгийг шинэчлэн байгуулсан бөгөөд 2022, 2023 онуудад 55 сурагч, 6 багш тус хөтөлбөрт хамрагдсан. Сайншанд сумын Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хэвийн явуулах, инженер техникийн ажилчдыг чадавхжуулах зорилгоор “Жайка” Олон Улсын байгууллагатай хамтран 3 жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлж танхимаар болон цахимаар 90 гаруй сургалт хийж, дадлагажуулах ажлыг зохион байгуулсан.  “Оюу толгой” ХХК, "Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг"-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын санхүүжилтээр төмөр замын торыг хэсэгчлэн авч, нүүдлийн замыг чөлөөлөх төслийг хэрэгжүүлж, зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөн хийх нөхцөлийг бүрдүүлэн Өргөн сумын нутагт 2 байршилд нийт 1,2 км торыг хэсэгчлэн авах ажлыг зохион байгуулсан.  "Дэлхийн Зөн Монгол" ОУБ-ын гамшигт тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд Гамшгийн эрсдэлийг олон нийтэд таниулах сургагч багшаар 57 хүн сургаж, 711 | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | малчид, иргэдэд гамшгийн талаарх мэдлэг ойлголтыг өгч, нийт 155 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны “Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах” МОН-33113 хамтарсан төслийн хүрээнд 1,2 тэрбум төгрөгийн санхүүжилттэй мал эмнэлгийн лабораторийн барилгын ажил хийгдэж дууссан бөгөөд ингэснээр аймгийн Мал эмнэлэг химийн лаборатори, гистологи эмгэг судлал, хор, халдварт өвчин судлал, хөгц мөөгөнцөр судлалын дөрвөн шинжилгээний тасагтай болж өргөжин, 200 дээжид нэгэн зэрэг шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн. | |
| 234 | | 252. Хүний хөгжил, нийгэм, эдийн засгийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх. | 2021 - 2024 | Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөр 2 | Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөр | | 3 | Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтыг тавин шинээр 2 муж, хот, 6 олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй харилцаа тогтоон гадаад хамтын ажиллагааг хөгжүүлж, аймгийн бүтээн байгуулалт, дэд бүтэц, ард иргэдийг амьдрах орчныг сайжруулах чиглэлээр 9.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай ажлууд хийгдсэн. БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газартай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газрын 100 хувийн дэмжлэгээр төвийн 150 сурагч, Замын-үүд сумын 50 сурагч, 20 багш Эрээн хотын 3-р сургуультай танилцаж, жил бүр зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хоттой хамтын ажиллагаагаа өргөжүүлэн эдийн засаг, хөрөнгө оруулалт, эрүүл мэнд, хүмүүнлэгийн салбарт үр ашигтай хамтран ажиллаж Боловсролын газар болон Бугат хотын Боловсролын товчоо, ЕБ-ын 1-р сургууль болон Бугат хотын Монгол сургууль, Политехникийн коллеж болон Бугат хотын үйлдвэр инженерийн сургууль | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | мөн ЕБ-ын 5-р сургууль болон Шизуока мужийн Жюүхакү ахлах сургуулийн хамтын ажиллагааны эхлэл 2022, 2023 онуудад тавигдсанаар боловсролын салбарт хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлсэн. Шизуока мужын Их сургуулийн Сувилахуйн сургууль, АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС хоорондын хамтын ажиллагааг улам өргөжүүлэх, эрдэм шинжилгээ, сургалт, багш оюутан солилцох хүрээнд санамж бичгийг байгуулсан. Дэлхийн зөн Олон Улсын Байгууллагын Америкийн Нэгдсэн Улсын олон улсын хөгжлийн агентлагийн Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх товчооны санхүүжилтээр 2022 оноос 3 жилийн хугацаатай хэрэгжсэн “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төслийн хүрээнд 76,3 сая төгрөгийн үнэ бүхий 5 га талбайг хашаажуулах хашааны материал, иж бүрэн усжуулалтын систем, усны насос, үрлэгч, хадуур, сийрүүлэгч, нийт 15 нэр төрлийн тоног төхөөрөмж, 18 сая төгрөгийн үнэ бүхий тарилгын хашаа, гурвалсан хайрцаг, задлангийн багаж, Мотопомп, хөргүүртэй зөөврийн хайрцгийг Иххэт, Хатанбулаг сумдын малчид, мал эмнэлгийн тасагт гардуулсан. | |
| 235 | 4.4.1. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах. | 4.4.1.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах аймгийн бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | | | | "Үндэсний аюулгүй байдлыг орон нутгийн түвшинд хангах бодлого"-ыг Оршин тогтнохын аюулгүй байдал, Эдийн засгийн аюулгүй байдал, Дотоодын аюулгүй байдал, Хүний аюулгүй байдал, Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдал гэсэн тэргүүлэх чиглэлтэйгээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 52 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд жил бүр төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 11 зорилт, 30 арга хэмжээг | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 85,3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн ба холбогдох агентлаг, сумдаас мэдээлэл авч жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг тайлагнаж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 14 дүгээр хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна. 2023 оны 05 дугаар сард Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллээр хангах орон тооны бус зөвлөлийн хурлыг зохион байгуулж 2 удаагийн сургалтыг зохион байгуулснаар хуулиар хүлээсэн чиг үүргийн байгууллагуудын мэдээ, мэдээллийг цаг тухайд нь хүргэж хагас, бүтэн жилээр мэдээллийн сан үүсгэсэн. Хөтөлбөрийг хэрэгжилтийн үр дүнд Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирч, ажил үүргийн давхардал арилсан. Мөн Монгол Улсын хууль тогтоомж, эх орон ч үзэл төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээгээр дамжуулж иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн. | |
| 236 | | 4.4.1.2. Батлан хамгаалах салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | | | Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулан баталгаажуулсан. Цэргийн тоо бүртгэл, нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулж зэвсэгт хүчний болон хил хамгаалах ангиудын хяналтын тоог 100 хувь биелүүлсэн. Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 102 жилийн ойг угтан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд Марш тактикийн тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээн, спортын цогцолбор тэмцээн, ард иргэдэд нээлттэй хаалганы өдөрлөг, цэрэг эх орны сэдэвт дууны уралдаан, хүүхэд залуучуудын дунд уулзалт ярилцлага цэрэг эх орны сэдэвт дууны уралдаан зэргийг зохион байгуулж 1200 гаруй | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | иргэдэд Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчилсан. Засгийн газрын тогтоол батлан хамгаалахын сайдын тушаалаар "Оюутан цэрэг" сургалтад Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны салбар сургуулийн нэгдүгээр курсийн 5, Политехникийн коллежийн 9 нийт 14 оюутныг сонгон шалгаруулж сургалтын "Цэргийн ерөнхий бэлтгэл" шатны сургалтыг зохион байгуулсан. Хүүхэд залуучуудад цэрэг эх-оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний нэгдүгээр шатыг ерөнхий боловсролын сургуулиуд 2023 оны 05 дугаар сарын 10-ны дотор сургууль тус бүр дээрээ, хоёрдугаар шат буюу аймгийг аварга шалгаруулах тэмцээнийг аймгийн Засаг даргын 2023 оны А/237 дугаар захирамжаар 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр аймгийн төв талбайд тус тус зохион байгуулсан бөгөөд тэмцээнд аймгийн ерөнхий боловсролын 12 жилийн 11 сургуулийн 200 гаруй сурагчийг хамруулсан. | |
| 237 | | 4.4.1.3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх | 2021 - 2024 | | | | | 14 сумын орон нутгийн хамгаалалтын томилгоог 2023 оны 1 дүгээр сард цэргийн тоо бүртгэлтэй уялдуулан, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагатай хамтатган тодотгосон бөгөөд сумдын нууц баримт бичиг газрын зураг, төлөвлөгөө тэдгээрийн хамгаалалтын байдалд үзлэг хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулсан. Сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний тодотголын явцад хяналт тавьж боловсруулалтад анхаарч удирдлага арга зүйгээр ханган ажилласан. Аймгийн засаг даргын захирамжаар орон нутгийн хамгаалалтын сургалтад ашиглах материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор зөөврийн компьютер 1 ком, цахилгаан үүсгүүр /агрегат 1 нэгж, лоом 10 ш, хүрз 10 ш, жоотуу 10 ш, зэргийн нийт 5.500.000 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төгрөгөөр худалдан авсан. Томилгоот нэгжийн сургалт сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 10 сард зохион байгуулагдана. Дайчилгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын мн/21 дүгээр тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.3.10 дахь заалт, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын стратегийн 600/02 удирдамжийн дагуу “Зэвсэгт хүчний ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах” төлөвлөгөөнд тодотгол хийж, дайчилгааны даалгавраар оногдуулан бүртгэсэн цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн нэрийн жагсаалт, тооцооны хуудсыг анги, командаар нь, автотехникийг марк, зориулалт, улсын дугаар, техник оногдуулан бүртгэх карт, жолоочийн нэрийн жагсаалтыг анги, командаар нь гарган тодотгож актыг тогтоосон хугацаанд ЗХЖШ-т хүргүүлсэн. | |
| 238 | | 4.4.1.4. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлж, “Оюутан-цэрэг” сургалт, хугацаат цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | | | | Зэвсэгт хүчний ойн баярын хүрээнд аймгийн Засаг даргын А/183 дугаар захирамжаар аймгийн Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд “Цэрэг Эх-оронч” сэдэвтэй “Гоцлол дуу”, “Хамтлаг дуу”-ны уралдаан зохион байгуулсан. Тус тэмцээнд “Гоцлол дуу”-ны төрөлд Ерөнхий боловсролын 7 сургуулийн 15 сурагч, “Хамтлаг дуу”-ны төрөлд Ерөнхий боловсролын 6 сургуулийн 9 хамтлаг оролцсон. Аймгийн Засаг даргын 2023 оны А/237 дугаар захирамжаар аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг 06 дугаар сарын 16-ны өдөр аймгийн төв талбайд зохион байгуулсан бөгөөд тус тэмцээнд ахлах ангийн 200 гаруй хүүхэд оролцсон. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас бэлтгэл, чөлөөнд гарсан ахмадууд | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | болон Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд “Мөрдөстэй ахмадууд” хэмжээнд Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан бэлтгэл хурандаа Д.Гүндсамбуу залуу хойч үе, хүүхэд залууст хандан “Мөрдөстэй амьдрал” сэдвээр илтгэл тавьсан бөгөөд тус арга хэмжээнд ЕБ-ын ахлах ангийн 200 хүүхэд оролцсон. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 111 дүгээр тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/103 дугаар тушаал, Дорноговь аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/266 дугаар захирамжийн дагуу Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны салбар сургуулийн хичээлийн байранд долоо хоногийн амралтын өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтын сонгон шалгаруулалтыг 2023 оны 04 дүгээр сарын 03-аас 05-ны өдрүүдэд эрүүл мэндийн үзлэг, биеийн тамирын шалгуур үзүүлэлтээр зохион байгуулсан. Хүсэлт гаргаж сонгон шалгаруулалтад тэнцсэн Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны салбар сургуулийн нэгдүгээр курсын 5, Политехникийн коллежийн 9 нийт 14 оюутны “Цэргийн ерөнхий бэлтгэл” шатны сургалтыг зохион байгуулсан. Өмнөговь аймагт зохион байгуулагдсан "Цэргийн мэргэжлийн бэлтгэл" шатны сургалтад 14 оюутныг мөн хамруулж дайчилгааны бэлтгэл үүрэгтний нөөцийг нэмэгдүүлсэн. Хяналтын тоог 100 хувь биелүүлсэн. | |
| 239 | 4.5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангийн ашиглалтыг сайжруулж, баяжуулалт, шинэчлэлтийн ажлыг зохион байгуулна. | 270. Төрийн албан хаагчдыг хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээрх арга зүйгээр хангаж, мэдлэг ур чадварыг сайжруулна. | 2021 - 2024 | 80 | Цахим сангийн ашиглалтын хувь | | 100% | Хяналт шинжилгээ үнэлгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх төрийн болон нутгийн бодлогын баримт бичгийг хяналтад авах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлагнах болон үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийх арга зүйд сургах зорилгоор сум, агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан 70 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | албан хаагчид "Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ" сэдэвт сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Сургалтаар "Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндсэн ойлголт, анхаарах асуудал", "Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй", "Тайлан бичих арга зүй, анхаарах асуудал" зэрэг 7 сэдвээр мэдээлэл хүргэж, дадлага ажил зохион байгуулан үр дүнг тооцон ажиллалаа. Мөн давхардсан тоогоор 25 байгууллагын 60 гаруй албан хаагчид хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлангийн талаар болон ХШҮ-ний цахим сангийн хэрэглээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| 240 | | 271. Төрийн байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлыг тогтмолжуулж, үр дүнг дээшлүүлнэ. | 2021 - 2024 | 100% | Шинээр батлагдсан бодлогын баримт бичгийг цахим санд оруулсан хувь | | 100% | Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангийн баяжуулалт шинэчлэлтийн хүрээнд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлагдсан 2 зорилтот хөтөлбөрийг тухай бүр 100% байршуулсан. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Ерөнхий сайдын болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын шуурхай үүрэг даалгаврын системийн шинэчлэлт хийгдэн, хэрэгжилтийг бүр илгээн хэвшсэн. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хагас жилээр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, дэд болон зорилтот 11 хөтөлбөрийн тайланг бүтэн жилээр аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 28 агентлаг, 4 төсөвт байгууллага, 14 сумын ЗДТГ-аас тайланг хүлээн авч хэвшсэн. | 100% |
| 241 | | 272. Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангийн ашиглалтыг сайжруулж, баяжуулалт, шинэчлэлтийн ажлыг | 2021 - 2024 | 90% | Тухай жилийн төлөвлөгөөнд тусгагдсан байгууллаг ын хувь | | 100% | Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /www.dornogovi.unelgee.gov.mn/-ийн ашиглалтыг сайжруулахаар нэвтрэх эрхгүй агентлаг, сум, төрийн үйлчилгээний байгууллагын 72 ажилчдын судалгааг авч Дорноговь | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зохион байгуулна. | | | | | аймгийн ХШҮ-ний мэдээллийн цахим санд нэвтрэх болон тайлагнах эрх үүсгүүлсэн. Бүртгүүлсэн албан хаагчид цахим санд хэвийн нэвтэрч, холбогдох тайланг цахим сан ашиглан илгээснээр тус сангийн бүртгэл, мэдээллийн баяжуулалт нэмэгдэж цаасан суурьтай баримт бичгийн эргэлт 80 хувиар буурсан. Мөн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийн дэд болон зорилтот хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргаас сайд нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайланг цахимаар авахаар нийт сум, агентлагт холбогдох заалт, арга хэмжээг хуваарилж, 42 байгууллагын тайланг цахимаар авч, хяналтад аван нэгтгэх ажиллагаа бүрэн хийгдсэн. | |
| 5. Ногоон хөгжлийн бодлого | | | | | | | | |
| 242 | 5.1.1. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 274. Агаарын бохирдлыг бууруулах өрхийн ухаалаг хэрэглээг бий болгох, цахилгаан халаалтыг дэмжих, дулааны станцын зуухыг утаа баригчтай болгох зэрэг арга хэмжээг судалж хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо-1 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 3 1 | Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд БОАЖЯ-ны Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 427,0 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумыг дулаанаар хангах 3 зуухanд уутат шүүлтүүр, үнс баригч суурилуулах ажлыг "Термомастер" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 481 дүгээр тогтоолын дагуу аймгийн хэмжээнд 2302 өрхөд 103,7 сая төгрөгийн, Засгийн газрын 2020 оны 221-р тогтоолын дагуу аймгийн хэмжээнд 5904 аж ахуйн нэгж байгууллага, 71871 өрх, нийт 77775 хэрэглэгчид 2,9 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлж агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн цахилгаан халаалтыг ашиглахад дэмжлэг үзүүлсэн. Тайлант хугацаанд 25 өрх цахилгаан халаалтыг өрхийн хэрэглээндээ нэвтрүүлснээр цахилгаан халаалттай өрх 294 болж өслөө. Монгол Улсын Их сургуулийн эрдэмтэн багш нартай хамтран 2023 | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | оны 3, 4 дүгээр сард дулааны алдагдал багатай “Пассив барилга” барих аргачлал, цахилгаан дулааны хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх боломжийн талаарх 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 100 гаруй иргэн хамруулан гарын авлага, мэдээллээр ханган ажилласан.  Монгол гэрийн халаалт дулаалгын багц, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, сэргээгдэх эрчим хүч, бүрэн шаталттай зуух, гэрийн нөхцөл дахь агаарын бохирдлыг бууруулах талаарх 8 төрлийн мэдээллийг цахим сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэх нөлөөллийн ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 4500 гаруй иргэн үзэж хандалт авсан байна. | |
| 243 | | 275. Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах ажлыг дэмжих замаар агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | Шахмал түлшний үйлдвэрийн тоо-1 | Шахмал түлшний үйлдвэрийн тоо | | 5% | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Дорноговь аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/493, А/670 дугаар тушаал, захирамжаар Сайншанд, Замын-Үүд сумын “Агаарын чанарыг сайжруулах, бүс тогтоох, бүсэд мөрдөх журам”-ыг батлан хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн лабораторид (PM-2.5) нарийн ширхэгт тоосонцор хэмжих "Dust Truk" багаж аймгийн агаарын бохирдлыг бууруулах зардлын 50,0 сая төгрөгийн санхүүжилтээр худалдан авч ашиглалтад оруулснаар тоонсонцор хэмжих явуулын үйлчилгээ үзүүлэх боломж бүрдсэн. Сайншанд сумын агаарт агуулагдах хүхэрлэг хий /SO2/, азотын давхар исэл /NO2/-ийн хэмжээг цаг уурын ажиглалтын станцаас өдөр бүр тодорхойлж (tsag-agaar.gov.mn) сайтад нийтэд нээлттэйгээр байршуулан мэдээллээ хангадаг, 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хэмжилтийг өмнөх оны мөн үеийн дундажтай харьцуулахад хүхэрлэг хий 0,001-ээр бага, азотын давхар исэл 0.04-өөр бага | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үзүүлэлттэй байна. Сайншанд сумын төвлөрсөн хогийн цэг, “Чандмань-Илч” уурын зуухны орчим, 2 дугаар баг Дэнжийн хэсэг, 1,3,7,8 дугаар багийн гэр хорооллын гудамж, Зүүн баян багийн төвд хөрсний бохирдолтой 10 цэгт нянгийн болон хүнд металлын иж бүрэн шинжилгээг “Ханлаб” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөх, орон сууцжуулах замаар утааг бууруулах зорилттой ажиллаж “Мандах наран-5” хорооллын 288 айлын орон сууц, 9 давхар 45 айлын орон сууц ашиглалтад орж, цэвэр усны шугамд 50 өрх, цахилгаан халаалтыг 25 өрх, бохир усны шугамд 40 өрх, дулааны шугамд 17 өрх холбогдсноор яндангийн тоог 375-аар бууруулаа. | |
| 244 | 5.1.2. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулна. | 276. Газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг мэргэжпийн байгууллагаар хийлгэж, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Арга хэмжээний тоо-1 | Арга хэмжээний тоо | | 2 | Газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг "Усны мэдээллийн өнө мөнхийн ундарга төв" ХХК-иар 42,6 сая төгрөгийн өртөгтэйгөөр гүйцэтгүүлж, холбогдох тайланг төрийн байгууллагууд болон олон нийтэд танилцууллаа. БОАЖ-ын сайдын 2022 оны А/213 дугаар тушаалаар Улаанбадрах суманд байрлах ураны орд газарт байгаль орчны мониторинг хийж, хүхрийн хүчил ашиглан ураныг ГДУО үйл ажиллагаанаас өөрчлөлт үүсэж байгаа эсэхийг хянах, үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох байгууллагуудыг бодит мэдээлэл, зөвлөмжөөр хангах ажлын хэсэг энэ оны 5 сард ажиллаж хөрсний бүтэц, шинж чанар, газрын доорх болон гадаргын усны найрлага шинж чанар, цацрагийн дэвсгэр түвшин болон оршин суугчдын сансрын туяа, газрын хөрсөн дэх байгалийн болон үүсмэл цацраг идэвхт изотопуудын гамма цацрагаас авах гадаад шарлагын жилд авах хэмжээ, ургамал, амьдарч байгаа малын мах, сүүнд бохирдол үүсэж байгаа эсэх тогтоох ажил | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хийгдсэн. Ажлын хэсгийн ерөнхий дүгнэлтээр Хүхрийн хүчил ашиглан ГДУО аргаар уран олборлох туршилтын үйл ажиллагаанаас жижиг, том торлолын олборлолт явагдах давхаргын уст үеийн усанд усны орчин (pH) сул шүлтлэгээс (pH 7.39-7.70) хүчиллэг (pH 2.61-4.29) болж өөрчлөгдсөн, усан дахь сульфат, хлор, нитрат, нитрид, аммоны ион болон уран, лантан, иттри, никель, манган, кобальт, рубиди, хүнцэл зэрэг металлуудын хэмжээ нэмэгдэж, радоны ээлэхүүнт идэвхийн хэмжээ буурснаас өөр өөрчлөлт илрээгүй. Малчдын унд ахуйн зориулалттай худгуудын ус болон олборлолт явуулах давхаргын дээр орших уст давхаргын усны шинж чанар, элементийн агуулгад өөрчлөлт гараагүй, зарим худагт уран, радоны агуулга бага зэрэг нэмэгдсэн,хөрсний бүрэлдэхүүн, хими, физик шинж чанар, хүнд хортой элементийн агуулгад өөрчлөлт илрээгүй, ургамалын уран торийн харьцаа Баруунбаян булагийн орчимд 31 дахин нэмэгдсэн, "Зөөгч" овоогийн жижиг торлолын дотор 2 дахин буурсан, маханд хүнцэл, хар тугалганы агуулга бага зэрэг нэмэгдсэн гэсэн дүгнэлт гарсан. | |
| 245 | | 277. Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг нарийвчлан тогтоож мөрдүүлж хэвшүүлэх | 2021 - 2024 | Эрүүл ахуйн бүс тогтоосон худгийн тоо-50 | Эрүүл ахуйн бүс тогтоосон худгийн тоо | | 100% 2 | Аймгийн Засаг даргын 2012 оны А/411 тоот захирамжийн дагуу аймгийн хэмжээнд нийт 95 худаг уст цэгт эрүүл ахуйн бүс тогтоож дэглэмийг мөрдүүлэн ажилладаг. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг 100 хувь тогтоосноор ус ашиглалт, хамгаалалт сайжирсан. Айраг, Алтанширээ, Даланжаргалан сумдад үйл ажиллагаа явуулдаг "Би Ти Девелопмент" ХХК 1 худаг, "Мин Ли Да" ХХК 1 худаг, “Норинко интернэйшнл кооперэйшн” ХХК 1 худаг, Говийн шандаст хүлэг ХХК 3 худаг, “Гаас” ХХК 2 худаг, Мак Цемент ХХК 2 худаг нийт 6 компаниуд | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | өөрсдийн эзэмшлийн шинээр гаргасан 10 худагт эрүүл ахуйн бүс тогтоож хашаажуулж, тэмдэгжүүлэх ажил хийгдсэн. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуй бүс, ус хангамжийн эх үүсвэрүүдийн тэжээгдлийн мужийн зааг, зураглал, холбогдох мэдээлэл, судалгааг шинэчлэн тогтоож хамгаалалтад авах газрын мэдээлэлд үндэслэн Өргөн, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан сумдын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн худгийн хамгаалалтын бүстэй 239 газар давхцалтай, 13 сумдын 86 булаг, ашигт малтмалын 46 тусгай зөвшөөрөлтэй талбай, 111 нуур, тойром ашигт малтмалын 44 тусгай зөвшөөрөлтэй давхцалтай байгаа тул иргэн, аж ахуйн нэгжүүдэд сонсох ажиллагааг явуулж, давхцалыг арилгуулахаар олон нийтэд танилцуулсан. Мөн усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуй бүс, ус хангамжийн эх үүсвэрүүдийн тэжээгдлийн мужийн зааг, зураглал, холбогдох мэдээллийг нэгтгэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах ажлын хэсэг ажиллаж байна. | |
| 246 | | 278. Булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалж, тохижуулах ажлыг үргэлжлүүлэх | 2021 - 2024 | Хамгаалж тохижуулсан булгийн тоо-68 | Хамгаалж тохижуулсан булгийн тоо | | 3 | Аймгийн хэмжээнд 370 булаг, шандын эхийг хашиж хамгаалахаас 2008-2020 онд 67, 2021 онд 7, 2022 онд 6, 2023 онд 9 нийт 89 булаг шанд хамгаалж тохижуулах ажил хийгдэж өмнөх онтой харьцуулахад 66,6 хувийн өссөн. Тайлант онд гадаргын усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 25.0 сая төгрөгийн хөрөнгөөр Айраг сумын Нарт багийн Ээзгийт булаг, Иххэт сумын Баян багийн Өлзийт булаг, Өргөн сумын 3 дугаар багийн Живчид булаг, Улаанбадрах сумын 1 дүгээр | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | багийн Хоньчийн булаг, Эрдэнэ сумын 2 дугаар багийн Бүлээн булаг нийт 5 булаг, Даланжаргалан суманд “Говийн шандаст хүлэг” ХХК-ний 1,0 сая төгрөгийн санхүүжилтээр Элдэвийн булаг,  Мандах суманд “Түмэн айл инвест”ХХК ний 1,0 сая төгрөгийн санхүүжилтээр Шавартайн булаг, Иххэт суманд “Хөх бишрэлт”ХХК ний 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр Хөгцөт булаг, Сайхандулаан суманд "Маргац интернэшнл гол" ХХК-ний 3,0 сая төгрөгийн санхүүжилтээр Улааншороот багийн Дэврэхийн булаг нийт 8 суманд 9 булгийн эхийг хашиж хамгаалж тохижуулан усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулсан.  Сумдад Усны сан бүхий газар ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, түүний ойр орчмын газрын хог хаягдлыг цэвэрлэх ажил хийгдсэн. Нийт 200 ААНБ, 3500  иргэн, ажилтан, албан хаагчид оролцон 2500,0 га талбайн ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 29 автомашин техник хэрэгслээр 470,0 тн хог хаягдлыг цэвэрлэн сумдын төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн. | |
| 247 | | 279. Сумдын ундны усыг чанарын шинжилгээнд хамруулж, цэнгэгжүүлэх төхөөрөмжийг суурилуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, стандартын шаардлага хангасан ундны усаар хангах, | 2021 - 2024 | Цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан худгийн тоо-35 | Цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан худгийн тоо | | 100% 40, 1 | Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах бодлогын хүрээнд чанар, стандартын шаардлага хангахгүй байгаа 55 худгаас 14 сумын 2021 онд 2, 2022 онд 2, 2023 онд 7 хутагт цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулснаар аймгийн хэмжээнд нийт 50 худагт цэнгэгжүүлэх төхөөрөмж тавьж 90.9 хувийн хэрэгжилттэй өмнөх онтой харьцуулахад 28,5 хувийн өсөлттэй байна. Тайлант онд Усны чанар, стандартыг сайжруулах ажлын хүрээнд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 200,0 сая төгрөгийн хөрөнгөөр Сайншанд сумын хүн амын ундны усан хангамжийн эх үүсвэрийн 1 | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | худагт усны хатуулаг, хүнцэл бууруулах төхөөрөмж, Улаанбадрах, Мандах сумдад 40,0 сая төгрөгөөр 2 худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж,Орон нутгийн хөгжлийн сангийн 5,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өргөн суманд 1 худаг, Эрдэнэ суманд 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 худаг нийт 7 ус хангамжийн эх үүсвэрийн худгуудад 345,0 сая төгрөгийн санхүүжилтээр ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулж иргэдийг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах ажлуудыг тус тус хийсэн. | |
| 248 | 5.1.3. Гэр хороолол, аялал жуулчлалын газруудын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлж сайн туршлагыг дэлгэрүүлнэ. | 280. Ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | Төслийн хэрэгжилтийн хувь Бүтээгдэхүүн үйлдвэрлэгч-0 | Төслийн хэрэгжилтийн хувь Бүтээгдэхүүн үйлдвэрлэгч | | 200 | Ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох дэвшилтэт технологийг нэвтрүүлэх чиглэлээр 2022 онд “Өнгө Нэм” ТББ-тай хамтран “Хог хаягдлын менежмент” танхимын сургалтыг 2 удаа зохион байгуулж, төр, хувийн хэвшлийн 200 гаруй төлөөлөлд хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, шингэн хаягдлын менежмент, стандартын бие засах газрын талаар мэдлэг олгосон. “Намрын ногоон өдрүүд”, төрийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг” зэрэг олон нийтийг хамарсан 3 арга хэмжээнд оролцож салбарын үйл ажиллагаатай холбоотой 1500 гаруй гарын авлага, материалыг иргэдэд хүргэж, 10 төрлийн постер, 3 төрлийн видео мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд хүргэсэн. 2023 онд Гэр хорооллын айл өрхийн ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэх ажлын хүрээнд "Нээлттэй Дорноговь" арга хэмжээнд айл өрхийн бичил цэвэрлэх байгууламжийн худалдаа суурилуулалтын чиглэлээр "Юнилос" ХХК, стандартын бие засах газрын чиглэлээр "Пластик центер" ХХК-ыг урьж оролцуулан, 14 сумын 1000 гаруй иргэнд танилцуулж гарын | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | авлага материал түгээсэн. Энэхүү ажлын хүрээнд Гэр хороолол, аялал жуулчлалын газруудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2 удаагийн албан бичгийг сумдад хүргүүлж худалдаа үйлчилгээ, шатахуун түгээх станц зэрэг 13 аж ахуйн нэгж стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон. Орон нутгийн төсвийн 157,5 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын наадмын талбайн 5 цэгт, Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын Энергийн төвийн орчинд 1 цэгт, Даланжаргалан сумын Халзан-Уул рашаан сувилал, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мод үржүүлгийн талбайд нэг нийт 8 стандартын шаардлага хангасан нийтийн ариун цэврийн байгууламж шинээр байгуулан ашиглалтад оруулсан. | |
| 249 | | 281. Хөрс бохирдуулагч эх үүсвэрийг бууруулахад олон нийтийн оролцоог эрчимжүүлэх. | 2021 - 2024 | Мэдээлэл сурталчилгаанд хамрагдсан ААНБ, иргэдийн тоо-87, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоо-34 | Мэдээлэл сурталчилгаанд хамрагдсан ААНБ, иргэдийн тоо сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоо | | 1000 150 | Алтанширээ, Дэлгэрэх, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумдад цэвэр бохир, дулааны төвлөрсөн инженерийн байгууламж баригдаж дээрх сумд, Сайншанд, Замын-Үүд, Даланжаргалан, Мандах сумын төвийн 137 айл өрх стандартын шаардлага хангасан соруулдаг нойл, 378 айл өрх 48 аж ахуйн нэгж байгууллага төвлөрсөн шугам сүлжээнд холбогдож нийт 563 айл өрх аж ахуйн нэгж байгууллага ариун цэврийн байгууламжаа стандартын шаардлагад нийцүүлж, Айраг, Сайншанд, Даланжаргалан, Дэлгэрэх, Замын-Үүд, Мандах, Хатанбулаг сумдын 100 гаруй айл өрх, 15 аж ахуйн нэгж байгууллага хуучин ашиглаж байсан нүхэн жорлонгоо дарж булшлан хөрсний бохирдлыг бууруулсан. Аймгийн хэмжээнд 3400 гаруй нүхэн жорлон тоологдож давхардсан тоогоор 10000 гаруй | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нүхэнд жорлонд ариутгал хийсэн. “Эрдэнэт үйлдвэр” ТӨКомпанийн санхүүжилтээр Улаанбадрах, Сайхандулаан сумдын ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг шинэчлэж боловсронгуй болгосон. Бүх нийтийн цэвэрлэгээг Нийтийн эзэмшлийн гудамж талбайд 50 удаа зохион байгуулж 7000 га талбайн 1400 тн хог хаягдлыг цэвэрлэж 1900 аж ахуйн нэгж байгууллага 13000 иргэн хамруулсан. Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан, Алтанширээ сумдад нийт 408 айлын орон сууц ашиглалтад орж, бохир усны шугамд 339 өрх холбогдож хөрс бохирдуулагч нүхэн жорлонгийн тоог бууруулллаа. | |
| 250 | 5.1.4. Ан амьтдын амьдрах орчныг тэтгэх, нүүдлийн замыг чөлөөлөхөд иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлнэ. | 282. Зарим сумдад сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг худаг гаргах, бороо цасны ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулж зэрлэг амьтдын ус хангамжийн эх үүсвэрийг бүрдүүлэх | 2021 - 2024 | Сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг худгийн тоо 0, Хөв цөөрмийн тоо 0 | Сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг худгийн тоо Хөв цөөрмийн тоо | | 1 1 | Хур борооны усыг хуримтлуулж, ан амьтныг ундаалах, ургамал, биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2021 онд Хөвсгөл сумын Жавхлант багийн нутагт уурхайн үйл ажиллагаа явуулдаг "Сора интернэшнл" ХХК 35,0 сая төгрөгийн санхүүжилтээр зэрлэг ан амьтны усалгаанд зориулан автомат системтэй 1 худаг шинээр гаргасан. Тус худаг хэвийн ажиллаж тухайн бүс нутаг дахь зэрлэг амьтдыг ундаалж байна. Мөн Хатанбулаг сумын Эргэл багийн нутаг дэвсгэрт “Тахилт хайрхан транс” ХХК 90.0 сая төгрөгийн санхүүжилтээр зэрлэг амьтдын усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор мэдрэгчтэй гүний худгийг гаргах ажлын зураг төсвийг гаргаж 2024 оны 01 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлэхээр хүлээгдэж байна. Өргөн сумын "Аргалийн уул", Эрдэнэ сумын "Хангинуурын даваа"-нд тус бүр 1м.куб ус хуримтлуулах хүчин чадалтай 2 ширхэг хөв цөөрмийг “Монгол тур" ХХК, "Маунтайн хантинг" ХХК-иуд хийж гүйцэтгэсэн бол Сайншанд сумын Ханбаянзүрх хайрхан уулын тусгай хамгаалалттай | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | газар нутаг 3 м.куб ус хуримтлуулах хүчин чадалтай хөвийг “Сайншанд салхин парк” ХХК байгуулсан. Аймгийн хэмжээнд бэлчээр, зэрлэг амьтдын усан хангамжийн зориулалтаар сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг худаг 4, хөв цөөрөм 6 ширхгийг шинээр байгуулсан нь худаг 6, хөв цөөрөм 20 болж 2020 онтой харьцуулахад сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг худаг 66.6 хувь, хөв цөөрөм 30 хувиар тус тус нэмэгдсэн. | |
| 251 | | 283. Дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэхэд ан амьтдад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Дэд бүтэцтэй төслүүдэд оруулсан санал зөвлөмжийн тоо-10 | Дэд бүтэцтэй төслүүдэд оруулсан санал зөвлөмжийн тоо | | Гүйцэтгэлээр | Зэрлэг ан амьтдад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах бодлогын хүрээнд зэрлэг амьтдад зориулж 2021 онд 430 боодол өвс, 2022 онд 950 боодол өвс, 2023 1681 боодол өвс бэлтгэж шаардлагатай газруудад байршуулахад зориулан нийт 38,9 сая төгрөгийг зарцуулан био техникийн арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан нь өмнөх оноос 86.5 хувиар өссөн. Өргөн, Эрдэнэ сумдын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрөх Улаанбаатар төмөр замын 839, 914, 958 дугаар хэсэгт замын 2 талын 1500м тор авсан. Айраг, Сайншанд, Өргөн, Эрдэнэ сумдын нутаг дэвсгэрт 2022 онд 1200м, 2023 онд 2020м нийт давхардсан байрлалд нийт 3220м төмөр замын торыг авсан нь 2021 онтой хариуцуулахад 87,2 хувиар нэмж төмөр замын торыг нээсэн. “Оюу Толгой” ХХК-ийн дэмжлэгтэйгээр Байгаль зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг Монгол дахь төлөөлөгчийн газраас хэрэгжүүлж буй “Өмнийн говийн бүс нутагт хууль бус антай тэмцэх төсөл”-ийн хүрээнд Өргөн, Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах сумдад хөдөлгөөнт багаас 55 удаагийн эргүүл хяналт хийж, хууль эрх зүйн хэвлэмэл хуудас 600 ширхэг, байгаль орчны салбарын эсрэг хууль бус үйл ажиллагааны талаар дуудлага хүлээн авах 98701414 шуурхай утасны дугаар олон нийтэд таниулах нөлөөллийн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн “Тогтвортой зэрэгцэн оршихуй” сэдэвт хүрээлэн буй орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх олон нийтэд чиглэсэн цуврал арга хэмжээг зохион байгуулж Ерөнхий боловсролын 800 гаруй сурагчдад “Байгаль дээр зэрлэг амьтад хэрхэн амьдардаг болон тэдний үүрэг оролцооны талаар сургалт”, хууль бус агнуурын асуудлыг хөндсөн жүжигчилсэн үзүүлбэр, “Тогтвортой зэрэгцэн оршихуй” байгаль орчны гэрэл зургийн үзэсгэлэнг гарган нийт 1500 гаруй иргэд, олон нийтэд нээлттэйгээр танилцуулан нөлөөллийн ажлыг хэрэгжүүлсэн. | |
| 252 | 5.1.5. Хог хаягдлын менежментийг сайжруулж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжинэ. | 284. Зарим сумдын хог хаягдлыг ангилан төвлөрүүлэх, аюултай хог хаягдлыг цуглуулах цэг байгуулах | 2021 - 2024 | Төвлөрүүлсэн аюултай хог хаягдал- 100 тн | Төвлөрүүлсэн аюултай хог хаягдал | | 200тн | Хог хаягдлын менежментийг сайжруулж, дахин боловсруулах бодлогын хүрээнд Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумдууд хувийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хуучин хог хаягдлын төвлөрсөн цэгийг түрж дарж булшлан шинээр 3.75 га талбайд төвлөрсөн цэгийг байгуулан хашиж хамгаалах, камержуулах ажлыг гүйцэтгэж бусад сумдууд хогийг цэгийг түрж хумих талбайн хэмжээг бууруулах ажлыг гүйцэтгэж хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайг 139.6-аас 42 га талбайгаар бууруулж 97 га талбай болсон. Айраг, Иххэт, Замын-Үүд, Өргөн, Сайншанд сумдын 8 ерөнхий боловсролын сургуульд хадгалагдаж байсан хугацаа дууссан химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийн сав баглаа зэрэг 257 нэр төрлийн 1.1 тн аюултай хаягдлыг эрх бүхий этгээдэд шилжүүлэн журмын дагуу устгуулсан. "Аюулыг авдарлая" аяны зохион байгуулж 16 ерөнхий боловсролын сургуулийн 2000 гаруй сурагчид хамрагдаж ахуйн хэрэглээнээс гарч буй хугацаа дууссан эм бэлдмэл, гар утас таблет, зай, чихэвч, цэнэглэгч зэрэг 900кг аюултай хаягдлыг ангилж цуглуулан түр хадгалах газарт | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төвлөрүүлсэн. Аймгийн нутаг дэвсгэрт уул уурхай, зам барилга, авто засварын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 38 аж ахуйн нэгжийг аюултай хаягдал үүсгэгчийн бүртгэлд бүртгэж дугаар олгон давхардсан тоогоор 60 аж ахуйн нэгж 247.8 тн аюултай хаягдлыг журмын дагуу ангилж цуглуулан эрх бүхий үйлдвэрт нийлүүлж устгуулж дахин боловсруулсан. Аюултай хаягдлыг ангилах цуглуулах чиглэлээр Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт аюултай хог хаягдал түр хадгалах агуулахын барилга угсралтын ажлыг "Цонбонтоосго" ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 90% байна. Уул уурхай олборлолт, баяжуулалт, хүнд даацын авто замын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аюултай хаягдал үүсгэгч 5 аж ахуйн нэгжийн үүсгэгчийн бүртгэж нэгдсэн дугаар олгосон. Уул уурхайн олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулдаг 3 аж ахуйн нэгж 7.8 тн аюултай хаягдлыг эрх бүхий үйлдвэрт нийлүүлж журмын дагуу устгуулж дахин боловсруулсан. | |
| 253 | | 285. Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах арга хэмжээг хэрэгжүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих | 2021 - 2024 | Үйлдвэрийн тоо-1 /Сайн Шанд/ Дахин боловсруулсан хог-270тн | Үйлдвэрийн тоо Дахин боловсруулсан хог | | Үйлдвэрийн тоо-1 /Замын-ҮҮД/, Дахин боловсруулсан хог-1500тн автопарк шинэчлэлийн тоо-1 | Хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрүүд болон төв суурин газруудын ойр орчмын 7000га талбайн ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулан 19000 аж ахуйн нэгж байгууллага, 13000 иргэн, ажилтан, албан хаагчид, 29 автомашин техник хэрэгсэлтэйгээр 1400тн хог хаягдлыг цэвэрлэсэн. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах цуглуулах, дахин боловсруулах чиглэлээр "Нээлттэй Дорноговь" арга хэмжээ, "Говийн V дугаар ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойн баяр" наадмаар "Өв соёлоо дээдлэж “Цэвэрхэн наадацгаая" зэрэг олон нийтийг | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хамарсан томоохон арга хэмжээнүүд болон сумдын хэмжээнд 28 удаагийн сургалт сурталчилгаа нөлөөллийн ажил зохион, 1000 орчим гарын авлага материал түгээн мэдээллээр хангахаас гадна, цахим сүлжээнд 5 удаагийн видео танилцуулга, 10 төрлийн шторк боршурыг цахимд байршуулан мэдээлэл хүргэснээр худалдаа, үйлчилгээний 35 газар, 2 зах, 10 нийтийн орон сууц, 10 сургууль, 15 цэцэрлэг, 30 аж ахуйн нэгж байгууллага хогоо ангилж хэвшсэн. "Эко Говь" хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн гадна цахилгаан хангамжийн ажил, дахивар хайлуулах төхөөрөмж, сургалтын мини тоног төхөөрөмж зэрэг үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажилд 70,0 сая төгрөгийн дэмжлэг, “Говийн ногоон сургууль” төслийг хэрэгжүүлэхэд 19,5 сая төгрөгийн дэмжлэгийг аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас тус тус санхүүжүүлж бодлогоор дэмжиж ажилласан.Мөн жижиг дунд, үйлдвэрийг дэмжих сангаас “Омбол оюу ундарга” ХХК хүнсний зориулалтын сав, баглаа боодлын үйлдвэр, үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авахад зориулан 300.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож дэмжсэн. 2021-2024 онд хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөвөрлөх зардал, машин техник, тоног төхөөрөмжийн зардал, хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрт олгосон дэмжлэг, төвлөрсөн хогийн цэгийг тохижуулж, хашаажуулах зардал, хог хаягдал ялган ангилалтын арга хэмжээнд улс, орон нутгийн төсвийн нийт 1,9 тэрбум төгрөг зарцуулсан. | |
| 254 | 5.1.6. “Ногоон Дорноговь” арга хэмжээг хэрэгжүүлж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ. | 286. Ногоон байгууламжийг нэмэгдүүлж, мод тарьж, ургуулсан иргэд, аж ахуйн | 2021 - 2024 | Тарьсан модны тоо-32000, Урамшуулсан иргэд, ААНБ-15 | Тарьсан модны тоо Урамшуулсан иргэд, ААНБ-ын тоо | | 40000 10 | Орон нутгийн төсвийн хөрөнгийн 80,0 сая төгрөгийн санхүүжилтээр 108 га талбайд “Говь парк” цэцэрлэгт хүрээлэн”-ийн зураг төсвийн ажлыг “Онч тэнхлэг” ХХК-иар гүйцэтгүүлж, 30 | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэгжийг дэмжиж, урамшуулах, | | | | | | ААН, байгууллагын 423 ажилтан, албан хаагчдын оролцоотой 2 төрлийн 8350 ширхэг мод тарьж ногоон байгууламжийн хэмжээг 2 га талбайгаар нэмэгдүүлж, 2700 метр хашаажуулах ажлыг 95.2 сая төгрөгийн санхүүжилтээр "Ховд сафари" ХХК, "Гүний худаг гаргах, нөөцийн сав байрлуулах" ажлыг 70.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Эрхэст ундарга" ХХК-иуд гүйцэтгэж, иргэдийн ая тухтай амарч зугаалах цогцолбор байгуулах ажлын эхлүүлсэн. Нийтийн эзэмшлийн 41 га талбайд 10 төрлийн 78330 ширхэг мод, 487 айл өрх, 92 аж ахуйн нэгж байгууллага өөрийн эзэмшлийн газартаа 10 төрлийн 69236 ширхэг модыг тарьснаар аймгийн хэмжээнд нийт 180104 ширхэг мод, бут сөөгийг шинээр суулгаж, 358 аж ахуй нэгж, байгууллага, 3786 иргэд оролцон ногоон байгууламжийн хэмжээг 98.2 га талбайгаар нэмэгдүүлсэн. Шинээр Сайншанд сумын 1 иргэнд 5 га, 1 байгууллагад 4 га газрыг Мод үржүүлгийн газрын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн. Аймгийн нутаг дэвсгэрт нийт 10 иргэн, аж ахуй нэгж, байгууллагууд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна. Ойн ангийн хүчин чадлыг нэмэгдүүлэх үүднээс сумын орон нутгийн төсвийн 64,0 сая төгрөгийн хөрөнгөөр тарьц, суулгац, үрсэлгээ хадгалах зориулалттай "Үрсэлгээ хадгалах зоорь"-ийг шинээр барьсан. 2021-2023 онд аймгийн хэмжээнд нийт 420000 гаруй мод тарьж, уг ажилд 10800 гаруй иргэн, 960 гаруй аж ахуйн нэгж байгууллага оролцож, 90 хувийн ургалттайгаар төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, 10 аж ахуйн нэгж, байгууллага, 93 өрхийг 32,4 сая төгрөгөөр урамшуулсан. | |
| 255 | | 287. "Монгол орны хуурай бүс нутгаас | 2021 - 2024 | Хэрэгжүүлсэн төслийн тоо 1 | Хэрэгжүүлсэн төслийн тоо | | 1 Таримал ойн зурвас 1 га | НҮБ-ийн цөлжилттэй тэмцэх конвенц, БОАЖЯ-тай хамтран "Монгол орны | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үүдэлтэй элсэн ба шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах төсөл"-ийг дэмжин ойн ангийн үйл ажиллагааг тогтмолжуулж, ойн зурвасыг нэмэгдүүлэх | | Үзүүлсэн дэмжлэгийн тоо 2 Ойн зурвас 1 га | Үзүүлсэн дэмжлэгийн тоо Ойн зурвасын хэмжээ | | | хуурай бүс нутгаас үүдэлтэй элсэн ба шороон шуурганаас хамгаалах, нөлөөллийг бууруулах" төслийн хүрээнд Замын-Үүд суманд 13,4 га талбайд ойн анги байгуулагдаж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 2023 онд хүлэмжид үрээр Агч, Буйлс, Жигд, Чонон хармаг, Цагаан харгана, Гүйлс, Нарс, Өрөл, Далан хальс, Хайлаас, Чимэглэлийн тоор, Олон цэцэгт сухай, Мөнгөлөг улиас, Бургас зэрэг 14 төрлийн модлог ургамал мөн гадаа талбайд улаан сухай 30,000 ширхэг, бургас 800 ширхэг, мөнгөлөг улиас 1,000 ширхэг тус тус мөчрөөр тариалалт хийсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад үйл ажиллагааг өргөжүүлж, үржүүлсэн тарьц суулгацын хэмжээг 15242 ширхэгээр нэмэгдүүлж 64%-иар өссөн. Мөн Эрдэнэ сумын Еншөөв багийн Ар цац нэртэй газарт "Шамбала-2056" төслийн хүрээнд 6 га газарт 10000 модыг тариалж ойн зурвасыг бий болгож, тус газарт 4 төрлийн 10000 гаруй модыг үржүүлж байна. Аймгийн хэмжээнд тариалангийн талбайн хамгаалалтын зурваст- 2895 ширхэг мод, булаг шанд, хөв цөөрмийг хамгаалахад 5730 ширхэг мод, автозамын хамгаалалтын зурваст- 7933 ширхэг, төмөр замын хамгаалалтын бүсэд 480 ширхэг, нийт 17038 ширхэг, нэгдсэн дүнгээр 58838 мод, бут сөөгийг тарьж хамгаалалтын зурвасыг нэмэгдүүлсэн. | |
| 256 | | 288. Мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг дэмжиж, заган ой, ховор ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх ажилд иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог идэвхжүүлэх, | 2021 - 2024 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо-1 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 2 | Аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 76,0 сая төгрөгийн санхүүжилтээр 40х8 метрийн хэмжээтэй 3 улирлын хүлэмжийг барьж өвлийн хучилга, усалгааны системийг холбож хайлаасыг үрээр тарьж 14000 ширхэг үр цухуйж, өсөлт 12 см-тай байна. Нарны сэргээгдэх эрчим хүчний насосыг суурилуулж, 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр 7 тонны багтаамжтай 3 ширхэг нөөцийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | савыг байрлуулж талбайн усалгааны асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Сайншанд сумын “Буянт ухаа” мод үржүүлгийн талбайд 2 хүлэмж шинээр барьж ашиглалтад оруулснаар цэцгийн мандал, модны тарьц суулгацыг бэлтгэх боломжийг бүрдүүлсэн. Шинээр Сайншанд сумын 1 иргэнд 5 га, 1 байгууллагад 4 га газрыг олгосноор аймгийн хэмжээнд мод үржүүлгийн 10 талбайтай болсон. Дээрх газруудын үйл ажиллагааг дэмжиж чиглэлээр нийт 10 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, Сайншанд сумын 2-р багт мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Арвин РММС" ХХК-иас 6 төрлийн 14387 ширхэг модыг, 63.2 сая төгрөгөөр, Замын-Үүд сумын ойн анги "Борхойн баянбүрд" ОНӨААТҮГ-аас 3 төрлийн 8300 ширхэг модны суулгацыг 27.7 сая төгрөгөөр худалдан дэмжсэн. “Борхойн баянбүрд” ОНӨААТҮГазар нь 2023 онд хүлэмжид үрээр агч, буйлс, жигд, чонон хармаг, чимэглэлийн тоор, мөнгөлөг улиас, бургас зэрэг 14 төрлийн модлог ургамал, гадаа талбайд мөчрөөр улаан сухай, бургас, мөнгөлөг улиасыг 31800 ширхэгийг тус тус тариалсан. Аймгийн хэмжээнд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 7 аж нэгж, байгууллага нь 2023 онд үрээр 63573 тарьц, суулгац, 43000 ширхэг модлог мөчрөөр үржүүлэг хийж, нийт 13 төрлийн 96573 ширхэг тарьц, суулгацыг ургуулсан нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад үржүүлсэн тарьц, суулгацын хэмжээг 46518 ширхэгээр нэмэгдүүлж, 2 дахин буюу 92,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | |
| 257 | 5.1.7. Уул уурхайн олборлолт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил болон эзэн холбогдогчгүй эвдэрсэн газрыг нөхөн сэргээх | 289. Эзэн холбогдогчгүй эвдэрсэн газрын тооллого, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай | 2021 - 2024 | Хамтран зохион байгуулсан арга хэмжээний тоо 3 Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ 39,8 га | Хамтран зохион байгуулсан арга хэмжээний тоо Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | | 2 10 га | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмал олборлогч иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын тооллого хийж нөхөн сэргээлтийн зардлыг тооцох ажлыг Дорнын | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | хамтран тогтмол зохион байгуулж, нөхөн сэргээлтийг үе шаттайгаар хийх, | | | | | | байгаль ХХК-иар гүйцэтгүүлж байна.Урьдчилсан байдлаар аймгийн хэмжээнд 77 байршилд 599 га талбай бүртгэгдсэн. Тус аймгийн Айраг, Даланжаргалан, Өргөн, Иххэт сумын нутагт уул уурхайн олборлолт, баяжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Мин ли да ХХК, Монголын алт ХХК, Фриенд шип ресурс ХХК, Билэгт баялаг ХХК, Монголиан флюор спар ХХК, Чулуун завод ХХК, Ачир ХХК, Пауэрлэнд ХХК, Тэнүүн байгаль ХХК, Ялгуун интернэшнл ХХК, Монцемент Баянтэгш ХХК, Хөхбишрэлт ХХК-иуд нь "Яшил", “Майхан дэл” , "Хөх өндөр", "Хонгор", "Баруун бурхант", "Сээрийн булаг", "Хар толгой", "Хавцгай", Баруун хошуу нэртэй газруудад 14.18 га талбайд 46139,5 мянган төгрөгийн зардлаар эзэнгүй орхигдсон газарт дүйцүүлэн хамгаалахаар техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгч актаар баталгаажуулсан байна. 2021 онд 71.3 га, 2022 онд 54.7 га, 2023 онд 14.18 га, нийт 140.18 га талбайд техник болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байгаа нь 71.5 хувийн хэрэгжилттэй байна. | |
| 258 | | 290. Уул уурхайн олборлолт болон төмөр зам, автозам, барилга байгууламж барихтай холбоотой эвдэрсэн газруудыг нөхөн сэргээх | 2021 - 2024 | Нөхөн сэргээлтийн хувь 100 | Нөхөн сэргээлтийн хувь | | 100% | Айраг, Даланжаргалан, Өргөн сумын нутагт уул уурхайн олборлолт, баяжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Мин ли да” ХХК, “Монголын алт” ХХК, “Фриендшип ресурс” ХХК, “Билэгт баялаг” ХХК, “Монголиан флюор спар” ХХК, “Чулуун завод” ХХК, “Ачир” ХХК, “Пауэрлэнд” ХХК, “Тэнүүн байгаль” ХХК, “Ялгуун интернэшнл” ХХК, “Монцемент” ХХК зэрэг компаниуд 46.1 сая төгрөгөөр "Яшил", “Майхан дэл” , "Хөх өндөр", "Хонгор", "Баруун бурхант", "Сээрийн булаг", "Хар толгой", "Хавцгай" “Баруун хошуу” нэртэй газруудад эзэнгүй орхигдсон 14.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж ургамал сэргэн ургах | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | боломжийг бүрдүүлсэн. Хатанбулаг сумын Агаруут, Эргэл багийн нутагт Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 484.4км хүнд даацын авто зам байгуулах төслийн ажилд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын 8 карьерийн 11.6 га талбайн нөхөн сэргээлтийг сумаас ажлын хэсэг ажиллан хүлээн авсан. Уул уурхайн олборлолт болон төмөр зам, автозам, барилга байгууламж барихтай холбоотой 2020 онд 226.65 га талбай, 8.7 га талбайд биологийн нөхөн сэргээлт, 2021 онд 71.3 га, 2022 онд 54.7 га, 2023 онд 25.83 га буюу нийт 151.83 га талбай эвдрэлд орж уг газруудад техник болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн нь 77.4 хувийн хэрэгжилттэй байна. | |
| 259 | 5.1.8.. Сайн дурын байгаль хамгаалагчдыг дэмжиж, байгаль орчны чиглэлээр ажиллах иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлнэ. | 291. Иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлэх | 2021 - 2024 | Зохион байгуулсан сургалтын тоо-3, хамрагдсан хүний тоо 3600 | Зохион байгуулсан сургалтын тоо хамрагдсан хүний тоо | | 3 7000 | “Мод тарих”, “Биологийн олон янз байдлыг хамгаалах, хулгайн антай тэмцэх”, “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох”, “Аюултай хог хаягдал”, “Усны зохистой хэрэглээ” зэрэг 10 төрлийн сэдвээр танилцуулга мэдээлэл, байгаль орчны салбарын үйл ажиллагааны талаар цахимд байршуулж олон нийтэд хүргэсэн нийт 12000 гаруй хүн үзэж сонирхсон. Мөн JIC олон улсын байгууллагатай хамтран Сайншанд сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад “Ногоон ирээдүй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан нийт 900 сурагч хамрагдсан. “Цэвэр ус цэнхэр алт”, “Бэлэн бай”, “Байгаль орчноо хамгаалахад бидний оролцоо”, “Мод тарихын ач холбогдол”, “Ус бидний ирээдүй”, “Гэрэлт ирээдүйн төлөө аюулыг авдарлая-2”, “Clean up” гэх мэт экологийн боловсрол олгох 24 арга хэмжээнд 3,860 гаруй сурагч, Зэрлэг амьтны эд эрхтэн худалдаалах, хулгай антай тэмцэх төслийн хүрээнд хилийн цэргийн 40 алба хаагч, Айраг, Иххэт, Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн, Эрдэнэ, Сайншанд сумдын 150 гаруй малчин өрхөд | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | “Амьтны тухай” хууль эрх зүйн мэдээллийг хүргэж байгаль орчны эсрэг хууль бус үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах утасны дугаартай түлхүүрийн оосор тарааж ажилласан. | |
| 260 | | 292. Сайн дурын идэвхтэн байгаль хамгаалагчдыг ажиллуулж, урамшуулах | 2021 - 2024 | Томилогдсон хүний тоо-24 | Томилогдсон хүний тоо | | 20 80% | Аймгийн хэмжээнд улс болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулах зорилгоор 31 байршил газрын 584037.51 га талбайг эзэнжүүлж 55 иргэнийг идэвхтэн байгаль хамгаалагч томилон ажиллаж байгаа нь 2021 онтой харьцуулахад байгаль хамгаалах иргэдийн тоо 196.4 хувиар өссөн байна. Иххэт, Өргөн, Эрдэнэ, Хатанбулаг, Мандах сумдын ан агнуурын бүс нутгийг иргэдийн нөхөрлөлийн гишүүд, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн 92 малчин өрх, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн 1017 малчин өрхийн гишүүд иргэдийн нөхөрлөлийн гишүүдээс сайн дурын идэвхтэй байгаль хамгаалагчаар томилон ажиллуулах тухай сумдын ЗДТГ болон ААНБ-д зөвлөмж хүргүүлсэн.  Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа, Их нартын байгалийн нөөц газрын тусгай хамгаалалттай газрын захиргааны байгаль хамгаалагчийн ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн 7,0 сая төгрөгийн хөрөнгөөр 2 мотоциклыг шинээр олгосон. | 90% |
| 261 | 5.1.9. Аймгийн Тусгай хамгаалалттай газар нутгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж, газар нутгийн хэмжээг нэмэгдүүлнэ. | 293. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг 32 хувьд хүргэж, холбогдох мэдээллийн санд бүртгүүлэн баталгаажуулж, хамгаалалтыг сайжруулах | 2021 - 2024 | Нутаг дэвсгэрийн эзлэх хувь-31.8, тэмдэгжүүлсэн газрын | Нутаг дэвсгэрийн эзлэх хувь тэмдэгжүүлсэн газрын тоо | | 32% 10 | Аймгийн хэмжээнд 2021 оны байдлаар улсын тусгай хамгаалалттай газар нутаг 811024.36 га, аймгийн тусгай хамгаалалттай газар нутаг 662799,69 га, сумын тусгай хамгаалалттай 1984323,5 га талбайг тус тус эзэлж аймгийн нийт нутаг дэвсгэрийн 31.5 хувийг тусгай хамгаалалттай газар нутаг эзэлж байна. 2022-2023 оны байдлаар улсын тусгай хамгаалалттай нэр бүхий 15 газар 811024.36 га, аймгийн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тусгай хамгаалалттай нэр бүхий 32 газар 665360,95 га, сумын тусгай хамгаалалттай нэр бүхий 64 газар 2048454,1 га аймгийн нийт нутаг дэвсгэрийн нийт 32.2 хувийг эзэлж байгаа нь тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь 0,69 хувиар өссөн байна. Улаанбадрах сумын нутаг дахь “Баянбогд уул”-ыг Улсын тусгай хамгаалалтад авах саналыг Монгол Улсын Ерөнхий сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлснээр Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 40 дүгээр хуралдаанаар хэлэлцэж уг асуудлыг судалж, холбогдох хууль тогтоожийн дагуу шийдвэрлэхийг Байгаль орчин, жуулчлалын сайдад чиглэл өгсөн. Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор Улсын тусгай хамгаалалтад байх шаардлагатай 3 газар, орон нутгийн тусгай хамгаалалтад оруулах 16 газрын эргэлтийн цэгийг баталгаажуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны А/665 дугаар захирамжаар томилж, тусгай хамгаалалтад авах газруудын саналын хүрээнд Алтанширээ, Иххэт, Сайншанд, Эрдэнэ сумдын нэр бүхий 7 газрын 166,385.8 га талбайн орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар төлөвлөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн. | |
| 262 | | 294. Газар доорх усны орд, усан сан бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах | 2021 - 2024 | Хамгаалалтад авсан усан сан бүхий газрын тоо-1 | Хамгаалалтад авсан усан сан бүхий газрын тоо | | 1 | Сайншанд сумын нутаг дэвсгэрийн усан хангамжийн эх үүсвэр болох Зээгийн хөтлийн газрын доорх усны ордын тэжээгдлийн мужийг усан сан бүхий байгалийн нөөц газрын ангиллаар аймгийн тусгай хамгаалалтад авч, хамгаалалтын дэглэм мөрдүүлэх ажилд хяналт тавьж 2 удаагийн сургалт сурталчилгааг зохион байгуулж давхардсан тоогоор 856 иргэн хамрагдсан. Сумын Иргэдийн Төлөөлгчдийн Хурлын 2022 оны 7/39, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 7/40, 7/41 дугаартай "Зарим газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай" тогтоолуудаар Хайлсан шанд, Холбоогийн уул, Баянбуурал нэртэй 28476.23 га газруудыг байгалын унаган төрх, өвөрмөц тогтоц бүхий түүх соёлын дурсгалт газар ангиллаар 30 жил орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, тухайн талбайг Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын бүртгэлд бүртгүүлсэн.  Өргөн, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан сумдын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн худгийн хамгаалалтын бүстэй 131 газар давхцалтай, 13 сумдын 86 булаг, ашигт малтмалын 46 тусгай зөвшөөрөлтэй талбай, 111 нуур, тойром ашигт малтмалын 44 тусгай зөвшөөрөлтэй давхцалтай байгаа тул иргэн, аж ахуйн нэгжүүдэд сонсох ажиллагааг явуулж, давхцалыг арилгуулж, шаардлагатай газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сумд ажиллаж байна. | |
| 6. Орон нутаг, хөдөөгийн хөгжил | | | | | | | | | |
| 263 | 6.1.1. Орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | 295. Зарим сумдын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах буюу өөрчлөлт оруулах. | 2021 - 2024 | ЕТ хийгдсэн сумын тоо 11, Шинээр хийгдэх сумын тоо 2, Өөрчлөлт оруулах сумын тоо 1. | ЕТ хийгдсэн сумын тоо 11, Шинээр хийгдэх сумын тоо 2, Өөрчлөлт оруулах сумын тоо 1. | | 1 | Аймгийн хэмжээнд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй 4, хийгдээгүй 10 сум байгаа ба төлөвлөгөө хийлгэх шаардлагатай сумдад шаардагдах зардлын асуудлыг шийдвэрлэх үүрэг чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэн ажиллалаа. Айраг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 62.0 сая төгрөгийн санхүүжилтээр 2040 он хүртэлх хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Инженер геодези” ХХК гүйцэтгүүлж Барилгын хөгжлийн төвд хянуулан сумын ИТХ-ын 2022 оны 08/05 дугаартай тогтоолоор ерөнхий төлөвлөгөөг баталсан.  Өргөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн 34.0 сая төгрөгийн  санхүүжилтээр 2040 он хүртэлх хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | "Тэнжин" ХХК гүйцэтгүүлж, 380 га газрыг хамруулан төлөвлөлтийг хийж байна. Орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд сумын 1, 2, 3, 4, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 332 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг “Инженер геодези” ХХК гүйцэтгүүлсэн. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын газрыг дахин зохион байгуулж, төвлөрсөн инженерийн хангамжид холбогдсон “Тохилог орон сууц” амины орон сууцны хорооллыг төлөвлөсөн. Замын-Үүд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2030 он хүртэл хугацаатайгаар төлөвлөж 3 дугаар багт 48 га талбайд шинэ суурьшлын бүс байгуулахаар шийдвэрлэж, зураг төслийг боловсруулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн хэсэгт 50, 150 хүүхдийн цэцэрлэг, Иргэдийн хөгжлийн төвийн барилгууд баригдаж 1.1 км автозам, 2.6 км дугуйн зам барих ажил хийгдсэн. | |
| 264 | | 296. Сайншанд, Замын-Үүд сумдын суурьшлын бүсэд хот хөгжлийн хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулж, дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | ЕТ-ний тодотгол хийгдэж буй сум 1, | ЕТ-ний тодотгол хийгдэж буй сум 1. | | 2 | Орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус сумын 1, 2, 3, 4, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 332 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 11/13 дугаар тогтоолоор батлуулсан. Энэхүү хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Сайншанд сумын 6, 7 дугаар багуудыг холбосон 3.5 км авто зам, 7 дугаар багт 1.1 км автозамуудын барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Сайншанд сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт "Тэс петролиум" ХХК-ийн урд талд Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан 2 жил дараалан газрыг зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулаагүй | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үндэслэлээр 149 иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтын газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, 1100 айлын орон сууц, 960 суудалтай ерөнхий боловсролын сургууль, 150 хүүхдийн цэцэрлэг барих 16.7 га газрыг чөлөөлж, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Дэнжийн хэсэгт хуучин 2 барилгыг дахин төлөвлөлтөд оруулж “170 айлын орон сууц” барих төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөлт хийгдсэн. Замын-Үүд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2030 он хүртэл хугацаатайгаар төлөвлөж 3 дугаар багт 48 га талбайд шинэ суурьшлын бүс байгуулахаар шийдвэрлэж, зураг төслийг боловсруулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн хэсэгт 50, 150 хүүхдийн цэцэрлэг, Иргэдийн хөгжлийн төвийн барилгууд баригдаж 1.1 км автозам, 2.6 км дугуйн зам барих ажил хийгдсэн. | |
| 265 | | 297. Сумдад “Тэгш гудамж” төсөл хэрэгжүүлнэ | 2022 - 2024 | - | - | | 1 | Аймгийн ИТХ-ын 2022 оны 10/09 дүгээр тогтоолоор "Сайншанд сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө"-г батлуулж хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймаг, сумын Засаг даргын шийдвэрээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлсэн боловч газар эзэмшигч нь тухайн газраа зориулалтын дагуу ашиглаагүй газруудыг дахин зохион байгуулалтад оруулж, төвлөрсөн инженерийн хангамжид холбогдсон нийтийн болон амины орон сууцны хороолол барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Сайншанд сумын ИТХ-ын 2021 оны 04/01 тогтоолоор гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах дахин төлөвлөх, төсөл хэрэгжүүлэх газрын байршлыг батлан Сайншанд сумын 7-р багийн нутаг дэвсгэрт шинээр суурьшлын бүс үүсгэх ажлын хүрээнд нисэхийн хэсэгт 317 өрхийн 30.37 га газарт дахин зохион | 50% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгуулж, ОНТ-ийн нийт 12.2 тэрбумын хөрөнгө оруулалтаар дулаан станц, цэвэр, бохир усны шугам, 1.59 км автозам, дахин зохион байгуулалтад хамрагдсан айл өрхийг цахилгаан эрчим хүчинд холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Замын-Үүд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2030 он хүртэл хугацаатайгаар төлөвлөгдсөн ба энэхүү ерөнхий төлөвлөгөөг үндэслэн 3 дугаар багт 48 га талбайд шинэ суурьшлын бүс байгуулахаар шийдвэрлэж хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн хэсэгт 50, 150 хүүхдийн цэцэрлэг, Иргэдийн хөгжлийн төвийн барилга, 1.1 км автозам, 2.6 км дугуйн зам баригдсан ба Соёл урлагийн ордон, 640 хүүхдийн сургууль, Өрхийн эмнэлгийн барилгуудыг барьж байна. “Тэгш гудамж” төслийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд Сайншанд суманд 160.0 сая төгрөгөөр 25 айл,  2022 онд Сайншанд суманд 40.0 сая төгрөгөөр 7 айлын хашааг шинэчилсэн. Түүнчлэн улсын төсвийн хөрөнгөөр Замын-Үүд сумын Хилчин багийн нутаг дэвсгэрт байрлах гэр хорооллыг дахин зохион байгуулалтад оруулж, 640 м авто зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг шинээр байгуулах ажлыг 1063.0 сая төгрөгөөр “Ди Вай Кей Би” ХХК гүйцэтгэж байна. | |
| 266 | | 298. Сайншанд суманд "Шинэ найрамдал" суурьшлын бүс байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулах. | 2023 - 2024 | - | - | | 0.0 | Орон нутгийн төсвийн 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 1, 2, 3, 4, 6, 7, 8 дугаар багуудад хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулсан. Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 11/13 тоот "Дахин төлөвлөлтийн газрын байршил,хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоох" тухай тогтоолоор Сайншанд сумын 7 дугаар багт Найрамдал хэсэгт 16,7621 га газар дахин төлөвлөлтөд оруулж | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | баталсан. | |
| 267 | | 299. “Хашаандаа сайхан амьдаръя" санаачлагын хүрээнд амины орон сууц, гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажпыг төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр хийх ажлыг үргэжлүүлэх. | 2021 - 2024 | 0 | 0 | | 50 | Дорноговь аймгийн 12 сум нь төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон ба Сайншанд сумын гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Орон нутгийн төсвийн 647,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 4, 6, 8-р багийн гэр хорооллын гудамжаар цэвэр усны шугам татах, Алтанширээ сумын төвийн нийтийн орон сууцыг гадна дулаан цэвэр усны шугамд холбох ажлуудыг "Ингүүмэл-Оргил" ХХК, "Чандмань-Илч" ХХК, "Ивээлт баян буурал" ХХК-ууд гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Шинээр баригдсан инженерийн шугам сүлжээнд 162 айл өрх холбогдох боломж бүрдсэн ба одоогоор 64 айл холбогдоод байна. Орон нутгийн төсвийн 816.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улаанбадрах сумын нэгдсэн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлыг "Түрүү гарав" ХХК гүйцэтгэж байна. Уг инженерийн шугам сүлжээ ашиглалтад орсноор 8 орон сууцны 31 айл төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломж бүрдэнэ. Иххэт сумын шинэ суурьшлийн бүс болох “Барга” хороололд 04 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг орон нутгийн төсвийн 344,8 сая төгрөгийн хөрөнгөөр "ЭРЧИМ” ХХК гүйцэтгэж, 254 өрх цахилгааны эх үүсвэрт холбогдох нөхцөлийг бүрдүүлсэн. Сайншанд сумын 7 дугаар багт Дулааны эх үүсвэр барих ажлыг орон нутгийн төсвийн 3,8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Чандмань-Илч” ХХК гүйцэтгэж, “Мандах наран-5” орон сууцны хорооллын 1000 айлын орон сууцыг хангахаас гадна Нисэх болон Өлзийт хорооллын 330 айл өрхийг төвлөрсөн дулаан хангамжид холбох нөхцөлийг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүрдүүлсэн. Түүнчлэн орон нутгийн төсвийн 199,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандах, Сайхандулаан сумдын төвд төвлөрсөн халаалт, цэвэр, бохир усны шугам барих ажлын зураг төсвийг "Хайдро дизайн прожект" ХХК нь гүйцэтгэж, зураг төслийг Барилгын  хөгжлийн төвд магадлал хийлгэхээр хүргүүлсэн. Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд 2023 онд 12 сумын 340 өрх холбогдсон нь өмнөх оноос 91-ээр, 2020 онтой харьцуулахад 194 өрхөөр хувиар тус тус өссөн. | |
| 268 | | 300. Хот, суурин газруудад үерийн ус зайлуулах сувагчлалыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжлүүлэх. | 2022 - 2024 | Зураг, төсөл хийгдсэн Шинээр барьсан сувагчлалын тоо 1,1 км. | Зураг, төсөл хийгдсэн Шинээр барьсан сувагчлалын тоо 1,1 км. | | 100% 0,5 км | Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН3388 төслөөр хэрэгжсэн “Дорноговь аймгийн Цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ”-ний ажил гүйцэтгэх А1.2.2-2021/84 дугаартай гэрээний нэмэлт өөрчлөлтийн дагуу 640.6 сая төгрөгийн санхүүжилтээр “Дорноговь аймгийн Сайншанд сумын үерийн хамгаалалтын барилга байгууламж, замын ус зайлуулах шугамын ажил”-ыг 2022 онд “Компорт импекс” ХХК гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд Сайншанд сумын 1, 6-р багийн нутаг дэвсгэрт 520 м урттай борооны ус зайлуулах шугам хоолой, 380 м урттай үерийн хамгаалалтын суваг хийгдсэн. Тайлант  хугацаанд Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр төв цэнгэлдэх хүрээлэн орчимд 1.3 км шуудуу, 150 м үерийн усны авто замын суваг, авто замын доорх ус зайлуулах хоолойг байгуулах ажлыг орон нутагт барилга бүтээн байгуулалт хийж буй аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагын хамтран гүйцэтгэсэн.  Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр Сайншанд сумын үерийн усны суваг, далан, шуудууны зураг төсөл боловсруулах ажлыг тусгаж, зураг төсөл боловсруулах | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тендерийг зарласан боловч оролцогчдоос Сангийн яаманд 2 удаагийн гомдол гарсны улмаас тендер хүчингүй болж, 2024 оны орон нутгийн төсөвт дахин тусгаж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. 2020 онтой харьцуулахад үерийн усны далан, шуудуу, сувагчлалыг 2350 м-ээр нэмэгдүүлсэн. | |
| 269 | | 269. Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулах, тохижуулах ажил хийнэ. | 2021 - 2024 | | | | | Сайншанд сумын 4, 7 дугаар багт төмөр замын гармаас Оргил худалдааны төвийн уулзвар хүртэл 2.4 км автозамд гэрэлтүүлэг шинээр хийх ажлыг 494.0 сая төгрөгөөр “Лэдсити” ХХК, Сайншанд сумын 7-р багт энэ онд 509, 509а байрны нийтийн эзэмшлийн талбайд бетон авто зогсоол байгуулах ажлыг 256.4 сая төгрөгөөр “Айсуй хөгжил” ХХК энэ онд тус тус хийж гүйцэтгэсэн. 2021 онд Сайншанд сумын 4-р багийн 34-36, 43-44, 87-91, 93-94-р байруудын дулааны шугам сүлжээ угсрах ажил 170.0 сая, 2022 онд Сайншанд сумын 4 дүгээр багийн нутагт 154 дүгээр байрны дээврийн засвар, 2021 онд Сайншанд сумын 6 дугаар багийн Чойлонгийн гудамжинд цэвэр, бохир усны төв шугам татах ажил 166.7 сая, Сайншанд сумын 3-р багийн гэр хорооллын гудамжаар 1050 м цэвэр, бохир усны шугам 82.4 сая төгрөг, 2022 онд Мандах наран хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил 3.9 тэрбум, Саран хөхөө театр, “Мандах наран-5” орон сууцны хорооллын гадна дулаан, цэвэр ус, бохир усны шугам сүлжээний ажил 2.3 тэрбум, цахилгаан хангамж, дэд станцын 622.3 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэсэн. Алтанширээ суманд Спорт заал барих ажлыг гүйцэтгүүлэхээр 2024 оны төсөвт 2.0 тэрбум төгрөг тусгасан. Сум, суурин доторх авто зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, гудамж гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 9,2 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 байршилд 300 гаруй машины багтаамжтай авто зогсоол шинээр байгуулсан. Улсын болон орон нутгийн төсвийн 22,7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр аймгийн хэмжээнд нийт 29,7 км авто зам, 1,4 км дугуйн болон явган хүний замыг шинээр барьж Сайншанд-Хамарын хийд чиглэлийн автозамыг нөхөж, сэргээн засварлах ажлыг гүйцэтгэсэн. Аймгийн хэмжээнд 9 байршилд тоглоомын талбай болон нийтийн эзэмшлийн талбайг байгуулан тохижуулж иргэд зорчигчдын эрүүл, аюулгүй орчинд зорчих, нийтийн эзэмшлийн талбайн ашиглалт, өнгө үзэмж сайжрах, хөдөлгөөний аюулгүй байдал, иргэд дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх боломжийг бүрдүүлсэн. | |
| 270 | 6.2.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөтөлбөр, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлнэ. | 6.2.1. Шилжин ирэгсэдийг дэмжсэн "Нээлттэй аймаг" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх | 2023 - 2024 | | | | | “Нээлттэй Дорноговь аймаг хөтөлбөр”-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11/01 тоот тогтоолоор батлуулж сумдын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэхээр тусгагдсан газрын тодорхой хувийг олгохоор төлөвлөж, мэдээллийг улс болон орон нутгаас зохион байгуулсан. Хөдөөгийн сэргэлт чуулган, Нээлттэй Дорноговь чуулганаар иргэд, олон нийтэд танилцуулж ажилласан. Нийслэлээс хөдөө орон нутагт шилжин суурьшсан 7 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлсэн бол 6 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлсэн. Аймгийн хэмжээнд гэр бүл, худалдаа бүх төрлийн үйлчилгээ, үйлдвэрлэлийн зориулалтаар олгогдох газрууд, бүрдүүлбэл зохих баримт бичиг, хандах албан тушаалтны талаарх мэдээллийг иргэдэд ойлгомжтой байдлаар бэлтгэн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | аймгийн Цахим хөгжил, харилцааны хэлтсийн цахим системд байршуулж ажилласан. | |
| 271 | | 6.2.1.2. Орон нутагт иргэдийг шилжин суурьшихад дэмжих, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | 2023 - 2024 | | | | | Аймгийн Засаг даргын 2023 оны А/595 дугаар захирамжаар "Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших аж ахуйн нэгж, иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах ажлын хэсэг"-ийг байгуулан ажиллав. Тус ажлын хэсэг "Нээлттэй аймаг" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж, АИТХ-ын 2023 оны 12/02, 12/03 дугаар тогтоолын хүрээнд "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах журам", "Түрээсийн орон сууцны сум, баг, байгууллагад олгох хувь хэмжээ"-г батлуулсан. Дээрх тогтоолын хүрээнд "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн 1 дүгээр ээлжинд 105 айлын орон сууцыг зорилтот бүлгийн иргэдэд, журмын дагуу олгосноос ХБИ-7, ахмад-11, өрх толгойлсон эх, эцэг-2, Олон хүүхэдтэй гэр бүл-6,Залуу гэр бүл-10, эмч, сувилагч, асрагч-14, сургуулийн багш-16, цэцэрлэгийн багш-15, малчин-17 байна. Үүнээс 45 төрийн албан хаагч түрээсийн орон сууцанд хамрагдаж, аятай тухтай ажиллаж, амьдрах боломжтой болсон. Мөн Улаанбаатар хотоос нарийн мэргэжлийн 10 эмч, 10 багшийг орон нутагт урин, орон сууцаар хангаж, 5 жил тогтвор суурьшилтай ажилласан тохиолдолд орон сууцыг өмчлөх эрх олгохоор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зар түгээн, материал хүлээн авч байна. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс сул ажлын байрны захиалгыг авч нэгтгэн, и-жоб цахим системд бүртгэн, шилжин ирэгсдийг ажлын байраар хангах | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бодлогыг хэрэгжүүлж байна. | |
| 272 | 6.2.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөтөлбөр, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлнэ. | 6.2.1.3. Аймгийн хөгжлийн тэргүүлэх бодлого, чиглэлд тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг хангах, уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжих, газар зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар шилжин суурьшигчдын тоог нэмэгдүүлэх | 2023 - 2024 | | | | | "Сайншанд сумын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар тусгагдсан нийт 43 нэгж талбарыг нийслэлээс хөдөө орон нутагт шилжин суурьсан 7 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлсэн бол 6 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлсэн. Мөн сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн зориулалтаар тусгагдсан 126 нэгж талбараас 45 нэгж талбарыг иргэн, хуулийн этгээдэд олгосон. Мөн барилгын салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд, зураг төсөл зохиогч, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 50 гаруй аж ахуйн нэгжүүдийг хамруулсан “Нээлттэй Дорноговь-Барилга, орон сууц” үзэсгэлэнгийн арга хэмжээг зохион байгуулсан. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах ажлын хүрээнд Дорноговь аймагт ажиллаж амьдарч байгаа боловч шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгээгүй ажилтан албан хаагчдын судалгааг байгууллагуудаас авсан. Мөн аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс шилжилт хөдөлгөөний бүртгэл хийх ажлын хүрээнд 545 иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг баталгаажуулж ажилласан. Аймгийн аж үйлдвэр хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулагдаж бэлэн болсонтой холбогдуулан сум болгонд эдийн засгийн бүтэц бий болгон нэмүү өртөг шингэсэн мал аж ахуйн болон газар тариалангийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах цаашлаад уул уурхайн компаниудад нийлүүлэх | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | замаар орлого олох боломжийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. “Шинэ хөдөө” төслийг хэрэгжүүлж төслийн хүрээнд 952,5 сая төгрөгийн үнэ бүхий 4 төрлийн хэмжээст хүлэмж 350 ш, 899,2 сая төгрөгийн үнэ бүхий 40 морины хүчтэй дугуйт трактор 20 ширхэг, анжис 20 ширхэг, роторт сийрүүлүүр 20 ширхэг, сийрүүлэгч манагч 20 ширхэг, төмс суулгагч 20 ширхэг, хүнсний ногооны үрлүүр 20 ширхэг, 38,0 сая.төгрөгийн үнэ бүхий 1,5 тн-ы багтаамжтай 40 ш усны нөөцийн савыг шинээр нэмэгдүүлэн олгосон. | |
| **Дундаж үнэлгээ:** | | | | | | | | | **93.6** |